

ЖИЛИЙН ТАЙЛАН

2020

01

ЕРӨНХИЙ АГУУЛГА

Хөгжлийг тодорхойлсон хагас жаран	4
Гүйцэтгэх захирлын мэндчилгээ	6
Удирдлагын баг бүтэц, зохион байгуулалт	8
2020 оны онцлох үйл явдал	12
Эдийн засгийн мэдээлэл	14
Хураангуй санхүүгийн тайлан	16
Компанийн засаглал	18
Тогтвортой байдал	20
Олон улсад танигдсан банк	24
Нийгмийн хариуцлага	25
Хүний нөөцийн удирдлага	28

02

**БИЗНЕСИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГАА**

Байгууллагын зах зээл	31
Жижиг дунд бизнесийн зах зээл	33
Иргэдийн зах зээл	34
Гадаад харилцаа, Олон улсын банкны үйл ажиллагаа	42
Ностро данс	46
Харилцагчийн үйлчилгээ	47
Хөрөнгө зохицуулалтын удирдлага	48
Эрсдэлийн удирдлага	50
Мэдээллийн технологи	54

03

**ХАРААТ БУС
АУДИТОРЫН ТАЙЛАН**

01

ЕРӨНХИЙ
АГУУЛГА

ХӨГЖЛИЙГ ТОДОРХОЙЛСОН ХАГАС ЖАРАН

1990 оны 10-р сарын 19-ний өдөр Монгол улсад 2 шатлалт банкны системийн эх үндэс тавигдаж арилжааны ууган банк Худалдаа, хөгжлийн банк байгуулагдсан билээ. Түүхт тэр өдрөөс хойш Монгол Улсын банк санхүүгийн салбар соёолж, навч нахиагаа дэлгэж, өдгөө үр үндсээ бусдадаа түгээсээр 30-н жилийн ойтойгоо золгож байна.

Худалдаа, хөгжлийн банк түүхийн хуудасны хагас жаранд салбартаа ДЭВШИЛ БҮХНИЙ АНХДАГЧ, ҮЛГЭРЛЭГЧ нь байж Монгол Улсын эдийн засгийн тулгуур хүч болж ирсэн бахдам амжилтаар 30-н жилийг үджээ.

Худалдаа, хөгжлийн банк нь 2007 оноос хойш олон улсын зах зээлд нийт 1.14 тэрбум ам.доллартой тэнцэхүйц 5-н удаагийн бондыг амжилттай арилжаалж, харилцагчдадаа хөнгөлөлттэй зээл хэлбэрээр олгож, улсын гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшийг тогтворжуулах болон худалдааны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулжээ. Бид олон улсын зах зээлд бонд арилжаалсан Монголын хамгийн анхны аж ахуйн нэгж төдийгүй, цорын ганц арилжааны банк байсаар байна.

Түүнчлэн банк, санхүүгийн салбарт анхны гэсэн тодотголтой бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлж, харилцагчид болон бизнесийн түнш байгууллагуудынхаа санхүүгийн эрэлт хэрэгцээг ханган ажиллаж ирсэн.

Монгол улсад үйл ажиллагаа эрхэлдэг 36,000 гаруй байгууллага манай банкны бүтээгдэхүүн үйлчилгээг ашиглан бизнесээ өргөжүүлдэг нь банк санхүүгийн систем, байгууллагын зах зээлийн 36 хувийг бүрдүүлдэг. Мөн Монгол Улсын гадаад төлбөр тооцооны 85 хувь, худалдааны санхүүжилтийн үйлчилгээний 55 хувийг бид дангаараа гүйцэтгэж байна. Түүнчлэн хамгийн олон гадаадын банктай корреспондент харилцаатай хамтран ажиллаж, олон улсад төлөөлөгчийн газартайгаар салбартаа тэргүүлэн ажилладаг билээ.

Худалдаа, хөгжлийн банк нь ирэх он жилүүдэд харилцагчдынхаа зах зээлийн эрэлт хэрэгцээнд үндэслэн банкны үйлчилгээг шинэ түвшинд хөгжүүлж, үйлчилгээнээс хүртэх сэтгэл ханамжийг нэмэгдүүлэн, анхдагч болоод тэргүүлэгч байр сууриа бататган хадгалж ажиллах болно.

30-н жилийн хугацаанд бидэнд итгэл хүлээлгэн, хөгжил дэвшил өөд хамтдаа тэмүүлсэн хүндэт харилцагчид, бизнесийн түнш байгууллагууд, олон улсын харилцаатай хамтрагч банкууд Та бүхэндээ гүн талархал илэрхийлье. Мөн Худалдаа, хөгжлийн банк болоод TDB соёлын стандартын үндэс суурийг тавилцсан анхдагчууд, уламжлан хөгжүүлж ирсэн үе үеийн удирдлагууд, ажилтнууд, ахмад ажилтнууд Та бүхэндээ хөгжлийг тодорхойлсон хагас жарны баярын мэндийг дэвшүүлж, нийт удирдлагын багийн зүгээс талархал илэрхийлье.

Хүсэл, зорилго, тэмүүллийг зогсоож үл дийлэх итгэлцэл, үнэ цэнийг тантай хамт бүтээв.



БАНКНЫ ЛОГО

Банкны лого нь мөнгөний нэгж болох зоосны хэлбэрт суурилж зохиогдсон бөгөөд түүнд урлаж шингээсэн агуулга нь зоосны голд дүрслэгдсэн мөнгөний авдарт тасралтгүй эргэлдэх мөнгөний эргэлтээр дөрвөн зүг найман зовхисоос эд баялаг хуримтлагдан арвижиж, эд мөнгөөр элбэг дэлбэг байхын утга бэлгэдлийг агуулдаг.

УРИА

“Хөгжил дэвшилд хамтдаа”

Уриа нь банкны ажилтнууд, харилцагчид, хөрөнгө оруулагчид зэрэг хүн бүхнийг хөгжил дэвшлийн зүгт хамтдаа алхахыг уриалан дуудах, нэгтгэх, зоригжуулсан утга бэлгэдэлтэй юм.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид харилцагчдадаа хүсэл, тэмүүлэлдээ хүрэхэд нь зориулж, хүлээлтээс нь давсан санхүүгийн цогц үйлчилгээг дэвшилтэт технологиор хүргэнэ.

ҮНЭТ ЗҮЙЛС

Бидний харилцагч

Үнэлэмжтэй

Төгс төгөлдөр

Эгнэгт нээлттэй

Эвсэг баг

Гүйцэтгэл төгс

Чин хүндлэл

БҮТЭЭГЧ
CREATOR

Customer centric

Recognition

Excellence

Accessible

Teamwork

Outperforming

Respect

АЛСЫН ХАРАА

Хөгжиж буй Монголын дэвшил бүхнийг манлайлагч банк байна.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хүндэт харилцагчид, түншүүд, хамтран ажиллагсад
Та бүхэнтэйгээ банкныхаа 2020 оны амжилт, ололт болон
банкныхаа түүхт 30 жилийн ойн мэдээллээ хуваалцаж
буйдаа туйлын баяртай байна.

Та бүхнийг хүндэтгэсэн,
ХХБ-ны Гүйцэтгэх захирал
Ононгийн ОРХОН



Худалдаа, хөгжлийн банкны хувьд 2020 он томоохон үйл явдлууд, өөрчлөлт шинэчлэлтээр дүүрэн жил байлаа. Тухайлбал 2015 онд олон улсын хөрөнгийн зах зээлд гаргасан 500 сая ам.долларын бондыг 100 хувь өөрийн эх үүсвэрээр амжилттай төлж хөрөнгө оруулагчид, харилцагчдынхаа итгэлийг хүлээсэн найдвартай банк гэдгээ тав дахь удаагаа бататгалаа.

Дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас улс үндэстэн бүрд эдийн засгийн таагүй нөхцөл байдал үргэлжилж буй энэ цаг үед тус бондыг хугацаанд нь амжилттай төлснөөр Монгол Улсынхаа нэр хүндийг олон улсын зах зээлд дахин эергээр хоногшуулж, хөрөнгө оруулагчдын итгэлийг хүлээсэн явдал боллоо. Дэлхийд нэр хүнд бүхий Уур амьсгалын ногоон сан (Green Climate Fund)-гаас ХХБ-ийг Уур амьсгалын ногоон сангийн Монгол Улс дахь итгэмжлэгдсэн байгууллагаар сонголоо.

Ингэснээр ХХБ хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй байгаль цаг уурын гамшигт үзэгдлийн эрсдэлийг бууруулах үндэсний төсөл, хөтөлбөрүүдэд урт хугацаат, нэн хөнгөлөлттэй нөхцөл бүхий санхүүжилтийг олгох боломж бүрдлээ. 2019 оноос эхлүүлсэн бизнесийн шинэ модельдоо бүрэн шилжих стратегийн хүрээнд 21 жилийн түүхтэй Улаанбаатар хотын банкныг өөртөө нэгтгэж, Монгол Улсын банкны салбарын түүхэнд байгаагүй хүчирхэг томоохон нэгдлийг бий болголоо. Мөн тус онд банкны маань үүсгэн байгуулагдсаны 30 жилийн

ой тохиосон ба Ковид-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас харилцагчид, түншүүд, бизнесийн хамтрагчдадаа зориулсан хүндэтгэл, талархлын арга хэмжээ болоод нийт ажилтнуудын баярын хурал зэргүүдийг зохион байгуулах боломж харахан бүрдсэнгүй.

Цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн таагүй нөхцөл байдал үргэлжилж, банкны секторын үйл ажиллагаанд нөлөөлөх нөхцөл байдал үүссэн хэдий ч бид харилцагчдынхаа бизнесийн нөхцөл байдал, санхүүгийн хүндрэлийг даван туулахад нь бизнесийнхээ үйл ажиллагааг уян хатан байдлаар тохируулан, бүхий л боломжит байдлаар хайртай бүхнийхээ төлөө хамтдаа хичээн ажиллаа.

Түүнчлэн төр засгаас болон төв банкнаас хэрэгжүүлж буй төлбөр тооцоо, зээл, хадгаламжийн бүтээгдэхүүнтэй холбоотой шийдвэрүүдэд манлайлан оролцож иргэд, харилцагчид, ажилтнууд та бүхнийгээ боломжит бүх хэлбэрээр дэмжин, хамтдаа цар тахлыг даван туулахаар хичээн ажиллах болно гэдгийг дурдмаар байна.

30 жилийн хугацаанд үргэлж бидэнд итгэл хүлээлгэсээр ирсэн, хөгжил дэвшил өөд тууштай хамтдаа тэмүүлсэн хүндэт харилцагчид, бизнесийн түнш байгууллагууд, олон улсын харилцаатай хамтрагч банкууд, эрхэм ажилтнууд Та бүхэндээ хөгжлийг тодорхойлсон хагас жарны баярын мэнд дэвшүүлэн, гүн талархал илэрхийлье.

УДИРДЛАГЫН БАГ



О.ОРХОН

Гүйцэтгэх захирал

О.БАНЗРАГЧ

Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч

А.ЭНХМЭНД

Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч

Д.ОТГОНБИЛЭГ

Гүйцэтгэх захирлын орлогч

Б.БАЯРМАА

Гүйцэтгэх захирлын орлогч

Д.НЯМРЭНЦЭН

Гүйцэтгэх захирлын орлогч

Ч.СОЛОНГО


Гүйцэтгэх захирлын орлогч


С.БААТАР

Гүйцэтгэх захирлын орлогч


Ц.ГАНБАЯР

Гүйцэтгэх захирлын орлогч





2020 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



Хиймэл оюун ухааны тусламжтайгаар харилцагчдынхаа төлбөр тооцоонд учирч болзошгүй эрсдэлээс хамгаалдаг боллоо.




Төлбөрийн картын мэдээллийн аюулгүй байдлын олон улсын PCI DSS-ийн шинэчлэгдсэн стандартыг дахин хангалаа.



500 сая ам.долларын бондоо 100 хувь өөрийн эх үүсвэрээр төлөв.



НҮБ-ын Уур амьсгалын ногоон сан (Green Climate Fund)-ийн Монгол Улс дахь итгэмжлэгдсэн байгууллага болов.



Системийн нөлөө бүхий Улаанбаатар хотын банкийг өөртөө нэгтгэв.



Үүсгэн байгуулагдсаны түүхт 30 жилийн ой тохиолоо.



Монгол Улсын гадаад төлбөр тооцооны 80 хувь, Худалдааны санхүүжилтийн үйлчилгээний 55 гаруй хувийг дангаараа гүйцэтгэсээр байна.



Бизнесийн шинэ стратеги, зорилго зорилт, алсын хараатайгаа уялдсан бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийг бүрэн хэрэгжүүллээ.



TDB Online үйлчилгээний цоо шинэ хувилбарыг илүү боломжоор баяжуулан харилцагч нартаа хүргэлээ.

...



Хамтын үнэ цэнийг бүтээх ХЯЗГААРГҮЙ МӨРӨӨДӨЛ төслөө амжилттай үргэлжлүүлсээр



Хуримтлалтай Монгол аяныг эхлүүллээ.

ЭДИЙН ЗАСГИЙН МЭДЭЭЛЭЛ

“Эдийн засгийн орчинд цар тахлын нөлөө сөргөөр нөлөөлөв”

Ковид-19 цар тахал нь ААН-үүдийн 45 хувьд нь маш ихээр, 28 хувьд нь дунд зэрэг, 15 хувьд нь бага зэрэг нөлөө үзүүлжээ. Аялал жуулчлал, боловсрол, зочид буудал, нийтийн хоол болон тээвэр агуулахын үйлчилгээний салбарт үйл ажиллагаа эрхэлж буй ААН-үүд цар тахлын нөлөөнд хамгийн их өртсөн байна. Юуны түрүүнд уул уурхай болон үйлчилгээний салбар (нүүрсний тээвэрлэлт, агаарын тээвэр, аялал жуулчлал) нэрвэгдэв. Харин хөдөө аж ахуй, эрүүл мэнд, үл хөдлөх хөрөнгө, барилга болон мэдээлэл харилцаа холбооны салбарын ААН-үүдийн үйл ажиллагаанд харьцангуй бага нөлөөлжээ.

“Иргэдийн зээлийн эргэн төлөлтөд хүндрэл үүсэв”


Тайлант онд ковид-19 цар тахлын тархалтаас урьдчилан сэргийлэхтэй холбогдуулан МУ-ын Засгийн газраас авсан арга хэмжээний хүрээнд Монгол Улс хилээ хааж, хорио цээрийн дэглэм тогтоосноор экспортын үйл ажиллагаа зогсонги байдалд орох, бөөний болон жижиглэн худалдааны нийлүүлэлт буурах, хүнсний бус худалдааны салбар, тээвэр, түрээс, үйлчилгээний салбарын орлого тасалдах сөрөг үр дагаврууд гарлаа. Үүнтэй холбоотойгоор Монголбанкнаас гаргасан, зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах, зээлийн ангиллыг тодорхой хугацаанд бууруулахгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шийдвэрийн дагуу Худалдаа, хөгжлийн банк харилцагчдынхаа зээлийн эргэн төлөлтийг хойшлуулж, харилцагчдын зээлийн ангиллыг бууруулахгүйгээр дэмжлэг үзүүлж ажиллав.

“Эдийн засагт болсон онцлох үйл явдал”


- Цар тахлын үед Монгол Улс мөнхийн хөрш Хятад улсад 30,000 хонь бэлэглэв.
- Эдийн засаг дахь цар тахлын нөлөөллийг бууруулах зорилгоор Засгийн газар 6 их наяд төгрөгийн хөтөлбөр хэрэгжүүлсэн ба үүнээс онцлоход НДШ-ийн төлөлтийг хагас жилийн хугацаанд бүх нийтээр тэглэсэн явдал байв.
- Монгол Улс 2020 оны 10-р сарын 24-нд Олон улсын санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага болох ФАТФ-ын Саарал жагсаалтаас гарав.

ДНБ


Цар тахал, гадаад болон дотоод орчны тодорхойгүй байдал нэмэгдсэнтэй холбоотойгоор ДНБ сүүлийн 2 жилийн хугацаанд буурсан үзүүлэлттэй байна.



Жилийн инфляц



ХАНШ (төгрөгийн ам_доллартай харьцах ханш)



БАНКНЫ СЕКТОР

Дэлхийн нийтээр төв банкууд бодлогын хүүгээ түүхэн бага түвшинд хүргэх замаар мөнгө зээлийн дэмжлэгийг идэвхжүүлж, нээлттэй захын үйл ажиллагаа эрхлэх замаар нөөц нийлүүлж банкны системийн дарамтыг бууруулахаар ажиллаж байна.

Гэсэн хэдий ч 2020 онд байгууллага болон иргэдэд олгосон нийт зээлийн хэмжээ өнгөрсөн оны эцсийн үзүүлэлтээс 1.3 их наяд төгрөгөөр буюу 6.4 хувиар буурчээ.

Нийт 19.7 их наяд төгрөгийн багц байгаагаас 9.5 их наяд төгрөг буюу 48.2 хувь нь иргэдийн зээл харин 10.2 их наяд төгрөг буюу 52.8 хувь нь байгууллагын зээл эзэлж байна.

МУ-ын засгийн газар болон Монголбанкнаас иргэд, ААН-үүдийг цар тахлын сорилттой үеийг эдийн засаг, санхүүгийн дарамт багатай даван туулахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор арилжааны банкуудтайгаа хамтран зээлийн эргэн төлөлтийн хуваарь, хугацаа болон нөхцөлд уян хатан байдлаар өөрчлөлтүүдийг оруулж ажилласан. Тайлант онд банкны салбарын олгосон зээлийн хэмжээ 6.4 хувиар буурсан нь цар тахлын сөрөг нөлөө иргэдийн амжиргааны түвшин болон байгууллагуудын ашигт ажиллагаанд хэрхэн нөлөөлснийг шууд бус утгаар илэрхийлж байна.

Тайлант оны чанаргүй зээлийн 74.5 хувийг, хугацаа хэтэрсэн зээлийн 79.4 хувийг хувийн байгууллагын зээл бүрдүүлж байна. Чанаргүй зээлийн үлдэгдэл 2,002.3 тэрбум төгрөгт хүрч 2019 он мөн үеэс 10 хувиар нэмэгдсэн байна. Чанаргүй зээлийн 21.0 хувийг уул уурхай, 19.6 хувийг боловсруулах, 13.5 хувийг барилга, 10.4 хувийг үл хөдлөх, 7.4 хувийг худалдааны салбарын зээл тус тус эзэлж байна. Чанаргүй зээлийн хэмжээ огцом өссөн байгаа нь банкны салбарын чанарын тогтвортой байдалд анхаарал хандуулах зайлшгүй шаардлагыг харуулж байна.

Өмнөх жилтэй харьцуулбал, 2020 оны 12-р сарын эцсийн байдлаар төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 16.1 хувь буюу 0.9 хувиар, гадаад валютаар олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 10.3 хувь буюу 0.4 хувиар тус тус буурчээ.

2020 онд нийт хадгаламжийн хэмжээ 18.0 их наяд төгрөг байгаагаас 85.4 хувь буюу 15.4 их наяд төгрөг нь иргэдийн, 14.6 хувь буюу 2.6 их наяд төгрөг нь байгууллагын хадгаламж байна. Нийт хадгаламжийн 25.7 хувь нь гадаад валютын хадгаламж байна. Үүнээс иргэдийн хадгаламжийн 22.8 хувийг, байгууллагын хадгаламжийн 42.8 хувийг гадаад валютын хадгаламж бүрдүүлж байна.

Хадгаламжийн үлдэгдэлд тооцох жигнэсэн дундаж хүү иргэдийн төгрөгийн хадгаламжийн хувьд 10.5 хувь, гадаад валютын хадгаламжийн хувьд 4.1 хувьтай байгаа бол хувийн байгууллагын төгрөгийн хадгаламжийн хувьд 8.8 хувьтай байна. Хадгаламжийн хүү харьцангуй багаар буурч байгаа нь банкуудын хооронд цөөн хэдэн томоохон хадгаламж эзэмшигчийн төвлөрсөн хадгаламжид хүчтэй өрсөлдөөн байгааг харуулсаар байна.

ХУРААНГУЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН ТУСДАА САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тэрбум төгрөгөөр

Хөрөнгө	2018	2019	2020
Бэлэн мөнгө ба Монголбанкн дахь мөнгөн хөрөнгө	1,015.0	1,096.1	857.0
Бусад банк, санхүүгийн байгууллага дахь мөнгөн хөрөнгө	279.8	301.4	570.0
Санхүүгийн хөрөнгө оруулалт	1,759.1	1,832.6	1,712.0
Охин болон хараат компани дахь хөрөнгө оруулалт	-	-	40.8
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	379.3	494.9	89.4
Зээл ба урьдчилгаа	3,054.7	3,503.2	4,108.7
Бусад хөрөнгө	250.6	103.8	112.7
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	80.1	80.9	149.0
Борлуулах зориулалттай үл хөдлөх хөрөнгө	64.9	-	4.1
Үндсэн хөрөнгө, цэвэр	397.5	392.3	458.6
Ашиглах эрхтэй хөрөнгө	-	12.7	10.1
Биет бус хөрөнгө, цэвэр	2.8	5.8	4.4
НИЙТ ХӨРӨНГӨ	7,283.8	7,823.7	8,116.8
Өр төлбөр	2018	2019	2020
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	182.0	189.4	102.9
Буцаан худалдаж авах гэрээгээр борлуулсан үнэт цаас	65.0	65.0	224.3
Харилцагчдын харилцах, хадгаламж	3,522.8	3,821.4	5,311.5
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	1.5	76.2	99.7
Санхүүгийн байгууллагаас авсан зээл	975.8	759.3	558.7
Хоёрдогч өглөг	-	150.0	-
Гаргасан өрийн үнэт цаас	1,461.2	1,536.5	160.1
Бусад өр төлбөр	146.6	508.6	628.4
Түрээсийн өр төлбөр	-	13.6	11.4
Орлогын татварын өглөг	-	-	0.1
Хойшлогдсон татварын өглөг	-	-	2.2
НИЙТ ӨР ТӨЛБӨР	6,355.0	7,120.0	7,099.3
Өөрийн хөрөнгө	2018	2019	2020
Хувьцаат капитал	55.2	50.0	72.7
Нэмж төлөгдсөн капитал	210.4	19.3	251.1
Дахин үнэлгээний нөөц	129.2	129.2	169.0
Борлуулах боломжит санхүүгийн хөрөнгийн хуримтлагдсан хэрэгжээгүй олз (гарз)	10.8	22.2	24.1
Мөнгөн гүйлгээний хейджийн үнэлгээний хуримтлагдсан хэрэгжээгүй олз	29.4	-	-
Хуримтлагдсан ашиг	493.8	483.0	500.6
НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	928.8	703.7	1,017.5
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	7,283.8	7,823.7	8,116.8

Тусдаа дэлгэрэнгүй орлогын тайлан

	2018	2019	2020
Хүүгийн орлого	664.5	701.6	707.9
Хүүгийн зардал	(476.3)	(521.7)	(506.2)
Хүүгийн цэвэр орлого	188.2	179.9	201.7
Шимтгэл, хураамжийн цэвэр орлого	37.9	40.4	39.4
Үйл ажиллагааны бусад орлого (алдагдал), цэвэр	38.8	32.1	(5.7)
Хүүгийн бус цэвэр орлого	76.7	72.5	33.7
Үйл ажиллагааны орлого	264.9	252.4	235.4
Үйл ажиллагааны зардал	(91.1)	(129.9)	(131.6)
Үнэ цэнийн бууралтын нөөцийн алдагдал	(129.1)	(58.1)	(64.7)
Хараат компанийн алдагдлаас ногдох хувь	-	-	(14.5)
Татварын өмнөх ашиг	44.7	64.4	24.6
Орлогын татварын зардал	(0.3)	(0.0)	(3.6)
Тайлант жилийн цэвэр ашиг	44.4	64.4	21.0

Харьцаа үзүүлэлтүүд

Ашигт ажиллагаа	2018	2019	2020
Зардлын орлогод эзлэх хувь	34.4%	51.5%	55.9%
Цэвэр хүүгийн зөрүү	3.5%	3.1%	3.5%
Өөрийн хөрөнгийн өгөөж	4.8%	9.1%	2.1%
Активын өгөөж	0.6%	0.8%	0.3%
Өсөлтийн харьцаанууд			
Активын өсөлт	6.3%	7.4%	3.7%
Зээлийн өсөлт	10.5%	14.7%	17.3%
Харилцах, хадгаламжийн өсөлт	14.3%	8.5%	39.0%
Өөрийн хөрөнгийн өсөлт	10.1%	-24.2%	44.6%
Активын чанар			
Зээл / Харилцах, хадгаламж	99.0%	103.0%	86.8%
Зээлийн активт эзлэх хувь	47.9%	50.3%	56.8%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар	42.3%	32.1%	39.3%
Өөрийн хөрөнгийн харьцаа			
1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ	16.6%	11.4%	14.8%
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	19.5%	17.0%	16.4%

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ХХБ нь олон улсын туршлагаар шалгарсан компанийн засаглалын бүхий л хэм хэмжээг хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд дээд түвшний, сайн байгууллагын засаглал нь бидний үйл ажиллагааны гол чиглүүлэгч болдог.

Бид компанийн засаглалын бүтцэдээ Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн болон удирдлагын багийн гишүүд, хувь нийлүүлэгчдийн хамтын ажиллагаа, нягт харилцааг нарийн тодорхойлж, байгууллагынхаа эрхэм зорилго, зорилтдоо хүрэхийн тулд ажилтан бүр ёс зүйн ямар хэм хэмжээг үйл ажиллагаандаа баримтлахыг нарийвчлан заасан байдаг.

Төлөөлөн удирдах зөвлөл

ХХБ-ны ТУЗ нь байгууллагын бүхий л шатанд ил тод, үнэнч шударга байдлыг чухалчлан, нээлттэй засаглалыг бий болгохын зэрэгцээ ямар ч нөхцөлд тохирсон алсын хараа, стратеги бүхий бодлогоор банкны үйл ажиллагааг чиглүүлж, дэмжин ажилладаг.

Удирдлагын баг

ХХБ-ны удирдлагын баг нь банк, санхүүгийн чадварлаг менежерүүдээс бүрддэг ба компанийн засаглалын зохистой бүтэц, олон жилийн туршлага нь удирдлагын багийн амжилттай ажиллах суурь нь болдог төдийгүй банкны урт удаан хугацааны ашигт ажиллагааг хангах, улмаар хувь нийлүүлэгчдийн үнэ цэнийг өсгөх боломжийг олгодог.

Компанийн засаглалын зорилго

Компанийн засаглалыг сайжруулан олон улсын шилдэг зарчим, туршлагуудын хэмжээнд хүргэх. Олон улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц, нэр хүндтэй үнэ цэнтэй, хөрөнгө оруулалтыг бодитой татаж чаддаг болох.

Ажилтнууд

ХХБ-ны амжилтын үндэс нь эрч хүчтэй, чадварлаг ажилтнууд бөгөөд тэднийг шударгаар урамшуулах, дэмжих, албан тушаал дэвшүүлэх хөгжлийн тогтолцоог сайжруулснаар харилцагчдадаа банкны шилдэг үйлчилгээг үзүүлж чаддаг.

Бид

ХХБ нь хууль, ёс зүйн хариуцлагын хүрээнд нийцсэн ажиллах орчныг бүрдүүлэхийг үргэлж эрмэлзсээр ирсэн бөгөөд харилцагч, бизнесийн түншүүд болон нийгэмдээ банкны шилдэг үйлчилгээг үзүүлэн, хувь нийлүүлэгчид болон харилцагчдынхаа өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ аливаа амжилт нь шударга байх ёстой гэдэгт итгэдэг.

Төлөөлөн удирдах зөвлөл

ТУЗ - ИЙН ДАРГА

Должин ЭРДЭНЭБИЛЭГ

ТУЗ - ИЙН ГҮЙЦЭТГЭХ ДЭД ДАРГА

Рандолф КОППА

Гишүүд

Дамбийжав ХҮРЭЛБААТАР

Дамдин ГАНТӨГС (2020.08)

Дагмид ЯНЖМАА

Зуунай ШАГДАРСҮРЭН (2020.05)


Жалбаа БОЛОРМАА

Жамсрандорж ДЭЛГЭРСАЙХАН

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Өнөрбат БАТЧИМЭГ

ДОТООД АУДИТ, ДОТООД ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО



ХХБ-ны Дотоод аудитын үйл ажиллагаа нь банкны Төлөөлөн удирдах зөвлөл, Аудитын хороонд ажлаа тайлагнаж, аудитын үр дүнг Гүйцэтгэх удирдлагад мэдээлэх зарчимтай бөгөөд банкны бүхий л үйл ажиллагааны үр өгөөжийг дотоод аудитын мэргэжлийн үүднээс системтэйгээр үнэлж дүгнэн, өмнөө тавьсан зорилгодоо хүрэхэд нь туслан, зөвлөгөө өгөх чиглэлээр ажилладаг.

Дотоод аудитын газар

Дотоод аудитын газар нь Дотоод аудиторуудын олон улсын институт (IIA)-ийн гаргасан Олон улсын мэргэжлийн практикийн хүрээ (International Professional Practice Framework), олон улсын сайн туршлагыг үйл ажиллагаандаа жишиг болгон ажиллаж байна.

Тайлант онд Дотоод аудитын үйл ажиллагааны хүрээнд:

- Үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн, банкандаа үнэ цэн нэмэхээс гадна банкныхаа үйл ажиллагааны бүх түвшинд эрсдэлийг бууруулах, хамтын ажиллагааг сайжруулахад хувь нэмрээ оруулж ажиллаа.
- Бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийн хүрээнд Дотоод аудитын газрын харьяанд Мэдээллийн технологийн аудитын хэлтэс, Чанарын удирдлагын алба шинээр байгуулан, олон улсын стандартын дагуу банкныхаа бүхий түвшинд зөвлөмж, зөвлөгөө өгч ажиллаа.

Ирэх 2021 онд аудитын программ хангамжийн шинэ хувилбарыг нэвтрүүлэх, тасралтгүй аудит болон зайнаас хийгдэх аудитуудад дэвшил гаргах, чанарын удирдлагын албаны үйл ажиллагааг тогтмолжуулах зорилт тавьж ажиллах болно.

Дотоод хяналтын тогтолцоо

Дотоод хяналтын үйл ажиллагаа нь банкны өдөр тутмын үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг ба бизнес, үйл ажиллагааны бүх түвшинд эрсдэлийг бууруулах тогтолцоо юм. Үүнд банкны дээд удирдлага, гүйцэтгэх удирдлага, ажилтнууд, холбоотой талууд оролцож, дотоод хяналтын үр дүнтэй, үр ашигтай байдалд Аудитын хороо, Дотоод аудитын газар үнэлэлт дүгнэлт өгөх зарчмаар ажилладаг. Түүнчлэн бизнесийн бүхий л түвшинд оновчтой хяналтын тогтолцоо бүрдүүлсэн байх шаардлагатай байдаг. Үүнд, удирдлагын түвшний хяналт, газар, нэгж бүрийн онцлогт тохирсон хяналт, газар дээрх хяналт, комплайнсын хэрэгжилт, зохицуулалтын бодлого, журам, заавар, программд хандах эрхийн зөвшөөрөл өгөх үйл ажиллагаа зэрэг багтана. ХХБ нь дотоод хяналтын тогтолцоогоо оновчтой болгох талаар арга хэмжээ авч, тасралтгүй сайжруулдаг. Тухайлбал, банкны бүх нэгжүүд Гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан "Дотоод хяналтын матриц"-ыг мөрдөж ажилладгаас гадна заавар журамдаа дотоод хяналттай холбоотой заалтыг тусгах, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтод хяналтын үүргийг тусгах, хяналтын чиг үүрэг бүхий ажлын байр, тайлагналтын тогтолцоотой.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ



Бид бизнесийн үйл ажиллагаандаа тогтвортой, хариуцлагатай байдлыг чухалчлан байгаль орчинд ээлтэй бизнесийг дэмжин, санхүүжүүлэх замаар урт хугацааны тогтвортой хөгжлийг бий болгох зөв жишгийг нийгэмдээ бүтээхээр ажилладаг.

2012 онд Нидерландын Хөгжлийн Банк (FMO)-тай хамтран “Байгаль орчин, нийгмийн хариуцлагын эрсдэлийн менежментийн систем” (БОНХМС) хэмээх Монгол Улсын хувьд цоо шинэ ойлголтыг цогцоор нь хэрэгжүүлж эхэлсэн Монголын анхны арилжааны банк болсон юм.

2013 оны 11-р сард Монголын нийт арилжааны банкууд “Монгол Улсын Тогтвортой Санхүүжилт (ТоС) - ийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хамтарсан тунхаг бичигт нэгдсэн нь манай улсын ирээдүйн хөгжилд хэрэгтэй томоохон дэвшил болохуйц үйл явдал болсон. Арилжааны банкууд нэгдэн ажилласнаар амьдрах орчин болох ус, хөрс, агаарын бохирдол, цаг уурын өөрчлөлт, хүний эрхийг зөрчсөн асуудлуудын эсрэг бат зогсож, байгаль орчин, нийгмийн эрсдэлийг бууруулах замаар тогтвортой хөгжлийг бий болгох хэтийн зорилго өөд тэмүүлж байна.

2020 оноос Банк шинэ зохион байгуулалтын бүтэцтэй ажиллаж эхэлсэн бөгөөд үүний хүрээнд Олон улсын банкны газрын Гадаад эх үүсвэрийн удирдлага, хяналт хэлтсийн дэргэд Ногоон санхүүжилтийн алба (“НСА”)–г байгууллаа. НСА нь дэлхийн шилдэг туршлагуудыг олон улсын санхүүгийн түнш байгууллагуудтай хамтран боловсруулах, үйл ажиллагаанд хэрэгжүүлэх мөн тогтвортой санхүүжилт босгох чиглэлээр идэвхтэй ажиллаж байна.

Байгаль орчин, нийгмийн хариуцлагын бодлого

Бид байгаль орчин, нийгмийн хариуцлагын бодлого, үйл ажиллагаандаа Монгол Улсын зохих хууль тогтоомж болон дүрэм зааврыг баримталж ажиллахаас гадна:

- НҮБ-ын Даян дэлхийн гэрээний арван зарчим;
- НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн санхүүгийн санаачилга: Байгаль орчны болон тогтвортой хөгжлийн талаарх санхүүгийн байгууллагуудын тунхаглал;
- Үндэстэн дамнасан корпорац болон нийгмийн бодлогын талаарх Олон улсын хөдөлмөрийн байгууллагын зарчмын гурван талт тунхаглал;
- Олон улсын санхүүгийн корпорац (ОУСК)-ийн Гүйцэтгэлийн найман стандарт;
- Монгол Улсын Тогтвортой санхүүгийн холбоо (ТоС холбоо)-ны Тогтвортой санхүүжилтийн найман зарчим;
- Бүс ба Зам санаачилгын Ногоон хөрөнгө оруулалтын долоон зарчмуудыг өөрийн үйл ажиллагаа болон санхүүгийн хэлцлүүддээ хэрэгжүүлж, мөрдөж ажиллахыг зорьдог.

Жендерийн эрх тэгш байдлын бодлого

Банк “Худалдаа, хөгжлийн банкны харилцагчдад баримтлах жендерийн бодлого”, “Худалдаа, хөгжлийн банкны дотооддоо баримтлах жендерийн бодлого”-уудыг нэгтгэн, шинэчлэн найруулж “Жендерийн эрх тэгш байдлын бодлого”-ыг олон улсын стандартын дагуу бэлдэн үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн.

Энэхүү бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөг Монгол Улсын Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомж, үндэсний хөтөлбөр болон бусад олон улсын байгууллагуудын тэргүүн туршлагыг харгалзсан ба НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгын Жендерийн эрх тэгш байдлыг хангах зорилго, зорилтуудыг дэмжин ажиллахаар зохицуулагдсан болно. Түүнчлэн Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2017-2021 он), Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамрагдах байгууллага, агентлагийн жендерийн бодлого (2016-2024)-д нийцсэн болно.

Уг бодлогоор эрх тэгш байдлыг хангахын төлөө шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх, жендерийн эрх тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийг чадавхжуулахад чиглэсэн төсөл, хөтөлбөрт дэмжлэг үзүүлэх, мэдлэгийг бий болгох, жендерийн харьцааг тэнцвэржүүлэх, ялган гадуурхалтаас сэргийлэхэд оршино.

Тогтвортой хөгжилд хамтдаа

ХХБанк 2020 оноос эхлэн өөрийн хэрэглээний ногоон зээлийн бүтээгдэхүүнийг өөрийн эх үүсвэрээс олгож эхэлсэн. Мөн бид онлайн худалдааны томоохон платформ болох Shoppy.mn-тэй хамтарсан ногоон зээлийн үйлчилгээг бий болгож, худалдан авагчдын хариуцлагатай сонголт, хэвшлийг дэмжиж ажиллалаа.

2020 онд 17 ТХЗ-ыг хэрэгжүүлж ажиллаж байгаа бөгөөд эдгээрийн дөрөвт нь стратегийн ач холбогдол өгч ажиллалаа. Улмаар 2020 онд ТХЗ-уудын дагуу ойролцоогоор 972 тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилтийг олгожээ.

Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг нийгмийн бүх бүлэгт хүртээмжтэй байлгах үүднээс хараагүй иргэдэд зориулсан брайль үсгийг ашиглах ажлыг АТМ-ы үйлчилгээ болон банкны төлбөр тооцооны төвүүдэд эхлүүлээд байна.



НҮБ-ЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУДААС ХХБ-НЫ БАРИМТЛАН, АЖИЛЛАЖ БУЙ 4 ЗОРИЛТ

4 ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ



НҮБ-ын тогтвортой хөгжлийн зорилтын

4.1 2030 он гэхэд бүх охид, хөвгүүдэд үнэ төлбөргүй, тэгш, чанартай бага, дунд боловсрол эзэмшүүлж, холбогдох, үр дүнтэй сургалтын үр дүнд хүргэнэ;

4.3 2030 он гэхэд бүх эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд мэргэжлийн болон дээд боловсрол их дээд сургууль зэрэг боловсролыг тэгш хүртээмжтэйгээр хүргэх байдлыг хангана;

4.5 2030 он гэхэд боловсролын жендерийн ялгааг арилгаж, эмзэг бүлгийн, түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй иргэд, уугуул иргэд, эмзэг нөхцөл байдалд байгаа хүүхдүүдийн боловсрол, мэргэжлийн бүх түвшинд тэгш хүртээмжтэй болгоно.

ХХБ-ны 2020 оны үйл ажиллагаа

Номын сангийн төсөл 2020 онд цар тахлын улмаас бага зэрэг удааширч 4 сургуулийн номын санг тохижуулж, 10,000 гаруй хүүхдүүдийн боловсролд хувь нэмэр орууллаа.

2020 онд давхардсан тоогоор 3,379 ажилтан дотоод сургалтад хамрагдсан. **Үүнд:**

- Тогтвортой санхүүжилтийн сургалт
- ТХБ-ын үнэлгээ, Ногоон зээлийн бүртгэлийн талаар харилцааны шинэ менежерүүдэд зориулсан сургалт
- Бүх ажилтнуудад зориулсан хүний эрх, хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын сургалт
- Жендерийн тэгш байдал ба ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, хэлтэс, хэлтсийн дарга нарт цаг уурын санхүүжилт олгох сургалт.
- Хоёр банкныг нэгтгэх ажлын хүрээнд шинээр элсэж буй бүх ажилтнуудад холбогдох сургалтуудыг зохион байгуулав.

5 ЖЕНДЕРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ



НҮБ-ын тогтвортой хөгжлийн зорилтын

5.1 Эмэгтэйчүүд, охидыг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг хаа сайгүй зогсооно;

5.5 Улс төр, эдийн засаг, олон нийтийн амьдралд шийдвэр гаргах бүх түвшинд эмэгтэйчүүдийн бүрэн, үр дүнтэй оролцоо, манлайлах тэгш боломжийг хангах;


5.c Жендерийн тэгш байдлыг дэмжих, бүх түвшинд бүх эмэгтэйчүүд, охидын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр зөв бодлого, хууль тогтоомжийг баталж бэхжүүлэх.

ХХБ-ны 2020 оны үйл ажиллагаа

Банк нь Жендерийн хороогоо жендертэй холбоотой үйл ажиллагаанд хяналт тавьж ажилладаг бол Жендерийн тэгш байдлын бодлогыг Банкны бүх түвшинд, мөн Банкны үйлчлүүлэгчидтэй холбоотойгоор хэрэгжүүлж ирсэн. Тиймээс ХХБанк нь Банкны үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээнд жендерийн тэгш байдлыг хангах замаар эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн жендерийн мэдрэмжтэй оролцоог дэмжихэд хувь нэмрээ оруулсаар байна.

Банкны нийт ажилтнуудын 63 хувь нь эмэгтэй, 37 хувь нь эрэгтэй ажилтнууд эзэлж байна. Цаашилбал, банкны дунд шатны удирдлагын 44 хувь нь эмэгтэй, 56 хувь нь эрэгтэй ажилтнууд байна. Нэмж дурдахад банкны С түвшний удирдах албан тушаалтнуудыг хүйсээр нь ангилахыг жигд гэж тооцсон болно.

2020 оны эцсийн байдлаар ХХБ-ны жижиг, дунд бизнесийн сегментийн харилцагчдын 59 хувь нь эрэгтэй, 41 хувь нь эмэгтэйчүүд байна. Банкны харилцагчдын 35 хувь нь эрэгтэй, үлдсэн 65 хувь нь эмэгтэйчүүд байна.



НҮБ-ын тогтвортой хөгжлийн зорилтын

8.3 Бүтээмжтэй үйл ажиллагаа, зохистой ажлын байр бий болгох, аж ахуй эрхлэх, бүтээлч байдал, инновацийг дэмждэг хөгжлийн чиг баримжаатай бодлогыг хөхүүлэн дэмжиж, санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй болгох замаар бичил, жижиг, дунд бизнесийг албан ёсны болгож, тэдгээрийн өсөлтийг дэмжих.

8.10 Хүн бүрт банк, даатгал, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг хүргэж өргөжүүлэх, түүнийг дэмжих дотоодын санхүүгийн институтын чадавхыг бэхжүүлэх.


ХХБ-ны 2020 оны үйл ажиллагаа

Санхүүгийн үйлчилгээг илүү хүртээмжтэй болгохын тулд онлайн үйлчилгээгээ шинэчиллээ. ХХБ Монголын бүх салбарын 400 орчим томоохон корпорацид үйлчилдэг. Банк 12-р сарын 31-ний байдлаар 95 салбар, 283 АТМ, 9,166 ПОС терминалаар дамжуулан харилцагчдад хүрч үйлчилж байна.

ХХБанк 2020 оноос эхлэн үйлчлүүлэгчдээ өөрийн эх үүсвэлийн хэрэглээний ногоон зээлийн бүтээгдэхүүнийг олгож эхэлсэн. Үүнд цахилгаан халаагч, дулаан тусгаарлагч материал, бага оврын цэвэрлэх байгууламж, эко жорлон, цахилгаан автомашин, скутер, эрчим хүчний хэмнэлттэй байшин, эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүнүүд орж байна. 2020 онд 688 жижиг, дунд бизнесийн харилцагчдад 187.9 тэрбум төгрөг, 4,322 иргэдэд 256.6 тэрбум орчим төгрөгийн тогтвортой санхүүжилт олгожээ.

2020 оны 4-р улирлын байдлаар ХХБ-ны ногоон зээлийн хэмжээ 55.6 тэрбум төгрөг буюу ойролцоогоор 19.52 сая ам.доллар байна. 2020 оны 3-р улиралтай харьцуулахад банкны ногоон зээлийн багц 67.8%-иар өссөн бөгөөд 2021 оноос улам өсөх хандлагатай байна.

Түүнчлэн, ХХБ-ны нийгмийн (social) зээлийн хэмжээ 2020 оны байдлаар ойролцоогоор 916.6 тэрбум төгрөг буюу 320.77 сая орчим ам.долларт байна. 2019 онтой харьцуулахад 15 орчим хувиа өссөн байна.



НҮБ-ын тогтвортой хөгжлийн зорилтын

13.3 Цаг уурын өөрчлөлтийг багасгах, цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох, цаг уурын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, урьдчилан сэрэмжлүүлэх талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлж, хүмүүсийн болон институтын чадавхыг сайжруулах.

13.а Эрсдэлийг бууруулах үндсэн арга хэмжээ болон түүний хэрэгжилтийн талаарх ил тод байдлын хүрээнд хөгжиж буй орнуудын хэрэгцээ шаардлагыг хангах, Ногоон цаг уурын сангийн үйл ажиллагааг тус санд хуримтлагдсан хөрөнгийг ашиглан аль болох хурдан бүрэн эхлүүлэх зорилгоор бүх төрлийн эх үүсвэрээс 2020 он гэхэд жил бүр 100 тэрбум ам.долларыг хамтран бүрдүүлэх зорилтын үүднээс НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцийг хэрэгжүүлэхээр хүлээсэн хөгжингүй улс орнуудын үүрэг амлалтыг биелүүлэх.

ХХБ-ны 2020 оны үйл ажиллагаа

Өдөр бүр 1 цаг гэрэл унтрааж эрчим хүчээ хэмнэх ногоон цаг аяныг санаачилсан. Банк нь хог хаягдлыг ангилах ашигласан батерей болон хуванцар материалын хогийн савыг байрлуулж цуглуулдаг. Цуглуулсан аюултай хог хаягдлыг Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоо, Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвд хүргүүлж байна.

2020 оны 4-р сард Банк нь Үндэсний Тогтвортой Хөгжлийн акт Холбоо болон -ны итгэмжлэлтэй болж.

ХХБ нь тогтвортой санхүүжилтийн эрх зүйн орчныг бэхжүүлэх, банк, санхүүгийн байгууллагууд, банк бус санхүүгийн байгууллагууд, олон нийтийн чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор хоёр жилийн хугацаатай хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн. Цаашилбал, ХХБанк 2020 оноос хойш олон талт хөгжлийн банкууд (ОТХБ) болон олон улсын хөгжлийн санхүүгийн байгууллагуудтай (ОУХБ) Монголын бизнес эрхлэгчдийг ногоон ирээдүйд чиглүүлэхэд чиглэсэн хамтын ажиллагааны сууриа тавьлаа. Монголын сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийн холбоонд гишүүнээр элссэн анхны гишүүн банкны хувьд ногоон эрчим хүчний төслүүд, тэдгээрийг хэрэгжүүлэх боломжийг эрэлхийлэх зорилгоор холбоотой идэвхтэй хамтран ажиллаж байна.

ОЛОН УЛСАД ТАНИГДСАН БАНК



The 100 Next Global
Companies 2020



Global Banking and
Finance Review



The Best Corporate
Bank in Mongolia



Asiamoney



Best Private
Bank



Asiamoney

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА



Дэлхий нийтийг хамарсан цар тахлын хүндрэлээс хүүхэд бүрийг хамгаалах үйлсэд манлайлан оролцлоо

“Дэлхийн эрүүл мэндийн байгууллага”-аас КОВИД-19 цар тахалд өртөх хамгийн өндөр эрсдэлтэй бүлгийг амьжиргааны түвшин доогуур, зорилтот бүлгийн иргэд, түүн дотроо хүүхдүүд гэж тодорхойлсон. Энэхүү судалгаатай холбоотойгоор хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл болон хүүхдийн боловсролын асуудлуудад онцгойлон ач холбогдол өгч дэлхий нийтээрээ нэгдэн, хамтын хүчин чармайлт гарган ажиллахыг уриалсаар байгаа.

Энэхүү уриалга, Хязгааргүй мөрөөдөл төслийн зорилгууд нэгдэж, Худалдаа, хөгжлийн банк гэртээ хөл хорионд байгаа зорилтот бүлгийн 10,000 хүүхдийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрсдэл багатайгаар даван туулахад нь зориулж эрүүл мэндийн багц бүтээгдэхүүн бэлэглэх ажлыг санаачлан, 100 хувь өөрийн хөрөнгөөр санхүүжүүлж Дэлхийн зөн ОУБ-тай хамтран айл өрх, хүүхэд бүрд хүргэж өгөх ажлыг зохион байгууллаа.

Ингэхдээ халдварын нөхцөл байдлаас шалтгаалан бизнесийн орлого нь буураад буй жижиг, дунд үндэсний үйлдвэрлэгч нарын бүтээгдэхүүнээс худалдан авалтыг хийсэн юм. Үүнд цэвэр даавуун амны хаалт, гар ариутгагч, дархлаа дэмжигч витаминууд болон ундаа зэрэг багтсан юм.

Түүнчлэн Худалдаа, хөгжлийн банк цар тахлын нөхцөл байдлыг хамтдаа даван туулах зорилгоор “Эрүүл мэндийн яам”-д нэн шаардлагатай эмнэлгийн хэрэгслүүдийг хүлээлгэн өгөх мөн цар тахлын эхэн үеийн давалгаанд өртөж, нэлээд хохирол амсаад байсан мөнхийн хөрш БНХАУ-ын ард иргэдэд цар тахалтай тэмцэхэд нь зориулан мөнгөн дэмжлэг тусламжийг тус тус хандивлалаа.



ХХБАНК
10 МЯНГАН ХҮҮХДЭД
ЭРҮҮЛ МЭНДИЙН
БАГЦ БҮТЭЭГДЭХҮҮН
БЭЛЭГЛЭЛЭЭ



“Хязгааргүй мөрөөдөл” төслийнхөө хүрээнд ерөнхий боловсролын сургуулиудын номын санг тохижуулах, номоор баяжуулах, ажлаа үргэлжлүүлээ

Тус төслийн нэг үндсэн чиглэл болох ЕБС-иудын номын санг дахин тохижуулах, номоор баяжуулах ажил маань 2020 онд цар тахлын дэгдэлт, нөхцөл байдлын улмаас удааширч нийтдээ 5 сургуульд хэрэгжлээ. Ингэснээр хязгааргүй мөрөөдөл төсөлд 8,700 сурагч, 500 гаруй багш, сурган хүмүүжүүлэгчид шинээр нэмэгдлээ.

Төв шуудангийн буланд шовх оройтой Монгол малгай, дээлээ өмсөөд жилийн дөрвөн улиралд халуун хүйтнийг ажрахгүйгээр ном зардаг өвөөг нийслэлчүүд бид андахгүй. Тэртээ 30 жилийн өмнөөс л хүүхэд залуучуудад зориулж утга төгөлдөр, уран яруу үгтэй ховор номууд зарж, номын үнэ цэн, соёлыг түгээхэд энэ насаа зориулж яваа нэгэн. Төслийн хүрээнд Н.Баасандорж гуай маань ЕБС-ийн хүүхэд залууст номтой нөхөрлөхийн ач тус, үр өгөөж, үнэ цэнийн талаар лекц уншиж хойч үедээ алт шиг үнэтэй сургаалаа үлдээж байгаа юм.



Монгол Улсын газрын зурагтай ижил хэлбэр дүрс бүхий номын тавиур нь “Ухаан саруул, оюун тунгалаг, мэдлэг, боловсролтой Монгол хүүхдүүдийг төлөвшүүлэх, бэлтгэх” утга бэлгэдэл агуулсан төдийгүй, сурагч хүүхдүүдийн сонирхлыг татаж, нүдийг мялаасан сайхан бүтээл болж чадсанаараа онцлог байдаг. 3 дахь жилдээ үргэлжилж буй “Хязгааргүй Мөрөөдөл” төслийн Номын сангийн тохижуулалтын ажил маань өнөөдрийн байдлаар Улаанбаатар хот болон орон нутгийн нийт 44 сургуулийн 150 мянга орчим хүүхэд залуучууд, 4,500 орчим багш сурган хүмүүжүүлэгчдийн боловсрол мэдлэгт бодит хувь нэмрээ оруулаад байна.

Мөн тус төсөлдөө Нийслэлчүүдийн эчнээ танил болсон ном зардаг “Дээлтэй өвөө” Н.Баасандорж гуайг нэгтгэн хамтран ажиллаж эхэлсэн.



**Олон улсын стандартыг хангасан
Хөл бөмбөгийн цэнгэлдэх хүрээлэнг бид
босголцож байна.**

Аливаа спортын хөгжил, амжилтад хүрэх замд компаниудын дэмжлэг туслалцаа, үнэнч хөгжөөн дэмжигчдийн оролцоо хамгийн чухал байдаг. Сүүлийн жилүүдэд манай улсад багийн спорт тэр дундаа хөлбөмбөгийн спортын хөгжил хурдсаж тамирчдын чансаа нь жил ирэх бүр сайжирсаар байна. Энэ цаг үед бид Монгол Улс дахь хөл бөмбөгийн спортын цаашдын хөгжил, спортын амжилтад том түлхэц болох зорилгоор “Монголын Хөл Бөмбөгийн Холбоо”-нд 500 сая төгрөгийн ивээн тэтгэлэг, дэмжлэгийг үзүүлээд байна. Ингэснээр Яармагт олон улсын стандартыг хангасан хөл бөмбөгийн цэнгэлдэх хүрээлэнг байгуулах ба үндэсний шигшээ баг тамирчдаа дэмжих, олон

улсын чанартай хөл бөмбөгийн тэмцээнүүдийг эх орондоо 2021 оноос эхлэн зохион байгуулах боломж бүрдэх юм. Ивээн тэтгэлгийн дүнгийн 70 хувийг цэнгэлдэх хүрээлэнгийн бүтээн байгуулалтад, үлдсэн 30 хувийг Үндэсний шигшээ баг тамирчдын бэлтгэл сургуулилт, олон улсын тэмцээн уралдаанд оролцоход шаардлагатай хувцас хэрэглэлүүдэд зарцуулагдаж байгаа юм. Яармаг дахь цэнгэлдэх хүрээлэнгийн онцлог нь Олон Улсын Хөлбөмбөгийн Холбоо (FIFA)-ны стандартын дагуу баригдаж буй Монгол дахь хамгийн том (73x115 метр) хөл бөмбөгийн талбай юм.

ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГА



Бид харилцагч төвтэй банк болох, платформ банк болох, олон улсын банк болох зорилгуудын хүрээнд авьяаслаг, мэргэшсэн ажилтнуудаар багаа бүрдүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх, ажилтнуудын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхэд чиглэлүүдэд 2020 оны турш анхааран ажиллалаа. Мөн шинэ стратегитай холбоотой Хүний нөөцийн урт хугацааны стратегийн, зорилго, зорилтуудаа тодорхойлов.

Тайлант онд 21 жилийн түүхт системийн нөлөө бүхий банк болох Улаанбаатар хотын банкныг өөртөө нэгтгэснээр, 480 гаруй мэргэжлийн дадлага, туршлага бүхий чадварлаг боловсон хүчнээр эгнээгээ тэлж улам хүчирхэгжлээ.

Ажилтнуудынхаа карьер хөгжлийг тасралтгүй, үр өгөөжтэй байлгах зорилгын дагуу ажилтнуудыг ажилтнаа босоо болон хөндлөн чиглэлд албан тушаал дэвшүүлэн томилохдоо ХХБ-ны жендерийн эрх тэгш байдлын бодлогыг хэрэгжүүлэн, хүйсийн харьцааг тэнцвэртэй хангаж ажиллав.

Банкны салбарт ажиллах ирээдүйн залгамж халаа банкируудаа оюутан цагаас нь бэлтгэх, найдвартай ажлын байраар тасралтгүй хангах зорилгоор СЭЗИС-тай хамтын ажиллагааны санамж бичгийг 2020 онд үзэглэлээ. Ингэснээр өөрсдийн салбартаа анхдагч төдийгүй тэргүүлэгчдийн нэгд зүй ёсоор хүлээн зөвшөөрөгддөг манай хоёр байгууллага нь харилцан туршлага солилцох төдийгүй оюутан залуусын боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх нийгэм, олон нийтийн санхүүгийн боловсролыг дэмжих үйлсэд урт хугацаанд хамтран ажиллахаар болсон юм.

Сургалт, хөгжил

- Ажилтнуудын тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй, идэвх зүтгэлтэй ажиллах, ахуйн нөхцөлийг сайжруулах, ажилтны нийгмийн асуудлыг дэмжих бодлогын хүрээнд нийт ажилтнуудынхаа 80 орчим хувьд хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгов.
- 2020 онд дэлхий даяар нүүрлээд буй цар тахлаас шалтгаалан сургалт, хөгжлийн үйл ажиллагааг дижитал, цахим шилжилтийг хийх эхлэлийг тавив. Тайлант хугацаанд 4,000 орчим ажилтнуудыг сургалтад хамрууллаа.
- Нийт ажилтнуудад олон улсын түвшний мэдлэг олгох, мэргэшүүлэх, хамгийн сүүлийн үеийн мэдээ, мэдээллийг өөрийн ажлын арга барилдаа нэвтрүүлж, хамт олноороо хөгжиж, дэвших боломжийг олгох зорилгоор онлайн сургалтын платформуудын талаар судалгаа хийн, мэдээлэл бэлтгэн, DIGITAL LEARNING ONLINE TRAINING хөтөлбөрийг хэрэгжүүлэв.
- Банкны соёлыг түгээгч, мэргэшсэн банкируудын тусламжтайгаар залуу манлайлагч ажилтнуудаа чадавхжуулах, хувь хүний болон мэргэжлийн чадамжуудыг нэмэгдүүлэх, хөгжүүлэх зорилгоор “Ментор хөтөлбөр” төслийг анх удаагаа зохион байгуулав. Тус төслийн үр дүнд ажилтан бүрийн сурч, хөгжих хүсэл эрмэлзлийг бий болгож, ажил үүрэгтээ болон нийгэмд сайн сайхан зүйлсийг түгээн дэлгэрүүлэхэд хувь нэмрээ оруулж ажиллаа.
- Ажилтнуудынхаа чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор “Good readers” номын клубийг үүсгэн байгуулж, дотоод вэб хуудсандаа цахим номын сантай болсноор ажилтан бүр уншсан номын тэмдэглэлээ байршуулдаг болсон.

Хөгжил, дэвшил

- Банкны 250 гаруй бодлого, заавар журмуудыг өөрчлөн, шинээр боловсруулах төслийг үе шаттайгаар газар, хэлтэс, нэгжүүдтэй хамтран удирдан зохион байгуулж, хэрэгжүүллээ.
- Шинэ стратеги, бүтэц зохион байгуулалттай холбоотой ажилтан бүрийг тогтвортой ажиллуулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх цалингийн оновчтой системийг боловсруулах бэлтгэл ажлыг хангалаа.
- Эхний хагас жилд ажилтнуудын сэтгэл ханамжийн судалгааг хийж 2018 онд хийсэн судалгаанаас 4 пунктээр өссөн эерэг үзүүлэлттэй гарсан байна. eNPS буюу Ажил олгогчийн брэндийн цэвэр идэвхжүүлэлтийн оноо САЙН үзүүлэлттэй гарч ажилтнууд банканд цаашдаа урт удаан хугацаанд ажиллах хүсэл эрмэлзэлтэй байгааг илэрхийлж байна.
- Ажилтнуудынхаа эрүүл мэнд, өсөлт хөгжил, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, амьдралын хэв маягт дэмжлэг үзүүлэх зорилгоор нэмэлт цалинг бий болгон, сар бүр олгодог болсон нь тэдний идэвх, сэтгэл ханамж, бүтээмжид эерэг нөлөөлөл үзүүлж байна.
- Ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих, мэдлэг, мэдээлэл олгох зорилгоор эрүүл мэндийн видео санг бий болгон хөгжүүллээ.


02

БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

БАЙГУУЛЛАГЫН ЗАХ ЗЭЭЛ

Бид 2020 онд эдийн засгийн хөдөлгөгч хүч болсон уул уурхай, хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний салбарын 1700 гаруй томоохон аж ахуй нэгж байгууллага, групп компаниудын бизнесийн хэрэгцээ шаардлагад нь нийцсэн зээл, депозит, худалдааны санхүүжилт болон төлбөр тооцооны 40 гаруй бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгож, харилцагчийн бизнесийг дэмжин харилцан ашигтай, хамтран ажиллаа.

2020 онд зах зээл дээрх тэргүүлэгч байр сууриа хадгалж, амжилттай ажилласнаар банкны том болон жижиг, дунд сегментийн зээлийн багц 3.0 их наяд төгрөгт хүрч, нийт байгууллагын зах зээлийн 37 хувийг эзэлж байна.



Өнгөрсөн онд банкны зүгээс хямд өртөг бүхий, урт хугацаатай санхүүжилтийг олгож, харилцагч байгууллагуудын санхүүгийн зардлыг бууруулж, төлбөрийн чадварыг нэмэгдүүлэх, цаашлаад харилцагчдынхаа санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор дараах хөтөлбөрүүдэд оролцсон. Үүнд:

- Монгол Улсын Засгийн Газрын 2017 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 20 дугаар тогтоолоор "Алт-2" үндэсний хөтөлбөрийг баталсан бөгөөд тус хөтөлбөрт хамрагдсан нийт харилцагчдын 54 хувийг тус банк санхүүжүүлсэн.
- Хөдөө аж ахуйн салбарын 2020-2021 оны өвөлжилт хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2020 оны 19 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд мах бэлтгэн нийлүүлэгч харилцагчдад 40.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон.
- Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хүрээнд Засгийн газрын 180 дугаар тогтоолоор Хүнсний хомсдол үүсэхээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлын нөөц бүрдүүлэх зорилгоор хүнсний улаан буудай импортлох компаниудад дамжуулан зээл олгох банкаар шалгарсан.
- Монголбанкны 2020 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн 5 дугаар тогтоол, 11 дүгээр сарын 23-ны өдрийн 6 дугаар тогтоолоор уул уурхайн бус экспортыг дэмжихэд зориулсан урт хугацаат санхүүжилтэд харилцагчдыг хамруулж эхэлсэн.
- Мөн өмнөх жилүүдэд эхэлсэн байсан Монгол Улсын Засгийн газар, Монголбанк, Хөгжлийн банкны хэрэгжүүлж буй "Экспортыг дэмжих, импортыг орлох үйлдвэржилтийг дэмжих" төсөл, Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн зээлийн төсөл хөтөлбөрүүд, мөн Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа "Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт", "Ажлын байр нэмэгдүүлэх төсөл", ХБНГУ-ын КФВ банкны санхүүжилттэй төсөл, Япон улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй "Жайка" төсөл зэрэг гадаад, дотоодын банк санхүүгийн байгууллагуудын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ нь банк зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээ тогтмол хангаж, олон улсын байгууллагын шаардлагыг биелүүлэн хариуцлагатай ажиллаж байгааг илтгэж байна.

Бид бүхий л валютаар нээх, гадаад дотоод гүйлгээ, шилжүүлгийг хурдан шуурхай хийх боломжтой харилцахын бүтээгдэхүүн, үлдэгдэлдээ хүү тооцуулах боломжтой хугацаагүй хадгаламжийн бүтээгдэхүүн, хугацаа болон валютын хувьд сонголттой, өрсөлдөхүйц хүүтэй хугацаатай хадгаламжийн бүтээгдэхүүнийг харилцагч нартаа санал болгож, мөнгөн хөрөнгөө үр ашигтай удирдахад нь дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Тайлант оны эцэст байгууллагаас татсан харилцах, хадгаламжийн бүтээгдэхүүний үлдэгдэл 1.2 их наяд төгрөг байснаас хугацаатай хадгаламжийн үлдэгдэл 491.2 тэрбум буюу банкны системийн байгууллагын хугацаатай хадгаламжийн үлдэгдлийн 31%-ийг бүрдүүлж байв.

2020

Байгууллагын харилцах хадгаламж 1.2 их наяд төгрөг

Хугацаатай хадгаламж

Харилцах, хугацаагүй хадгаламж

Зах зээлд эзлэх хувь 31%

Монгол Улсын гадаад худалдаа, импортын хэмжээ буурсан жил байсан хэдий ч дотоодод гаргасан нийт баталгааны тоо 10,000-д хүрч, түүнчлэн Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас зарласан тендерийн 35 хувьд нь дангаараа тендерийн баталгаа гаргасан нь харилцагчийн дотоодоос хийх худалдан авалт, тендер болон гэрээт гүйцэтгэлийг банкны баталгаагаар хангаж, амжилттай ажилласныг харуулж байна.

Бүтээгдэхүүн үйлчилгээг цахимжуулах ажлын хүрээнд онлайн шугамын зээл, тодорхойлолтуудыг ажилтны оролцоогүйгээр цахимаар авах тухай харилцагчдад таниулж, мэдээлэл зөвлөгөөгөөр ханган, амжилттай ажиллаж байгаа ба мөн хөл хорионы үед төлбөр тооцоогоо цахимаар хийх зайлшгүй шаардлага үүссэнээр ТиДиБи онлайн үйлчилгээнд боломжит харилцагчдыг хамрууллаа.

Харилцагч төвтэй банк болох зорилтын хүрээнд шинэ бүтэц зохион байгуулалтад шилжин, харилцагчийн онцлогт тохирсон бүтээгдэхүүн хөгжүүлэлт, харилцагчийн хүсэлтийг түргэн шуурхай шийдвэрлэх шинжилгээ, хяналтын систем, харилцагчаас санал, гомдол, хүсэлтийг хүлээн авч, тогтвортой хамтын ажиллагааг хангах борлуулалтын сувагтай болсон. Ингэснээр банкны зүгээс харилцагчийн хэрэгцээ шаардлага, бизнесийн төрөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт тохирсон багц бүтээгдэхүүнийг санал болгож, санхүү, бизнесийн бүхий л асуудлуудыг түргэн шуурхай шийдвэрлэх замаар цаашдын хамтын ажиллагааг улам гүнзгийрүүлэн ажиллахаар зорьж байна.

ЖИЖИГ ДУНД БИЗНЕСИЙН ЗАХ ЗЭЭЛ

Худалдаа, хөгжлийн банк улс орны эдийн засгийн гол тулгуур болсон баялаг бүтээгч жижиг, дунд бизнес эрхлэгчдийг тууштай дэмжиж, тэдгээрийн эрэлт хэрэгцээнд нийцсэн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг түргэн шуурхай, эрсдэлгүй хүргэж ирсэн. 2020 онд банк өөрийн 60 мянган жижиг, дунд бизнес эрхлэгч харилцагчдад 97 салбар, тооцооны төв, цахим сувгууд болон мэргэшсэн харилцааны менежерүүд, зээлийн мэргэжилтнүүдээр дамжуулан бүтээгдэхүүн, үйлчилгээгээ хүргэж ажиллаа. Банк 2020 онд жижиг, дунд бизнесийн сегментийн дунд хойлж жижиг, дунд бизнесийн сегментүүдийг Олон Улсын стандартад нийцүүлж дотоод үйл ажиллагаанд нэвтрүүлсний зэрэгцээ сегментийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, суваг болон үнийн бодлогыг тодорхойлж, “Харилцагч төвтэй банк” болох зорилгын хүрээнд шинэ бүтэц зохион байгуулалтад шилжлээ.

Дэлхий дахинд нүүрлээд буй цар тахлын нөлөөгөөр эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдал үүсэж, бизнес эрхлэгчид томоохон сорилттой нүүр тулсан нөхцөлтэй байлаа. Энэ үед банк үйл ажиллагаа нь зогссон, тасалдсан, санхүүгийн хүндрэлд орсон харилцагчдын үйл ажиллагааг л талаар дэмжиж зээлдэгчдийн зээлийн нөхцөлд өөрчлөлт оруулах (зээлийн хүү болон үндсэн төлбөрөөс чөлөөлөх, хугацааг сунгах, шимтгэлээс чөлөөлөх гэх мэт) замаар жижиг, дунд бизнес эрхлэгчдэд тулгарсан санхүүгийн хүндрэлийг даван туулахад найдвартай түнш нь байж чадлаа. Тайлант хугацаанд Банк Жижиг, дунд бизнесийг дэмжигчийн байр сууриа хадгалж дотоодын болон гадаадын төсөл, хөтөлбөрүүдэд манлайлан оролцож дараах байгууллагуудтай нягт хамтран ажиллаж байна.

- ЯОУХАБ (JICA)-ын 2 үе шаттай зээлийн төсөл, Германы KFW банкны зээлийн төсөл, ЗБДС болон Азийн Хөгжлийн Банкны санхүүжилттэй зээлийн төслүүдийн хэрэгжүүлэгч санхүүгийн байгууллагаар ажиллав.
- АНУ-ын Олон Улсын Хөгжлийн агентлаг (USAID)-ийн санхүүжилтээр “Бизнесийн Тогтвортой Хөгжлийг Сайжруулах, Ил Тод Байдлыг Нэмэгдүүлэх (BEST)” хөтөлбөрийг “Хөгжлийн Шийдэл” ТББ-тай хамтран хэрэгжүүлж эхлэв.

2020 оны голлох үзүүлэлтүүд

2020.12.31-ны өдрийн байдлаар банкнаас жижиг, дунд бизнес эрхлэгчдэд олгосон зээлийн нийт үлдэгдэл **398.7** тэрбум төгрөг байна.

Зээлийн үлдэгдэл /Бүтээгдэхүүнээр/

Бизнесийн зээл

237,439.4

Үл хөдлөх хөрөнгийн зээл

84,734.4

Төслийн зээл

68,170.4

Бусад

8,410.1

Орлого

Зээлийн хүүний орлого

108,551.4 сая төгрөг

Хүүгийн бус орлого

3,325.5 сая төгрөг

Банк 2021 онд жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлээр дараах стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

- Жижиг, дунд бизнес эрхлэгчид бизнесээ эхлүүлэх, өргөжүүлэх, чадваржуулахад хамгийн өргөн, олон талт хамтын ажиллагаатай банк байх;
- Байгаль орчин, нийгэмд ээлтэй жижиг, дунд бизнесийг дэмжигч тэргүүлэгч банк байх;
- Үндэсний үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжсэн цогц хөтөлбөр хэрэгжүүлэх;

ИРГЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ



Иргэдийн банкны салбарт харилцагчдад зориулсан банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, өгөөжийг сайжруулан, харилцагчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн зах зээлд өндөр өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээг банкны салбар болон цахим сувгаар дамжуулан харилцагчдаа хүргэн ажилладаг бөгөөд 2020 онд дижитал стратегийн хүрээнд зайнаас үйлчилгээ үзүүлэх боломжит бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэхэд чиглэн ажиллаа.

Татан төвлөрүүлсэн хөрөнгийн хувьд:

Иргэдийг хуримтлалтай болгох, түүний үр ашгийг харилцагчдад таниулах, санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгын хүрээнд “Хуримтлалтай Монгол” аяныг эхлүүллээ. Хуримтлалтай байх, хуримтлалаа тогтмол нэмэгдүүлэх эсэх нь иргэдийн орлогын хэмжээнээс илүүтэйгээр санхүүгийн боловсролын түвшинтэй хамааралтай байдаг. Манай улсын хувьд нийт өрхийн 76% нь хуримтлалгүй гэдгийг Үндэсний статистикийн хорооны тайлангаас харж болно. “Хуримтлалтай Монгол” аяны хүрээнд банк хүүхэд багачуудыг мөнгөтэй зөв харилцаж сургах, нийт иргэдэд хуримтлалын ач холбогдлыг ойлгуулах, хуримтлал үүсгэх хялбар арга замд хөтлөх зэрэг шат дараалсан ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

Мөн иргэдийн сегментийн харилцагч нарт зориулсан бүтээгдэхүүн үйлчилгээний нөхцөл, давуу талуудыг өрсөлдөхүйц байхад илүүтэй анхааран, цахимаар бүх төрлийн хадгаламжийн данс харилцагч өөрөө нээх, хуримтлал үүсгэх боломжуудыг нэмэгдүүлэх, илүү таатай үйлчилгээ үзүүлэх бодлого баримтлан ажиллаа.

Иргэдийн зээлийн хувьд:

Харилцагчид зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэл багатайгаар хүргэх, бүрдүүлэх бичиг баримтыг багасгах, дэвшилтэт технологид тулгуурлан шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, зайнаас зээлийн үйлчилгээг хүргэж, зээлийн нөхцөл сайжруулах бодлого баримтлан ажиллаа.

2020 ОНЫ ОНЦЛОХ АЖЛУУД, ОЛОЛТ АМЖИЛТУУДААС ДУРДВАЛ:

“Хуримтлалтай монгол” аяныг эхлүүлээ

Худалдаа, хөгжлийн банк 30 жилийнхээ ойн хүрээнд дэлхийн хуримтлалын өдрийг угтаж, иргэдийн санхүүгийн боловсролд мэдлэг, мэдээлэл нэмэх “Хуримтлалтай Монгол” аяныг эхлүүлсэн. Улс орны эдийн засгийн дархлааг тогтоодог чухал хүчин зүйл нь тухайн улсын иргэдийн нийт “Хуримтлал” байдаг. Дэлхийд Швейцар, Швед, Герман зэрэг барууны орнууд хуримтлалаараа тэргүүлдэг ба иргэдийнх нь 95-аас дээш хувь нь хуримтлалтай, нийт орлогынхоо 8-10 хувийг тогтмол хадгалдаг байна. Зөвхөн баруунд ч гэлтгүй эдийн засгийн үсрэнгүй хөгжилтэй бүх оронд иргэдийнхээ санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, хуримтлалын ач холбогдлыг ойлгуулахад онцгой анхаардаг. Үүний нэг тод жишээ нь дэлхий даяар жил бүрийн 10-р сарын 31-ний өдөр зохион байгуулдаг “Дэлхийн хуримтлал”-ын өдөр билээ.

Монголбанк, Монголын Банкны Холбоо, ХБНГУ-ын Хадгаламжийн банкны олон улсын хамтын ажиллагааны сан, арилжааны банкууд хамтран 9 дэх жилдээ “Дэлхийн хадгаламжийн өдөр”-ийг 2020 оны 10-р сард тэмдэглэн өнгөрүүлээ.


Худалдаа, хөгжлийн банкны зүгээс тус арга хэмжээний нээлтийн үйл ажиллагаанд хүрэлцэн ирсэн эхний 100 харилцагчид гарын бэлэг, 20,000 төгрөгийн үлдэгдэлтэй Маамуу хүүхдийн хадгаламж нээх эрхийн бичиг бэлэглэж, 2020 онд шинээр нэвтрүүлсэн “Хялбар хуримтлал” үйлчилгээгээ танилцуулан, хуримтлалаа хялбархан бий болгох, нэмэгдүүлэх аргуудыг танилцуулсан.

Түүнчлэн Ерөнхий боловсролын сургуулийн бага ангид “Өнөөдрийн хуримтлал-Маргаашийн ирээдүй” сэдэвт сургалтыг өмнөх жилүүдийн адил зохион байгууллаа. Энэ жилийн сургалтаар 25 сургуулийн 1,000 гаруй сурагчдад мөнгөний үнэ цэнийг ойлгуулах, яагаад мөнгө хэрэгтэй болдог, яагаад мөнгийг арвилан хэмнэх, үр ашигтай зарцуулах хэрэгтэй талаар боловсрол олгож, ирээдүйд хуримтлалтай иргэн байхын ач холбогдол, хадгаламжийн үр ашгийг таниуллаа.

Хуримтлалтай байх, хуримтлалаа тогтмол нэмэгдүүлэх эсэх нь иргэдийн орлогын хэмжээнээс илүүтэйгээр санхүүгийн боловсролын түвшинтэй хамааралтай байдаг. Манай улсын хувьд нийт өрхийн 76% нь хуримтлалгүй гэдгийг Үндэсний статистикийн хорооны тайлангаас харж болно.

“Хуримтлалтай Монгол” аяны хүрээнд хүүхэд багачуудыг мөнгөтэй зөв харилцаж сургах, нийт иргэдэд хуримтлалын ач холбогдлыг ойлгуулах, хуримтлал үүсгэх хялбар арга замд хөтлөх зэрэг шат дараалсан ажлуудыг хийхээр төлөвлөөд байна.

Тус аяны хүрээнд иргэдэд санхүүгийн дарамтгүйгээр хуримтлалаа нэмэгдүүлэх боломжтой ХЯЛБАР ХУРИМТЛАЛЫН үйлчилгээг зах зээлд нэвтрүүлээ. Уг үйлчилгээ нь харилцагч данснаасаа зарлага гаргах болон орлого нэмэх бүртгээ тодорхой хэмжээний үнийн дүнг автоматаар, хадгаламж руугаа шимтгэлгүй шилжүүлэх хялбар сонголтуудтай бүтээгдэхүүн юм. Аяны хүрээнд хамтран ажиллагч зарим байгууллагын ажилтнуудад зориулан “Хадгаламж өлсөхөөс эхэлнэ” номын зохиогч, лектор Г.Мөнгөнийг урьж оролцуулсан “Бидний санхүүгийн сэтгэлгээ” сэдэвт өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгт хамрагдсан харилцагчид Мөнгөн лекторын сонирхолтой лекцийг сонсож, хувь хүн гэр бүлийн санхүүгээ хэрхэн үр ашигтай удирдахыг суралцаж, 2020 онд банкны шинээр нэвтрүүлсэн “Хялбар хуримтлал” үйлчилгээнд бүртгүүлэн, хуримтлалаа хялбархан нэмэгдүүлэх аргад суралцлаа. 2021 онд бид санхүүгийн салбарын олон улсын чиг хандлага болох цахим технологийг үйл ажиллагаандаа ашиглахыг эрчимжүүлэх, Финтекүүдтэй харилцан ашигтай хамтран ажиллах, банкны стратегийн зорилтуудтай уялдуулан иргэдийн бүтээгдэхүүн үйлчилгээний нөхцөлийг сайжруулах, иргэдийн зах зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг дэвшилтэт технологи ашиглан цахим сувгаар дамжуулан, харилцагчдад улам таатай хялбар байдлаар хүргэх боломжийг нэмэгдүүлэх, банкны даатгал зуучлалын үйлчилгээнд технологийн дэвшлийг бүрэн нэвтрүүлэх зорилгыг тавин ажиллаж байна.





Зүрхнээсээ дэмжье урамшуулалт аяныг амжилттай үргэлжлүүлээ

Банкныхаа 30 жилийн ойг угтан 15 харилцагчаа дотны хүний хамтаар буюу нийт 30 хүнийг хүн төрөлхтний эв найрамдлын бэлэг тэмдэг болсон Токио-2020 олимпын наадмыг үзүүлэх “Зүрхнээсээ дэмжье” урамшуулалт аяныг зарласан. Дэлхий нийтээр тархсан цар тахлаас шалтгаалан олимпын наадам 2021 оны зун зохион байгуулагдахаар болсон тул бид урамшуулалт аяны үргэлжлэх хугацааг сунгаж, урамшууллын эздийг үе шаттайгаар шалгаруулахаар болсон билээ. 2020 оны 10-р сарын 09-ний өдөр эхний тохирлын 3 хос буюу 6 урамшууллын эздийг тодрууллаа.

Ногоон зээлийн бүтээгдэхүүн шинээр нэвтрүүлээ

Байгаль орчин, нийгэмд ээлтэй “Ногоон зээл”-ийн бүтээгдэхүүнийг нэвтрүүлээ. Ингэснээр Монгол Улсын агаарын болон хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор байгаль орчинд ээлтэй, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг зээлээр санхүүжүүлэх эхлэл боллоо.

Онлайн хэрэглээний лизингийн шинэ хувилбар нэвтрүүлээ. Харилцагчдын хэрэгцээ шаардлага, цаг завьг хэмнэсэн Shoppy.mn, ITStore.mn, next.mn зэрэг онлайн худалдааны веб сайтуудаар дамжуулан Монгол улсад анх удаа 10 сая төгрөг хүртэл дүнтэй, 30 сар хүртэл хугацаатай хэрэглээний онлайн лизингийн үйлчилгээг нэвтрүүлээ. Ингэснээр иргэд зайнаас Худалдаа, хөгжлийн банкны харилцагч эсэхээс үл хамааран банктай хамтран ажиллаж буй байгууллагуудын веб сайтад худалдаалагдаж буй бараанаас сонгон урьдчилгаа төлбөр төлөлгүй хэрэгцээт бараагаа банкны зээлээр худалдан авч, гэртээ хүргүүлэн авах боломж бүрдлээ.

Харилцагчдадаа санхүүгийн хүндрэлтэй цаг үед дэмжлэг үзүүлээ

Дэлхий дахинд коронавирусын халдварт өвчин (COVID-19) тархаж байгаатай холбоотой үүсээд буй аюултай нөхцөл байдлаас шалтгаалан харилцагчаа санхүүгийн дарамтад орохоос урьдчилан сэргийлэх, онцгой үеийг даван туулахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор банк зээлийн хүү, зээлийн үндсэн төлбөрийг хойшлуулан гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулсан ба үйлчилгээний шимтгэл авахгүй байх шийдвэр гарган ажиллаа.

“Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан “Маамуу хүүхдийн хадгаламж” эзэмшигчдэдээ цахим бэлэг хүргүүлээ

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Маамуутай хүүхдийн баяр” болон “Junior customer” арга хэмжээг энэ жил нөхцөл байдалтай уялдуулан онлайнаар зохион байгуулж, харилцагчдадаа цахимаар бэлэг хүргүүлээ. Энэхүү үйл ажиллагааг “Шоппи” ХХК-тай хамтран зохион байгуулсан бөгөөд харилцагчид TDB Online үйлчилгээг ашиглан бэлгээ хүлээн авснаараа шинэлэг байлаа.

Даатгалын зуучлалын салбарыг тэргүүлэгч байр сууриа бататгалаа

Бид даатгал зуучлалын үйлчилгээндээ харилцагчийн эрх ашиг бүрэн хамгаалагдаж, гэрээний дагуу даатгалын нөхөн төлбөрөө авч байх зарчмыг нэн түрүүнд баримталж ажилладаг. Тайлант онд нийт 2.89 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг харилцагч, даатгуулагч нартаа олгууллаа. Түүнчлэн зуучлалын үйлчилгээний гол зорилго нь талуудын эрх ашгийг харилцан эрх тэгш байлгахад оршдог ба бид хамтран ажиллагч даатгалын компаниуддаа нийт 4.39 тэрбум төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлж, банкны даатгалын зуучлалын салбарыг тэргүүлсэн амжилттайгаар өнгөрөгч оноо үүдлээ.

Салбар, нэгжийн хүртээмж

Бид харилцагчдадаа олон улсын стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг тав тухтай, таатай орчинд хүргэх зорилгоор банкныхаа Энхтайван, Зайсан, Шангри-Ла салбаруудын байршлыг өөрчлөн, "Allen International" байгууллагын загвар дизайны дагуу олон улсын банкуудын дизайн, тохижилт бүхий засварын ажлыг хийж, салбарын гадаад, дотоод орчныг сайжруулан, өнгө төрхийг шинэчиллээ.

2021 онд Харилцагчдадаа илүү ойртох, салбар нэгжийн хүртээмжийг сайжруулах зорилгоор доорх салбаруудыг шинээр нээхээр засварын ажлыг 2020 оноос эхлүүлээ.

- Шинээр байгуулагдаж буй Олон улсын нисэх буудалд байрлах Шинэ нисэх салбар
- Макс моол худалдааны төвд байрлах Макс моол салбар
- Парк-Од худалдааны төвд байрлах Парк-Од салбар
- Мишээл тавилгын их дэлгүүрийн Misheel Walking Street-д байрлах Мишээл салбар

Банкныхаа 30 жилийн түүхэн ой тохиосон энэхүү жил бид бүтэц, зохион байгуулалтдаа томоохон тэлэлтийг хийж, 21 жилийн түүхтэй Улаанбаатар хотын банктai нэгдсэн. Тус нэгдлийн үр дүнд Худалдаа, хөгжлийн банк 33 салбар, нэгжээр хүрээгээ тэлж, нийт 98 салбар, тооцооны төв, тооцооны касстай болж харилцагчдадаа улам ойртлоо.

Дижитал шилжилт

Худалдаа, хөгжлийн банк нь Монгол Улсын банк, санхүүгийн салбарт цахимжуулалт (дижиталчлал), дижитал шилжилтийг тэргүүлэх байр суурьтайгаар гүйцэтгэж байгаа банкны хувьд энэ тайлант онд харилцагчдадаа илүү нийцтэй, хүртээмжтэй, харилцагч бүрийн хүсэл сонирхолд тохирсон байдлаар банкны үйлчилгээг илүү хялбараар, илүү аюулгүйгээр хүргэхэд чиглэсэн технологийн, платформын шинэчлэлийг хийж ажилласан нь банкний ирээдүйд илүү үр бүтээмжтэй ажиллах технологи, инновацын бааз суурийг бий болгосон явдал юм.

Худалдаа, хөгжлийн банк стратеги бодлогынхоо хүрээнд банкны системийн суурь бүтэц, программ хангамжийн хүчин чадлаа нэмэгдүүлж, дэвшилтэт технологиудыг шат дараатайгаар нэвтрүүлж байгаа буюу харилцан уялдаа бүхий программ хангамж, системүүдийг нэгтгэсэн цогц платформыг бий болгож, үйлчилгээгээ мэдээллийн аюулгүй байдал, нууцлал хамгааллын өндөр түвшинд, илүү шуурхай өндөр хүчин чадалтайгаар хүргэж, харилцагчдад банкны салбарын цагийн хуваарь болон орон зайнаас үл хамаарч хүссэн үедээ цахимаар олон шинэ үйлчилгээг авах боломжийг нэмэгдүүлсээр байна.

Банкны бүтээгдэхүүн үйлчилгээг, дижиталчлахын сацуу харилцагч байгууллагуудынхаа үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэл, процессыг хялбарчлахад ихээхэн анхаарч Корпорэйт Гэйтвэй сувгийн холболт хийх шийдлийг Монгол улсад үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж байгууллагуудын түгээмэл ашигладаг ERP систем хөгжүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллах замаар түүний ашиглалт, боломжийг нэмэгдүүлж, тэдгээрийн хэрэглэгч байгууллагуудад банкны үйлчилгээг байгууллагын орчинд цахимаар хүргэх боломжийг бий болгон ажиллаж байна. Тайлант хугацаанд цахим бүтээгдэхүүн үйлчилгээнд давхардсан тоогоор 745,701 харилцагч бүртгэлтэй байгаа нь банкны нийт идэвхтэй харилцагчийн 90-ээс дээш хувийг хамарч байна. 2020 оны байдлаар банкны хэмжээнд хийгдсэн нийт гүйлгээний 95% цахимжсан хэлбэрээр буюу банкны ажилтны оролцоогүй хийгдсэн байна. Энэ нь иргэд, байгууллагууд илүү цахим үйлчилгээг сонгож байгааг харуулж байна.



Банкны салбарт бэлэн гүйлгээ болон бэлэн бус гүйлгээ **5%**



Посоор хийгдсэн гүйлгээ хамгийн их буюу **59%**




АТМ дээрээс шилжүүлэг **5%**



Карт, интернэт банк болон бусад цахим үйлчилгээ **90%**



TDB Online банкны гүйлгээ **31%**



TDB Online – банкны үйлчилгээ

TDB Online буюу интернэт банкны хэрэглэгчдийн тоо өмнөх онтой харьцуулахад 33 хувь, банкны цахим сувгаар хийгдсэн гүйлгээний тоо 59 хувиар тус тус нэмэгдлээ.

Банк өөрийн гол цахим суваг болох TDB Online үйлчилгээгээр дамжуулан санхүүгийн гурван тулгуур болох Банк санхүү, Даатгал, Үнэт цаасны үйлчилгээг цахимаар үзүүлэх боломжийг шинэчилж илүү хялбар болгож, олон төрлийн банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний шийдлийг хөгжүүлж харилцагч нартаа хүргэсээр байна.

Тайлант онд TDB Online үйлчилгээг шинэчлэн дараах боломжуудыг нэмэгдүүллээ.

- Харилцагчдын хэрэглээг нэмэгдүүлэх,
- Харилцагчдад онлайнаар банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг хялбар байдлаар хүлээн авах боломжийг бий болгох,
- Үйл ажиллагааны зардлыг бууруулах,
- TDB Online банкны үйлчилгээний загвар, дизайн, ашиглалтыг хялбар, хурдан, ойлгомжтой болгох.

Мөн шинээр доорх үйлчилгээнүүдийг нэвтрүүллээ.

- TDBPay цахим түрийвч,
- Виртуал карт,
- Төлбөрийн карт захиалга,
- Картын пин код авах, блок гаргах,
- QR код уншуулан ATM-с бэлэн мөнгө авах,
- Хялбар хуримтлалын үйлчилгээг.

2020 онд нийт 110 үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын дотоод орчинд банкны үйлчилгээг холбон, тэдгээрийн хэрэглэгчдэд банкны болоод төлбөр тооцооны үйлчилгээг улам ойртуулан ажиллаа. Мөн харилцан хамтран ажилладаг бусад байгууллагуудын үйлчилгээг банкны аппликэйшнээр дамжуулан хүлээн авах, зөвхөн харилцагчийн банк санхүүгийн хэрэгцээг хангахаас илүүтэй бусад хэрэгцээг хангах үүднээс интернэт худалдааны “www.shoppymn”, үзвэр үйлчилгээний тасалбар борлуулалтын “www.zero.mn” сайтуудтай холбогдож уг байгууллагуудын бүтээгдэхүүн үйлчилгээг банкны TDB Online үйлчилгээг ашиглан авах боломжийг нэвтрүүлээд байна.

Мөн тус онд харилцагчийн хуваарьт төлбөр тооцоог гар утасны хуанлтай холбох хөгжүүлэлт хийгдлээ. Ингэснээр харилцагч өөрийн хуваарьт төлбөр тооцооны мэдээллээ цаг алдалгүй харах, хянах боломж, харилцагч бүх банкны бүх картаа TDBPay wallet-д бүртгүүлэн төлбөр тооцоог хурдан шуурхай гүйцэтгэх боломж, TDB Online үйлчилгээний аппликэйшнийг ашиглан дурын данснаасаа ATM-с карт ашиглалгүй мөнгө авах QR cash үйлчилгээг тус тус нэвтрүүлж ажиллаа.

Систем хоорондын интеграцлал хийх замаар үйл ажиллагааны процессыг хялбарчлах, автоматжуулах зорилго бүхий Корпорэйт Гэйтвэй (Corporate gateway) сувгийн холболт хийх үйлчилгээг ашиглагч болон хамтран хөгжүүлэлт хийж буй хөгжүүлэгч байгууллагынхаа тоог энэ онд 28-р нэмлээ. Энэхүү үйлчилгээ нь банкны бүхий л үйлчилгээг API хэлбэрээр дамжуулан системийн холболт хийх замаар харилцагч байгууллагын гараар хийгдэж буй механик үйл ажиллагааг автоматжуулж үйл ажиллагааны шат дарааллыг багасгах, хөнгөвчлөх цаг хугацаа, зардал хэмнэх зэргээр бизнесийн хурдасгуур болсон цахим банкны дараагийн шат болсон үйлчилгээ билээ.

Бэлэн мөнгөний орлого, зарлагын АТМ-р хийгдэж буй гүйлгээний бүрдэл хэсгүүдийг бүрэн хангах үүднээс орлого болон шилжүүлгийн гүйлгээнд гүйлгээний утга бичих боломжийг шинээр бий болгов. Мөн бүх АТМ-д орос хэлний сонголтыг нэмэгдүүлж гадаад харилцагчид АТМ-р үйлчлүүлэх таатай нөхцөлийг бий болголоо. Картгүй болон зайнаас картаа уншуулах (contactless) үйлчилгээг дэмжих ажлуудыг АТМ-д шат дараалалтайгаар амжилттай нэвтрүүлж, чанар шаардлагыг сайжруулан ажиллаж байна. Мессежээр АТМ-ын байршлын мэдээлэл авдаг үйлчилгээнд 24 цагаар ажилладаг АТМ, Орлогын АТМ-ын мэдээллийг тус тусд нь авах боломжтой болгож өргөжүүлэв.

Улаанбаатар хотын банк (УБХБ)-тай нэгдэх үйл ажиллагааг амжилттай хийж харилцагч үйлчлүүлэгчдэд ямар нэгэн хүндрэл үүсгэхгүйгээр АТМ-уудыг богино хугацаанд хүлээн авч банкны АТМ үйлчилгээний хүртээмж, цар хүрээг нэмэгдүүллээ.

Хөлхорионы үед банкны АТМ-н үйлчилгээний халдвар хамгааллын арга хэмжээг авч зай барих тэмдэглэгээгээр харилцагчдын хооронд зай бариулах, АТМ-ын дэлгэцээр анхааруулга хүргэх, гар ариутгагч суурилуулах, мэргэжлийн байгууллагаар тогтмол цэвэрлэгээ, ариутгал хийх ажлыг гүйцэтгэж харилцагчид болон иргэдийнхээ аюулгүй байдлыг хангаж ажиллаа.

Мөн Монголын банкуудын холбооноос санаачилж явуулсан “Ятгах тусам нягтал” аянд нэгдэжидэвхтэй ажилласан ба төлбөрийн картын мэдээллийн аюулгүй байдлын олон улсын стандарт болох “PCI DSS”-н шаардлагыг бүх АТМ-уудынхаа хувьд амжилттай хангав.



Карт, төлбөр тооцооны үйлчилгээ

2020 онд бид харилцагчдынхаа болоод зах зээлийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан, олон улсын чиг хандлагыг дагаж цаг зав хэмнэсэн, харилцагч банкны салбарт заавал биечлэн ирэхгүй байх боломжийг бүрдүүлэх, сүүлийн үеийн дэвшилтэт бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчдад хялбар байдлаар хүргэхэд онцгойлон анхаарч олон төрлийн шинэ, хялбар бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүллээ.

Тайлант онд төлбөрийн карт хэрэглэгчдийн тоо 2019 онтой харьцуулахад 11%-иар нэмэгдэж, Монгол Улсын Виза картаар гадаадад хийгдэж буй гүйлгээний 40-өөс дээш хувийг тус банкны Виза картаар гүйцэтгэсэн үзүүлэлтэй байгаа нь Монгол улс дахь хамгийн том, хамгийн найдвартай картын систем бүхий банк болохыг давхар илэрхийлж байна.

Картын бүтээгдэхүүн хөгжүүлэлт

“PCI DSS” буюу төлбөрийн картын мэдээллийн аюулгүй байдлын олон улсын стандартын дагуухарилцагчийн картын нууц кодыг зайнаас TDB Online болон 1900-1977 сувгаар бүртгэлтэй гар утсанд нь пин код илгээдэг боллоо.

Харилцагчдад банкны үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх, цаг хэмнэх үүднээс TDB Online үйлчилгээгээр дамжуулан картаа хүссэн газартаа захиалан хүргүүлэн авах, Картад үзүүлэх нэмэлт үйлчилгээ, картаа удирдах боломж болон өөрийн төлбөрийн картаараа Интернет худалдан авалт хийхэд зориулагдсан Virtual card-ийг захиалан авах боломжийг TDB Online үйлчилгээнд 100% нэвтрүүллээ.

Дэлхий нийтэд тулгараад байгаа цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан харилцагчаа халамжлах, банкны салбарт заавал биечлэн ирэхгүйгээр төлбөрийн картын захиалга өгөх боломжийг өргөжүүлж, шинээр данс нээлгэн картаа захиалах, хүргүүлэн авах боломжийг банкны 24/7 лавлах утас болох 1900-1977 сувгаар дамжуулан авах боломжийг бүрдүүллээ.

Харилцагчдад зориулсан урамшуулалт аян

ХХБ зорилтот харилцагчдынхаа хэрэглээний онцлогт тохируулан үйлчилгээ, урамшууллын нөхцөл болон шинэлэг загвар бүхий хамтарсан картын бодлогыг амжилттай хэрэгжүүлдэг цорын ганц банк бөгөөд 16 жилийн турш харилцагч байгууллагуудтайгаа хамтран харилцагчдад зориулсан урамшуулалт аянуудыг зохион байгуулж байна. Бид нийт харилцагчдадаа банкны бүтээгдэхүүн

үйлчилгээний зөв хэрэглээний талаарх мэдлэг ойлголтыг түгээх, тухайн бүтээгдэхүүнийг ашиглан хамгийн таатай нөхцөлөөр хөнгөлөлт, урамшуулал эдлэх боломжийг бүрдүүлэх, ингэснээр харилцагчдад ямар давуу талууд бий болж буйг таниулахад урамшуулалт аяны гол зорилго оршдог билээ. 2020 онд картын урамшуулал болон төрөл бүрийн аяныг зохион байгуулж, харилцагчдынхаа идэвх оролцоог нэмэгдүүллээ.

Үүний хүрээнд “Зүрхнээсээ дэмжье аян”, Визатай байгуулсан урамшууллын гэрээний хүрээнд Team Visa хөтөлбөрт Монгол улсаас анх удаа тамирчныг элсүүлж, өөрийн нүүр царай болгон хамтран ажиллах боломжтой болсон бөгөөд банкны 30 жилийн ойгоо угтан 15 харилцагчаа дотнын хүний хамтаар буюу нийтдээ 30 харилцагчаа хүн төрөлхтний эв найрамдлын бэлэг тэмдэг болсон Токио-2020 “ОЛИМПЫН НААДАМ”-ыг үзүүлэх аяныг амжилттай зохион байгууллаа.

Мөн “Visa-тай хамт” урамшууллын хөтөлбөрийн хүрээнд Олон улсын болон дотоодын онлайн худалдан авалтыг урамшуулах Онлайн худалдан авалт хийсэн харилцагчаас 70 харилцагчид урамшуулал олголоо. Урамшууллын хугацаанд нийт 17,000 гаруй харилцагч оролцсон бөгөөд азтай 70 харилцагч тодорхой дүнгээр худалдан авалтын эрх авсан бол супер 10 харилцагч худалдан авалтын өндөр эрх бүхий Олимпын VISA Алтан картаа гардан авлаа.ХХБ болон ЮнионПэй байгууллага нь карт эзэмшигчдийнхээ дунд жил бүр уламжлал болгон явуулдаг ЮнионПэй картаар олон улсад худалдан авалт хийх бүрдээ худалдан авалтын үнийн дүнгийнхээ 10%-ийг буцаан авах ээлжит урамшуулалт аяныг зохион байгуулан дууслаа.

Урамшуулалт үйлчилгээний байгууллага элсэх болон тэмдэглэлт өдрүүдийг угтан төлбөрийн карт эзэмшигчдэдээ зориулан урамшуулалт аяныг зохион байгууллаа. ХХБ-тай хамтран ажилладаг томоохон худалдаа, үйлчилгээний байгууллагуудаас худалдан авалт хийхдээ ХХБ-ны кредит карт болон хамтарсан төлбөрийн картаа ПОС төхөөрөмж дээр уншуулаад 5-10% хувийг буцаан авах боломжийг харилцагчдад олголоо.

Дэвшилтэд технологийг дэмжих хамтрагч байгууллагуудаа сурталчлах ажлын хүрээнд банкны төлбөрийн картаараа ухаалаг гар утас худалдан авсан тохиолдолд барааны үнийн тодорхой хувийн буцаан олголтыг харилцагчдаа олгон ажиллаа.

ПОС-ын үйлчилгээний шинэчлэлт

Харилцагчдад банкны үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, хүсэлт шаардлагыг цаг алдалгүй шийдвэрлэхийн тулд ПОС суурилуулах хүсэлт гаргагчийн хүсэлтийг онлайнаар зайнаас хүлээн авах, дундын ПОС буюу нэг ПОС дээр дөрөв хүртэлх мерчант холбон гүйлгээ хийх боломжийг бүрдүүллээ. Тайлант хугацаанд УБХБ-тай нэгдсэн нь пос терминалын тоо 2019 онтой харьцуулахад 32%-иар өссөн үзүүлэлттэй ажилласан байна.

Төлбөрийн картын мэдээллийн аюулгүй байдал

ХХБ төлбөрийн картын мэдээллийн аюулгүй байдлын "PCI DSS" олон улсын стандартыг 3 дахь жилдээ бүрэн хангаж, уг стандартын 3.2.1 шинэчлэгдсэн хувилбарын батламжаа хүлээн авлаа. Тус батламжийг Олон улсын "PCI Security Standards Council" буюу төлбөрийн картын аюулгүй байдлын стандартын зөвлөлөөс хүлээн зөвшөөрөгдсөн Аюулгүй байдлын эрсдэлийг үнэлдэг (Qualified Security Assessor - QSA) ControlCase байгууллагаас Монгол улсаас ХХБ-ийг энэхүү стандартыг бүрэн хангасан хэмээн 3 дахь жилдээ батламжиллаа. Энэхүү стандартыг анх 2006 оны 9 сард дэлхийд төлбөрийн картын үйлчилгээгээр тэргүүлэгч 5 байгууллага хамтран, карт эзэмшигч харилцагчдын мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах, сайжруулах үндсэн зорилготойгоор батлан гаргаж байсан ОУ-ын нэр хүнд бүхий стандарт юм.




ГАДААД ХАРИЛЦАА, ОЛОН УЛСЫН БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА



Тайлант онд цар тахлаас үүдэлтэй хөл хорио тогтоосон үед бид харилцагч байгууллагуудад банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг саадгүйгээр авах боломжоор хангаж, шаардлагатай заавар, зөвлөгөөгөөр хангаж ажиллаа.

2020 оны онцлох ажлууд, ололт амжилтуудаас дурдвал:

- Банкны шинэ бүтцийн хүрээнд гадаад эх үүсвэр татах чиглэлээр шаардлагатай судалгаануудыг хийж нийт 109 банк, санхүүгийн байгууллагуудтай холбогдож хамтын ажиллагааг эхлүүлээ.
- БНХАУ-ын Хөгжлийн банктэй хамтран БНХАУ-аас хийх импорт болон “Нэг бүс, нэг зам” санаачилгын хүрээнд хэрэгжих төслийг санхүүжүүлэх зорилгоор ам.доллар болон юанийн санхүүжилтийн гэрээ байгууллаа. Ингэснээр ХХБ-ны харилцагчдын БНХАУ-ын аж ахуйн нэгжүүдтэй хийх худалдааг өртөг багатайгаар санхүүжүүлэх боломжтой нээгдлээ.
- Анхны баримтын худалдааны санхүүжилтийг (буцаан үл дуудагдах төлбөрийн үүрэг бүхий) Эдийн засгийн хамтын ажиллагааны олон улсын банк (IBEC)-тай хамтран амжилттай хийж гүйцэтгэлээ. Энэхүү санхүүжилтийн хүрээнд барилга болон ачилтын зориулалттай тусгай тоног төхөөрөмжийг (зөөврийн кран) Монгол Улсад нийлүүлэх гадаад худалдааны гэрээ байгуулагдаж, тус гэрээний дагуу Европын тэргүүлэгч банканд төлбөр төлөх үүргийг IBEC хүлээсэн болно. Энэхүү төлбөрийн хэрэгсэл нь худалдагч, худалдан авагч талуудад төлбөр тооцооны таатай нөхцөлийг санал болгох онцлогтой юм.
- 7.2 сая еврогийн дүнтэй ОХУ-ын улаан буудайн экспортын санхүүжилтийг олон улсын түнш банкуудтай хамтран IBEC-ийн худалдаа, экспортын санхүүжилтийн хэрэгслийг ашиглан амжилттай хийж гүйцэтгэв. Тус аккредитивийн баталгаа болон санхүүжилтийг гүйцэтгэсэн банк нь олон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг ВТБ Группийн харьяа ВТБ Банк (Европ) юм.
- ОХУ болон Монгол Улсын хоорондын худалдааг дэмжих зорилгоор Олон улсын хөрөнгө оруулалтын банк (IIB)-тай хамтран Москвагийн Кредит банкнаас 2.5 сая ам.долларын эх үүсвэрийг амжилттай татав.
- Москвагийн Кредит банктэй ОХУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй санхүүжилтийн мастер гэрээг амжилттай байгууллаа. Гэрээний дагуу ХХБ-ны харилцагчид ОХУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй санхүүжилтийг авах нөхцөл бүрдэж байна.
- Тайвань, Монгол Улс хоорондын худалдааг дэмжих зорилгоор тус улсын Экспорт-Импортын банктэй худалдааны санхүүжилтийн шугамыг шинэчлэн баталж, харилцагчдынхаа хүсэлтийн дагуу санхүүжилт



- Польш Улсын хөгжлийн банк болох Bank Gospodarstwa Krajowego (BGK)-тай хамтын ажиллагааг эхлүүлж тус улсаас худалдан авалт хийх ХХБ-ны харилцагчид илүү хямд, урт хугацаатай эх үүсвэр олгох боломжийг нээв.
- Урт хугацааны итгэлт бизнес түнш болох ХБНГУ-ын Коммерцбанкттай хамтран ажиллаж, 50 сая ам.долларын эх үүсвэрийг амжилттай татлаа.
- Гадаад гуйвуулгын төлбөр тооцоог саадгүй явуулахын үүднээс Erste Bank болон Natixis банканд Multi-currency account /олон валютын зориулалтаар ашиглах боломжтой данс/-г амжилттай нээв. Мөн Bayern LB банканд EUR, Kookmin банканд GBP дансыг амжилттай нээлээ.
- БНХАУ-ын China Construction Bank (CCB)-тай төлбөр тооцооны систем болох Cross-border Interbank Payment System (CIPS) рүү бүрэн шилжих нэмэлт гэрээг амжилттай хийж, харилцагч нарынхаа улс дамнасан юанийн гүйлгээг амжилттай гүйцэтгэх боломжийг бүрдүүлэв.
- 2020 оны 4 дүгээр сард Уур амьсгалын ногоон сангийн үндэсний итгэмжлэгдсэн байгууллага болж уур амьсгалын чиглэлээр төсөл, хөтөлбөрүүдэд нэг удаадаа 250 сая ам.доллар хүртэлх санхүүжилт татах боломжтой болов. Үүний хүрээнд 2020 оны 10 дугаар сард УАНС-ийн Итгэмжлэлийн Мастер гэрээг байгуулав.
- Монгол дахь Тогтвортой, ногоон санхүүжилтийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилт бүхий УАНС-ийн техникийн тусламжийн төслийг дамжуулан хэрэгжүүлэгч байгууллагаар сонгогдон ToC Холбоотой хамтран ажиллах болов.
- Тогтвортой санхүүжилтийг хөгжүүлэх зорилтын хүрээнд олон улс болон дотоодын нийт 56 байгууллагатай уулзалт, хурлыг зохион байгуулж, хамтын ажиллагааг эхлүүллээ.



**Худалдаа, хөгжлийн банкны
Токио дахь төлөөлөгчийн газар**

Токио дахь төлөөлөгчийн газрын 2020 оны ажлын үр дүн:

Худалдаа, хөгжлийн банкны Токио дахь төлөөлөгчийн газар цар тахлаас үл хамааран үйл ажиллагаагаа идэвхтэй үргэлжлүүлж, Монгол улсад хөрөнгө оруулалт хийх, бизнес эрхлэх сонирхолтой иргэд байгууллагуудыг мэдээллээр хангаж ажиллав. 2020 онд Токио дахь төлөөлөгчийн газраар дамжуулан мэдээлэл холбоо, компьютер програм хангамж, бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниуд болон хувь хүмүүс Худалдаа, хөгжлийн банкны харилцагч болж, санхүүгийн үйлчилгээ авч байна.

Худалдаа, хөгжлийн банкны Токио дахь төлөөлөгчийн газар Японы мега банкууд, орон нутгийн банкууд, жижиг дунд хэмжээтэй санхүүгийн байгууллагууд, үнэт цаасны компаниуд, даатгалын компаниуд болон бусад институциональ хөрөнгө оруулагчидтай харилцаагаа хөгжүүлж цаашид Японы санхүүгийн зах зээлээс эх үүсвэр татах суурийг тавив. Түүний дотор мэдээллийг технологид суурилсан, эх үүсвэр татах шинэ арга зам болох крауд фандинг багтаж байна.

Япон улсын Нийгата, Шизуока мужийн төрийн байгууллагуудтай хамтран Япон улсын бизнес эрхлэгчдийг Монголын компаниудтай холбох зорилготой худалдааны санхүүжилтийн семинарыг зохион байгуулав. Арга хэмжээнд оролцсон Япон компаниуд Монголын компаниудтай худалдаа, хөрөнгө оруулалтын харилцаа үүсгэн, хамтран ажиллаж эхэлсэн.

E-Account үйлчилгээг сайжруулж харилцагчиддаа интернэт банкаараа дамжуулан олон улсын дебит карт захиалах боломжийг бүрдүүлээ.

Худалдаа, хөгжлийн банк нь Япон улс дахь WECHAT PAY үйлчилгээний албан ёсны эзэмшигч байгууллага болох NETSTARS компанитай хамтран тус үйлчилгээний Монгол улс дахь албан ёсны төлөөлөгч болсноор WECHAT PAY хэрэглэгчдийн төлбөр тооцоог өөрийн банкны пос терминал машинаар дамжуулан хийх боломжтой болсон.

НОСТРО ДАНС

№	Валют	Улс	Банкны нэр	Байршил	SWIFT код
1	USD:	KR	KEB HANA BANK	SEOUL, KOREA	KOEXKRSE
2			KOOKMIN BANK	SEOUL, KOREA	CZNBKRSE
3		CN	INDUSTRIAL AND COMMERCIAL BANK OF CHINA	ERLIANHAOTE, CHINA	ICBKCNBJNMA
5			BANK OF CHINA (HONG KONG) LIMITED	HONG KONG, CHINA	BKCHHKHH
6			BANK OF INNER MONGOLIA	HOHHOT, CHINA	HSSYCNBH001
7		RU	ZAO UNICREDIT BANK	MOSCOW, RUSSIA	IMBKRUUM
8			OJSC SBERBANK (HEAD OFFICE)	MOSCOW, RUSSIA	SABRRUUM
9			JSC RUSSIAN AGRICULTURAL BANK	MOSCOW, RUSSIA	RUAGRUMM
10			JSC VTB Bank	MOSCOW, RUSSIA	VTBRRUMM
11			PSJC TRANSKAPITALBANK, RUSSIA	MOSCOW, RUSSIA	TJSCRUMM
12		SG	OCBC BANK	SINGAPORE	OCBCSGSG
13		DE	COMMERZBANK AG	FRANKFURT, GERMANY	COBADEFF
14		TH	KASIKORNBANK PUBLIC COMPANY LIMITED	BANGKOK, THAILAND	KASITHBK
15	EUR:	DE	BAYERISCHE LANDESBANK	MUENCHEN, GERMANY	BYLADEMM
16		DE	COMMERZBANK AG	FRANKFURT, GERMANY	COBADEFF
17	JPY:	JA	MUFG Bank, LTD	TOKYO, JAPAN	BOTKJPJT
18			MIZUHO BANK, LTD.	TOKYO, JAPAN	MHCBJPJT
19			SUMITOMO MITSUI BANKING CORPORATION	TOKYO, JAPAN	SMBCJPJT
20	GBP:	DE	COMMERZBANK AG	FRANKFURT, GERMANY	COBADEFF
21		KR	KOOKMIN BANK	SEOUL, KOREA	CZNBKRSE
22	CHF:	DE	COMMERZBANK AG	FRANKFURT, GERMANY	COBADEFF
23	AUD:	AU	AUSTRALIA NEW ZEALAND BANKING CORPORATION LIMITED	MELBOURNE, AUSTRALIA	ANZBAU3M
24	KRW:	KR	KEB HANA BANK	SEOUL, KOREA	KOEXKRSE
25			KOOKMIN BANK	SEOUL, KOREA	CZNBKRSE
26	CNY:	CN	AGRICULTURAL BANK OF CHINA	ERLIANHAOTE, CHINA	ABOCCNB050
26			CHINA CONSTRUCTION BANK CORPORATION	ERLIANHAOTE, CHINA	PCBCCNB050
28			INDUSTRIAL AND COMMERCIAL BANK OF CHINA	ERLIAN, CHINA	ICBKCNBJNMA
30			SHANGHAI PUDONG DEVELOPMENT BANK	SHANGHAI, CHINA	SPDBCNSH
31			BANK OF CHINA (HONG KONG) LIMITED	HONG KONG, CHINA	BKCHHKHH
32			BANK OF CHINA INNER MONGOLIA BRANCH	HOHHOT, CHINA	BKCHCNBJ880
33			BANK OF INNER MONGOLIA	HOHHOT, CHINA	HSSYCNBH001
34	CAD	CA	NATIONAL BANK OF CANADA	MONTREAL, CANADA	BNDCCAMMINT
35	RUB:	RU	ZAO UNICREDIT BANK	MOSCOW, RUSSIA	IMBKRUUM
36			SBERBANK (BAIKALSKY HEAD OFFICE)	IRKUTSK, RUSSIA	SABRRU66
37	NZD:	NZ	ANZ BANK New Zealand Limited	WELLINGTON, NEW ZEALAND	ANZBNZ22
38	HKD:	JA	MUFG Bank, LTD	HONG KONG	BOTKHKHH
39	SGD:	SG	OCBC BANK	SINGAPORE	OCBCSGSG
40	SEK:	SE	NORDEA Bank AB	STOCKHOLM, SWEDEN	NDEASESS
41	TRY:	TR	TURKIYE IS BANKASI A.S.	ISTANBUL, TURKEY	ISBKTRIS
42	THB	TH	KASIKORNBANK PUBLIC COMPANY LIMITED	BANGKOK, THAILAND	KASITHBK

ХАРИЛЦАГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭ



Худалдаа, хөгжлийн банк нь харилцагч төвтэй банк болох стратегийн зорилгын хүрээнд үйлчилгээний чанараа тогтмол сайжруулахад анхаарч, "Voice of Customers" буюу харилцагчдынхаа дуу хоолойг сонсож, түүнд үндэслэн бүтээгдэхүүн үйлчилгээ, бизнес процессоо сайжруулах арга хэлбэрт шилжин ажиллаж байна. Мөн харилцагч бүрийнхээ эрх ашгийг хамгаалж, аливаа санхүүгийн эрсдэлтэй гүйлгээнээс сэргийлэх, аливаа санал хүсэлтийг шийдвэрлэх, санхүүгийн боловсрол олгох зөвлөмж мэдээллээр хангах зэрэг бүх талын арга хэмжээг авч хэрэгжүүлдгийн нэг нь Монголбанк, Цагдаагийн ерөнхий газар болон Монголын банкны холбооноос нийт арилжааны банкууд дунд зохион байгуулсан "Ятгах тусам нягтал" аянд манлайлан оролцож, 3-р байрт шалгарлаа.

Тайланд хугацаанд 24/7 цагийн турш харилцагчдаа үйлчилгээ үзүүлж ажилладаг Контакт төв нь дуудлагын төвийн үйлчилгээний стандартаа шинэчлэн тодорхойлж, харилцагчдынхаа аливаа санхүүгийн асуудлыг эхний хандалтаар шийдвэрлэх зарчмыг баримтлан ажиллаж байна. Тухайлбал, дуудлагын төвийн харилцагчдад үйлчлэх багтаамжийг нэмэгдүүлэн, нэгэн зэрэг 20 харилцагчийн дуудлагыг хүлээн авах боломжийг 30 болгон өргөжүүлж, нэг дуудлагад ногдох дундаж хугацааг 1.49 минут болгон бууруулж чадлаа.

Түүнчлэн дуудлагын явцад харилцагчийг дүрсээр баталгаажуулах дэвшилтэт шийдэл болох "Amazon Web services Face recognition" технологийг ашиглаж эхэлсэн нь зайнаас харилцагчаа таньж, үзүүлэх үйлчилгээний тоог нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтын дараах үйлчилгээг үзүүлэх хүртээмжийг нэмэгдүүлэх суурь болов.

Ковид-19 цар тахлын нөлөөгөөр контакт төвд ирэх харилцагчдын хандалт 52.8% -иар өсч, 2020 онд нийт 720,000 хандалтыг хүлээн авсан билээ. Өсөн нэмэгдэж буй харилцагчдынхаа хэрэгцээ шаардлагад нийцүүлж, шуурхай үйлчилгээг үзүүлэхийн тулд контакт төвийнхөө хүчин чадлыг нэмэгдүүлснээс гадна хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт программ хангамжийг контакт төвийн үйл ажиллагаандаа нэвтрүүлэх төслийн ажлыг амжилттайгаар эхлүүлээд байна.

Тайлант хугацаанд нийт 11 мянган харилцагчийг 2.3 тэрбум төгрөгтэй тэнцэхүйц хэмжээний санхүүгийн эрсдэлээс хамгаалж, 5.5 мянган харилцагчийнхаа санал хүсэлтийг хүлээн авч шуурхай шийдвэрлэн ажиллаа.

ХӨРӨНГӨ ЗОХИЦУУЛАЛТЫН УДИРДЛАГА



Валютын зах зээл

Дотоодын валютын зах зээлд тэргүүлэгч банкны хувьд тус банк нь Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй бүхий л томоохон байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, бизнес эрхлэгчдийн гадаад валютын хэрэгцээг хангах хариуцлагатай үүргийг гүйцэтгэдэг. Тайлант онд банкны валютын арилжааны эргэлт тайлант хувиар өссөнөөс гадна системийн нөлөө бүхий Улаанбаатар хотын банктай нэгдсэн нэгдлийн үр дүнд банкаар дамжуулан валютын гүйлгээ хийх харилцагч, үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдлээ.

2020 онд ковид-19 цар тахлаас үүдэлтэй хөл хорионоос үүдэн улсын гадаад худалдааны барааны эргэлт бууралттай байсан ба оны сүүлийн саруудад цар тахал дотоодод дэгдэж, хатуу хөл хорио тогтоосонтой холбогдуулан харилцагчдийн валютын эрэлт хэрэгцээ багассан, харилцагч банкны салбараар биечлэн ирж үйлчлүүлэх боломж хязгаарлагдсан хэдий ч банк нь технологийн дэвшил, интернэт банкны үйлчилгээгээрээ валютын арилжааг зайнаас буюу цахимаар хүргэн, харилцагчийн эрэлт хэрэгцээг тасралтгүй хангаж ажиллаа.

Мөнгөний зах зээл

2020 онд банк Монголбанкаас тогтоосон заавал байлгах нөөц, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын шаардлагыг тасралтгүй хангахын зэрэгцээ дотоодын мөнгөний зах зээл дэх тэргүүлэх байр сууриа хадгалж ажиллаа. ХХБ нь өөрийн сул чөлөөтэй нөөц хөрөнгөөр дотоод, гадаадын үнэт цаасны арилжаанд оролцохын зэрэгцээ дотоодын бусад банк, санхүүгийн байгууллагуудад үнэт цаас зуучлах үйл ажиллагааг идэвхтэй эрхэлж зөвхөн иргэд, аж ахуйн нэгжүүд төдийгүй бусад банк, санхүүгийн байгууллагуудын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэсэн. Мөн гадаад валютын нөөцийн удирдлагын хүрээнд олон улсын хөрөнгийн зах зээл дээр гарсан Засгийн газрын бондын арилжааг идэвхтэй эрхэллээ.

Алт, үнэт металлын зах зээл

Цар тахлаас үүдэн зах зээлд үүссэн тодорхойгүй байдал, хөрөнгө оруулагчдын эрсдэлээс зайлсхийх хандлагын үр дүнд дэлхийн зах зээлд алтны ханш харьцангуй тогтмол, өсөлтийг үзүүлж байсан ба алт олборлогч аж ахуйн нэгж, байгууллагууд нь олборлолтоо нэмэгдүүлэх сонирхол улам бүр нэмэгдсэн. Тайлант онд Монголбанкны худалдан авсан үнэт металлын хэмжээ оны нийт дүнгээр 23.6 тоннд хүрч, өмнөх оноос 8.3 тонноор нэмэгдэн түүхэн дэх хамгийн өндөр түвшинд хүрсэнтэй зэрэгцэн банкны биет алтны арилжааны зах зээлд эзлэх хувь мөн нэмэгдсэн.

Мөн Монголбанкнаас Алт-2 хөтөлбөрийг эрчимжүүлэх зорилгоор алт олборлогч аж ахуйн нэгж, байгууллагуудад урьдчилгаа төлбөрийн буюу эргэлтийн хөрөнгийн болон урт хугацаат буюу хөрөнгө оруулалтын санхүүжилтийг арилжааны банкуудаар дамжуулан санхүүжүүлэх хөтөлбөрт банк нь идэвхтэй оролцож, алт олборлогч харилцагч аж ахуйн нэгж, байгууллагууддаа хамгийн их дүнтэй санхүүжилтийг олгосон ба урьдчилгаа төлбөрийн санхүүжилтийн хүлээсэн үүргээ цаг хугацаанд нь амжилттай гүйцэтгэлээ.



Актив пассивын удирдлага

Тайлант онд банк нь активын чанарыг нэмэгдүүлж, балансын зохистой бүтцийг хангахын зэрэгцээ тогтвортой өсөлт хийх зорилготой ажилласны үр дүнд Улаанбаатар хотын банктai хийсэн нэгдлийн дараа банкны нийт актив 9.6 хувь, цэвэр зээл 15.4 хувь, харилцагчаас татан төвлөрүүлсэн хөрөнгө 39.5 хувиар тус тус өслөө.

Банк нь олон улсын зах зээлд гаргасан Монгол Улсын Засгийн газрын баталгаатай 500.0 сая ам.долларын бондын төлбөрийг хуримтлагдсан купоны хамт 2020 оны 5 дугаар с ард цаг хугацаанд нь амжилттай төлсөн ба бондын эргэн төлөлтийн дараа ч банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа зохицуулагч байгууллагын шаардлагыг давуулан хангаж байна.

Банк нь олон улсад ашиглагддаг банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ, активын чанар, банкны хөрвөх чадвар, хүүний мэдрэмжийн өнөөгийн нөхцөл байдал болон ирээдүйн төсөөллийг нэгтгэн харуулдаг шинжилгээний загварыг дотоод үйл ажиллагаандаа ашиглан банкны актив, пассивын иж бүрэн удирдлага, хяналтыг хэрэгжүүлсэнээс гадна, балансын оновчтой хуваарилалтын зарчмыг ашиглан банкны эрсдэл даах чадварыг сайжруулах, ашигт ажиллагааг нэмэгдүүлэхээр ажиллаа.

Кастодиан үйлчилгээ

Банкны кастодиан харилцагчдын дотоодын болон олон улсын зах зээл дээр хадгалуулж буй үнэт цаас, хөрөнгийн төрөл, хэмжээ нэмэгдсэн ба банк нь биржийн бус зах зээлд арилжаалагдсан үнэт цаасны бүртгэл, хадгалалт болон төлбөр тооцоог нэгдсэн байдлаар харилцагчдад хүргэх үйлчилгээг эхлүүлэн, дотоодын үнэт цаасны зах зээлийн хөгжилд өөрийн хувь нэмрээ орууллаа.

Санхүүгийн зохицуулах хорооноос “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам” батлагдсантай холбогдуулан зах зээлд оролцогч байгууллагуудтай хамтарч олон улсын стандартад нийцсэн биржийн бус зах зээлийн үнэт цаасны арилжааны төлбөр тооцоо, хадгалалтын үйлчилгээг харилцагчдад үзүүлэхээр зорин ажиллаж эхэлсэн.

Банк нь үнэт цаасны төлбөрийн клирингийн үйлчилгээний хүрээнд үнэт цаасны дараа төлбөр тооцооны T+2 горим, төлбөрийн эсрэг нийлүүлэлтийн зарчмыг амжилттай нэвтрүүлэн, холбогдох дэд бүтцийн байгууллагуудтай хамтран ажиллаа.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА



Худалдаа, хөгжлийн банк нь Байгууллагын Эрсдэлийн удирдлага (Enterprise Risk Management, цаашид ERM)-ын зохистой засаглалыг мөрдлөг болгон ажилладаг. ERM нь эрсдэлийн орчныг тасралтгүй хянах, сайжруулах боломжийг бий болгож, эрсдэлийн талаарх ойлголт, мэдлэг, найдвартай ажиллагаа, стратеги шийдвэр гаргах зэрэг үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг. Банкны хувь нийлүүлэгчдийн хурлаас банкны стратегийн шийдвэрүүдийг гаргах бөгөөд уг стратегид тулгуурлан банкны эрсдэлийн засаглалыг хэрэгжүүлэх үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэх үүрэг бүхий хамгийн дээд нэгж нь ТУЗ юм.

Банкны ТУЗ нь эрсдэлийн зохистой засаглал, эрсдэлийн аппетит (банкны хүлээн зөвшөөрөх эрсдэлийн дээд хэмжээ) зэрэг эрсдэлийн бодлогын баримт бичгийг баталдаг бөгөөд Эрсдэл хариуцсан гүйцэтгэх захирлын орлогч нь банкны өдөр тутмын эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавьж, ТУЗ болон түүний дэргэдэх "Эрсдэлийн удирдлагын хороо"-нд тайлагнадаг. Эрсдэл хариуцсан гүйцэтгэх захирлын орлогч нь эрсдэлийн хамгаалалтын 2-р шат болох эрсдэлийн удирдлагыг хариуцдаг ба үйл ажиллагааны хүрээнд дараах газар, нэгжүүд үйл хамаардаг.

- Эрсдэлийн удирдлагын бодлого, зохицуулалтын газар;
- Зээлийн эрсдэлийн газар;
- Тусгай актив, бүтцийн өөрчлөлтийн хэлтэс;
- Зах зээл, хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын хэлтэс;
- Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын газар;
- Цахим эрсдэлийн удирдлагын хэлтэс;
- Комплайнсын хэлтэс.



Эрсдэл хариуцсан гүйцэтгэх захирлын орлогч нь банкны хороод болох Зээлийн хороо, Зээлийн дэд хороо, Актив пассивын хороодод “вето” эрхтэй гишүүнээр, Тендерийн хороо, Чанаргүй активын хороодод даргаар ажилладаг.

Эрсдэлийн хамгаалалтын 2-р шат болох эдгээр газар нэгжүүд нь банкны эрсдэлийн удирдлагын арга хэмжээнүүд болох өдөр тутмын эрсдэлтэй үйл ажиллагаанд хяналт тавих (risk monitoring), эрсдэлийг олж ирлүүлэх (risk identification), эрсдэлийг үнэлж хэмжих (risk assessment), лимитүүдийн биелэлтийг мэдээллэх (risk reporting), тухай бүрт эрсдэлийг бууруулах арга хэмжээг авах (risk mitigation), эрсдэлийн удирдлагыг сайжруулах (risk management improvement) арга хэмжээг тасралтгүй хийсээр байна.

Эрсдэлийн хамгаалалтын 1-р шат болох бизнесийн нэгжүүд нь өөрт олгогдсон эрхийн хүрээнд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэг бол 3-р шат нь Дотоод аудитын нэгжийн үүрэг байдаг.

Эрсдэлийн удирдлагын тогтолцоог тогтмол сайжруулах зорилтын хүрээнд олон улсын болон дотоодын зохицуулагч байгууллагын гаргасан эрсдэлийн удирдлагын стандарт, зөвлөмжид банкны үйл ажиллагааг нийцүүлэн ажилладаг. Үүнтэй холбоотойгоор тайлант онд дараах ажлуудыг хийлээ.

- Базел II-ын бүлэг II (Pillar 2) дахь гол бүрэлдэхүүн хэсэг болох банкны эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаандаа мөрдлөг болгох эрсдэлийн аппетит (банкны хүлээн зөвшөөрөх эрсдэлийн дээд хэмжээ) болон хязгаарлалтуудыг илүү өргөн хүрээнд олон улсын ахисан түвшний арга, аргачлалд тулгуурлан гол эрсдэлүүд тус бүрээр шинэчлэн тодорхойлж, үйл ажиллагаанд нэвтрүүлэх ажлыг хийлээ.
- Банкны шинэчлэгдсэн бүтцийн хүрээнд “Эрсдэлийн удирдлагын газар”-ыг “Эрсдэлийн удирдлагын бодлого, зохицуулалтын газар” буюу эрсдэлийн бодлого, дүрэм журам, арга аргачлалыг бодлогын хувьд хариуцан ажиллах бусад өдөр тутмын эрсдэлийн үйл ажиллагаанаас тусдаа чиг үүрэг бүхий газар болгон өөрчилсөн.
- Мөн дээрх бүтцийн өөрчлөлтийн хүрээнд Цахим эрсдэлийн удирдлагын хэлтсийг шинээр байгуулаад байна. Тус хэлтэс нь мэдээллийн технологийн эрсдэл, цахим бүтээгдэхүүн үйлчилгээний эрсдэлийн удирдлагын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага

Банк үйл ажиллагааны эрсдэлд гадаад хүчин зүйл болон программ, системийн доголдол, дотоод үйл ажиллагаанаас үүсэх аливаа эрсдэлийг хамааруулан, түүнийг үр дүнтэй удирдах арга хэрэгслийг тасралтгүй сайжруулан ажиллаж байна.

Банкны үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын бүрэлдэхүүн хэсэг болох Эрсдэл ба Хяналтын өөрийн үнэлгээний аргачлалыг үйл ажиллагаанд нэвтрүүлсэнтэй холбоотойгоор газар нэгжүүдийн уялдаа холбоог хангах, тайлан мэдээг нэг дороос авах цогц программ хангамжийг дотооддоо хөгжүүлэн, үйл ажиллагаанд нэвтрүүлээ. Ингэснээр эрсдэлт нөхцөл байдлыг урьдчилан илрүүлж, түүнийг шаардлагатай нэгжид мэдээлэх замаар эрсдэлээс сэргийлэх боломж бүрдсэн төдийгүй энэ зарчмаар банкны нийт нэгжүүд үр дүнтэйгээр хамтран ажиллаж байна.

Мөн бид төслийн үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын арга аргачлалыг олон улсын стандартын дагуу боловсруулан, банкны томоохон бизнесийн төслүүдийг амжилттай хэрэгжүүлэх, учирч болох эрсдэлийг урьдчилан тодорхойлох, түүнийг удирдах ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Өнгөрч буй онд олон улсын PWC аудитын компанитай хамтран банкны эрсдэлийн аппетитын тунхаг бичгийг боловсруулж, үйл ажиллагааны эрсдэлийн аппетит тооцох арга аргачлалыг тоон болон чанарын үзүүлэлтээр тодорхойлоо.

ХХБ дижитал банк болох зорилгын хүрээнд олон томоохон ажлууд хийж байгаагийн нэг нь Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын газрын харьяанд Цахим эрсдэлийн удирдлагын хэлтсийг байгуулсан явдал юм. Цахим эрсдэлийн удирдлагын хэлтэс нь банкны мэдээллийн технологи, мэдээллийн аюулгүй байдал, цахим бүтээгдэхүүн үйлчилгээ, төлбөр тооцооны эрсдэлийг удирдлагын арга аргачлалыг боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтэнд хяналт тавих чиг үүрэгтэйгээр ажиллаж байна.

Мөн цахим төлбөр тооцооны системийн аюулгүй байдлыг хангах зорилгоор мэдээллийн технологи, мэдээллийн аюулгүй байдалд учирч болох эрсдэлийг үнэлэх, мөн тэдгээрийн эмзэг сул байдлыг илрүүлэх туршилт шалгалтуудыг тогтмол хугацаанд хийж хэрэгжүүлэн олон улсын Payment Card Industry Data Security Standard шаардлагыг хэрэгжүүлэхээр ажиллаа. Түүний үр дүнд 2020 онд баталгаажуулах сертификатын шаардлагыг хангасан бөгөөд үүгээр дотооддоо бид 4 дэх жилдээ уг стандартыг бүрэн хангасан банк боллоо.

Зээлийн эрсдэлийн удирдлага

Тайлант онд Банк нь Монголбанкнаас батлан мөрдүүлж буй “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журам”-д нийцүүлэн холбогдох зээлийн ангилал, эрсдэлийн санг байгуулж, Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажиллалаа.

Зээлийн эрсдэлийн зорилтод түвшинд (аппетит) нийцүүлэн эрсдэлийг удирдахын сацуу нэн тэргүүнд зээлийн багцын чанарыг сайжруулах, улмаар Банкны богино болон урт хугацааны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлогуудыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Зээлийн эрсдэлийн газар нь зээлийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог хөгжүүлэх зорилтын хүрээнд олон улсын болон дотоодын зохицуулагч байгууллагын гаргасан эрсдэлийн удирдлагын стандарт, зөвлөмжийг банкны үйл ажиллагаанд нийцүүлэн хэрэгжүүлдэг. Үүний хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт СТОУС 9 (IFRS9)-ыг нэвтрүүлэхтэй холбоотой зээлийн эрсдэлийн үнэлгээ, зээлийн үнэ цэнийн бууралтыг тооцох аргачлал, заавар журмыг боловсрууллаа.
- Банкны түүхэн өгөгдөлд үндэслэсэн харилцагчийн зээлжих зэрэглэлийг (Credit rating/Credit scoring) тогтоох загварыг Machine learning algorithms буюу статистик загварчлалд үндэслэн ахисан түвшинд хөгжүүлж үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд бэлэн боллоо. Ингэснээр зээл судлах, шийдвэрлэх үйл явцыг илүү түргэн шуурхай, оновчтой болгож тухайн харилцагчийн зан төлөвт тохирсон зээлийн нөхцөлийг санал болгох боломж бүрдэж байна.

Барьцаа хөрөнгийн бодлого, журам болон үнэлгээний арга аргачлалыг боловсронгуй болгох, барьцаа хөрөнгийн үнэлгээнд олон улсын стандартыг нэвтрүүлэх чиглэлээр онцгой анхаарч ажиллалаа. Тус ажлын хүрээнд M.A.D Urban байгууллагын Хөрөнгийн үнэлгээний чиглэлээр Royal Institute of Chartered Surveyors (RICS) байгууллагад бүртгэл бүхий мэргэшсэн хөрөнгийн үнэлгээчдийн багаас хөрөнгийн үнэлгээг олон улсын үнэлгээний стандарт (IVS)-д нийцүүлэн шинэчлэх талаар зөвлөх үйлчилгээг авсан. Үүний үр дүнд банкны барьцаа хөрөнгийн үнэлгээний арга, аргачлал, хөрөнгийн үнэлгээний тайлан, банкны барьцаа хөрөнгийн бодлого, барьцаа хөрөнгө үнэлэх журмыг ҮОУС-ын дагуу шинэчлэн батлуулж, хөрөнгийн үнэлгээний өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж байна.

Зах зээлийн эрсдэлийн удирдлага

Зах зээл, хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын хэлтэс нь банкны гол, гол эрсдэлүүдийг үнэлэх арга аргачлал, загварыг судлан сайжруулах, хөгжүүлэх, нэвтрүүлэх улмаар банкны хүлээж болзошгүй эрсдэлд дүгнэлт гарган тайлан мэдээ бэлтгэх, мөн зах зээлийн судалгааг дотоодын болон олон улсын хэмжээнд өргөн хүрээтэй хийж банкны бизнесийн орчин бусад үйл ажиллагаанд нөлөөлөх нөлөөллийг тогтоож, банкны удирдлагуудад мэдээллийг тухай бүрд хүргүүлж ажилладаг. Үүнд:

- Эдийн засгийн голлох салбаруудаар судалгаа, төсөөллийг хийж, эрсдэлийг судлан шийдвэр гаргах нэгжүүдэд тогтмол хүргүүлдэг.
- Банкны хөрвөх чадварын эрсдэлийг мөнгөн урсгалын behavioural GAP тайлан, Базелийн LCR, NSFR харьцаанууд, төвлөрлийн үзүүлэлтүүдээр 7 хоног бүр хэмжин, тайлагнаж, тухай бүр дүгнэлт зөвлөмжийг өгдөг.
- Банкны зах зээлийн эрсдэлийг Value at Risk аргачлалаар өдөр бүр хэмжиж, удирдлагыг хэрэгжүүлдэг.
- Хүүгийн эрсдэлийг (IRRBB) сар бүр банкны Duration gap тооцоололд үндэслэн хэмжиж, тайлагнадаг.
- Харилцагч тал, улс орны эрсдэлийг харилцагч тал бүрээр зээлжих зэрэглэлд үндэслэн, зээлжих зэрэглэлгүй бол дотооддоо хөгжүүлсэн загварт суурилан settlement, pre-settlement лимитийг тодорхойлдог.

Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлага

Монгол Улсын тэргүүлэх арилжааны банкны хувьд манай банк бусад банкууддаа үлгэр жишээ байж, туршлагаасаа хуваалцан, байгаль орчин, нийгэмдээ ээлтэй банк байхыг зорин ажилладаг билээ.

Банк нь Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн менежментийнхээ хүрээнд харилцагчдадаа олгох санхүүжилтээрээ дамжуулан, зээлийн эрсдэлийг үнэлэх, бууруулах үйл явцтай адил зарчмаар харилцагчдынхаа байгаль орчин, нийгэмд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлж, үнэлэх улмаар тэдгээр эрсдэлээс үүсэж болох санхүүгийн хор хөнөөлөөс харилцагчийг хамгаалах, нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажилладаг.

Бид Тогтвортой санхүүжилт (ТОС)-ийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ нийт банкны ажилтнууд тэр дундаа зээлийн ажилтнуудаа сургах, зээлийн эрсдэлийн шинжээч нарыг мэргэшүүлж үйл ажиллагааны бүхий л шатанд тогтвортой санхүүжилтийн зарчмуудыг хэрэгжүүлэхэд анхаарч ажилласан бөгөөд үүний үр дүнд 2020 онд давхардсан тоогоор нийтдээ 168 ажилтнуудаа байгаль орчин, нийгмийн эрсдэлийн менежментийн системийн сургалтад хамрууллаа.

ХХБ нь агаарын бохирдол бууруулах, сэргээгдэх эрчим хүч, эко машин, ус, эрчим хүчний хэмнэлтийг бий болгох, хог хаягдал бууруулах гэх зэрэг ангиллуудад багтах нийт 1093 ногоон зээлийг тайлант онд олгосон бөгөөд цаашид ногоон зээлийн бүтээгдэхүүний хөгжүүлэлт, ногоон зээлийн өсөлтийг дэмжихээр төлөвлөн ажиллаж байна.

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ



ХХБ-ны мэдээллийн технологийн үйл ажиллагаа нь Олон улсын стандарт шаардлагад нийцсэн мэдээллийн технологийн дэвшилтэд техник, арга хэрэгсэлд тулгуурлан банкны үйл ажиллагааны тасралтгүй, найдвартай байдлыг хангах, ажилтнуудын хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлж, харилцагчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэхэд онцгойлон анхаарч, мэдээллийн технологийн сүүлийн үеийн техник, программ хангамжийн технологиудыг өргөн ашиглаж байна.

Бид тайлант онд Олон улс, корреспондент банк, зохицуулагч байгууллагын шаардлагыг хангах, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж, дотоод үйл ажиллагааг сайжруулах, харилцагчид банкны үйлчилгээг улам ойртуулах, өөрт шаардлагатай мэдээллийг интернэтээр авах, төлбөр тооцоог хялбар гүйцэтгэх программ хангамж, технологийн боломжийг хангах мэдээллийн технологийн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ажилласан байна.

Эдгээрээс дурдвал:

Худалдаа, хөгжлийн банк болон Улаанбаатар хотын банкны нэгдлийн хүрээнд 2 банкны систем, программ хангамж болон мэдээллийн технологийн дэд бүтцийн түвшинд богино хугацаанд харилцагчид хүндрэл багатайгаар амжилттай нэгтгэлээ.

Олон улсын мэдээллийн технологийн засаглал удирдлагын COBIT5 тогтолцоонд суурилсан Мэдээллийн технологийн хөндлөнгийн аудитыг хийлгэж, зохицуулагч байгууллагын шаардлагыг хангав.

Банкны үндсэн дата төвд Dell IDPA технологийн шийдлийг нэвтрүүлсэн нь мэдээллийн сангийн системүүдийг нөөцлөхөд үүсч болох эрсдэлээс сэргийлэх, мэдээллийн найдвартай нөөц бий болгох боломжийг бүрдүүлж, нөөцлөлт хийхэд зарцуулагдах хугацааг 8 дахин, тэдгээрийг сэргээх үйл ажиллагаанд зарцуулах хугацааг 2 дахин, нөөцлөлтийн хадгалах төхөөрөмжид эзлэх хэмжээг 5 дахин бууруулсан. Уг технологийн шийдлийг амжилттай

нэвтрүүлснийг Dell technology-аас сайшаан, манай банкныг www.delltechnologies.com сайт дээр сайн туршлагаар онцлон нийтэлсэн.

Олон улсын мөнгөн гуйвуулгын SWIFT сүлжээний аюулгүй байдлын төхөөрөмжийг бүрэн шинэчилсэн ба SWIFT Sanction screening, Name screening системүүдийг амжилттай нэвтрүүлснээр гүйлгээний хяналт сайжрах, процессыг автоматжуулах, корреспондент банкнуудаас тавьж буй стандарт, шаардлагыг хангах зэрэг давуу талууд бий боллоо. Мөн Nostro Reconciliation модулийг нэвтрүүлснээр гүйлгээ дамжуулсны шимтгэл хуваарилалтын гар ажиллагааг автоматжууллаа.

Монголбанкнаас 2020 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн томоохон ажлуудын нэг болох төлбөрийн ₮ картыг EMV чип технологид шилжүүлэх ажилд манай банк тэргүүлэн оролцож, ₮ EMV чип



картыг хэвлэх, хүлээн авах боломжийг АТМ, ПОС терминалууд дээрээ бүрэн хангаад байна. Үүний зэрэгцээ Автомат клиринг хаус системийн багц гүйлгээний интерфэйст сайжруулалт хийснээр буцаалтын гүйлгээг системээс шууд илгээх боломжтой болсон ба мөн Дансны нэгдсэн сан нэвтрүүлснээр хүлээн авагчийн дансны нэр, дугаар зөрөх алдаанаас үүдэлтэй гүйлгээ амжилтгүй болох эрсдэл буурах давуу тал бий болсон.

Цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан харилцагчийн зээл хойшлуулах хүсэлтийг онлайнгаар авах, улмаар харилцагчийн хүсэлтийн дагуу зээлийн эргэн төлөлтийн хуваарийг багцаар хойшлуулах ажиллагааг автоматжуулснаар уг ажилд зарцуулах хүн/өдөр –г дунджаар 70 дахин багасгав.

Харилцагч Ти Ди Би Онлайн систем ашиглан Олон улсын эрхтэй биет бус карт буюу Виртуал картыг хормын дотор авч, онлайн худалдан авалт, бэлэн бус гүйлгээнд шууд ашиглах боломжтой боллоо. Виртуал картын бүтээгдэхүүн нэвтрээд 5 сарын хугацаанд 5500 гаруй карт үүсгэгдэн ашиглагдаж байгаа нь харилцагчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн болсныг илтгэж байна.

Ти Ди Би онлайн системд картын ПИН код солих боломжийг нэвтрүүлснээр харилцагч банкны салбарт ирэхгүйгээр уг үйлчилгээг цахимаар авдаг болсон ба энэ нь харилцагч талдаа цаг хугацаа хэмнэх, банк талдаа ПИН код хэвлэх зардал болон

цаасны хаягдал хэмнэсэн өндөр ач холбогдолтой ажил боллоо.

Шоппи ХХК-тай хамтран нэвтрүүлсэн Хэрэглээний онлайн зээлийн үйлчилгээг шинэчлэн сайжруулж, ДАН системээр орлого нотлох, зээлийн судалгааг хялбаршуулсан шийдлийг нэвтрүүлснээр аль ч банкны харилцагч богино хугацаанд зээлийн хүсэлтээ илгээн 30 сарын хугацаатай, 10 сая төгрөг хүртэл дүн бүхий зээлийн хүсэлтийг онлайнгаар шийдвэрлүүлэх боломжтой боллоо.

ККТТ компанитай хамтран Qraу үйлчилгээндээ дэвшилтэт технологи болох Wallet үйлчилгээг амжилттай нэвтрүүлснээр харилцагч дурын банкны картаа үйлчилгээний байгууллагын аппликейшн дээр хадгалж, хүссэн үедээ картын дугаар оруулахгүйгээр онлайн худалдан авалт, төлбөр тооцоо хийх боломжтой болсон ба улмаар уг боломжийг Ти Ди Би Онлайн системд нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Мөн харилцагчийг тоон гарын үсгээр баталгаажуулах, гэрээ байгуулах, E-Mongolia цахим системийн харилцагчийг банкаар баталгаажуулах зэрэг боломжуудыг бүрдүүллээ.

Тайлант онд мэдээллийн системийн сайжруулалт, автоматжуулалтын ажилд өндөр ач холбогдол өгч ажилласны үр дүнд цахим сувгаар гарсан гүйлгээ өмнөх онтой харьцуулахад 16.5 хувиар нэмэгдсэн бөгөөд банкны хэмжээнд хийгдсэн нийт гүйлгээний 95 хувь нь цахим суваг ашиглан хийгдсэн байгаа нь өмнөх оноос 5 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

03

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК
(Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж)

Аудитлагдсан санхүүгийн тайлан
2020 оны 12 дугаар сарын 31

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

Аудитлагдсан санхүүгийн тайлан

Агуулга	Хуудас
Банкны талаарх мэдээлэл	1
Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга ба гүйцэтгэх удирдлагын мэдэгдэл	2
Хараат бус аудиторын дүгнэлт	3 – 4
Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан	5
Санхүүгийн байдлын тайлан	6
Өмчийн өөрчлөлтийн тайлан	7
Мөнгөн гүйлгээний тайлан	8 – 10
Санхүүгийн тайлангийн тодруулгууд	11 – 78

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Банкны талаарх мэдээлэл

ТУЗ-ийн гишүүд:

Д. Эрдэнэбилэг (ТУЗ-ийн дарга)

Р. Коппа

Д. Янжмаа

Д. Хүрэлбаатар

Ж. Болормаа

Ж. Дэлгэрсайхан

Нарийн бичгийн дарга:

У. Батчимэг

Албан хаяг:

Энхтайвны өргөн чөлөө 19,
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Улаанбаатар хот 14210,
Монгол улс

Аудиторууд:

Эрнст энд Янг Монголия Аудит ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга ба гүйцэтгэх удирдлагын мэдэгдэл

Худалдаа Хөгжлийн Банк ХХК-ийн (цаашид “Банк” гэх) Төлөөлөн Удирдах Зөвлөл (“ТУЗ”)-ийн дарга Должингийн Эрдэнэбилэг, Гүйцэтгэх захирал Ононгийн Орхон болон Санхүү хариуцсан захирал Дуламжавын Энхтуяа, бид Банкны санхүүгийн тайлангууд нь 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Тодруулга 2-т тусгасан тайлан бэлтгэх үндэслэлийн дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.

Должингийн Эрдэнэбилэг
Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга



Ононгийн Орхон
Гүйцэтгэх захирал

Дуламжавын Энхтуяа
Санхүү хариуцсан захирал

Улаанбаатар хот, Монгол улс

Огноо: 2021 оны 3-р сарын 31

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Худалдаа Хөгжлийн Банк ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

Дүгнэлт

Бид Худалдаа Хөгжлийн Банк ХХК (“Банк”)-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Банкны санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Тодруулга 2-т тусгасан тайлан бэлтгэх үндэслэлийн дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (“АОУС”)-уудын дагуу хийж гүйцэтгэлээ. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн “Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага” хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан “Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм”-ийн дагуу Банкнаас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Тодруулга 2-т тусгасан тайлан бэлтгэх үндэслэлийн дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Банкны удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Банкны үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Банкны үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй.

Засаглал хариуцсан этгээдүүд нь Банкны санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналуудаас санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч “АОУС”-ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу тайлагналууд нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

“АОУС”-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг.

Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэнд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

Худалдаа Хөгжлийн Банк ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд (үргэлжлэл)

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага (үргэлжлэл)

- Банкны дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Банкны үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Банкны тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь Тодруулга 2-г тусгасан тайлан бэлтгэх үндэслэлийн дагуу зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгддэг.

Бусад зүйл

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Банкны хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн Банкны хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



Ernst & Young Mongolia Audit LLC
ЭРНСТ ЭНД ЯНГ МОНГОЛИЯ АУДИТ ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид

Гарын үсэг зурсан



Доржбат Мандахбаяр
Захирал

Баталсан



Адриан Чу
Партнер

Улаанбаатар хот, Монгол улс
Огноо: 2021 оны 3-р сарын 31

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан

	Тодруулга	2020 мян.төг	2019 мян.төг
Хүү болон түүнтэй адилтгах орлого	7	707,870,414	701,609,264
Хүү болон түүнтэй адилтгах зардал	8	(506,145,302)	(521,699,037)
Хүүгийн цэвэр орлого		201,725,112	179,910,227
Шимтгэл, хураамжийн орлого	9	54,072,967	55,442,199
Шимтгэл, хураамжийн зардал	9	(14,708,811)	(15,069,569)
Шимтгэл, хураамжийн цэвэр орлого		39,364,156	40,372,630
Үйл ажиллагааны бусад орлого/(зардал)	10	(5,672,447)	32,067,455
Нийт үйл ажиллагааны орлого		235,416,821	252,350,312
Үнэ цэнийн бууралтын алдагдлын зардал	11	(64,675,317)	(58,086,927)
Үйл ажиллагааны цэвэр орлого		170,741,504	194,263,385
Үйл ажиллагааны зардал	12	(131,602,195)	(129,888,474)
Хараат компанийн алдагдлын Банканд ногдох хувь	17	(14,501,873)	–
Татварын өмнөх ашиг		24,637,436	64,374,911
Орлогын албан татварын зардал	13.1	(3,660,409)	(206)
Тайлант жилийн ашиг		20,977,027	64,374,705
Бусад дэлгэрэнгүй орлого/(зардал) (татварын дараах):			
<i>Дараагийн тайлант үеүдэд ашиг, алдагдлын тайлан руу дахин ангилагдах бусад дэлгэрэнгүй орлого (татварын дараах):</i>			
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн хэрэгжээгүй цэвэр өөрчлөлт	33	(1,424,125)	11,506,771
Мөнгөн гүйлгээний хейджийн нөөц		–	(29,398,246)
Бусад дэлгэрэнгүй алдагдал		(1,424,125)	(17,891,475)
Тайлант жилийн татварын дараах нийт дэлгэрэнгүй орлого		19,552,902	46,483,230

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салиггүй нэг хэсэг болно.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх

Санхүүгийн байдлын тайлан

	Тодруулга	2020 мян.төг	2019 мян.төг
Хөрөнгө			
Бэлэн мөнгө ба Монголбанканд байршуулсан мөнгө	14	856,968,353	1,096,100,972
Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	15	570,008,607	301,381,272
Санхүүгийн хөрөнгө оруулалт	16	1,711,998,541	1,832,616,770
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт	17	40,813,475	–
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	18	89,371,192	494,861,756
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	19	4,108,718,370	3,503,151,646
Бусад хөрөнгө	20	112,659,306	103,788,084
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	21	148,990,218	80,897,528
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө	22	4,138,693	–
Үндсэн хөрөнгө	23	458,644,011	392,311,221
Ашиглах эрхтэй хөрөнгө	24	10,132,850	12,717,699
Биет бус хөрөнгө	25	4,374,414	5,870,617
Нийт хөрөнгө		8,116,818,030	7,823,697,565
Өр төлбөр			
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	26	102,946,144	189,383,778
Репо хэлцэл	27	224,287,616	65,013,356
Харилцагчдын харилцах, хадгаламж	28	5,311,418,183	3,821,434,134
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	18	99,723,102	76,226,529
Зээлээр авсан санхүүжилт	29	558,736,354	759,290,707
Хоёрдогч өглөг	30	–	150,046,057
Гаргасан өрийн бичиг	31	160,140,274	1,536,488,710
Бусад өр төлбөр	32	628,403,246	508,520,501
Түрээсийн өглөг	24	11,384,522	13,591,398
Орлогын татварын өглөг	13.2	111,957	–
Хойшлогдсон татварын өр төлбөр	13.3	2,155,509	–
Нийт өр төлбөр		7,099,306,907	7,119,995,170
Эздийн өмч			
Энгийн хувьцаа	33	72,723,171	50,000,707
Нэмж төлөгдсөн капитал	33	251,086,754	19,298,006
Бусад нөөц	33	193,056,881	151,476,785
Хуримтлагдсан ашиг		500,644,317	482,926,897
Нийт эздийн өмч		1,017,511,123	703,702,395
Нийт өр төлбөр ба эздийн өмч		8,116,818,030	7,823,697,565

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

Өмчийн өөрчлөлтийн тайлан

	Энгийн хувьцаа мян.төг (Тод. 33)	Нэмж төлөгдсөн капитал мян.төг (Тод. 33)	Бусад нөөц мян.төг (Тод. 33)	Хуримтлагдсан ашиг мян.төг	Нийт эздийн өмч мян.төг
2019 оны 1 сарын 1-ээр	55,205,582	210,393,158	169,368,260	493,813,082	928,780,082
Тайлант жилийн ашиг	—	—	—	64,374,705	64,374,705
Бусад дэлгэрэнгүй орлого	—	—	(17,891,475)	—	(17,891,475)
Нийт дэлгэрэнгүй орлого	—	—	(17,891,475)	64,374,705	46,483,230
Эргэлтээс гаргасан энгийн хувьцаа	(5,204,875)	(191,095,152)	—	—	(196,300,027)
Зохицуулагч байгууллагын шаардлагын дагуу нэмж байгуулсан сан (Тод. 16)	—	—	—	(75,260,890)	(75,260,890)
2019 оны 12 сарын 31-ний болон 2020 оны 1 сарын 1-ний байдлаар	50,000,707	19,298,006	151,476,785	482,926,897	703,702,395
Тайлант жилийн ашиг	—	—	—	20,977,027	20,977,027
Бусад дэлгэрэнгүй орлого	—	—	(1,424,125)	—	(1,424,125)
Нийт дэлгэрэнгүй орлого	—	—	(1,424,125)	20,977,027	19,552,902
Хэрэгжсэн дахин үнэлгээний нөөц	—	—	(17,689)	17,689	—
Нэгдэлийн үр дүнд хүлээн зөвшөөрсөн хараат компанийн нөөцийн дахин ангилал (Тод. 17)	—	—	3,277,296	(3,277,296)	—
УБХБ-аас шилжиж ирсэн нөөц (Тод. 6)	—	—	39,744,614	—	39,744,614
Нэгдэлтэй холбоотойгоор нэмж гаргасан хувьцаа (Тод. 6)	9,973,842	94,537,126	—	—	104,510,968
Шинээр гаргасан хувьцаа (Тод. 33)	12,748,622	137,251,622	—	—	150,000,244
2020 оны 12 сарын 31-ний байдлаар	72,723,171	251,086,754	193,056,881	500,644,317	1,017,511,123

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

Мөнгөн гүйлгээний тайлан

	Тодруулга	2020 мян.төг	2019 мян.төг
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Татварын өмнөх ашиг		24,637,436	64,374,911
<i>Тохируулгууд:</i>			
Санхүүгийн үүсмэл хэрэгслийн бодит үнэ цэнийн өөрчлөлт		7,287,137	(40,597,385)
Санхүүгийн үүсмэл хэрэгслийн хейджийн үр ашиггүй хэсэг	10	–	(29,688,815)
Хөрөнгө оруулалтын үнэт цаас борлуулсны (олз)/гарз	10	(3,544,575)	5,059,717
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн (“ХОЗҮХХ”) үнэ цэнийн өөрчлөлтийн олз	10	(20,122,404)	(783,002)
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө борлуулсны (олз)/гарз	10	(3,022,069)	626,152
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтаас хүлээн зөвшөөрсөн олз	10	(768,590)	–
Үндсэн хөрөнгө борлуулсны олз	10	(169,780)	–
Орон сууцны зээлийн бүтцийн өөрчлөлтөөс үүссэн цэвэр гарз	10	5,592,847	–
Өмчлөх бусад хөрөнгө борлуулсны цэвэр гарз	10	365,423	100,204
Хараат компанийн алдагдлын Банканд ногдох хувь	17	14,501,873	–
Эрсдэлийн сангийн зардал:			
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	11	43,917,310	41,897,020
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	11	7,337,693	16,599,541
Зээлийн баталгаа, батлан даалт	11	(652,177)	(695,052)
Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	11	(440,001)	156,638
Бусад хөрөнгө	11	14,512,492	118,780
Хөрөнгө оруулалтын үнэт цаас	11	–	10,000
Үндсэн хөрөнгийн элэгдэл	12	12,977,972	10,315,416
Биет бус хөрөнгийн хорогдуулга	12	2,421,188	2,101,911
Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдэл	12	4,865,339	3,930,742
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	12	34,119	7,678,098
Биет бус хөрөнгө данснаас хассаны гарз	12	346,076	–
Зээлээр авсан санхүүжилтийн хүүгийн зардал		111,325,297	79,305,409
Хоёрдогч өглөгийн хүүгийн зардал		20,666,526	45,833
Гаргасан өрийн бичгийн хүүгийн зардал		64,729,464	144,234,052
Түрээсийн өглөгийн хүүгийн зардал		1,821,379	2,135,697
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн бус гүйлгээ		45,336,899	80,303,860
Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг		353,956,874	387,229,727
Үйл ажиллагааны хөрөнгө ба өр төлбөрийн өөрчлөлтүүд:			
Монголбанк дахь заавал байлгах нөөц		(128,337,531)	(54,386,227)
Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө		65,835,770	(32,498,664)
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа		154,965,035	(318,684,789)
Бусад хөрөнгө		5,953,514	4,465,295
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө		21,112,053	1,406,730
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж		(104,335,246)	7,024,802
Репо хэлцэл		150,847,622	–
Харилцагчдын харилцах, хадгаламж		681,415,078	221,742,212
Бусад өр төлбөр		(29,327,557)	457,873,252
Үндсэн үйл ажиллагаанаас хүлээн авсан мөнгөн гүйлгээ		1,172,085,612	674,172,338
Төлсөн орлогын албан татвар		(5,470,061)	(206)
Түрээсийн өглөгийн хүүгийн хэсэгт хамаарах төлөлт		(1,821,379)	(2,135,697)
Зээлээр авсан санхүүжилтийн хүүгийн төлөлт		(123,622,668)	(81,644,198)
Хоёрдогч өглөгийн хүүгийн төлөлт		(20,712,359)	–
Гаргасан өрийн бичгийн хүүгийн төлөлт		(78,299,373)	(144,596,808)
Үндсэн үйл ажиллагаанаас хүлээн авсан цэвэр мөнгөн гүйлгээ		942,159,772	445,795,429

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салиггүй нэг хэсэг болно.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

Мөнгөн гүйлгээний тайлан (үргэлжлэл)

	Тодруулга	2020 мян.төг	2019 мян.төг
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Нэгдлийн үр дүнд хүлээн авсан бэлэн мөнгө	6	7,705,567	–
Санхүүгийн хөрөнгө оруулалтын худалдан авалт		(149,727,966)	(212,772,725)
Санхүүгийн хөрөнгө оруулалт борлуулсны орлого		368,144,729	267,667,416
Үндсэн хөрөнгө борлуулсны олз		3,770,943	–
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	23	(4,919,708)	(38,581,897)
Биет бус хөрөнгийн худалдан авалт	25	(381,917)	(4,858,940)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас хүлээн авсан цэвэр мөнгөн гүйлгээ		224,591,648	11,453,854
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Зээлээр авсан санхүүжилтийн татан авалт		359,758,646	384,317,370
Зээлээр авсан санхүүжилтийн эргэн төлөлт		(596,544,559)	(625,683,787)
Өрийн бичгээр татсан эх үүсвэр		–	2,400,876
Санхүүгийн үүсмэл хэрэгслийн хэрэгжилтээс олсон орлого		421,700,000	–
Өрийн бичгийн эргэн төлөлт		(1,397,320,000)	–
Хоёрдогч өглөгийн (эргэн төлөлт)/татсан эх үүсвэр		(150,000,224)	150,000,224
Шинээр гаргасан хувьцаа /(Эргэлтээс гаргасан хувьцаа)	33	150,000,244	(196,300,027)
Түрээсийн өглөгийн үндсэн төлбөрийн эргэн төлөлт		(4,317,826)	(3,057,043)
Санхүүгийн үйл ажиллагаанд зарцуулсан цэвэр мөнгөн гүйлгээ		(1,216,723,719)	(288,322,387)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт/(бууралт)		(49,972,299)	168,926,896
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	35	1,426,345,590	1,257,418,694
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	35	1,376,373,291	1,426,345,590
Хүүтэй холбоотой үйл ажиллагааны мөнгөн урсгал			
Төлсөн хүү		(483,879,585)	(514,345,092)
Хүлээн авсан хүү		542,726,441	597,185,752
Мөнгөн бус үйл ажиллагаанууд			
Ашиглах эрхтэй хөрөнгө ба түрээсийн өглөгийн нэмэгдэл	24	1,682,331	1,043,140
Санхүүгийн хөрөнгө оруулалтаас хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт руу хийсэн дахин ангилал	17	26,876,310	–
Зээлийн үүргийн гүйцэтгэлийг барьцаа хөрөнгөөр хангуулсан		52,892,702	–
Үндсэн хөрөнгөөс биет бус хөрөнгө руу хийсэн дахин ангилал		–	337,179
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгөнөөс өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө рүү хийсэн дахин ангилал		–	59,722,713
Санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн өр төлбөрийн өөрчлөлт			
Түрээсийн өглөг			
		2020 мян.төг	2019 мян.төг
1 сарын 1-нээр		13,591,398	15,605,301
Мөнгөн бус нэмэгдэл		1,682,331	1,043,140
УБХБ-аас шилжиж ирсэн		970,544	–
Түрээсийн гэрээ цуцлагдсан түрээсүүд		(541,925)	–
Тайлант үеийн хүүгийн зардал		1,821,379	2,135,697
Түрээсийн өглөгийн хүүгийн төлөлт		(1,821,379)	(2,135,697)
Түрээсийн өглөгийн үндсэн хэсгийн төлөлт		(4,317,826)	(3,057,043)
12 сарын 31-нээр		11,384,522	13,591,398

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салиггүй нэг хэсэг болно.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

Мөнгөн гүйлгээний тайлан (үргэлжлэл)

Санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн өр төлбөрийн өөрчлөлт (үргэлжлэл)

	Зээлээр авсан санхүүжилт мян.төг	Хоёрдогч өглөг мян.төг	Гаргасан өрийн бичиг мян.төг
2019 оны 1 сарын 1-нээр	981,328,159	–	1,475,814,484
Шинээр татсан эх үүсвэр	384,317,370	150,000,224	2,400,876
Эргэн төлөлт	(625,683,787)	–	–
Хүүгийн төлөлт	(81,644,198)	–	(144,596,808)
Цэвэр (эргэн төлөлт)/татсан эх үүсвэр	(323,010,615)	150,000,224	(142,195,932)
Хойшлогдсон төлбөр	(2,977,663)	–	–
Хойшлогдсон төлбөрийн хорогдуулалт	7,529,610	–	12,474,112
Гадаад валютын ханшийн зөрүү	17,115,807	–	46,161,994
Санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн мөнгөн бус гүйлгээ	21,667,754	–	58,636,106
Хуримтлагдсан хүүгийн зардал	79,305,409	45,833	144,234,052
2019 оны 12 сарын 31 болон 2020 оны 1 сарын 1-ний байдлаар	759,290,707	150,046,057	1,536,488,710
Шинээр татсан эх үүсвэр	359,758,646	–	–
УБХБ-аас шилжиж ирсэн (Тод. 6)	37,733,505	–	–
Эргэн төлөлт	(596,544,559)	(150,000,224)	(1,397,320,000)
Хүүгийн төлөлт	(123,622,668)	(20,712,359)	(78,299,373)
Цэвэр (эргэн төлөлт)/татсан эх үүсвэр	(322,675,076)	(170,712,583)	(1,475,619,373)
Хойшлогдсон төлбөр	(7,538,698)	–	–
Хойшлогдсон төлбөрийн хорогдуулалт	8,114,179	–	5,360,502
Гадаад валютын ханшийн зөрүү	10,219,945	–	29,180,971
Санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн мөнгөн бус гүйлгээ	10,795,426	–	34,541,473
Хуримтлагдсан хүүгийн зардал	111,325,297	20,666,526	64,729,464
2020 оны 12 сарын 31-ний байдлаар	558,736,354	–	160,140,274

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

1. Банкны талаарх мэдээлэл

Худалдаа, хөгжлийн банк ХХК (“Банк”) нь 1990 оны 10 дугаар сарын 19-ний өдөр Монгол улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан ба 1993 онд хийгдсэн анхны банкны салбарын хяналт, шалгалтын актын дор Монголбанкнаас олгосон 8 тоот зөвшөөрлийн дагуу банк, санхүүгийн үйлчилгээ үзүүлэх бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг.

Банк нь Монгол улсад бүртгэлтэй, тус улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг хязгаарлагдмал хариуцлагатай компани юм. Банкны төв байрны албан ёсны хаяг нь Худалдаа, хөгжлийн банкны байр, Энх тайвны өргөн чөлөө 19, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Улаанбаатар хот 14210, Монгол улс.

Банк нь Банкны тухай хууль болон Монголбанкны 2020 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн Н/100 тоот тогтоолд тус тус үндэслэн 2020 оны 6 дугаар сарын 26-нд Улаанбаатар хотын банк ХХК (“УБХБ”)–тай албан ёсоор нэгдсэн. Нэгдэл нь Банк болон УБХБ-ны хооронд байгуулсан Нэгтгэн нийлүүлэх гэрээгээр зохицуулагдсан ба 2020 оны 6 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн УБХБ-ны бүх хөрөнгө, өр төлбөр, нөөц болон салбарууд нь Банканд нэгтгэгдсэн (“Нэгдэл”) болно (Тодруулга 6-г харна уу).

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар банкны 45.26%-ийг Люксембургт бүртгэлтэй Глобулл Инвестмент энд Девелопмент Эс Си Эй (“Глобулл”) эзэмшиж байв. АНУ-д бүртгэлтэй Ю Эс Глобал Инвестмент ХХК Глобуллыг бүхэлд нь эзэмшдэг. (Банкны хувьцаа эзэмшигчид болон тэдгээрийн эзэмшлийн хувийг Тодруулга 33-аас харна уу).

2021 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолоор 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон жилийн санхүүгийн тайлангуудыг гаргахыг зөвшөөрөв.

2. Тайлан бэлтгэх үндэслэл

Банкны санхүүгийн тайлангуудыг СТОУС 9 “Санхүүгийн хэрэгслүүд”-ийн хэрэгжилтээс бусдаар Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл (“НББОУСЗ”)–өөс баталж гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (“СТОУС”)–ын дагуу боловсруулсан банкны нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу бэлтгэж толилуулсан. Банк нь санхүүгийн хөрөнгүүдийн үнэ цэнийн бууралтын бүртгэлдээ Монголбанкаас баталсан заавар, журмыг үргэлжлүүлэн мөрдөж байгаа болно. СТОУС 9 “Санхүүгийн хэрэгслүүд”-ийн хэрэгжилтийг Монголбанкны зүгээс хойшлуулсан.

СТОУС-аас ялгаатай Монголбанкнаас баталсан заавар, журмаар зохицуулсан Банканд томоохон нөлөөлж буй дараах зүйлс байна. Дэлгэрэнгүйг холбогдох тодруулгуудад тайлбарласан болно.

- Зээлийн болзошгүй эрсдэлийн сан, авлага, аккредитив, ашиглагдаагүй зээлийн үүрэг, эх үүсвэргүй санхүүжилт, өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө
- Санхүүгийн хөрөнгийн ангилал (хорогдуулсан өртгөөр, бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх, бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх)

Санхүүгийн тайлангууд нь бодит үнэ цэнийн аргаар бүртгэгдэх санхүүгийн үүсмэл хэрэгсэл, борлуулах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө, анх хүлээн зөвшөөрснөөс хойш дараа тайлант үед бодит үнэ цэнээр хэмжигдэх барилга болон газар, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, үнэт металлыг эс тооцвол түүхэн өртөгийн зарчмаар бэлтгэгдсэн болно. Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг тодруулгад өөрөөр зааснаас бусад тохиолдолд мянгачилан, Монгол Улсын мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөгөөр тайлагнасан.

Санхүүгийн тайлангийн толилуулга

Банк нь санхүүгийн байдлын тайлангийн зүйлсийг хөрвөх чадварынх нь дарааллаар толилуулсан. Санхүүгийн байдлын тайлангийн өдрийн дараах 12 сарын дотор (богино хугацаанд) ба 12 сараас хойших хугацаанд (урт хугацаанд) хүлээн авах эсвэл төлөх төлбөрийн талаарх шинжилгээг тодруулга 40-д толилуулсан.

Ирээдүйн үйл явдлаас хамааралгүйгээр хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг цэвэршүүлэх хуулиар олгогдсон эрхтэй ба хөрөнгө, өр төлбөрийг зэрэг хүлээн зөвшөөрөх эсвэл цэвэр дүнгээр нь барагдуулах хандлагатай байгаа үед санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрүүдийг хооронд нь цэвэршүүлж, цэвэр дүнг санхүүгийн байдлын тайланд толилуулна. Нягтлан бодох бүртгэлийн стандарт эсвэл тайлбарт шаардаагүй эсвэл зөвшөөрөөгүй мөн банкны нягтлан бодох бүртгэлийн бодлогод тусгайлан толилуулаагүй тохиолдолд орлого ба зардлын дүнгүүдийг ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд цэвэршүүлэхгүй.

3. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн тайлангийн тодруулгад орсон өөрчлөлтүүд

2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон доорхи СТОУС-ууд болон нэмэлт өөрчлөлтүүдээс бусад Банкны хэрэгжүүлж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь өмнөх санхүүгийн жилийнхтэй адил байна. Банк нь дор дурдсан СТОУС 16-д орсон өөрчлөлтөөс бусдаар батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй аливаа стандарт, түүний тайлбар, өөрчлөлтүүдийг хэрэгжүүлж эхлээгүй болно.

3. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн тайлангийн тодруулгад орсон өөрчлөлтүүд (үргэлжлэл)**СТОУС 3-ын нэмэлт өөрчлөлтүүд: Бизнесийн тодорхойлолт**

СТОУС 3 Бизнесийн нэгдэлд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр бизнесийг нэгтгэн үзэхийн тулд үйл ажиллагаа болон хөрөнгийн нэгдсэн цогц нь хамгийн багадаа орц, гарц, бодитой үйл явцыг багтаасан байх ёстой. Цаашилбал, бизнес нь бүх оролт болон процессыг оруулалгүйгээр оршин тогтнох боломжтой болохыг тодруулсан болно. Уг нэмэлт өөрчлөлтөөр гарцад харилцагчдад үзүүлсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ, хөрөнгө оруулалтын орлого болон бизнесийн хэвийн үйл ажиллагаанаас үүссэн бусад орлогууд багтахыг нарийвчилж өгсөн. Түүнчлэн, бизнесийн нэгдлээр худалдан авсан бизнесийн үйл ажиллагааг бодитой үйл явц гэж тодорхойлох удирдамж болон худалдан авсан бизнесийн хөрөнгийн нэгдсэн цогцыг бизнес мөн эсэхийг хялбараар үнэлэх боломжтой сонголтот бодит үнэ цэнийн төвлөрлийн тестийг тус тус танилцуулсан. Эдгээр нэмэлт өөрчлөлт нь Банкны санхүүгийн тайланд нөлөөлөөгүй боловч ирээдүйд Банк нь аливаа бизнесийн нэгдэлд орох тохиолдолд нөлөөлж болзошгүй юм.

СТОУС 7, СТОУС 9 ба НББОУС 39-ын нэмэлт өөрчлөлтүүд: Жишиг зээлийн хүүгийн шинэчлэл

СТОУС 9 ба НББОУС 39, Санхүүгийн хэрэгслүүд: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтэд оруулсан нэмэлт өөрчлөлтүүд нь жишиг зээлийн хүүгийн шинэчлэлд шууд нөлөөлж буй бүх хейджийн харилцаанд хамаарах хэд хэдэн хөнгөлөлтийг үзүүлдэг. Хэрэв шинэчлэл нь хейджийн зүйл эсвэл хейджийн хэрэгслийн жишигт суурилсан мөнгөн урсгалын цаг хугацаа ба/эсвэл хэмжээнд тодорхойгүй байдал үүсгэж байвал хейджийн харилцаанд нөлөөлнө. Эдгээр нэмэлт өөрчлөлт нь Банк нь хүүгийн хейджийн харилцаагүй тул Банкны санхүүгийн тайланд нөлөөлөхгүй.

НББОУС 1 ба НББОУС 8-ын нэмэлт өөрчлөлтүүд: “Материаллаг” байдлын тодорхойлолт

Нэмэлт өөрчлөлтүүд нь “материаллаг”-ийн шинэ тодорхойлолтыг “тухайн мэдээлэлийг орхисон, буруу бичсэн эсвэл тодорхой бус орхисон тохиолдол нь санхүүгийн тайлангийн үндсэн хэрэглэгчдийн санхүүгийн тайланг үндэслэн гаргасан шийдвэрт нөлөөлөх болно гэж тусгажээ. Нэмэлт өөрчлөлтүүд нь материаллагийг санхүүгийн тайлангийн агуулгаар мэдээллийн шинж чанар, хэмжээ, дангаар нь эсвэл бусад мэдээлэлтэй хослуулан авч үзнэ гэж тодорхойлжээ. Мэдээллийн буруу ташаа байдал нь анхдагч хэрэглэгчдийн гаргасан шийдвэрт нөлөөлөхүйц үндэслэлтэй гэж үзэж болох юм. Эдгээр нэмэлт, өөрчлөлт нь санхүүгийн тайланд нөлөөлөөгүй бөгөөд цаашид Банканд нөлөөлөхгүй гэж үзэж байна.

Санхүүгийн тайлангийн үзэл баримтлалын хүрээ (2018 оны 3 сарын 29-нд батлагдсан)

Энэхүү үзэл баримтлалын хүрээ нь стандарт биш бөгөөд үүнд агуулагдах ойлголтуудын аль нь ч ямар ч стандартын үзэл баримтлал, шаардлагыг үгүйсгэхгүй. Энэхүү үзэл баримтлалын хүрээний зорилго нь НББОУС3-д стандарт боловсруулахад туслах, холбогдох стандарт байхгүй тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тууштай бодлого боловсруулахад туслах, бүх талуудад стандартыг ойлгож, тайлбарлахад туслах явдал юм. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлогоо үзэл баримтлалын хүрээнд үндэслэн боловсруулсан аж ахуйн нэгжүүдэд нөлөөлнө. Шинэчилсэн үзэл баримтлалын хүрээнд зарим шинэ ойлголт, шинэчилсэн тодорхойлолт, хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх шалгуурыг багтаасан бөгөөд зарим чухал ойлголтуудыг тодруулсан болно. Эдгээр нэмэлт өөрчлөлт нь Банкны санхүүгийн тайланд нөлөөлөөгүй.

СТОУС 16 Ковид-19-тэй холбоотой Түрээсийн хөнгөлөлтийн нэмэлт өөрчлөлтүүд

2020 оны 5 дугаар сарын 28-нд НББОУС3 нь Ковид-19-тэй холбоотой түрээсийн хөнгөлөлтийн тухай СТОУС 16 Түрээс-д нэмэлт, өөрчлөлт оруулсан. Нэмэлт өөрчлөлтүүд нь түрээслэгчдэд Ковид-19 цар тахлын шууд үр дагавраас үүдэлтэй түрээсийн хөнгөлөлтийг бүртгэх түрээсийн өөрчлөлтийн бүртгэлийн талаарх СТОУС 16-н зааврыг хэрэгжүүлэхэд хөнгөлөлт үзүүлдэг. Энэхүү хөнгөлөлтийн зорилго нь түрээслэгч нь түрээслүүлэгчээс Ковид-19-тэй холбоотой авсан түрээсийн хөнгөлөлтийг түрээсийн өөрчлөлт мөн эсэхийг үнэлэхгүй байж болох сонголтыг оруулж өгсөн. Энэ сонголтыг хийсэн түрээслэгч нь Ковид-19-тэй холбоотой түрээсийн хөнгөлөлтийг СТОУС 16-д заасан түрээсийн өөрчлөлт гэж үзээгүй үед тооцсонтой адил аргаар тооцно. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь Банкны санхүүгийн тайланд онцгой нөлөө үзүүлээгүй болно.

4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд**Гадаад валютын ханшийн тэгшитгэл**

Банкны үйл ажиллагааны болон тайлагналын мөнгөн тэмдэгт нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох “Монгол төгрөг” юм. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө ба өр төлбөрийг тайлагналын өдрийн спот ханшаар дахин хөрвүүлдэг. Мөнгөн зүйлсийн ханшийн тэгшитгэл эсвэл төлбөр тооцооноос үүссэн аливаа зөрүүг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Түүхэн өртгөөр бүртгэдэг мөнгөн бус зүйлсийг анх гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар хөрвүүлнэ. Харин өмчийн хөрөнгө оруулалт зэрэг бодит үнэ цэнэ нь гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийг бодит өртгийг тодорхойлсон өдрийн ханшаар хөрвүүлж бүртгэнэ. Бодит үнэ цэнийн аргаар бүртгэдэг мөнгөн бус зүйлсийн ханшийн тэгшитгэлээс үүссэн олз эсвэл гарзыг бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз ба гарз хэсэгт толилуулна.

4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)**Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт**

Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтыг нягтлан бодох бүртгэлийн өмчийн аргыг ашиглан бүртгэнэ. Хараат компани гэж Банкны мэдэгдэхүйц нөлөөлөлтэй компанийг хэлнэ. Мэдэгдэхүйц нөлөө гэдэг нь хараат компанийн санхүү болон үйл ажиллагааны бодлогын шийдвэрт шууд оролцох эрхийг хэлнэ.

Өмчийн аргыг ашиглах үед хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт нь санхүүгийн байдлын тайлан дахь өртөг дээр худалдан авалтын дараах хараат компанийн цэвэр хөрөнгийн Банкны хувь оролцооны өөрчлөлтийг нэмсэнтэй тэнцүү байна. Хараат компанитай холбоотой бүртгэгдсэн гүүдвилл нь хөрөнгө оруулалтын дүнд багтах бөгөөд дангаар нь үнэ цэнийн бууралт хэмжихгүй мөн хорогдуулахгүй.

Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хараат компанийн үйл ажиллагааны үр дүнгийн Банкны эзэмшлийн хувь хэмжээгээрх хэсгийг тусгана. Хараат компанийн өмчид шууд өөрчлөлт орсон үед Банк энэхүү өөрчлөлтийг өөрийн хувь эзэмших хэмжээгээр хүлээн зөвшөөрөн, шаардлагатай тодруулгыг өмчийн өөрчлөлтийн тайландаа тусгана. Банк болон хараат компани хооронд хийгдсэн ажил гүйлгээнээс үүссэн аливаа бодит бус ашиг, алдагдлыг хараат компанийн эзэмшлийн хувь хэмжээ хүртэлх хэсгээр устгах бичилт хийнэ.

Хараат компанийн ашгийн хувийг ашиг, алдагдал ба дэлгэрэнгүй орлогын тайланд толилуулна. Энэ ашиг нь хараат компанийн хувьцаа эзэмшигчдэд хамааралтай бөгөөд татварын дараах ашиг болно. Мөн хараат компани охин компанитай бөгөөд түүнд цөөнхийн сонирхолын хэсэг бүртгэгддэг бол түүнийг ч мөн авч үзсэн ашиг байна.

Хараат компанийн санхүүгийн тайланг Банкны тайлангийн хугацаатай нэг хугацаанд бэлтгэнэ. Шаардлагатай бол, хараат компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өөрчилж Банкны нягтлан бодох бүртгэлийн бодлоготой нийцүүлнэ.

Өмчийн аргыг хэрэглэсний дараа, хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтад нэмэлт үнэ цэнийн бууралтын сан байгуулах шаардлагатай эсэхийг Банк тодорхойлно. Банкны хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтад үнэ цэнийн бууралт үүссэн гэх бодит нотолгоо байгаа эсэхийг санхүүгийн тайлан бэлтгэх бүрдээ тодорхойлно. Хэрэв тийм нотолгоо байгаа бол уг хөрөнгө оруулалтын эргэн төлөгдөх дүн, бүртгэлийн дүн хоёрын зөрүүгээр алдагдлын дүнг тооцож, уг дүнг ашиг, алдагдлын тайланд ‘хараат компанийн ашгийн хувь’ хэсэгт хүлээн зөвшөөрнө.

Хараат компани дахь мэдэгдэхүйц нөлөөллөө алдсаны дараа Банк үлдсэн хөрөнгө оруулалтаа бодит үнээр тооцож хүлээн зөвшөөрнө. Уг нөлөөллөө алдсаны дараах дансны үнэ, үлдсэн хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэ хоёрын зөрүү болон хөрөнгө борлуулсны ашиг, алдагдлуудыг ашиг алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хэрэгслүүд – анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн хэмжилт*Хүлээн зөвшөөрөх өдөр*

Бүх санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг анхлан хүлээн зөвшөөрөхдөө арилжаа хийсэн өдрөөр (Банк нь тухайн хэрэгслийн гэрээний нэг тал болсон өдөр) хүлээн зөвшөөрнө. Үүнд хэвийн нөхцөлтэй арилжаа буюу санхүүгийн хөрөнгө худалдан авах, худалдахад холбогдох хөрөнгийн зах зээлийн журам, хэлэлцээр тогтоосон хугацаанд зайлшгүй шилжүүлэхийг шаарддаг арилжаа орно.

Санхүүгийн хэрэгслийн анхны хэмжилт

Санхүүгийн хэрэгслийг анх бодит үнэ цэнээр буюу өгсөн (хөрөнгийн хувьд) эсвэл хүлээн авсан (өр төлбөрийн хувьд) төлбөрийн бодит үнэ цэнээр бүртгэнэ. Санхүүгийн хэрэгслийн анхдагч хэмжилтэд бодит үнэ цэнэ нь орлого, зардлын дансанд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрөөс бусад тохиолдолд ажил гүйлгээний өртгийг оруулна.

Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдлын тайланд бүртгэх санхүүгийн үүсмэл хэрэгслүүд

Санхүүгийн үүсмэл хэрэгслийг дараах 3 шинж чанар хангасан тохиолдолд санхүүгийн хэрэгсэл эсвэл бусад гэрээ гэж тодорхойлно:

- Үнэ цэнэ нь тодорхой хүүгийн түвшин, санхүүгийн хэрэгслийн үнэ, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ, валютын ханшийн өөрчлөлт, зээлжих зэрэглэл болон гэрээний холбогдох талын үүрэг хариуцлагад хамаарахгүй бусад хувьсагчийн өөрчлөлтөөс хамаардаг бол
- Анхны цэвэр хөрөнгө оруулалт шаарддаггүй эсвэл зах зээлийн хүчин зүйлсийн нөлөөлөл нь ижил байхуйц бусад төрлийн гэрээнүүдэд шаардагдахаас бага анхны цэвэр хөрөнгө оруулалт шаарддаг
- Ирээдүйд төлөгдөхөөр бол

4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)**Санхүүгийн хэрэгслүүд – анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн хэмжилт (үргэлжлэл)**

Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдлын тайланд бүртгэх санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (үргэлжлэл)

Банк нь төрөл бүрийн харилцагчидтай санхүүгийн үүсмэл хэрэгслийн хэлцлүүд хийдэг бөгөөд эдгээрт кросс своп хэлцэл, гадаад валютын болон хүүгийн форвард гэрээ хэлцлүүд зэрэг орно. Санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийг бодит үнэ цэнээр нь бүртгэдэг ба бодит үнэ цэнэ нь эерэг байгаа үед хөрөнгө, харин сөрөг байгаа үед өр төлбөр гэж бүртгэнэ. Санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг хэйджийн нягтлан бодох бүртгэл хэрэглэж байгаагаас бусад үед “Арилжааны цэвэр орлого”-д бүртгэдэг.

Санхүүгийн хэрэгслүүдэд агуулагдсан санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийг салгаж авч үзэх ёстой (дээр дурдсанчлан) ба тэдгээрийн эдийн засгийн үзүүлэлтүүд болон эрсдэлүүдийг агуулагч гэрээний эдийн засгийн үзүүлэлтүүд болон эрсдэлүүдтэй нягт холбоотой биш, мөн агуулагч гэрээг худалдах зорилгоор эзэмшээгүй ба анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх гэж ангилаагүй тохиолдолд тэдгээрийг бодит үнээр нь бүртгэнэ. Агуулагч гэрээнээс нь салгасан санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийг арилжааны багц дахь бодит үнэ цэнийн өөрчлөлтөөр нь бүртгэх ба уг өөрчлөлтийг нь ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт

Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтуудад өрийн болон өмчийн үнэт цааснууд багтана. “Арилжаалах зорилгоор эзэмшиж буй” ба “бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх” гэсэн ангилалд ороогүй өмчийн үнэт цааснуудыг “Борлуулахад бэлэн” гэж ангилна. Тодорхойгүй хугацаагаар эзэмших хандлагатай, төлбөрийн чадварын хэрэгцээг хангах үүднээс эсвэл зах зээлийн нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас ирээдүйд борлуулахаар эзэмшиж байгаа хөрөнгө оруулалтууд нь өрийн үнэт цааснууд байна. Банк нь аливаа зээл ба авлагуудыг “Борлуулахад бэлэн” санхүүгийн хөрөнгө гэж ангилаагүй. Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтыг анхны хэмжилтийн дараа бодит үнэ цэнээр нь бүртгэнэ.

Бусад дэлгэрэнгүй орлогын тайлангийн борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын нөөц хэсэгт бүртгэдэг. Хөрөнгө оруулалтыг данснаас хасах үед харгалзах эзний өмчид хуримтлагдсан олз эсвэл гарзыг орлогын үр дүнгийн тайланд бусад үйл ажиллагааны орлогоор хүлээн зөвшөөрнө. Банк нь нэг төрлийн үнэт цаасанд нэгээс илүү удаа хөрөнгө оруулсан бол тэдгээрийг “эхэлж авснаа эхэлж зарлагадах” зарчмыг баримтлан борлуулсан гэж үзнэ. Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтаас олсон хүүгийн орлогыг тухайн хэрэгслийн өгөөжийн салшгүй хэсэг болох хөнгөлөлт/урамшуулал болон холбогдох зардлыг харгалзан үзсэн үр ашигт хүү (“YAX”)-ийн аргыг ашиглан хүүгийн орлогоор бүртгэнэ.

Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтыг эзэмшиж байх хугацаанд олсон ногдол ашгийг төлбөрийн эрх нь тогтоогдсон үед орлогын тайланд үйл ажиллагааны бусад орлогоор хүлээн зөвшөөрнө. Хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтаас үүссэн алдагдлыг ашиг, алдагдлын тайлангийн “Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдал”-д хүлээн зөвшөөрч, борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын нөөцөөс хасна.

Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас

Хугацааны эцэс хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалтад тогтмол болон тодорхойлж болохуйц дүнтэй, дуусгавар болох хугацаатай, хугацааны эцэс хүртэл эзэмших зорилгоор банк худалдан авсан үүсмэл бус санхүүгийн хөрөнгүүдийг хамруулна. Анхны хэмжилтийн дараа хугацааны эцэс хүртэл эзэмших хөрөнгө оруулалтыг YAX-ийн аргаар тооцсон хорогдуулсан өртгөөр бүртгэх ба үүнээс үнэ цэнийн бууралтыг хасч толилуулна. Хорогдуулсан өртгийг тооцохдоо YAX-ийн салшгүй хэсэг болох тухайн санхүүгийн хөрөнгийг худалдан авахад төлсөн шууд зардал ба хөнгөлөлт, урамшууллыг харгалзана. Хорогдуулалтыг ашиг алдагдлын тайланд “Хүү ба түүнтэй адилтгах орлого”-оор бүртгэнэ. Тухайн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтаас үүссэн алдагдлыг “Үнэ цэнийн бууралтын сан” хэсэгт зардлаар хүлээн зөвшөөрнө.

Хэрэв Банк бага биш дүнтэй “дуусгавар хугацаа хүртэл эзэмших” хөрөнгө оруулалтыг дуусгавар хугацаанаас нь өмнө худалдах эсвэл дахин ангилах бол (зарим нэг онцгой тохиолдлуудаас бусад) нийт бүлгээр нь “борлуулахад бэлэн” бүлэгт дахин ангилна. Үүнээс гадна Банк нь дараагийн хоёр жилд аливаа нэг санхүүгийн хөрөнгийг “дуусгавар хугацаа хүртэл эзэмших” бүлэгт ангилахыг хориглодог.

Банк, санхүүгийн байгууллагад байриуулсан харилцах хадгаламж болон харилцагчдад олгосон зээл, урьдчилгаа

Энд идэвхитэй зах зээл дээр бүртгэлгүй, тогтмол эсвэл тодорхойлох боломжтой төлбөртэй дараахаас бусад, “Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж” ба “Харилцагчдад олгосон зээл, урьдчилгаа” гэсэн үүсмэл бус санхүүгийн хөрөнгүүд багтана. Үүнд:

- Банк нэн даруй эсвэл ойрын хугацаанд борлуулах хандлагатай байгаа ба Банк анх хүлээн зөвшөөрөхдөө “Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх” гэж ангилсан санхүүгийн хэрэгслүүд;
- Банк анх хүлээн зөвшөөрөхдөө “Борлуулахад бэлэн” гэж ангилсан санхүүгийн хэрэгслүүд;

4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

Санхүүгийн хэрэгслүүд – анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн хэмжилт (үргэлжлэл)

Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах хадгаламж болон харилцагчдад олгосон зээл, урьдчилгаа (үргэлжлэл)

- Банк зээлийн үнэ цэнийн бууралтын улмаас биш өөр бусад шалтгааны улмаас анх оруулсан хөрөнгөө нийт дүнгээр нь эргүүлэн олж авч чадахгүй болсон санхүүгийн хэрэгслүүд.

Анхны хэмжилтийн дараа “Бусад банкин дахь харилцах, хадгаламж” ба “Харилцагчдад олгосон зээл, урьдчилгаа”-г үр ашигт хүүний аргыг хэрэглэн хорогдуулсан өртгөөс үнэ цэнийн бууралтын санг хассан дүнгээр бүртгэнэ. Хорогдуулсан өртгийг үр ашигт хүүгийн салшгүй хэсэг болох худалдан авалтын урамшуулал, хөнгөлөлт болон шимтгэлийг оролцуулан тооцно. Хорогдуулалтыг ашиг алдаглын тайланд ‘Хүү болон түүнтэй адилтгах орлого’-д хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Уг хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтаас үүссэн алдагдлыг ашиг алдагдлын тайланд “Үнэ цэнийн бууралтын сан”-д зардлаар хүлээн зөвшөөрнө.

Банк зээлийг хадгалж үлдэх хандлагатай байгаа ба богино хугацаанд худалдахгүй гэсэн амлалт гаргасан бол энэ амлалтыг хэрэгжүүлэх нь төвөгтэй ба алдагдал хүлээх магадлалтай үед л энэ амлалтыг бүртгэнэ.

Зээлээр авсан санхүүжилт ба гаргасан өрийн бичиг

Зээлээр авсан санхүүжилт ба гаргасан өрийн бичиг нь гадаад дотоодын санхүүгийн байгууллагаас гэрээгээр хүлээсэн үүргийг хэлнэ.

Анхны хэмжилтийн дараа, зээлээр авсан эх үүсвэр ба гаргасан өрийн бичгийг дараагийн тайлант хугацаанд үр ашигт хүүний аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ. Хорогдуулсан өртгийг тухайн гүйлгээтэй холбоотой шууд зардлуудыг харгалзан үзсэн ҮАХ-ийн аргаар тооцно.

Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн аль алиных нь элементүүдийг агуулсан нийлмэл санхүүгийн хэрэгслүүдийн бүрэлдэхүүн хэсгүүдийг, хүлээн зөвшөөрөгдөх өдөр салгана.

Банк нь эдгээр үүсмэл бус санхүүгийн хэрэгслүүдийг бүртгэлд тусгахдаа, эхлээд тухайн хэрэгсэл нь нийлмэл эсэх талаар болон тухайн хэрэгслүүд болон бүрэлдэхүүн хэсгүүдийг НББОУС 32-ын дагуу санхүүгийн өр төлбөр болон хөрөнгө эсвэл өөрийн хөрөнгө гэж ангилна.

Банк нь санхүүгийн хэрэгслийн бүрэлдэхүүн хэсгүүдийг дараах байдлаар хүлээн зөвшөөрнө: (а) Банканд санхүүгийн өр төлбөр болж байвал, (б) Тухайн хэрэгслийг эзэмшигчид, хэрэгслийг Банкны өөрийн хөрөнгийн хэрэгсэлд хөрвөх бололцоо өгч байвал. Хөрвөх хэрэгслийн өр төлбөр болон өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүнүүдийн ангилал нь, тухайн хөрвөх нөхцөл нь зарим нэг эзэмшигчдийн хувьд эдийн засгийн давуу талтай байсан ч хөрвөх нөхцөл нь хэрэгжих эсэх болон түүний өөрчлөгдөх магадлалаас шалтгаалан өөрчлөгддөггүй. Хөрвөх санхүүгийн хэрэгслийн өөрийн хөрөнгө болон өр төлбөрийн бүрэлдэхүүн хэсгүүдийн бүртгэлийн дүнг хуваарилахдаа, өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүний дүн нь тухайн хэрэгслийн нийт бодит үнэ цэнээс өр төлбөрийн бүрэлдэхүүн гэж тусад нь тодорхойлсон дүнг хассанаас үлдсэн дүн байна. Нийлмэл санхүүгийн хэрэгсэлд агуулагдсан өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүнээс (өөрийн хөрөнгийн хөрвөх нөхцөл гэх мэт) бусад аливаа үүсмэл хэрэгслийн үнэ цэнэ нь (худалдан авах опцион гэх мэт) өр төлбөрийн бүрэлдэхүүнд багтана. Банк нь тухайн хэрэгслийн өөрийн хөрөнгө болон өр төлбөрийн бүрэлдэхүүнүүдийг салгах гэж буй бол тухайн өр төлбөрт салгах шаардлагатай агуулагдсан санхүүгийн үүсмэл хэрэгсэл байгаа эсэхийг үнэлнэ. Банк санхүүгийн үүсмэл хэрэгслийг агуулагч гэрээнээс нь зөвхөн доорх нөхцөлд салгаж бүртгэнэ:

- Тухайн санхүүгийн үүсмэл хэрэгслийн эдийн засгийн болон эрсдэлийн шинж чанар нь агуулагч гэрээний эдийн засгийн болон эрсдэлийн шинж чанартай нягт холбоотой биш үед
- Тухайн санхүүгийн үүсмэл хэрэгсэлд ижил нөхцөлтэй тусдаа хэрэгсэл санхүүгийн үүсмэл хэрэгслийн тодорхойлолтыг хангаж буй тохиолдолд
- Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгддэггүй холимог (нэгтгэсэн) хэрэгсэл (жишээ нь, бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрөөс салгаагүй санхүүгийн үүсмэл хэрэгсэл)

4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

Санхүүгийн хэрэгслүүд – анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн хэмжилт (үргэлжлэл)

Харилцагчдын харилцах, хадгаламж

Үүнд харилцагчдаас татсан харилцах, хугацаагүй, хугацаатай хадгаламж болон банкны баталгааны эх үүсвэр хамаарна. Анхны хэмжилтийн дараа үед харилцагчдад өгөх өр төлбөрүүдийг ҮАХ-ийн аргаар хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ.

Бусад санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж

Бусад банк, санхүүгийн байгууллагуудаас татсан төгрөгийн болон валютын хадгаламжууд болон дотоод гадаадын арилжааны банкууд, Монголбанкны хугацаатай хадгаламжууд мөн хамаарна. Банк нь, харилцагчдийн харилцах хадгаламжийг мөнгөн хөрөнгө нь банканд шилжсэн үед хүлээн зөвшөөрдөг. Анхны хэмжилтийн дараа бусад Банкуудад өгөх өр төлбөрийг ҮАХ-ийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ.

Эхний өдрийн олз ба гарз

Ажил гүйлгээний үнэ нь ижил төстэй санхүүгийн хэрэгслүүдийн бусад зах зээл дээрх ашиглагдахуйц бодит үнээс ялгаатай эсвэл зөвхөн нээлттэй зах зээлийн мэдээллийн үнэлгээний аргад суурилсан байвал Банк бодит үнэ цэнэ ба ажил гүйлгээний үнийн зөрүүг нэн даруй ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө (Эхний өдрийн олз ба гарз). Илэрхий нээлттэй мэдээлэлд суурилагүй бол ажил гүйлгээний үнэ болон үнэлгээний загварын зөрүүг орлого орж ирэх нь тодорхой болсон эсвэл санхүүгийн хэрэгслийг үл хүлээн зөвшөөрөх үед бодит үнэ цэнийг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хөрөнгийн дахин ангилал

“Борлуулахад бэлэн” ангиллаас дахин ангилсан санхүүгийн хөрөнгө дээр өмнө нь хүлээн зөвшөөрч, өөрийн хөрөнгөнд бүртгэсэн харгалзах олз гарзыг тухайн хөрөнгө оруулалтын үлдсэн хугацааны туршид ҮАХ-ийн аргаар хорогдуулж, ашиг, алдагдлын тайланд бүртгэнэ. Хэрэв хорогдуулалсан шинэ өртөг ба хүлээгдэж буй мөнгөн урсгал нь ялгаатай бол үүссэн зөрүүг мөн хөрөнгийн үлдсэн хугацааны туршид ҮАХ-ийн аргаар хорогдуулж бүртгэнэ. Тухайн хөрөнгөнд үнэ цэнийн бууралт үүсвэл өмнөх хугацаа эзний өмчид бүртгэсэн дүнг ашиг алдагдлын тайлан руу шилжүүлэн бүртгэнэ.

Хэрэв хөрөнгө нь зээл, авлагын тодорхойлолтод нийцэж байгаа бөгөөд Банк хөрөнгийг ойрын ирээдүйд эсвэл хугацааны эцэс хүртэл нь эзэмших хандлагатай болон чадвартай байгаа бол Банк үүсмэл бус санхүүгийн хөрөнгийг “Арилжааны зориулалттай” гэсэн ангиллаас “Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа” гэсэн ангилалд дахин ангилж болно. Хэрэв санхүүгийн хөрөнгийг дахин ангилсан ба орж ирэх мөнгөний хэмжээ өссөний улмаас Банк ирээдүйд хүлээн авах мөнгөний ойролцоолсон дүнг дараагийн тайлант хугацаанд өсгөсөн бол уг өсөлтийн нөлөөг ойролцоолсон тооцоололд өөрчлөлт оруулсан өдрөөс эхлэн “Үр ашигт хүүний түвшинд хийсэн залруулга” гэж хүлээн зөвшөөрнө.

Хэрэв арилжааны зориулалттай хөрөнгө оруулалтаас материаллаг дүнгээр борлуулсан эсвэл дахин ангилсан(онцгой тохиолдлоос бусад үед) тохиолдолд тухайн хөрөнгө оруулалтыг бүхэлд нь борлуулахад бэлэн хөрөнгө оруулалт руу ангилна.Түүнчлэн Банк нь дараагийн хоёр жилд аливаа нэг санхүүгийн хөрөнгийг “Арилжааны зориулалттай” бүлэгт ангилахыг хориглодог.

Дахин ангилал нь удирдлагын шийдвэрээс хамаарах ба хэрэгсэл тус бүр дээр тодорхойлно. Банк анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа аливаа нэг санхүүгийн хэрэгслийг “Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгдэх” бүлэгт дахин ангилахгүй.

Санхүүгийн хөрөнгө

Дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг (хэрэглэх боломжтой бол, санхүүгийн хөрөнгийн хэсгийг эсвэл хоорондоо төсөөтэй нэг бүлэг санхүүгийн хөрөнгийн хэсгийг) үл хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрхийн хугацаа дууссан бол
- Банк тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрхээ шилжүүлсэн, эсвэл “дамжуулан өнгөрөөх” хэлцлийн дагуу хүлээн авсан мөнгөө нийт дүнгээр нь саатуулалгүйгээр гуравдагч талд төлөх үүрэг хүлээсэн бол
- Банк тухайн хөрөнгийн эрсдэл ба өгөөжийг шилжүүлсэн, эсвэл
- Банк тухайн хөрөнгөтэй холбоотой эрсдэл ба өгөөжийг шилжүүлээгүй болон хадгалж үлдээгүй боловч хөрөнгийн хяналтыг шилжүүлсэн тохиолдолд

4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)**Санхүүгийн хэрэгслүүд – анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн хэмжилт (үргэлжлэл)***Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)*

Банк хөрөнгөөс мөнгө хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл “дамжуулан өнгөрөөх” хэлцэл хийсэн боловч хөрөнгөтэй холбоотой ихэнх эрсдэл, өгөөж болон хяналтыг шилжүүлээгүй тохиолдолд хөрөнгийг Банкны уг хөрөнгөд үргэлжлүүлэн оролцсоор байх хэмжээгээр нь хүлээн зөвшөөрнө. Энэ тохиолдолд Банк холбогдох өр төлбөрийг мөн хүлээн зөвшөөрнө. Шилжүүлсэн хөрөнгө ба холбогдох өр төлбөр Банкны хадгалж үлдсэн эрх, үүргийг тусган харуулсан сууриар хэмжинэ.

Энэхүү үргэлжилсэн оролцоо нь хөрөнгийн баталгаа хэлбэртэй байвал үүнийг тус хөрөнгийн анхны бүртгэлийн дүн ба Банкны төлөх шаардлагатай болох хамгийн их дүнгийн аль багаар хэмжинэ.

Санхүүгийн өр төлбөр

Санхүүгийн өр төлбөрийг төлөхөөс чөлөөлөгдсөн, өр төлбөр цуцлагдсан эсвэл хугацаа нь дууссан бол үл хүлээн зөвшөөрдөг. Хэрэв одоо байгаа санхүүгийн өр төлбөрийн зээлдүүлэгч нь хэвээрээ боловч ялгаатай нөхцөлтэй зээлийн гэрээгээр сольсон эсвэл одоо байгаа зээлийн нөхцөл эрс өөрчлөгдсөн бол эдгээр өөрчлөлт шинэчлэлтийг анхны санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт ба шинэ өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт гэж үзнэ. Анхны санхүүгийн өр төлбөрийн бүртгэлийн дүн ба төлсөн дүн хоёрын зөрүүг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

Хейджийн бүртгэл

Банк нь өр төлбөр (олон улсын зах зээлд гадаад валютаар гаргасан өрийн бичиг)-өөс хүлээгдэж буй гарах мөнгөн урсгалын тодорхой эрсдлээс хамгаалах зорилгоор хейджийн хэрэгсэл буюу санхүүгийн үүсмэл хэрэгсэл (урт хугацаат валютын своп хэлцэл)-ийн хэлцэл хийдэг

Хүлээн зөвшөөрсөн хөрөнгө эсвэл өр төлбөр болон ирээдүйд гарах магадлал өндөр гүйлгээтэй холбоотой мөнгөн гүйлгээ өөрчлөгдөж ашиг алдагдалд нөлөөлөх эрсдэлээс хамгаалах зорилгоор хейдж хийхийг мөнгөн гүйлгээний хейдж гэнэ. Үүсмэл хэрэгслийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн үр өгөөжтэй хэсэг нь бусад дэлгэрэнгүй орлогод мөнгөн гүйлгээний хейдж гэж бүртгэгдэж, өөрийн хөрөнгийн нөөц хэсэгт хуримтлагдана. Бодит үнэ цэнийн үр өгөөжгүй хэсэгтэй хамааралтай олз, гарз нь бусад дэлгэрэнгүй орлогоор дамжин тайлант жилийн ашиг, алдагдалд бүртгэгдэнэ. Хейджийн хэрэгслийн хугацаа дууссан, худалдсан эсвэл хэрэгжүүлсэн эсвэл тухайн хейдж нь хейджийн шалгуурыг хангахаа больсон тохиолдолд, бусад дэлгэрэнгүй орлогод хуримтлагдсан олз гарз нь тайлант жилийн ашиг, алдагдал руу бүртгэх ба хейджийн бүртгэлийг үргэлжлүүлэн ашиглахгүй. Хейджийн бүртгэлийг ирээдүйд хэрэгжих гүйлгээнд ашиглахаа зогсоосон бол тухайн гүйлгээ ирээдүйд хэрэгжиж ашиг, алдагдалд нөлөөлөх үеэр буюу хейджийн хэрэгслийн үр ашигт хэсгийг өөрийн хөрөнгөөс ашиг, алдагдал руу дахин ангилах үед бусад дэлгэрэнгүй орлогын хэсэгт нь өмнө бүртгэгдсэн дүнг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Хэрэв ирээдүйд хэрэгжихээр хүлээгдэж байсан гүйлгээ хэрэгжихгүй байх магадлалтай болвол бусад дэлгэрэнгүй орлогын хэсэгт бүртгэсэн дүнг ашиг, алдагдал руу дахин ангилж, тохируулга бичилт хийнэ.

Буцаан худалдан авах ба урвуу буцаан худалдан авах хэлцлүүд

Ирээдүйд тодорхой заасан хугацаанд буцаан худалдан авах нөхцөлтэй хэлцэл (“репо”)-ийн дор худалдсан үнэт цаасыг санхүүгийн байдлын тайлангаас үл хүлээн зөвшөөрөхгүй. Учир нь Банк эзэмшилтэй холбоотой ихэнхи эрсдэлийг хүлээж, өгөөжийг хүртэж байна. Санхүүгийн байдлын тайланд хүлээн авсан бэлэн мөнгийг хөрөнгөөр, репо хэлцлийн хуримтлагдсан хүүг өр төлбөрөөр тусгах ба энэ нь банканд олгосон зээл гэсэн эдийн засгийн утга агуулгыг илэрхийлнэ. Борлуулсан ба ирээдүйд буцаан худалдан авах үнийн зөрүүг хүүний зардал гэж үзэж үр ашигт хүүний аргыг ашиглан гэрээний хугацааны турш хуримтлуулна. Нөгөө тал нь үнэт цаасыг худалдах эсвэл дахин барьцаалах эрхтэй бол, Банк нь тухайн үнэт цаасуудыг санхүүгийн байдлын тайландаа борлуулахад бэлэн барьцаанд тавьсан санхүүгийн хөрөнгө эсвэл борлуулахад бэлэн барьцаанд тавьсан санхүүгийн хөрөнгө оруулалтын аль тохиромжтой ангилалд үлдээнэ.

Эсрэгээрээ, буцаан худалдах хэлцэл (“урвуу репо”)-ийн дагуу худалдан авсан үнэт цааснуудыг санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрдөггүй. Банкны төлсөн мөнгө ба хуримтлагдсан хүүний дүнг санхүүгийн тайланд “Зээлсэн үнэт цаас ба урвуу буцаан худалдан авах хэлцлүүдийн бэлэн мөнгөөрх барьцаа” гэж тусгах ба энэ нь Банкнаас авсан зээл гэсэн эдийн засгийн утга агуулгыг илэрхийлнэ. Худалдан авсан ба буцаан худалдах үнийн зөрүүг “Хүү болон түүнтэй адилтгах орлого” гэж бүртгэх ба ҮАХ-ийн аргыг ашиглан гэрээний хугацааны турш хуримтлуулна.

4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)**Бодит үнэ цэнийн тодорхойлолт**

Бодит үнэ цэнэ гэдэг нь хэмжилт хийсэн өдрийн зах зээлд оролцогчдын хооронд хийсэн дэс дараалалтай гүйлгээний үр дүнд борлуулснаас орж ирэх мөнгөн дүн болон өр төлбөрт шилжүүлсэн мөнгөн дүн юм. Бодит үнэ цэнийн хэмжилт нь дараах зах зээл дээр хөрөнгийг борлуулсан эсвэл өр төлбөрийг шилжүүлсэн гүйлгээний дүнгээр тодорхойлно. Үүнд:

- Хөрөнгө ба өр төлбөрийн үндсэн зах зээлд, эсвэл
- Үндсэн зах зээл байхгүй тохиолдолд, хөрөнгө ба өр төлбөрийн хувьд хамгийн ашигтай зах зээлд

Үндсэн болон хамгийн ашигтай зах зээл нь Банкны хувьд оролцож болохуйц зах зээлүүд байх ёстой.

Хөрөнгө ба өр төлбөрийн бодит үнэ цэнийг хэмжихэд ашигласан үнэ нь зах зээлд оролцогчид нь хөрөнгө ба өр төлбөрийн эдийн засгийн хамгийн өндөр үр өгөөжийг хүртэнэ гэсэн төсөөлөл дээр үндэслэдэг.

Санхүүгийн бус хөрөнгийн бодит үнэ цэнийн хэмжилтийг, тухайн зах зээлд оролцогч тал нь хөрөнгийг ашигласнаар хамгийн өндөр эдийн засгийн үр өгөөжийг хүртэж чадаж байх эсвэл уг хөрөнгийг борлуулснаар худалдан авсан талд уг хөрөнгийг ашигласнаар хамгийн өндөр эдийн засгийн үр өгөөжийг өгч байх, нөхцөлд тооцно.

Банк нь бодит үнэ цэнэ тооцоход шаардлагатай мэдээллүүд нь хангалттай олдочтой үед үнэлгээний техникүүдийг хэрэглэх нь тохиромжтой байдаг ба ажиглагдахуйц өгөгдлийн хэрэглээг нэмэгдүүлж, үл ажиглагдахуйц өгөгдлийн хэрэглээг хамгийн бага түвшинд байлгадаг.

Бодит үнэ цэнээрээ хэмжигдэж, санхүүгийн тайланд тайлагнаж байгаа бүх хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлох, толилуулахдаа дараах түвшнийг хэрэглэдэг.

Түвшин 1 - хөрөнгө, өр төлбөрийн хувьд хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй (залруулаагүй), идэвхитэй зах зээл дээрх үнэ,

Түвшин 2 - бүртгэсэн бодит үнэ цэнэд томоохон нөлөө үзүүлэх бүх өгөгдлүүдийг нь шууд болон шууд бусаар ажиглах боломжтой бусад техникүүд,

Түвшин 3 - бүртгэлд бүртгэгдсэн бодит үнэ цэнэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг, зах зээл дээр ажиглагддаг мэдээлэл ашигладаггүй аргачлалууд.

Банк нь санхүүгийн тайлант хугацааны эцэс бүрт санхүүгийн тайландаа хүлээн зөвшөөрсөн бүх хөрөнгө ба өр төлбөрийн хувьд түвшин хооронд хөдөлгөөн гарсан эсэхийг дахин нягталж үздэг (бодит үнэ цэнийн хэмжилтэнд нөлөөлөхүйц хамгийн бага түвшний өгөгдөлд үндэслэн).

Санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнийн шинжилгээ болон бусад шаардлагатай мэдээллийг Тодруулга 36-д тусгасан.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Банк нь санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгө нь үнэ цэнийн бууралтад орсныг нотлох бодит нотолгоо байгаа эсэхийг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр үнэлж үзнэ.

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааг харгалзах эрсдэлийн сангаар нь бууруулсан дүнгээр толилуулна. Банк нь зээл ба урьдчилгаанд үүссэн үнэ цэнийн бууралтыг Монгол банкны журмын дагуу давтамжтайгаар хянадаг ба хэрэв үнэ цэнийн бууралт бий болсон бодит нотолгоо үүсвэл зээл ба урьдчилгааны дансны үнийг нөхөгдөх дүн хүртэл бууруулж, харгалзах эрсдэлийн санг байгуулдаг. Эрсдэлийн сангийн нэмж байгуулахдаа ашиг алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө. Тухайн зээлийг зээлдэгч нь бүрэн барагдуулах боломжгүй болох нь тодорхой болсон тохиолдолд шаардлагатай бүх хууль зүйн арга хэмжээг авч эцсийн алдагдлыг тодорхойлсны дараа тухайн зээлийг данснаас хасдаг. Хэрэв зохицуулагч байгууллагын шаардлагын дагуу нэмэлтээр эрсдэлийн сан байгуулах бол эзний өмч руу шууд тохируулга хийж бүртгэнэ.

Банк нь Монголбанкны эрсдэлийн сан байгуулах журмын дагуу зээлийн авлагыг хугацааны ба чанарын үзүүлэлтэд үндэслэн харгалзах ангилал ба эрсдэлийн сангийн хувийг тус тус тодорхойлдог. Уг журмын дагуу тухайн зээл ба урьдчилгаа нь аль ангилалд хамаарагдаж байгаагаас хамааран хэвийн, анхаарал хандуулах, хэвийн бус, эргэлзээтэй ба муу гэсэн ангилал тус бүрт харгалзах 0.5%, 1%-с 5%, 5%-с 25%, 15%-с 50% and 50%-с 100% -ийн эрсдэлийн сангийн хувиудаар эрсдэлийн санг бүртгэдэг. Хадгаламж барьцаалсан зээл ба овернайт зээлүүдэд эрсдэлийн сан байгуулдаггүй.

Зээлийн ангиллалыг тогтооход ашиглагдах чанарын үзүүлэлтийн шинжилгээнд зээлийн хувийн хэргийн бүрэн байдал, эдийн засгийн нөхцөл байдал, зээлдэгчийн санхүүгийн үзүүлэлтүүд, барьцаа хөрөнгийн үнэлгээ ба зээлийн бүтцэд орсон өөрчлөлтүүдийг авч үздэг. Түүнчлэн Банк нь Монголбанкны эрсдэлийн сангийн журмын дагуу тэнцлийн гадуурх хөрөнгө ба болзошгүй өр төлбөрийн ангиллыг тухайн үүрэг хүлээгч талд хийсэн чанарын шинжилгээний үр дүнд үндэслэн тогтоож мөн харгалзах эрсдэлийн санг байгуулах үүрэгтэй.

4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)**Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)**

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа (үргэлжлэл)

Монголбанкны тэнцлийн гадуурх хөрөнгө ба болзошгүй өр төлбөрийн сан байгуулах журамд хугацааны үзүүлэлтээс хамааруулан тохирох эрсдэлийн санг тодорхойлохыг тусгасан байдаг. Үүнд тухайн тэнцлийн гадуурх хөрөнгө ба болзошгүй өр төлбөрийн хэрэгжих хугацаа нь 1 жилээс доош бол хэвийн, анхаарал хандуулах, хэвийн бус, эргэлзээтэй ба муу гэсэн ангиллыг тогтоох ба эрсдэлийн хувиуд нь ангилал тус бүрт харгалзан 0%, 5%, 25%, 50%, 100% тус тус байна. Хэрэв хэрэгжих хугацаа нь 1 жилээс дээш бол Банк нь анхаарал хандуулах, хэвийн бус, эргэлзээтэй, муу гэсэн ангиллуудаар үнэлэх ба ангилалт тус бүрт харгалзах 0%, 1%, 15%, 35%, 75% хувиудаар эрсдэлийн сан байгуулна.

Хэрэв тайлангийн дараах үйл явдлаас хамааран үнэ цэнийн бууралтын алдагдал буурах магадлалтай бол аливаа бууралтын дүнгээр эрсдэлийн санг буцааж ашиг алдаглын тайланд хүлээн зөвшөөрнө.

Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгүүд

Банк нь “Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалт”-ын үнэ цэнийн бууралтанд орсон эсэхийг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр үнэлж үздэг. Борлуулахад бэлэн гэж ангилагдсан өрийн үнэт цааснуудын хувьд Банк нь үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байгаа эсэхийг нэг бүрчлэн шалгана:

Банкны бүх мөнгөн гүйлгээгээ эргэн авах чадварт нөлөөлөх тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгал эсвэл суурь барьцаа (хөрөнгө барьцаалсан үнэт цаасны хувьд, Банк нь төлөгдөөгүй үлдэгдлийг үндсэн барьцаанаас төлүүлнэ гэж үзэж буй тохиолдолд)-нд хэмжиж болохуйц бууралт байгааг харуулсан бодит өгөгдөл бий болсон эсэхийг үнэлнэ. Үнэ цэнийн бууралтаар бүртгэгдэх дүн нь худалдан авалт ба өнөөгийн бодит үнэ цэнэ хоёрын зөрүүнээс орлогын тайланд өмнө нь хүлээн зөвшөөрсөн байсан тухайн хөрөнгө оруулалттай холбоотой үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр хэмжигдэх хуримтлагдсан алдагдлын дүн байна.

Бүртгэлийн бууруулсан дүн дээр хүүний орлогыг үргэлжлүүлэн хуримтлуулах ба үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжих зорилгоор ирээдүйн мөнгөн урсгалыг бууруулахад ашигласан хүүг ашиглан хуримтлуулна. Хүүний орлогыг “Хүү ба түүнтэй адилтгах орлого”-ын нэг хэсэг болгон бүртгэнэ. Хэрэв дараагийн тайлант хугацаанд орлогын тайланд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараах зээлийн үйл явдлын улмаас өрийн хэрэгслийн бодит үнэ цэнэ өсөж эсвэл буурвал, үнэ цэнийн бууралтын алдагдлыг орлогын тайлангаар дамжуулан буцаана.

“Борлуулахад бэлэн” гэж ангилагдсан өмчийн үнэт цааснууды хувьд, бодит нотолгоонд доорх багтана:

- Тухайн хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэ нь өртгийн дүнтэй харьцуулахад буурсан ба энэ нь ‘мэдэгдэхүйц’ болон ‘урт хугацаанд үргэлжлэхүйц’ байгаа эсвэл,
- Өмчийн үнэт цаасыг гаргагчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхүйц бусад мэдээллүүд

Банк нь бодит үнэ цэнийн бууралтыг 20%-д хүрсэн тохиолдолд “мэдэгдэхүйц”, бодит үнэ цэнийн бууралт нь 6-с дээш сар үргэлжилсэн тохиололд “урт хугацаанд үргэлжлэхүйц” гэж тус тус тодорхойлдог.

Үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байгаа тохиолдолд хуримтлагдсан алдагдал (худалдан авалт ба өнөөгийн бодит үнэ цэнэ хоёрын зөрүүнээс орлогын тайланд өмнө нь хүлээн зөвшөөрсөн байсан тухайн хөрөнгө оруулалттай холбоотой үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр хэмжигдэх)-ыг өөрийн хөрөнгөөс хасч дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө. Өмчийн үнэт цаасны үнэ цэнэ бууралтын алдагдлын буцаалтыг орлогын тайлангаар дамжуулдаггүй, үнэ цэнийн бууралтын дараах бодит үнийн өсөлтийг дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана.

Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө

Банк нь дотоод бодлогынхоо дагуу тухайн өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийг банкны үйл ажиллагаанд ашиглах эсвэл борлуулах зорилгоор эзэмшихээ тодорхойлдог. Тухайн хөрөнгийн ангилал нь банкны гол үндсэн хөрөнгүүдтэй нийцсэн мөн өртөг нь зах зээлтэй харьцуулахад бага эсвэл одоогийн дансны үнэ нь анхны барьцааны үнээс бага байгаа тохиолдолд банкны үйл ажиллагаанд ашиглах нь ашигтай гэж үздэг. Банк нь Монголбанкны эрсдэлийн сангийн журам болон дотоод бодлогынхоо дагуу тухайн өмчлөх бусад хөрөнгийг ирээдүйд зарж борлуулах зорилгоор эзэмшинэ гэж тодорхойлсон бол тухайн хөрөнгийг өмчилсөн өдрөөрх бодит үнэ цэнээс тухайн санхүүгийн бус хөрөнгийн борлуулалтын өртгийг хассан дүнгээр “Борлуулах зориулалттай хөрөнгө”-ийн ангилал руу бүртгэнэ.

Орлого ба зардал хүлээн зөвшөөрөлт

Эдийн засгийн өгөөж нь банканд орж ирэх нь тодорхой болсон хэмжээгээр, найдвартайгаар хэмжиж болох үед орлогыг хүлээн зөвшөөрнө. Орлогыг хүлээн зөвшөөрөхөөс өмнө дараах тусгай шалгуурууд хангагдсан байх ёстой. Үүнд:

4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)**Орлого ба зардал хүлээн зөвшөөрөлт (үргэлжлэл)***Хүүгийн орлого ба зарлага*

Хорогдуулсан өртгөөр нь хэмждэг бүх санхүүгийн хэрэгслүүдийн, хүүний орлого, зардлыг ҮАХ-ийн хувийг (ирээдүйд төлөх эсвэл хүлээн авах мөнгөн урсгалын ойролцоолон тооцоолсон дүнг санхүүгийн хэрэгслүүдийн хүлээгдэж буй хугацаа эсвэл түүнээс богино хугацааны туршид санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бүртгэлийн цэвэр дүнрүү нь бууруулах хүү) ашиглан бүртгэнэ. Тооцоололд санхүүгийн хэрэгслийн гэрээний бүх нөхцлүүдийг (жишээ нь: урьдчилгаа төлбөрийн хувилбарууд) харгалзан үзсэн ба тухайн хэрэгсэлд шууд хамааралтай ба зээлийн ирээдүйн алдагдал биш харин ҮАХ-ийн салшгүй нэг хэсэг болж байгаа аливаа төлбөр эсвэл өсөн нэмэгдэх зардлуудыг багтаасан. Санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөрийн дансны үнэ нь төлөлт болон цуглуулалтын тооцоолол өөрчлөгдөхөд залруулагддаг.

Залруулсан дансны үнийг анхны ҮАХ-г ашиглан тооцоолох ба дансны үнэд гарсан өөрчлөлтийн нөлөөллийг ашиг, алдагдлаар бүртгэнэ. Гэхдээ, бүртгэсний дараагаар мөнгөний нөхөн төлөлт нэмэгдсэнээс үүдэн ирээдүйн мөнгөн урсгалын төлөлтийн үнэлгээг нэмэгдүүлэн дахин ангилсан санхүүгийн хөрөнгийн хувьд, уг нөлөөллийг үнэлгээ өөрчлөгдөх өдрөөс ҮАХ-ийн залруулгаар бүртгэнэ.

Хураамж ба шимтгэлийн орлого

Банк нь өөрийн харилцагч нарт үзүүлдэг төрөл бүрийн үйлчилгээнээс хураамж, шимтгэлийн орлого олдог. Банк нь харилцагчдад үйлчилгээ үзүүлэх үед харгалзах хураамж болон шимтгэлийн орлогыг хүлээн зөвшөөрнө. Аливаа үйлчилгээний гэрээ эхэлсэн өдрөөр банкны гүйцэтгэх үүрэг болон үйлчилгээний хугацаа тодорхойлогдож, хэрэгжиж эхэлнэ. Банкны борлуулалтын гэрээ нь олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээнээс бүрддэггүй ба дэлгэрэнгүй мэдээллийг дор тусгав.

Банк харилцагчлал үйлчилгээг үзүүлсэн тухай бүр эсвэл гэрээний хугацааны төгсгөлд буюу үйлчилгээг бүрэн үзүүлсэн тохиолдолд (доор өөрөөр заагаагүй бол) төлбөрийн дүнг нэхэмжилдэг. Банк нь харилцагчдад үйлчилгээг бүрэн үзүүлж дуусах хүртэл тухайн үйлчилгээний процессыг бүрэн хариуцдаг тул борлуулалт хийх, төлбөр хүлээн авах үйл явцыг дээрх байдлаар зохион байгуулж, ажилладаг.

Гэрээт хугацаацаагаар үзүүлж буй үйлчилгээний хураамжийн орлого

Гэрээт хугацааны туршид үйлчилгээг үзүүлж олох орлогыг тэр хугацааны туршид нь хуримтлуулна. Үүнд шимтгэлийн орлого, хөрөнгийн зохицуулалт, кастодиан, бусад зохицуулалт болон зөвлөх үйлчилгээний хураамжууд багтана.

Гүйлгээний үйлчилгээний хураамжийн орлого

Гуравдагч талтай гүйлгээний талаар хэлэлцээр хийх эсвэл гүйлгээнд оролцохтой холбоотойгоор үүссэн хураамжууд (хувьцаа эсвэл бусад үнэт цаасыг худалдан авах, бизнес худалдан авах, худалдах зохицуулалт гэх мэт)-ыг холбогдох гүйлгээ дууссан үед хүлээн зөвшөөрнө. Тодорхой нэг гүйцэтгэлтэй уягдсан хураамж эсвэл хураамжийн бүрэлдэхүүн хэсгийг холбогдох шалгуурууд хангагдсаны дараа хүлээн зөвшөөрнө.

Холбогдох санхүүгийн хэрэгслийн салшгүй хэсэг бүхий хураамжийн орлого

Үүнд зээл олголтын шимтгэлийн орлого, зээлийн батлан даалтын хураамж болон бусад зээлийн үйлчилгээтэй холбогдон гардаг хураамжийн орлогууд багтана. Холбогдох санхүүгийн хэрэгслийн салшгүй хэсэг болдог эдгээрийн хураамжийн орлого (өсөн нэмэгдэх өртгийн хамт)-ыг ҮАХ-ээр тохируулга хийж хүүгийн орлогоор хүлээн зөвшөөрнө. Хэрэв зээлийн баталгаа, батлан даалтын үйлчилгээ нь цуцлагдвал хүлээн авсан холбогдох хураамжийн орлогыг дуусгавар болсон өдрөөр шууд орлогоор бүртгэнэ.

Хураамж ба шимтгэлийн зардал

Хураамж ба шимтгэлийн зардалд бусад арилжааны банкуудад төлсөн тогтмол дүнтэй хураамжийн болон удирдлагын зардлууд багтана. Хураамжийн зардал нь бодит үйлчилгээ авсаны үр дүнд хүлээн зөвшөөрөгддөг.

Тодорхой үр дүнд үндэслэн хүлээн зөвшөөрдөг хураамжийн бүрдэл хэсгүүдийг гэрээний дагуу шаардлага хангасны дараагаар хүлээн зөвшөөрдөг.

Бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Санхүүгийн байдлын тайланд тусгасан бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгүүд нь 3 сар ба түүнээс бага хугацаатай бусад банк санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж болон касс дахь бэлэн мөнгө зэрэг үнэ цэнийн буралтын эрсдэл маш бага хөрөнгүүд хамаарна.

Мөнгөн гүйлгээний тайлан дахь бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нь Монголбанкн дахь хязгаарлалтгүй харилцах данс, 3 сар ба түүнээс богино хугацаатай засгын газрын үнэт цаас, бусад банкин дахь харилцах, хадгаламжуудаас бүрдэнэ.

4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)**Үндсэн хөрөнгө**

Барилга байгууламж ба газраас бусад үндсэн хөрөнгийг анхлан өртгөөр бүртгэнэ. Анхны өртөгт тухайн үндсэн хөрөнгийн зайлшгүй хэсгийг шинээр солих зэрэг шууд хамааралтай зардлууд орох ба хүлээн зөвшөөрөлтийн шаардлагыг хангаж байгаа тохиолдолд өртөгт шингэнэ. Хэрэв тухайн үндсэн хөрөнгө зарим зайлшгүй хэсгийг тогтмол хугацаагаар сольж байршуулах шаардлага үүсдэг бол Банк нь тухайн хэсгийг үндсэн хөрөнгөөс тусад нь болон харгалзах ашиглалтын хугацаа ба элэгдүүлэх аргыг тодорхойлж хүлээн зөвшөөрнө. Үндсэн хөрөнгийн анх бүртгэхэд шууд холбогдон гарсан хяналт шалгалтын зардал нь үндсэн хөрөнгөөр бүртгэх шаардлагыг хангаж байгаа тохиолдолд өртөгт шингээж бүртгэнэ. Бүх төрлийн засвар үйлчилгээний зардлыг ашиг алдагдлаар бүртгэнэ.

Анхны хэмжилтээс хойших тайлант үед барилга болон газраас бусад үндсэн хөрөнгийн ангиллууд нь хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан өртгөөр илэрхийлдэг.

Барилга байгууламж ба газар нь бодит үнэ цэнээр хэмжигдэнэ. Үнэлгээг 3-5 жилийн давтамжтайгаар хийнэ. Дахин үнэлэгдэх өдрүүдийн хооронд, барилгуудад үнийн бууралтийг илэрхийлэхүйц хэмжээнд элэгдэл тооцно. Дахин үнэлгээний нэмэгдлийг (өмнө нь ашиг, алдагдлын тайланд тусгасан дахин үнэлгээний алдагдлыг буцааж буй тохиолдолд, уг хэсгийг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө) бусад дэлгэрэнгүй орлогын тайлангаар дамжуулан "Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөөц" нэртэйгээр өөрийн хөрөнгийн хэсэгт хуримтлуулна.

Хөрөнгийн дахин үнэлгээний дүн болон хөрөнгийн анхны өртөг дээр суурилсан элэгдлүүдээс үүссэн зөрүүг жил бүр хөрөнгийн дахин үнэлгээний нөөцөөс хуримтлагдсан ашиг руу шилжүүлнэ. Мөн дахин үнэлгээний өдрийн байдлаарх хуримтлагдсан элэгдлийг хөрөнгийн бүртгэлийн нийт дүнтэй цэвэршүүлж, бүртгэлийн дүнг дахин үнэлгээний дүнгээр дахин илэрхийлнэ. Борлуулах эсвэл данснаас хасах тохиолдолд тухайн хөрөнгөтэй холбоотой дахин үнэлгээний нөөцийг хуримтлагдсан ашиг руу шилжүүлнэ.

Дуусаагүй барилгыг барилгын тоног төхөөрөмжийн өртөг болон бусад зардлаас үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр илэрхийлнэ. Дуусаагүй барилгыг тухайн хөрөнгө баригдаж дууссан эсвэл үйл ажиллагаанд ашиглаж эхэлтэл элэгдүүлдэггүй.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг тухайн хөрөнгийн ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргаар тооцож үлдэх өртөг хүртэл дараах хугацаагаар элэгдүүлнэ:

<u>Хөрөнгийн төрөл</u>	<u>Ашиглалтын хугацаа (жилээр)</u>
Барилга байгууламж ба газар	25 – 60
Оффисын тавилга ба тоног төхөөрөмж	3 – 15
Компьютер ба бусад	2 – 13

Үндсэн хөрөнгө ба түүний томоохон хэсгүүдийг худалдан борлуулах үед эсвэл түүний ашиглалт, борлуулалтаас ирээдүйд эдийн засгийн үр ашиг хүлээгдэхгүй болсон үед данснаас хасна. Үүнтэй холбоотойгоор үүссэн аливаа нэг олз, гарзыг (хөрөнгө борлуулалтын цэвэр орлого ба бүртгэлийн дүн хоёрын зөрүүгээр тооцно) тухайн тайлант жилийн ашиг, алдагдлын тайланд тусгана.

Үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн арга нь өмнө хийгдсэн тооцоолол ба үндсэн хөрөнгөд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн үр ашгийн хүлээгдэж буй хэрэглээний хэв загварт нийцэж байгаа гэдгийг баталгаажуулах үүднээс үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн аргыг тайлант жилийн эцэс бүрт хянаж үздэг.

Хувь хүн болон албан байгууллагуудаас худалдан авсан газар ашиглах зөвшөөрлүүдийг анхлан бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрдөг. Банк жил бүр Засгийн газарт, газар ашиглах зөвшөөрлийн төлбөр төлдөг бөгөөд тэр нь материаллаг бус хэмжээтэй юм. Монгол улсын газрын тухайн хууль нь 2003 оны 1 сарын 1-нээс эхлэн хэрэгжиж эхэлсэн ба уг хуульд монгол улсын аж ахуйн нэгжүүдийн газар эзэмших эрхийн талаар зүйлчилж өгсөн.

Газар ашиглах зөвшөөрлийг дахин шинэчлэх үйл явц, дахин шинэчлэх төлбөрийн дүн болон жил бүрийн төлбөрийн дүнгийн бага хэмжээтэй байдал зэрэг нь эдгээр газар ашиглах зөвшөөрлүүдэд хорогдол тооцохгүй гэсэн дүгнэлтэд хүргэж байгаа юм.

Түрээс

Банк нь гэрээ байгуулагдах үед түрээсийн шинж чанар агуулсан эсэхийг үнэлдэг. Өөрөөр хэлбэл гэрээнд тодорхойлогдож байгаа хөрөнгийг хэсэг хугацааны турш ашиглан хянах эрхийг шилжүүлсэн болно.

Банк - түрээслэгч

Банк нь богино хугацаатай түрээс эсвэл бага өртөгтэй хөрөнгийг түрээслэхээс бусад тохиолдолд бүх түрээсийг хүлээн зөвшөөрөх, хэмжих нэг аргыг ашигладаг. Банк нь түрээсийг төлөх түрээсийн өр төлбөрийг болон хөрөнгийг ашиглах эрхийг хүлээн зөвшөөрдөг.

4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)**Түрээс (үргэлжлэл)***Ашиглах эрхтэй хөрөнгө*

Банк нь ашиглах эрхтэй хөрөнгийг түрээсийн өдрөөс эхлэн хүлээн зөвшөөрдөг (жишээлбэл, үндсэн хөрөнгийг ашиглах боломжтой болсон өдөр). Ашиглах эрхтэй хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл, үнэ цэнийн бууралтын алдагдлыг хасч өртгөөр нь хэмжиж, түрээсийн өр төлбөрийг дахин үнэлэхэд тохируулна. Ашиглах эрхтэй хөрөнгийн өртөгт түрээсийн өр төлбөр, хүлээн авсан түрээсийн эхний өртөг, түрээсийн урамшууллыг авалгүйгээр эхлэхээс өмнө хийсэн түрээсийн төлбөрүүд орно. Ашиглах эрхтэй хөрөнгийг түрээсийн хугацаанд шулуун шугамын аргаар элэгдүүлнэ. Ашиглах эрхтэй хөрөнгөд үнэ цэнийн бууралт тооцно.

Түрээсийн өглөг

Түрээсийн эхлэх өдөр Банк нь түрээсийн нийт хугацааны туршид хийгдэх түрээсийн төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнээр хэмжсэн түрээсийн өглөгийн хүлээн зөвшөөрнө. Түрээсийн төлбөрт тогтмол төлбөр (түрээсийн урамшууллыг аваагүй), индекс эсвэл хувь хэмжээнээс хамааран хувьсах түрээсийн төлбөрүүд, үлдэгдэл үнийн баталгааны дагуу төлөх хүлээгдэж буй төлбөрүүд орно. Индекс эсвэл хувь хэмжээнээс хамааралгүй хувьсах түрээсийн төлбөрийн тайлант үеийн зардал гэж хүлээн зөвшөөрнө.

Түрээсийн хүүгийн хэмжээг тодорхойлох боломжгүй тохиолдолд Банк нь түрээс эхлэх үеийн зээлийн өсөн нэмэгдэх хүүг ашиглан түрээсийн өр төлбөрийн өнөөгийн үнэ цэнийг тооцоолно. Түрээс эхэлсэн өдрөөс хойш түрээсийн өр төлбөрийг хуримтлагдсан хүүгээр нэмэгдүүлж, төлсөн түрээсийн төлбөрөөр бууруулдаг. Мөн түүнчлэн түрээсийн хугацаанд өөрчлөлт оруулаг, тогтмол төлбөрийн шинж чанарт өөрчлөлт оруулах эсвэл уг хөрөнгийг худалдаж авах үнэлгээнд өөрчлөлт оруулах зэрэг өөрчлөлтүүд гарсан тохиолдолд түрээсийн өр төлбөрийн дүнг дахин тооцоолно.

Богино хугацаат түрээсүүд

Банк нь зарим богино хугацааны оффисын түрээсийн (12 сар болон түүнээс бага хугацаатай түрээс эсвэл эсвэл АТМ-ийн талбайн түрээсгэх мэт) хувьд хүлээн зөвшөөрөлтийн чөлөөлтийг ашигласан. Богино хугацаат түрээсийн төлбөрийг түрээсийн хугацааны туршид шулуун шугамын аргаар зардалд хүлээн зөвшөөрнө.

Түрээсийн гэрээг шинэчлэх, цуцлах сонгол бүхий түрээсийн гэрээний хугацааг тодорхойлох

Банк нь түрээсийн үл цуцлагдах хугацааг тодорхойлохдоо тухайн түрээсийг үргэлжлүүлэн түрээслэх нь тодорхой үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд сунгагдах хугацаа эсвэл тухайн үргэлжлүүлэн түрээслэх нь үндэслэлгүй гэж үзсэн тохиолдолд цуцлах хугацааг оруулна тооцно.

Банк нь тухайн түрээсийн гэрээг дахин сунгагдах үндэслэлийг тодорхойлоход тодорхой үнэлэмжийг ашигласан. Өөрөөр хэлбэл тухайн түрээсийг сунгах эсвэл цуцлах сонголтыг хэрэгжүүлэхэд нөлөөлөх эдийн засгийн хөшүүргийг бий болгох бүхий л хүчин зүйлийг авч үзсэн. Түрээс эхэлсэн өдрөөс хойш Банкны өөрийн хянаж чадах үйл явдал, нөхцөл байдал болон сунгах (эсвэл цуцлах) сонголтыг хэрэгжүүлэх чадварт өөрчлөлт орсон тохиолдолд түрээсийн хугацааг дахин үнэлнэ.

Банк нь салбарын үйл ажиллагаанд нь өндөр ач холбогдолтой түрээсийн талбайн сунгах хугацааг түрээслэх хугацааны нэг хэсэг болгон шинэчилсэн хугацааг оруулсан.

Биет бус хөрөнгө

Банкны биет бус хөрөнгөд компьютерийн програм хангамж, лиценз болон газар ашиглах эрх орно.

Зөвхөн биет бус хөрөнгийн өртгийг зохистойгоор хэмжиж болох ба хүлээгдэж буй эдийн засгийн ирээдүйн өгөөж нь банканд орж ирэх нь магадлалтай болсон үед л биет бус хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.

Тусад нь авсан биет бус хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь бүртгэдэг. Анх хүлээн зөвшөөрснөөс хойших тайлант үед, биет бус хөрөнгийг хуримтлагдсан хорогдуулалт болон үнэ цэнэ бууралтын алдагдлыг хассан бүртгэнэ.

Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа нь тодорхой эсвэл тодорхой бус эсэхийг үнэлнэ. Ашиглалтын тодорхой хугацаатай биет бус хөрөнгийг эдийн засгийн үр ашигтай хугацааны туршид нь хорогдуулна. Ашиглалтын тодорхой хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулах хугацаа болон аргыг хамгийн багадаа тайлант жил бүрийн эцэст хянаж үздэг. Хүлээгдэж буй ашиглалтын хугацаа эсвэл хүлээгдэж буй ирээдүйн үр өгөөжийн хэв загварт орсон өөрчлөлтийг хорогдуулалтын хугацаа эсвэл аргын аль тохиромжтойг нь өөрчлөх замаар бүртгэлд тусгах ба уг өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт гэж үзнэ.

Хязгаарлагдмал хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулалтын зардлыг ашиг, алдагдлын тайланд биет бус хөрөнгийн үүрэгтэй нь нийцсэн зардлын бүлэгт хүлээн зөвшөөрнө. Биет бус хөрөнгийн өртгийг 3-10 жилийн ашиглалтын хугацааны туршид, шулуун шугамын аргыг ашиглан, үлдэх өртөг хүртэл нь хорогдуулна.

4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)**Хөрөнгө оруулалтын зориулалттай үндсэн хөрөнгө**

Хөрөнгө оруулалтын зориулалттай үндсэн хөрөнгийг анх шууд холбогдон гарсан аливаа зардлыг шингээсэн өртгөөр хүлээн зөвшөөрнө. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа бодит үнэ цэнийн аргаар тайлант өдрөөрх зах зээлийн үнэлгээгээр толилуулна. Бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн аливаа олз ба гарзыг холбогдох татварын нөлөөг тооцсон дүнгээр тайланд үед ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Бодит үнэ цэнийг тодорхойлохдоо Олон улсын үнэлгээний стандартын хорооноос зөвлөсөн үнэлгээний загварыг мөрдсөн хараат бус мэргэшсэн үнэлгээчний жилийн үнэлгээний тайланг үндэслэнэ.

Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийг борлуулсан үед(жишээ нь худалдан авагч тал тухайн хөрөнгийг бүрэн ашиглах эрхийг авсан өдрөөр) эсвэл ашиглалтаас бүрэн гарсан болон тухайн хөрөнгийг борлуулснаар хүртэх эдийн засгийн өгөөж байхгүй болсон үед данснаас хасна. Тухайн хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийг данснаас хасахдаа бусад хувьсах хүчин зүйлүүд болох гол санхүүгийн бүрэлдэхүүн оршиж байгаах эсэх, мөнгөн бус шинжтэй давуу талууд болон худалдан авагч талд өгөх өглөг(зарим тохиолдолд) зэргийн нөлөөг авч үзнэ.

Хэрэв хөрөнгийн зориулалтад өөрчлөлт орсон бол хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөөс/-д шилжүүлдэг. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг банкны ашиглалтад буй үндсэн хөрөнгө руу шилжүүлэх тохиолдолд ашиглалтад өөрчлөлт орсон өдрөөрх бодит үнэ цэнээр хөрөнгийн өртгийг тооцож дараагийн хэмжилтүүдийг хийнэ. Үндсэн хөрөнгөөс хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөд шилжвэл, Банк нь тухайн өдрөөр дагаж мөрдөж буй Үндсэн хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу хүлээн зөвшөөрнө. .

Борлуулах зориулалттай үл хөдлөх хөрөнгө

Банк нь эргэлийн бус хөрөнгийн дансны үнэ нь тухайн хөрөнгийг ашигласнаар бус борлуулснаар орж ирэх мөнгөн урсгалаас нөхөгдөхөөр байгаа тохиолдолд борлуулах зориулалттай үл хөдлөх хөрөнгө руу шилжүүлдэг. Борлуулах зориулалттай үл хөдлөх хөрөнгийг түүний дансны үнэ ба бодит үнэ цэнээс борлуулалтын зардлыг хассан дүнгийн аль багаар хэмжинэ. Борлуулалтын зардал нь тухайн хөрөнгийг борлуулахтай шууд холбогдон гарсан зардлаас холбогдох санхүүгийн болон орлогын албан татварын зардлыг хассан дүнтэй тэнцүү байна.

Хөрөнгийг зөвхөн тухайн нөхцөлд богино хугацаанд борлуулах боломжтой буюу өндөр магадлалтай байгаа тохиолдолд борлуулах зориулалттай үл хөдлөх хөрөнгөөр ангилна. Шаардагдах борлуулалтын үйл ажиллагаа нь борлуулалтад мэдэгдэхүйц өөрчлөлт бий болгох эсвэл борлуулалтыг зогсоох нөлөөгүй байх шаардлагатай. Удирдлагаас тухайн хөрөнгийг борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө руу ангилах шийдвэр гаргаснаас хойш нэг жилийн хугацаанд борлуулалтыг бүрэн хийж дуусгахаар төлөвлөнө.

Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Хөрөнгө нь үнэ цэнийн бууралтад орсон байж болох шинж тэмдэг байгаа эсэхийг Банк тайлант хугацаа тутамд шалгаж үздэг. Хэрэв тийм шинж тэмдэг илэрсэн эсвэл жилд нэг удаа хийдэг хөрөнгийн үнэ цэнийн бууралтын тестийг хийх шаардлагатай үед Банк нь хөрөнгөөс цуглуулан авах боломжтой дүнг тооцоолно. Цуглуулан авах дүн нь хөрөнгийн эсвэл бэлэн мөнгө бий болгогч нэгжийн бодит үнэ цэнэ (борлуулалтын зардлыг хасаж тооцсон) ба ашиглалтын үнэ цэнэ хоёрын аль өндөр нь байна. Хөрөнгийн эсвэл бэлэн мөнгө бий болгогч нэгжийн дансны дүн нь цуглуулан авах дүнгээс илүү байгаа үед хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон гэж үзэн цуглуулан авах дүн хүртэл нь бууруулж бүртгэнэ. Ашиглалтын үнийг үнэлэхдээ, тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалыг мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ ба хөрөнгөд харгалзах эрсдэлүүдийн талаарх өнөөгийн зах зээлийн үнэлгээнүүдийг тусгасан татварын өмнөх хөнгөлөлтийн хувь хэмжээгээр бууруулан өнөөгийн үнэ цэнийг олно. Борлуулалтын зардлыг хассаны дараах бодит үнэ цэнийг тодорхойлохдоо тохиромжтой үнэлгээний загварыг ашиглан тооцоолно. Үнэлгээний үржүүлэгч, нийтэд хувьцаагаа зардаг охин компанийн хөрөнгийн бирж дээрх хувьцааны үнэ эсвэл бодит үнэ цэнийн бусад үзүүлэлтүүдээр эдгээр тооцооллыг хэмжиж болно.

Гүүдвиллээс бусад хөрөнгүүд дээр, тайлагналын өдөр бүр өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын алдагдал арилсан эсвэл буурсан эсэх талаар ямар нэгэн шинж тэмдэг байгаа эсэх талаар үнэлгээг хийдэг. Хэрэв тийм шинж тэмдэг илэрвэл Банк нь тухайн хөрөнгийн эсвэл бэлэн мөнгө бий болгогч нэгжийн нөхөн төлөгдөх дүнг ойролцоогоор тооцож үзнэ. Хамгийн сүүлд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрснөөс хойш хөрөнгийн цуглуулан авах дүнг тодорхойлоход ашигласан тооцооллуудад өөрчлөлт гарсан тохиолдолд л өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтыг буцаана. Буцаалт нь хязгаартай байх ба ингэснээр хөрөнгийн бүртгэлийн дүн нь цуглуулан авах дүн ба өмнөх жилүүдэд хөрөнгийн үнэ цэнийн алдагдлыг хүлээн зөвшөөрөөгүй байсан бол байх ёстой байсан бүртгэлийн цэвэр дүнгээс (элэгдлийг хассан цэвэр дүнгээс) хэтрэхгүй байна. Ийм буцаалтуудыг ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

Санхүүгийн баталгаа

Бизнесийн хэвийн нөхцөлд Банк аккредитив, баталгаа, хүлээн зөвшөөрөлт гэх мэт санхүүгийн баталгааг гаргадаг. Санхүүгийн баталгааг санхүүгийн тайлангуудад анхлан бүртгэхдээ бодит үнээр нь буюу хүлээн авсан урамшууллын дүнгээр “Бусад өр төлбөр”-т хүлээн зөвшөөрдөг. Ийнхүү анхлан хүлээн зөвшөөрсний дараа баталгаа бүрт Банкны хүлээх хариуцлагыг хорогдуулсан урамшуулал ба уг баталгааны улмаас үүсэх аливаа нэг санхүүгийн үүргийг биелүүлэхэд шаардлагатай зардлын хамгийн сайн тооцоолсон дүн хоёрын аль ихээр нь хэмжинэ.

Санхүүгийн баталгааны холбогдох өр төлбөрийн аливаа өсөлтийг ашиг, алдагдлаар бүртгэнэ.

Ажилтнуудын тэтгэмж

Богино хугацаат тэтгэмж

Цалин ба түүнтэй холбогдох бусад зардлуудыг Банкны ажилтнуудаас холбогдох үйлчилгээг үзүүлсэн тухайн жилд нь зардалд тусгана.

Ажилтнуудад ээлжийн амралт зэрэг богино хугацааны чөлөөтэй үед нөхөн олговрыг ажилласан жилийг нь харгалзан олгодог бөгөөд өвчтэй байх хугацааны нөхөн олговрыг цаг тухайд нь олгодог.

Заавал төлөгдөх даатгалын шимтгэлүүд

Монгол улсын холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд нь Монгол улсын эрүүл мэнд, нийгмийн даатгалын санд шимтгэл төлнө. Эдгээр шимтгэлийг гарсан хугацаанд нь ашиг, алдагдлын тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө.

Нөөц

Банканд өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн өнөөгийн үүрэг (хуулийн эсвэл ёс зүйн) байгаа энэхүү үүргээ биелүүлэхэд эдийн засгийн өгөөж агуулсан баялгийг зарцуулах нь тодорхой болсон ба үүргийн дүнг бодитойгоор ойролцоолон тооцоолох боломжтой үед нөөцийг хүлээн зөвшөөрнө. Аливаа нэг нөөцтэй холбоотой зардлыг ашиг, алдагдлаар аливаа нөхөн төлбөрийг хассан цэвэр дүнгээр нь толилуулна.

Сегментийн тайлан

Банкыг бүрэлдүүлэгч аль нэг үйл ажиллагааны сегмент нь бизнесийн үйл ажиллагааны хүрээнд бусад бүрэлдэхүүн хэсгүүдээс орлого олох, зардал хүлээх зэрэг орлого зарлагын гүйлгээг тогтмол хийдэг. Банкны үйл ажиллагаа хариуцсан шийдвэр гаргагч албан тушаалтан нь бүх үйл ажиллагааны сегментийн үр дүнг тогтмол хянаж, сегментүүдэд шаардлагатай нөөцүүдийг хуваарилах, боломжит санхүүгийн үзүүлэлтүүдийг ашиглан гүйцэтгэлийг нь үнэлэх үүрэгтэй ажилладаг.

Татвар

Тайлант хугацааны орлогын албан татвар

Одоогийн болон өмнөх тайлант хугацааны өнөөгийн албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг татварын байгууллагаас буцаан авахаар хүлээж байгаа эсвэл татварын байгууллагад төлөх дүнгээр хэмжинэ. Энэ дүнг тооцоолоход хэрэглэсэн татварын хувь хэмжээ, татварын хуулиуд нь санхүүгийн байдлын тайлангийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байсан.

Хойшлуулсан татвар

Хойшлуулсан орлогын албан татварыг тайлагналын өдрийн байдлаарх хөрөнгө, өр төлбөрийн татварын суурь, тэдгээрийн санхүүгийн бүртгэлийн дүн хоёрын хооронд түр зөрүүний дүнгээс тайлан тэнцлийн аргыг хэрэглэн тооцдог. Дараахаас бусад бүх түр зөрүүнүүд дээр хойшлуулсан орлогын албан татварын өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Хэрэв хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгө нь бизнесийн нэгдлийн үеийн бус гүйлгээнээс үүссэн ба гүйлгээ хийгдэх үед нягтлан бодох бүртгэлийн ашиг ба татвар ногдох ашгийн аль алинд нөлөө үзүүлэхгүй хөрөнгө, өр төлбөрүүдийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн бол;
- Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт, хамтарсан компани дахь ашиг сонирхолтой холбоотой татвар ногдох түр зөрүүнүүдийн хувьд, үүссэн түр зөрүү нь ойрын ирээдүйд арилах ба түр зөрүүг ашиглаж болох татвар ногдох ашиг олох магадлал байгаа бол.

4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

Татвар (үргэлжлэл)

Хойшлуулсан татвар (үргэлжлэл)

Хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгийн бүртгэлийн дүнг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр хянаж үздэг ба энэхүү хөрөнгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн ашиглахад хангалттай хэмжээний татвар ногдох орлого орж ирэх магадлал буурах үед уг бүртгэлийн дүнг бууруулна. Үл хүлээн зөвшөөрсөн хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгийг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр дахин үнэлж үздэг ба хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгийг ашиглахыг зөвшөөрсөн татвар ногдох орлого ирээдүйд орж ирэх магадлалтай болсон үед хүлээн зөвшөөрнө.

Хөрөнгийг олж авах эсвэл өр төлбөрийг барагдуулах тэр тайлант хугацаанд хэрэглэгдэнэ гэж хүлээж байгаа (тайлант жилийн эцсийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байсан татварын хувь хэмжээ, татварын хуулиуд дээр үндэслэн) татварын хувь хэмжээгээр хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгө, өр төлбөрийг хэмжинэ.

Өөрийн хөрөнгөнд шууд хүлээн зөвшөөрсөн зүйлүүдтэй холбоотой тайлант жилийн болон хойшлуулсан татваруудыг мөн өөрийн хөрөнгөнд хүлээн зөвшөөрөх ба ашиг, алдагдалын тайланд хүлээн зөвшөөрөхгүй.

Нэг татвар төлөгч, нэг татварын байгууллагад хамаарах хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлэн тайлагнах хуулиар олгогдсон эрхтэй бол хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлэн тайлагнаж болно.

Эздийн өмч

Энгийн хувьцаа

Энгийн хувьцааг өөрийн хөрөнгөөр ангилсан. Шинэ хувьцаа гаргахтай шууд холбоотой нэмэгдэл зардлыг хувьцаа гаргасан орлогоос татварыг хассаны дараах байдлаар өөрийн хөрөнгийг хорогдуулах байдлаар толилуулна.

Нэмж төлөгдсөн капитал

Нэмж төлөгдсөн капитал нь хувьцааны нэрлэсэн үнээс илүү гарсан дүнгээрх нийлүүлсэн хувь юм. Нэмж төлөгдсөн капитал нь мөн хувьцаа эзэмшигчдийн нэмэлтээр оруулсан хөрөнгөнөөс үүсч болно.

Хуримтлагдсан ашиг

Хуримтлагдсан ашиг нь зарласан ногдол ашгаар буурдаг хуримтлагдсан ашиг, алдагдлыг илэрхийлнэ. Үүнд мөн нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлтийн нөлөө, өмнөх тайлант үеийн залруулга багтана.

Дахин үнэлгээний нөөц

Банкны барилга болон газар дахин үнэлсэнээс үүссэн нэмэгдлийг хөрөнгийн дахин үнэлгээний нөөц дансанд бүртгэдэг.

Мөнгөн гүйлгээний хейджийн нөөц

Мөнгөн гүйлгээний хейджийн хэрэгслийн үр өгөөжтэй хэсгийн олз гарз бүртгэгддэг нөөцийн сан.

Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын үнэлгээний нөөц

Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн цэвэр өөрчлөлтийг уг хэсэгт хуримтлуулан бүртгэнэ.

Холбоотой талын ажил гүйлгээ

Холбоотой талууд гэдэгт Банктай дараах байдлаар холбогдсон аж ахуй нэгж болон хувь хүн орно. Үүнд:

Банктай дараах байдлаар холбогдсон хувь хүн эсвэл тухайн хувь хүний ойрын төрөл садан:

- Банканд дангаараа эсвэл хамтран хяналт тогтоосон;
- Банканд томоохон нөлөөлөлтэй эсвэл
- Банкны эсвэл Банкны толгой компанийн гол удирдах албан тушаалтнуудын нэг.

Дараах нөхцлүүдийн аль нэг нь биелсэн тохиолдолд аж ахуй нэгж нь Банканд хамааралтай болно. Үүнд:

- Аж ахуйн нэгж болон Банк нь нэг ижил группийн гишүүд байх (толгой компани, охин компани болон нөгөө охин компани тус бүр нь бусадтайгаа холбоотой).
- Нэг аж ахуйн нэгж нь нөгөө аж ахуйн нэгжийн хараат компани эсвэл хамтын хэлэлцээрт компани (эсвэл нөгөө аж ахуйн нэгж нь гишүүн болох Банкны хараат компани эсвэл хамтарсан хэлэлцээрт компани).
- Аль аль аж ахуйн нэгж нь нэг ижил гуравдагч этгээдийн хамтарсан хэлэлцээрт компаниуд.
- Нэг аж ахуйн нэгж нь гуравдагч аж ахуйн нэгжийн хамтарсан хэлэлцээрт компани бөгөөд нөгөө этгээд нь гуравдагч аж ахуйн нэгжийн хараат компани.

4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)**Холбоотой талын ажил гүйлгээ (үргэлжлэл)**

- Аж ахуйн нэгж нь Банкны эсвэл Банктай холбоотой аж ахуйн нэгжийн ажиллагсдыг урамшуулах зорилгоор ажил эрхлэлтийн дараах тэтгэмж олгодог. Хэрвээ Банк нь уг хөтөлбөрийг хэрэгжүүлдэг бол дэмжлэг хүртэж буй ажиллагсад нь мөн Банктай холбоотой тал болно.
- Аж ахуйн нэгжийг Банканд дангаараа эсвэл хамтран хяналт тогтоосон хувь хүн дангаараа эсвэл хамтран хяналт тогтоодог.
- Банканд дангаараа эсвэл хамтран хяналт тогтоосон хувь хүн нь аж ахуйн нэгжид томоохон нөлөөлөлтэй эсвэл уг аж ахуйн нэгжийн (эсвэл аж ахуйн нэгжийн толгой компанийн) гол удирдах албан тушаалтнуудын нэг.
- Аж ахуйн нэгж нь эсвэл Банкны аль нэг гишүүн нь Банк эсвэл Банкны толгой компанид гол удирдах албан тушаалтай.

Холбоотой талуудтай хийсэн материаллаг бүх гүйлгээ болон дансдын үлдэгдлийн мэдээллүүдийг санхүүгийн тайланд хавсаргасан бөгөөд Тодруулга 39-д задаргааг толилуулсан.

Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд

Банкны санхүүгийн тайлангуудыг батлан гаргах өдрийн байдлаар батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартуудын жагсаалтыг дор үзүүлэв. Банк энэхүү стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүдийг хүчин төгөлдөр хэрэгжиж эхлэх үеэс дагаж мөрдөнө.

- | | |
|---|--|
| • СТОУС 9, НББОУС 39, СТОУС 7, СТОУС 4 ба СТОУС 16-ийн нэмэлт өөрчлөлтүүд | <i>Жишиг зээлийн хүүгийн шинэчлэл (“ЖЗХШ”) - Үе шат-2¹</i> |
| • СТОУС 17 | <i>Даатгалын гэрээ³</i> |
| • СТОУС 17-ийн нэмэлт өөрчлөлтүүд | <i>Даатгалын гэрээ³</i> |
| • НББОУС 1-ийн нэмэлт өөрчлөлтүүд | <i>Эргэлтийн ба эргэлтийн бус өр төлбөрийн ангилал³</i> |
| • СТОУС 3-ын нэмэлт өөрчлөлтүүд | <i>Үзэл баримтлалын тайлбар²</i> |
| • НББОУС 16-ын нэмэлт өөрчлөлтүүд | <i>Үндсэн хөрөнгө: Зориулалтын дагуу ашиглаж эхлэхээс өмнөх хөрөнгийн орлого²</i> |
| • НББОУС 37-ын нэмэлт өөрчлөлтүүд | <i>Алдагдалтай гэрээ – Гэрээний биелэлтийн өртөг²</i> |
| • СТОУС 1 СТОУС-ын анхны хэрэгжүүлэлт | <i>СТОУС-ыг анхлан хэрэгжүүлж буй охин компани²</i> |
| • СТОУС 16-д нэмэгдсэн тайлбар жишээнүүд | <i>Түрээсийн урамшуулал²</i> |
| • НББОУС 41 – Хөдөө аж ахуй | <i>Бодит үнэ цэнийн хэмжилтэд татвар ногдуулах²</i> |
| • СТОУС 10 ба НББОУС 28-ын нэмэлт өөрчлөлтүүд | <i>Хөрөнгө оруулагч ба түүний хараат компани, хамтарсан хэлэлцээрт компанийн хооронд худалдсан эсвэл хандивласан хөрөнгө⁴</i> |

¹2021 оны 1 сарын 1-н болон түүнээс хойш тайлант хугацаанд хүчин төгөлдөр болно

²2022 оны 1 сарын 1-н болон түүнээс хойш тайлант хугацаанд хүчин төгөлдөр болно

³2023 оны 1 сарын 1-н болон түүнээс хойш тайлант хугацаанд хүчин төгөлдөр болно

⁴Одоогоор хүчин төгөлдөр болох хугацаа тодорхойгүй боловч хэрэгжүүлэх боломжтой

СТОУС 9, НББОУС 39, СТОУС 7, СТОУС 4 ба СТОУС 16 Жишиг зээлийн хүүгийн шинэчлэл - Үе шат 2-д хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүд

НББОУС3-өөс 2020 оны 8 сард банк хоорондын зээлийн хүүг (“БХЗХ”) эрсдэлгүй хүүгээр (“ЭХ”) солихтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор СТОУС 9, НББОУС 39, СТОУС 7, СТОУС 4 ба СТОУС 16-д Жишиг зээлийн хүүгийн шинэчлэл Үе шат 2-ийн (“ЖЗХШ Үе шат-2”) нэмэлт өөрчлөлтүүдийг хийсэн.

ЖЗХШ Үе шат 2-т олон хөнгөлөлт, нэмэлт тодруулга орж байгаа. Энэхүү хөнгөлөлт нь санхүүгийн хэрэгслийг БХЗХ-с ЭХ-д шилжүүлэхэд хамаарна.

ЖЗХШ-ээр үүссэн гэрээний мөнгөн урсгалыг тодорхойлох үндэслэлд орсон өөрчлөлтийг хөвөгч хүүгийн түвшний өөрчлөлт гэж тооцох практик ач холбогдолтой ба санхүүгийн хэрэгслийн хувьд БХЗХ үнэлгээнээс ЭХ-д шилжих нь эдийн засгийн хувьд ижил зарчмаар явагдана.

ЖЗХШ Үе шат 2 нь хүүгийн жишиг үнэлгээг ЭХ-ээр солих үед Банкны хейджийн харилцааг үргэлжлүүлэх боломжийг олгох түр зуурын хөнгөлөлтийг үзүүлдэг. Энэхүү хөнгөлөлтийг хэрэгжүүлэхийн тулд Банк хейджийн тэмдэглэгээ, хейджийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай болдог. Үүнд ЭХ-г тайлбарлах зорилгоор хейджийн эрсдэлийг болон хейджийн хэрэгслийн тайлбарыг дахин тодорхойлох ба/эсвэл ЭХ-г харгалзан хейджийн үр дүнг үнэлэх аргад нэмэлт өөрчлөлт оруулах юм. Хейджийн баримт бичгийн шинэчлэлтийг тайлант хугацааны эцэст хийж цаашид хэрэгжүүлнэ. Хейджийн үр ашгийг урвуу байдлаар үнэлэхдээ Банк бодит үнэ цэнийн хуримтлагдсан өөрчлөлтийг тэг болгох үүднээс хейдж тус бүрээр нь сонгон авч үзэж болно.

4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)**Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд (үргэлжлэл)*****СТОУС 9, НББОУС 39, СТОУС 7, СТОУС 4 ба СТОУС 16 Жишиг зээлийн хүүгийн шинэчлэл - Үе шат 2-д хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүд (үргэлжлэл)***

Банк нь хүүгийн эрсдэлийн бүрэлдэхүүн хэсгийг тусад нь тодорхойлсон тохиолдолд хейджийн зүйлийн бодит үнэ цэнэ эсвэл мөнгөн гүйлгээний өөрчлөлтийн гэрээний дагуу тогтоогдоогүй хейджийн эрсдэлийн бүрэлдэхүүн хэсэг гэж тодорхойлж болох бөгөөд энэ нь өргөн хэрэглэгддэг тогтсон жишиг юм. Жишээлбэл: зах зээл дээр зээл, деривативын үнийг тогтоох.

Жишиг зээлийн хүү хараахан тогтоогүй байгаа ЭХ-үүдийн хувьд 24 сарын дотор ЭХ-г таних боломжтой болно гэсэн Банкны үндэслэлтэйгээр тооцоолсон тохиолдолд энэхүү шаардлагаас чөлөөлөгдөнө. Банк нь бүлгийн зүйлийн хейджийн хувьд хэрэгслийг ЭХ-д хамаарах дэд бүлгүүдэд шилжүүлэх шаардлагатай. ЖЗХШ Үе шат 2-ыг хэрэгжүүлэхээс өмнө зөвхөн БХЗХ-ээс болж цуцлагдсан бөгөөд ЖЗХШ Үе шат 2-ыг хэрэгжүүлэхэд хейджийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангасан аливаа хейджийн харилцааг анх хэрэгжүүлж эхэлсэн. Банк нь 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхлэх ЖЗХШ Үе шат 2-ыг хэрэгжүүлснээс санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг үнэлж байгаа ба Банканд материаллаг нөлөө үзүүлнэ гэсэн хүлээлтгүй байна.

СТОУС 17 - Даатгалын гэрээ

2017 оны 5 дугаар сард НББОУС3 нь даатгалын гэрээний хүлээн зөвшөөрөлт, хэмжилт, тайлагнал болон толилуулгын зарчмуудыг тусгасан нягтлан бодох бүртгэлийн иж бүрэн шинэ стандарт болох СТОУС 17 Даатгалын гэрээ стандартыг батласан. СТОУС 17 нь хүчин төгөлдөр болох хугацаанаасаа эхлэн 2005 онд батлагдсан СТОУС 4 Даатгалын гэрээ стандартыг орлоно. СТОУС 17 нь даатгалыг гаргаж буй аж ахуйн нэгжийн төрлөөс үл хамааран бүх төрлийн даатгалын гэрээнд (жишээлбэл, амь нас, шууд бус даатгал, дахин даатгал гэх мэт) мөн түүнчлэн тодорхой онцлог бүхий баталгаа болон санхүүгийн хэрэгслүүдийг хамаарна. Хамрах хүрээний хувьд цөөн хэдэн зүйлсийг үл хамрана. СТОУС 17 нь СТОУС 9 эсвэл СТОУС 17-ийн хүрээнд ямар хэрэгслүүд эсвэл тэдгээрийн бүрэлдэхүүн хэсгүүд болохыг тодорхойлоход нөлөөлж болох даатгалын шинж чанар бүхий банкны бүтээгдэхүүний нягтлан бодох бүртгэлийн шинэ шаардлагыг нэвтрүүлж байна.

Даатгалын үйлчилгээ үзүүлдэг зээлийн карт ба түүнтэй адилтгах бүтээгдэхүүнүүд: эдгээр бүтээгдэхүүнийг ихэнх олгогчид СТОУС 9-ийн дагуу санхүүгийн хэрэгсэл болох нягтлан бодох бүртгэлийн зарчимаар үргэлжлүүлэх боломжтой болно. СТОУС 17 нь даатгалын гэрээний тодорхойлолтыг хангасан зээлийн картын гэрээг (мөн түүнтэй адилтгах зээлийн болон төлбөрийн зохицуулалт бүхий бусад гэрээг) зөвхөн хэрвээ тухайн үйлчлүүлэгчтэй байгуулсан гэрээний үнийг тогтоохдоо үйлчлүүлэгчийн даатгалтай холбоотой эрсдэлийг үнэлээгүй бол хамрахгүй.

Даатгалын төлбөрийг зээлийн картын гэрээний нөхцлөөр хангах тохиолдолд, олгогч нь дараахь зүйлийг хийх шаардлагатай:

- Даатгалын бүрэлдэхүүн хэсгийг салгаж, түүнд СТОУС 17-г хэрэглэнэ
- Холбогдох бусад стандартууд (жишээлбэл, СТОУС 9, СТОУС 15 Хэрэглэгчидтэй байгуулсан гэрээний орлого эсвэл

НББОУС 37 Нөөц, болзошгүй өр төлбөр ба хөрөнгө)-ийг Даатгалын тодорхойлолтыг хангасан боловч даатгалын тохиолдлын нөхөн төлбөрийг гэрээний дагуу даатгуулагчийн үүргийг биелүүлэхэд шаардагдах хэмжээгээр хязгаарласан зээлийн гэрээ: Зээл олгогчид – жишээ нь, нас баралтаас болон чөлөөлөгдсөн зээл - СТОУС 9 эсвэл СТОУС 17-г хэрэглэх сонголттой тул сонголт нь багцын түвшинд явагдах бөгөөд эргэлт буцалтгүй болно.

СТОУС 17 нь 2023 оны 1 сарын 1-н болон түүнээс хойш эхэлсэн тайлангийн хугацаанд хүчин төгөлдөр болно. Банк нь анх удаа СТОУС 17-г хэрэглэх өдрөөс өмнө буюу түүнээс өмнө СТОУС 9 ба СТОУС 15-ийг хэрэгжүүлсэн тохиолдолд хүчин төгөлдөр болох хугацаанаас өмнө хэрэглэхийг зөвшөөрнө. Банк одоогоор СТОУС 17-г хэрэгжүүлэх нь санхүүгийн тайланд нөлөөлөхгүй гэж үзэж байна.

СТОУС 17 Даатгалын гэрээний нэмэлт өөрчлөлтүүд

СТОУС 17-д орсон нэмэлт өөрчлөлтүүд нь уг стандартаар шаарддаг гол шаардлагуудыг хябаршуулж, санхүүгийн үзүүлэлтүүдийг авч хийсэн тайлбаруудаас багтсан. Түүнчлэн СТОУС 17-г хэрэгжүүлж эхлэхэд шаардагдах суурь ажлуудыг багасгах тодорхой чөлөөлөлтүүдийг мөн танилцуулсан. СТОУС 17-г хэрэгжүүлж эхэлсэн байх хүчин төгөлдөр өдрийг 2023 оны 1 сарын 1-н болон түүнээс хойш байхаар тогтоосон ба эрт хэрэгжүүлэлтийг зөвшөөрсөн. Нэмэлт өөрчлөлтүүд нь Банканд нөлөөлөхгүй гэж үзэж байна.

НББОУС 1-ийн нэмэлт өөрчлөлтүүд: Эргэлтийн ба эргэлтийн бус өр төлбөрийн ангилал

2020 оны 1 дүгээр сард НББОУС3 нь НББОУС 1-ийн 69-76 дугаар хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах замаар өр төлбөрийг эргэлтийн ба эргэлтийн бус гэж ангилах шаардлагыг тодорхойлсон болно.

4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд (үргэлжлэл)

НББОУС 1-ийн нэмэлт өөрчлөлтүүд: Эргэлтийн ба эргэлтийн бус өр төлбөрийн ангилал (үргэлжлэл)

Нэмэлт өөрчлөлтүүд:

- Төлбөр тооцоог хойшлуулах эрх гэж юу болох
- Тайлант хугацааны эцэст хойшлуулах эрхтэй байх ёстой
- Аж ахуйн нэгжийн хойшлуулах эрхээ хэрэгжүүлэх магадлал энэ ангилалд нөлөөлөхгүй
- Зөвхөн хөрвөх өр төлбөрт оруулсан дериватив нь өөрөө өмчийн хэрэгсэл болох тохиолдолд л өр төлбөрийн хугацаа нь түүний ангилалд нөлөөлөхгүй

Нэмэлт өөрчлөлтүүд нь 2023 оны 1 дүгээр сарын 1-нээс хойших жилийн тайлангийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилдэг болох бөгөөд эдгээрийг буцаан мөрдөх журмаар хэрэгжүүлж болно. Банк одоогоор энэхүү нэмэлт, өөрчлөлт нь одоогийн практикт хэрхэн нөлөөлөх, одоо хэрэгжиж буй зээлийн гэрээнд дахин хэлэлцээр хийх шаардлагатай эсэхийг үнэлж байна.

НББОУС 16 Үндсэн хөрөнгийн нэмэлт өөрчлөлтүүд: Зориулалтын дагуу ашиглаж эхлэхээс өмнөх хөрөнгийн орлого

2020 оны 5 дугаар сард НББОУСЗ-өөс "Үндсэн хөрөнгө – Зориулалтын дагуу ашиглаж эхлэхээс өмнөх хөрөнгийн орлого"-г батласан бөгөөд үүнд аж ахуйн нэгж байгууллагууд үндсэн хөрөнгийг өөрийн өртөгөөс тухайн хөрөнгийг байршил, нөхцөл байдалд нь авчрах явцад үйлдвэрлэсэн эд хөрөнгийг зарж борлуулах орлогоос хасахыг хориглосон болно. Үүний оронд аж ахуйн нэгж эдгээр зүйлсийн борлуулалтаас орлого хүлээн зөвшөөрөх, эдгээр бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх зардлыг ашиг, алдагдалд тооцно.

Энэхүү нэмэлт өөрчлөлт нь 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойших тайлангийн хугацаанд хүчин төгөлдөр болох бөгөөд тухайн хөрөнгө хэрэглэхэд бэлэн болсон аль эсвэл анх удаа нэмэлт өөрчлөлтийг хэрэгжүүлж эхлэсэн хугацаанаас өмнөх хамгийн боломжит хугацаа руу буцаан мөрдөж болно.

СТОУС 3-ын нэмэлт өөрчлөлтүүд: Үзэл баримтлалын тайлбар

2020 оны 5 дугаар сард НББОУСЗ-өөс СТОУС 3 Бизнесийн нэгдэл - үзэл баримтлалын хүрээний талаархи нэмэлт, өөрчлөлтийг оруулсан. Нэмэлт өөрчлөлтүүд нь 1989 онд гаргасан Санхүүгийн тайланг бэлтгэх, танилцуулах хүрээ, түүний шаардлагыг мэдэгдэхүйц өөрчлөхгүйгээр 2018 оны 3 дугаар сард батласан Санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын хүрээний зөвлөмжөөр солих зорилготой юм.

Түүнчлэн удирдах зөвлөлөөс НББОУС 37 эсвэл СТОУСТХ 21 Татвар-т хамаарах өр төлбөр ба болзошгүй өр төлбөрийн улмаас үүсэх "2 дахь өдөр" болзошгүй ашиг, алдагдлаас зайлсхийх үүднээс СТОУС 3-г хүлээн зөвшөөрөх зарчимд үл хамаарах зүйлийг нэмэлтээр оруулсан. Үүний зэрэгцээ Удирдах зөвлөлөөс Санхүүгийн тайлан бэлтгэх, танилцуулах тогтолцооны зөвлөмжийг орлуулснаар нөлөөлөлд өртөх болзошгүй хөрөнгийн талаар СТОУС 3-т байгаа удирдамжийг тодруулж өгсөн.

Нэмэлт өөрчлөлтүүд нь 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойших жилийн тайлангийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ. Нэмэлт өөрчлөлтүүд Банканд нөлөөлөхгүй гэж үзэж байна.

НББОУС 37-ийн нэмэлт өөрчлөлтүүд: Алдагдалтай гэрээ - Гэрээ биелэлтийн өртөг

2020 оны 5 дугаар сард НББОУСЗ-өөс НББОУС 37-д нэмэлт өөрчлөлт оруулж, гэрээ нь давагдашгүй эсвэл алдагдалтай эсэхийг үнэлэхдээ аж ахуйн нэгж ямар зардлыг тооцох шаардлагатайг тодорхойлсон болно. Нэмэлт өөрчлөлтүүд нь "шууд хамааралтай зардлын хандлагыг" хэрэгжүүлдэг. Бараа, үйлчилгээ үзүүлэх гэрээнд шууд хамааралтай зардлууд нь нэмэгдсэн өртөг болон гэрээний үйл ажиллагаатай шууд холбоотой зардлын хуваарилалтыг хоёуланг нь багтаана. Ерөнхий болон захиргааны зардал нь гэрээнд шууд хамааралгүй бөгөөд гэрээнд заасны дагуу эсрэг талдаа тодорхой төлбөр тооцоогүй тохиолдолд хасагдана.

Энэхүү нэмэлт өөрчлөлт нь 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойших жилийн тайлангийн хугацаанд хүчин төгөлдөр болно. Банк эдгээр нэмэлт өөрчлөлтийг анх оруулсан тайлангийн жилийн эхэнд бүх үүргээ биелүүлээгүй байгаа гэрээнд хэрэгжүүлнэ.

СТОУС-ын үйл явцыг 2018-2020 оны туршид жил бүр боловсронгуй болгох ажлын хүрээнд НББОУСЗ-өөс СТОУС 1-д нэмэлт өөрчлөлт оруулсан. Энэ нэмэлт өөрчлөлтийг СТОУС 1-ийн Д16 (а)-г охин компани нь хэрэгжүүлэхээр сонгосон тохиолдолд хамааралтай бөгөөд толгой компанийн СТОУС-д шилжсэн огноог үндэслэн толгой компанийн тайлагнасан дүнг ашиглан хөрвүүлэлтээс үүссэн хуримтлагдсан зөрүүг хэмжихийг охин компанид зөвшөөрсөн. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойших хугацаанд хүчин төгөлдөр болно. Нэмэлт өөрчлөлтүүд Банканд нөлөөлөхгүй гэж үзэж байна.

4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)**Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд (үргэлжлэл)*****НББОУС 41 Хөдөө аж ахуйн нэмэлт өөрчлөлтүүд: Бодит үнэ цэнийн хэмжилтэд татвар ногдуулах***

НББОУСЗ нь 2018-2020 оны жилүүдэд СТОУС-ын стандартыг сайжруулах ажлын хүрээнд НББОУС 41 Хөдөө аж ахуй, стандартад нэмэлт өөрчлөлт оруулсан. Нэмэлт өөрчлөлтөөр НББОУС 41-ийн 22 дахь хэсэгт зааснаар аж ахуйн нэгжүүд НББОУС 41-ийн хүрээнд хөрөнгийн бодит үнэ цэнийг хэмжихдээ татвар ногдуулах мөнгөн гүйлгээг хасах шаардлагыг хассан болно. Энэхүү нэмэлт өөрчлөлтийг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойших тайлант хугацааны бодит үнэ цэнийн хэмжилтэд хэрэгжүүлж эхлэнэ. Нэмэлт өөрчлөлт нь Банканд нөлөөлөхгүй гэж үзэж байна.

СТОУС 10 ба НББОУС 28-ын нэмэлт өөрчлөлтүүд: Хөрөнгө оруулагч ба түүний хараат компани, хамтарсан хэлэлцээрт компани хооронд худалдсан эсвэл хандивласан хөрөнгө

Эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийн хүчин төгөлдөр өдөр нь анх 2016 оны 1 сарын 1 болон түүнээс хойших санхүүгийн жилд хүчинтэй гэж заасан. 2016 оны 1 дүгээр сарын нэгэнд НББОУЗ-өөс тухайн нэмэлт өөрчлөлтийг хараат компани хамтарсан хэлэлцээрт компанийн нягтлан бодох бүртгэл болон зарим гүйлгээний бүртгэлд хэрэгжүүлэх аргыг хялбаршуулж илүү өргөн хүрээнд төлөвлөлт хийх шаардлага гарсныг мэдэгдэж хүчин төгөлдөр болох өдрийг хойшлуулсан. НББОУСЗ-өөс өргөн хүрээний төлөвлөлтийн үе шат бүрэн дуусах үед хүчин төгөлдөр хэрэгжүүлэх эхлэх өдөр тодорхой болохоор байна. Хэдийгээр уг нэмэлт өөрчлөлтүүдийг шууд хэрэгжүүлэх боломжийг хориглоогүй. СТОУС 10 ба НББОУС 28-ын нэмэлт өөрчлөлтөөр (2011 оны) хөрөнгө оруулагч ба түүний хараат компани эсвэл хамтын хэлэлцээрт компани хооронд борлуулалт эсвэл оруулсан хөрөнгийн гүйлгээнд хамааралтай СТОУС 10 ба НББОУС 28-д заасан стандартууд хоорондоо зөрчилддөг тууштай биш байгааг онцолсон. Мөн уг нэмэлт өөрчлөлтөөр хөрөнгө оруулагч ба түүний хараат компани эсвэл хамтын хэлэлцээрт компани хооронд борлуулалт эсвэл оруулсан хөрөнгийн гүйлгээний үр дүнд үүссэн олз ба гарзыг бүрэн хүлээн зөвшөөрөхийг зааварчилсан. Хөрөнгөөрх гүйлгээ нь бизнесийн шинжтэй биш тохиолдолд уг гүйлгээнээс үүссэн аливаа олз ба гарзыг тухайн хараат компанид эсвэл хамтын хэлэлцээрт компанид эзэмшиж байгаа хөрөнгө оруулагчийн эзэмшлийн бус хувиар хувь тэнцүүлж хөрөнгө оруулагч нь санхүүгийн тайландаа ашига ба алдагдлаар хүлээн зөвшөөрөхийг заасан. Нэмэлт өөрчлөлтүүдийг зөвхөн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш хугацаанд мөрдөж болно.

5. Нягтлан бодох бүртгэлийн гол үнэлэмж, тооцоолол ба төсөөллүүд

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэх ажил нь санхүүгийн тайлангийн өдрийн байдлаар орлого, зардал, хөрөнгө ба өр төлбөр дээр үнэлэмж, ойролцоолсон тооцоолол, төсөөлөл хийх ба тэдгээрийн дагалдах тодруулгууд болон болзошгүй өр төлбөр тодруулга зэргийг хамардаг ба эдгээр нь зарим тохиолдолд удирдлагаас гаргасан үнэлэмж, тооцоолол болон төсөөлөл дээр үндэслэдэг. Эдгээр төсөөлөл болон тооцооллын үр дүн нь ирээдүйн тайлант жилүүдэд хөрөнгө ба өр төлбөрийн дансны үнэд материаллаг залруулгууд хийх шаардлага буюу тодорхойгүй байдал үүсгэж болдог. Банк нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэх явцдаа дараагийн тайлант жилүүд дэх хөрөнгө ба өр төлбөрийн дансны үнэд материаллаг залруулга үүсгэж болзошгүй тодорхой эрсдэл бүхий дараах гол тооцооллууд болон ирээдүйн төсөөлөл, үнэлэмжүүдийг ашигласан.

Банк хянах боломжгүй бусад хүчин зүйлүүд ирээдүйд үүссэнээс шалтгаалан банкны одоогийн тодорхойлсон байгаа ирээдүйн төсөөлөл болон нөхцөл байдлыг өөрчлөхөд хүргэж болзошгүй. Санхүүгийн байдлын тайланд орсон мэдэгдэхүйц нөлөөтэй зүйлсийг тэдгээрт ашигласан удирдлагын үнэлэмж ба/эсвэл тооцооллууд нь хоорондоо хэрхэн нийцэж байгааг доор тусгав.

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралт

Банк нь санхүүгийн тайлангийн өдрөөр болон сар бүрийн эцэст харилцагчдад олгосон гол зээл ба урьдчилгаа тус бүрт үнэлгээ хийж ашиг, алдагдал, бусад дэлгэрэнгүй орлогын тайланд үнэ цэнийн бууралтын алдагдал бүртгэх шаардлага байгаа эсэхийг тодорхойлдог. Ерөнхийдөө уг үнэлгээ нь удирдлагын үнэлэмжийг шаарддаг буюу тухайн үнэлгээнд харилцагч тус бүрийн эдийн засгийн чадамж, төлбөр төлбөх чадвар болон санхүүгийн үзүүлэлтүүдийг үнэлсэнээр тухайн харилцагчийн ангилалыг тогтоож, холбогдох эрсдэлийн санг тодорхойлдог. Эдгээр үнэлгээнүүд нь олон хүчин зүйлүүдээс хамаарах төсөөллүүдэд тулгуурлах ба бодит үр дүнгээс ялгаатай байж болох бөгөөд сангийн ирээдүйн өөрчлөлтөд хүргэж болох юм. Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны ашиг, алдагдлын тайлан бүртгэгдсэн үнэ цэнийн бууралтуудыг тодруулга 11 ба 19-д дэлгэрэнгүй толилуулав.

Санхүүгийн үүсмэл хэрэгслийн бодит үнэ цэнэ

Санхүүгийн байдлын тайланд бүртгэгдсэн санхүүгийн үүсмэл хэрэгслийн бодит үнэ цэнийг хэмжилтийн өдрөөрх идэвхтэй зах зээл дээрх үнээр хэмжиж чадахгүй бол бодит үнэ цэнийг дискаунтлагдсан мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн үнэлгээний аргыг ашиглан хэмжиж болно. Энэхүү үнэлгээний загварт ашигласан орцуудыг ажиглаж болохуйц идэвхтэй зах зээлийн мэдээллээс олж авсан ба тэдгээр нь нийцтэй биш тохиолдолд бодит үнэ цэнийг тодорхойлохдоо тодорхой түвшний үнэлэмжийг авч ашигласан.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 дугаар сарын 31

5. Нягтлан бодох бүртгэлийн гол үнэлэмж, тооцоолол ба төсөөллүүд (үргэлжлэл)

Санхүүгийн үүсмэл хэрэгслийн бодит үнэ цэнэ (үргэлжлэл)

Ашигласан төсөөллүүдийн өөрчлөлтүүд нь тайлагнасан санхүүгийн үүсмэл хэрэгслийн бодит үнэ цэнэд нөлөөлж болно. Дэлгэрэнгүй толилуулгыг Тодруулга 38-аас харна уу.

6. Улаанбаатар Хотын Банк ХХК-тай нэгдэл

2020 оны 6 сарын 8-ны өдрийн УБХБ-ны хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр тус банкны үйл ажиллагааг бүрэн зогсоож, УБХБ-ыг татан буулгаж ХХБ-тай нэгтгэх шийдвэр гаргасан. УБХБ нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг, хязгаарлагдмал хариуцлагатай компани байсан ба 2020 оны 6 сарын 26-ны байдлаар нийт 15 салбар, 400 гаруй ажилтантай арилжааны банкны үйл ажиллагаа эрхэлж байсан.

Банкууд нь нэг эцсийн өмчлөгчтэй байсан тул удирдлагын зүгээс 2020 оны 6 сарын 26-ны өдрөөр уг нэгдлийг нийтлэг хяналт доорх бизнесийн нэгдэл гэж тодорхойлсон. Тиймээс энэхүү нэгдэл нь СТОУС 3 Бизнесийн нэгдэл стандартын хүрэнээс гарсан ба нэгдсэн компаниудын тайланг нэгтгэх аргыг ирээдүйд мөрдөх журмыг ашиглан бүртгэлийг хийсэн. Банкуудын санхүүгийн тайлангууд нь ижил нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу бэлтгэгддэг байсан.

Нэгдлийн өдрөөрх УБХБ-ны хөрөнгө ба өр төлбөрийн дансны үнийг дор толилуулав:

2020 оны 6 сарын 26
мян.төг

ХӨРӨНГӨ

Бэлэн мөнгө ба Монголбанканд байршуулсан мөнгө*	7,705,567
Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	106,323,028
Санхүүгийн хөрөнгө оруулалт	30,443,201
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт	27,670,448
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	862,934,618
Бусад хөрөнгө	48,768,904
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	5,631,893
Үндсэн хөрөнгө	78,026,336
Ашиглах эрхтэй хөрөнгө	1,085,892
Биет бус хөрөнгө	889,144
НИЙТ ХӨРӨНГӨ	1,169,479,031

ӨР ТӨЛБӨР

Харилцагчдын харилцах, хадгаламж	808,568,971
Репозити	8,426,638
Бусад банк санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	17,897,612
Зээлээр авсан санхүүжилт	37,733,505
Бусад өр төлбөр	149,862,479
Түрээсийн өглөг	970,544
Хойшлогдсон татварын өр төлбөр	1,763,700
НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,025,223,449

ЦЭВЭР ХӨРӨНГӨ

144,255,582

*Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээнд толилуулсан нэгдлийн үр дүнд шилжиж ирсэн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг илэрхийлнэ.

2020 оны 6 сарын 26-ны өдрөөр УБХБ-ны бүх хөрөнгө, өр төлбөр, нөөц болон салбарууд нь Банктай нэгтгэгдсэн ба нэг бүр нь 15,128 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 659,282 ширхэг энгийн хувьцааг гаргасан. УБХБ-ны барилга ба газрын дахин үнэлгээний нөөц болох 39,744,614 мян.төг-ийг Банкны дахин үнэлгээний нөөц рүү шилжүүлэн бүртгэсэн ба цэвэр хөрөнгөөс үлдэж буй 94,537,126 мян.төг-ийг нэмж төлөгдсөн капитал дансанд хүлээн зөвшөөрсөн (Тодруулга 33-г харна уу).

Хэрэв нэгдэл 2020 оны эхэнд хийгдсэн бол банкны хүү ба түүнтэй адилтгах орлого 761,146,201 мян.төг харин татварын өмнөх ашиг 13,396,452 мян.төг байх байсан.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 дугаар сарын 31****7. Хүү болон түүнтэй адилтгах орлого**

	2020	2019
	мян.төг	мян.төг
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	504,880,714	438,487,359
Хөрөнгө оруулалтын үнэт цаас	185,324,204	236,316,801
Бэлэн мөнгө ба Монголбанканд байршуулсан мөнгө	10,054,972	13,467,842
Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	7,366,110	12,196,782
Урвуу репо хэлцэл	244,414	1,140,480
	707,870,414	701,609,264

2020 онд хөрөнгө оруулалтын үнэт цааснаас олсон хүүгийн орлогод 138,672,295 мян.төг (2019 онд: 160,505,875 мян.төг)-ийн татвараас чөлөөлөгдөх Засгийн газрын үнэт цаасны хүүгийн орлого багтсан.

8. Хүү болон түүнтэй адилтгах зардал

	2020	2019
	мян.төг	мян.төг
Харилцагчдын харилцах, хадгаламж	263,072,945	254,928,316
Зээлээр авсан санхүүжилт	119,439,476	86,835,019
Гаргасан өрийн бичиг	70,089,966	156,708,164
Хоёрдогч өглөг	20,666,526	45,833
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	24,044,755	15,608,004
Репо хэлцэл	7,010,255	5,438,004
Түрээсийн өглөг (Тодруулга 24)	1,821,379	2,135,697
	506,145,302	521,699,037

9. Шимтгэл, хураамжийн цэвэр орлого

	2020	2019
	мян.төг	мян.төг
Шимтгэл, хураамжийн орлого		
Картын үйлчилгээ	22,147,477	25,526,257
Зээлийн үйлчилгээ	16,034,765	13,303,670
Гуйвуулгын үйлчилгээ	10,248,276	11,154,328
Гар утас болон цахим банкны үйлчилгээ	3,435,793	3,192,494
Бусад	2,206,656	2,265,450
	54,072,967	55,442,199
Шимтгэл, хураамжийн зардал		
Картын үйлчилгээний шимтгэл	11,667,136	12,473,227
Бусад	3,041,675	2,596,342
	14,708,811	15,069,569
Шимтгэл, хураамжийн цэвэр орлого	39,364,156	40,372,630

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 дугаар сарын 31

10. Үйл ажиллагааны бусад орлого/(зардал)

	2020 мян.төг	2019 мян.төг
Үнэт цаас борлуулсны цэвэр олз/(гарз)	3,544,575	(5,059,717)
ХОЗҮХХ-ийн үнэлгээний олз (Тодруулга 21)	20,122,404	783,002
Үнэт металлын арилжааны цэвэр олз/(гарз)	1,657,337	2,122,005
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө борлуулсны цэвэр олз/(гарз)	3,022,069	(626,152)
Өмчлөх бусад хөрөнгө борлуулсны цэвэр олз/(гарз)	(365,423)	(100,204)
Үндсэн хөрөнгө борлуулсны цэвэр олз	169,780	–
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтаас хүлээн зөвшөөрсөн олз (Тодруулга 17)	768,590	–
Своп хэлцлийн хүүгийн цэвэр орлого/(зардал)	(5,072,115)	594,042
Орон сууцны зээлийн бүтцийн өөрчлөлтөөс үүссэн цэвэр гарз (Тодруулга 19)	(5,592,847)	–
Своп хэлцлийн бодит үнэ цэнийн үнэлгээнээс үүссэн хэрэгжээгүй олз/(гарз)	(6,983,603)	1,500,797
Гадаад валютын арилжааны цэвэр олз/(гарз)	(17,512,007)	1,422,905
Хейджийн үр ашиггүй хэсэг (Тодруулга 18)	–	29,688,815
Бусад	568,793	1,741,962
	(5,672,447)	32,067,455

11. Үнэ цэнийн бууралтын алдагдлын зардал

	2020 мян.төг	2019 мян.төг
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа (Тодруулга 19)	43,917,310	41,897,020
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө (Тодруулга 20)	7,337,693	16,599,541
Бусад банк санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө (Тодруулга 15)	(440,001)	156,638
Бусад хөрөнгө (Тодруулга 20)	14,512,492	118,780
Хөрөнгө оруулалтын үнэт цаас	–	10,000
Зээлийн баталгаа, батлан даалт (Тодруулга 36)	(652,177)	(695,052)
	64,675,317	58,086,927

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 дугаар сарын 31

12. Үйл ажиллагааны зардал

	2020 мян.төг	2019 мян.төг
Ажилтнуудын цалин, хөлс ба урамшуулал	53,374,168	46,915,912
Мэргэжлийн үйлчилгээ	21,910,928	10,553,627
Үндсэн хөрөнгийн элэгдэл (Тодруулга 23)	12,977,972	10,315,416
Даатгал	6,841,023	9,364,230
Зар сурталчилгаа, олон нийтийн харилцаа	6,558,443	12,070,066
Мэдээллийн технологийн ашиглалт	5,048,774	4,220,135
Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдэл (Тодруулга 24)	4,865,339	3,930,742
Техникийн туслалцаа ба гадаадын банкны гуйвуулгын хураамж	3,181,143	3,390,193
Биет бус хөрөнгийн хорогдуулалт (Тодруулга 25)	2,421,188	2,101,911
Харилцаа холбооны үйлчилгээ	2,316,802	1,724,410
Бичиг хэрэг, хангамжийн хэрэгсэл	1,533,807	1,870,499
Ашиглалтын зардал	1,039,742	955,906
Засвар, үйлчилгээ	915,499	3,699,082
Хүлээн авалт, үзвэр үйлчилгээ	478,578	1,631,407
Түрээс	408,258	796,128
Бэлэн мөнгөний зохицуулалт	392,553	770,784
Тээвэр	356,782	593,576
Биет бус хөрөнгө данснаас хассаны гарз (Тодруулга 25)	346,076	–
Томилолт	296,763	2,026,543
Харуул хамгаалалт	145,750	283,230
Сургалт	139,846	367,493
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз (Тодруулга 23)	34,119	7,678,098
Бусад	6,018,642	4,629,086
	131,602,195	129,888,474

13. Орлогын албан татвар

13.1 Орлогын албан татварын зардал

2020 болон 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх орлогын албан татварын зардал:

	2020 мян.төг	2019 мян.төг
Орлогын албан татвар:		
Тайлант үеийн орлогын албан татварын зардал	1,101,888	206
Өмнөх тайлант үеийн дутуу бүртгэсэн орлогын албан татварын зардал (Тодруулга 36)	4,480,130	–
Хойшлуулсан татвар:		
Татварын түр зөрүү (Тодруулга 13.3)	(1,921,609)	–
	3,660,409	206

Банк нь санхүүгийн тайланд орлогын дүнг орлогын албан татварын хуульд заасан чөлөөлөгдөх эсвэл үл чөлөөлөгдөх зүйлүүдээр залруулсан дүнг үндэслэн орлогын албан татварын зардлыг тооцдог. Банк нь Монгол Улсын татварын хууль тогтоомжын дагуу 6 тэрбум (2019 онд: 3 тэрбум) төгрөг хүртэлх татвар ногдох орлогоос 10% (2019 онд: 10%), 6 тэрбум (2019 онд: 3 тэрбум)-аас илүү гарсан дүнгээс 25% (2019 онд: 25%) орлогын албан татвар төлдөг. Засгийн Газрын бондын хүүгийн орлого нь хуулийн дагуу татвар ногдохгүй орлого болно.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 дугаар сарын 31****13. Орлогын албан татвар (үргэлжлэл)****13.1 Орлогын албан татварын зардал (үргэлжлэл)**

Банк нь татварын өмнөх ашгаас хуулиар тогтоосон хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын татварын зардлыг Банканд хүчин төгөлдөр үйлчлэх орлогын татварын хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын татварын зардалд 2019 болон 2020 оны 12 дугаар сарын 31-нээр хэрхэн тохируулсныг дараах байдлаар үзүүлэв. Үүнд:

	2020 мян.төг	2019 мян.төг
Татварын өмнөх ашиг	24,637,436	64,374,911
Татварын хувь хэмжээ болох 25%-иар тооцсон орлогын татварын зардал (2019 онд: 25%)	6,159,359	16,093,728
Татвар ногдох орлогоос хасагдахгүй зардлын нөлөө	26,964,573	27,247,149
Хүлээн зөвшөөрөөгүй хойшлогдсон татварын хөрөнгө	–	609,759
Тусгай хувь хэмжээгээр татвар ногдох орлогын нөлөө	1,067,568	206
Татварын хувь хэмжээний зөрүү	1,258,785	(2,139,481)
Татвар ногдохгүй орлогын нөлөө	(1,601,932)	(1,684,686)
Татвараас чөлөөлөгдөх орлогын нөлөө	(34,668,074)	(40,126,469)
Өмнөх тайлант үеийн дутуу бүртгэсэн орлогын албан татварын зардал	4,480,130	–
Тайлант жилийн татварын зардал	3,660,409	206

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Банкны ирэх 2-4 жилийн хугацаанд, татварын алдагдал хэзээ үүссэнээс хамааран, татвар ногдох орлогоос хасч тооцох татварын алдагдал нь 6,097,594 мян.төг (2019 онд: 40,813,295 мян.төг) байна. Албан татвар ногдуулах орлогоос жил бүр хасагдах алдагдлын хэмжээ нь 50%-аас хэтрэхгүй байна.

Банк нь татварын алдагдлаас үүссэн хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд учир нь дараагийн 4 жилд татварын алдагдлыг шилжүүлэн ашиглаж болох хангалттай татвар ногдох ашиг олох нь тодорхойгүй байна.

2020 оны орлогын албан татварын хувь хэмжээ нь 14.86% (2019 онд: 0%).

13.2 Орлогын албан татварын өглөг

	2020 мян.төг	2019 мян.төг
1 сарын 1-ээр	–	–
Тайлант жилийн орлогын албан татварын зардал	5,582,018	206
Төлсөн татвар	(5,470,061)	(206)
12 сарын 31-ээр	111,957	–

13.3 Хойшлуулсан татварын өр төлбөр

	2020 мян.төг	2019 мян.төг
Хойшлуулсан татварын өр төлбөр		
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтын дахин үнэлгээ	2,677,562	–
Санхүүгийн үүсмэл хэрэгслийн дахин үнэлгээ	(548,280)	–
Хараат компанийн ашгийн хувь	(20,645)	–
Түрээсийн өглөг ба Ашиглах эрхтэй хөрөнгө	46,872	–
	2,155,509	–

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 дугаар сарын 31

13. Орлогын албан татвар (үргэлжлэл)

13.3 Хойшлуулсан татварын өр төлбөр (үргэлжлэл)

Хойшлуулсан татварын (хөрөнгө)/өр төлбөр	Бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрсөн мян.төг	Ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрсөн мян.төг	УБХБ-аас шилжиж ирсэн мян.төг	Нийт мян.төг
Борлуулах зориулалттай санхүүгийн хөрөнгө оруулалтын дахин үнэлгээ	2,677,562	–	–	2,677,562
Санхүүгийн үүсмэл хэрэгслийн дахин үнэлгээ	–	(548,280)	–	(548,280)
Хараат компанийн ашгийн хувь	(364,144)	(1,373,329)	1,716,828	(20,645)
Түрээсийн өглөг ба Ашиглах эрхтэй хөрөнгө	–	–	46,872	46,872
	2,313,418	(1,921,609)	1,763,700	2,155,509

14. Бэлэн мөнгө ба Монголбанканд байршуулсан мөнгө

	2020 мян.төг	2019 мян.төг
Бэлэн мөнгө	67,040,947	77,491,509
Монголбанк дахь харилцах	789,927,406	565,692,561
Монголбанканд байршуулсан хадгаламж	–	360,894,217
Монголбанканд байршуулсан овернайт хадгаламж	–	92,022,685
	856,968,353	1,096,100,972

Монголбанкнаас тавигддаг шаардлагын дагуу Монголбанканд харилцан данс байршуулдаг. Монголбанканд байршуулах бэлэн мөнгөний заавал байлгах нөөцийн үлдэгдэл нь хоёр долоо хоногийн туршид харилцагчдын харилцах, хадгаламжын дундаж үлдэгдлийн төгрөгийн 6.0% ба гадаад валютын 15.0% (2019 онд: 10.5% ба 12.0%)-иас тус тус багагүй байдаг. 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банкны заавал байлгах шаардлагатай 14 хоногийн дундаж нөөцийн хэмжээ төгрөгөөр 168,376,157 мян.төг (2019 онд: 215,545,776 мян.төг) ба гадаад валютаар 425,158,583 мян.төг (2019 онд: 249,651,434 мян.төг) байсан.

15. Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө

	2020 мян.төг	2019 мян.төг
Гадаадын банк, санхүүгийн байгууллага дахь харилцах	422,344,623	120,055,248
Гадаадын банканд байршуулсан барьцааны данс	143,779,003	15,250,230
Дотоодын банк, санхүүгийн байгууллага дахь харилцах	2,383,173	956,071
Дотоодын банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хадгаламж*	1,501,808	165,119,723
	570,008,607	301,381,272

*2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх дотоодын банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хадгаламжинд УБХБ-тай байгуулсан хамтын санхүүжилтийн гэрээний дагуу байршуулсан 75,040,000 мян.төг ба 4,595 мян.америк долларын бэлэн мөнгөөрх баталгаа багтсан. Уг баталгаануудын харгалзах эрсдэлийн сангийн алдагдлыг хоёр банк нэгдэх үед буцаах бичилт хийж тохируулсан (Тодруулга 6 ба 11).

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 дугаар сарын 31****16. Санхүүгийн хөрөнгө оруулалт**

	2020	2019
	мян.төг	мян.төг
Борлуулахад бэлэн:		
Биржид бүртгэлгүй Монголбанкны үнэт цаас (а)	688,492,320	598,900,912
Орон сууцны зээлээр баталгаажсан үнэт цаас (б)	127,666,125	97,023,096
Өмчөөрх хөрөнгө оруулалт, бодит үнэ цэнээр (в)	27,108,838	53,412,762
Биржид бүртгэлтэй Засгийн газрын бонд (г)	25,542,064	29,262,345
Биржид бүртгэлгүй өмчийн үнэт цаас, өртгөөр (д)	7,313,358	3,876,615
Өмчлөх бусад хөрөнгө (е)	92,257,890	92,257,890
Өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн сан	(92,257,890)	(92,257,890)
	876,122,705	782,475,730
Дуусгавар хугацаа хүртэл эзэмших:		
Засгийн газрын бонд (ё)	769,901,041	984,163,506
Монгол улсын Хөгжлийн банкны бонд (ж)	65,974,795	65,977,534
	835,875,836	1,050,141,040
	1,711,998,541	1,832,616,770

- (а) Биржид бүртгэлгүй Монголбанкны үнэт цаасыг нэрлэсэн үнээр эсвэл урамшуулал, хорогдуулалттай үнээр худалдаж авч болно. Аливаа урамшуулал/хорогдуулалтыг тухайн үнэт цаасны дуусах хугацаа хүртэл шулуун шугамын аргаар хорогдуулна.
- (б) Орон сууцны ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас (“ИЗББ”) нь Монголын Үнэт цаасны тухай хуулийн дагуу Монголын Ипотекийн Корпораци (“МИК”)-аас гаргасан хүүтэй, урт хугацаат энгийн бондноос бүрдэх ба уг бондыг арилжааны банкууд нь хамгийн багадаа 3 жил эзэмших ёстой (Тодруулга 19-г харна уу).
- (в) 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар бодит үнэ цэнээрээ бүртгэгддэг өмчийн үнэт цаас нь МИК-ийн эздийн өмчийн 9.99%-тай дүйцэх 31,035,000 мян.төг-ийн дүнтэй хөрөнгө оруулалт ба нэгдлийн үр дүнд уг хөрөнгө оруулалтыг хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт руу ангилсан (Тодруулга 17-г харна уу). Үлдсэн дүн нь Виза корпорацид оруулсан өмчийн хөрөнгө оруулалт юм.
- (г) Бирж дээр бүртгэлтэй Засгийн газрын бондод гадаадын хөрөнгийн бирж дээр нээлттэй арилжаалагддаг Засгийн газрын бондууд багтана.
- (д) Бирж дээр бүртгэлгүй өмчийн хөрөнгө оруулалтын ангилалд хаалттай хувьцаат компанид оруулсан өмчийн хөрөнгө оруулалтууд багтана. Уг хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжгүй тул өртгийн аргаар бүртгэдэг. Эдгээр хөрөнгө оруулалтыг зах зээлд арилжаалах боломжгүй ба банкны зүгээс мөн ирээдүйд эдгээр хөрөнгө оруулалтыг борлуулах сонирхолгүй байдаг.
- (е) 2016 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Банк нь Монголиан Нэйшнл Рэйр Ээрт Корпорэйшн ХХК (“МНРИК”)-ийн хувьцааг авсан ба энэ нь Банкны МНРИК-тэй хийсэн зээлийн гэрээнд заасан нөхцлийн дагуу МНРИК нь Банкнаас авсан зээлийн үүргээ биелүүлэх боломжгүй болсонтой холбоотой юм. Хувьцааг Монголбанкны журмын дагуу борлуулах бэлэн хөрөнгө оруулалтаар ангилж өртгөөр нь бүртгэсэн. Банк 2018 онд Монголбанкнаас хийгдсэн Активын чанарын үнэлгээгээр уг өмчлөх бусад хөрөнгөд 16,997,000 мян.төг-ийн эрсдэлийн сан байгуулсан. 2019 онд мөн Монголбанкны шаардлагын дагуу 75,260,890 мян.төг-ийн эрсдэлийн санг хүлээн зөвшөөрч хуримтлагдсан ашигт бүртгэсэн.
- (ё) Засгийн газрын бонд нь хөрөнгийн биржид бүртгэлгүй, хүүтэй Монгол улсын Засгийн газрын бонд юм.
- (ж) Монгол улсын хөгжлийн банк (“ХБ”)-ны бонд нь АСЕМ төслийн хүрээнд ХБ-аас гаргасан хүүтэй, урт хугацаатай хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй бондоос бүрдсэн.

17. Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт

2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Банк нь МИК-ийн 19.99% (2019 онд: 9.99%) (МИК-ийн халаасны хувьцааг авч үзвэл 27.15% (2019 онд: 13.57%))-г эзэмшиж байв. Нэгдлийн үр дүнд Банк нь уг хөрөнгө оруулалтыг хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтаар бүртгэж эхэлсэн.

МИК-ийн үндсэн үйл ажиллагаа нь Монгол улсад ИЗББ гарган, түүгээр барьцаалан эсвэл олон улсын зах зээл дээр гаргасан бондын санхүүжилтээр орон сууцны зээлийн багц худалдан авах юм. МИК нь Монгол улсын хөрөнгийн биржид (“МХБ”) бүртгэлтэй хувьцаат компани юм.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 дугаар сарын 31

17. Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт (үргэлжлэл)

Банк нь 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар МИК-ийн 4,139,912 ширхэг (2019 онд: 2,069,000 ширхэг) хувьцааг эзэмшиж байгаа ба МХБ дээрхи МИК-ийн нэгж хувьцааны хаалтын ханш 14,950 төг (2019 онд: 15,000 төг) байв.

Энэхүү Банкны санхүүгийн тайлан гарах өдрийн байдлаар, МИК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн аудитлагдсан санхүүгийн тайлан гараагүй байсан. Банк нь МИК-д оруулсан хөрөнгө оруулалтаа өмчийн аргаар бүртгэдэг ба ингэхдээ МИК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх гол үйл явдлуудыг зохистойгоор тохируулсан хамгийн боломжит сүүлийн санхүүгийн мэдээллийг ашигласан. МИК-ийн аудитлагдсан санхүүгийн тайлан нь Банкны ашигласан санхүүгийн мэдээллээс өөр байж болох ба аливаа зөрүү нь 2021 онд залруулагдана. Дараах хүснэгтэд Банкны МИК-д оруулсан хөрөнгө оруулалтын мэдээллийг хураангуйлан үзүүлэв:

	2020 мян.төг	2019 мян.төг
1 сарын 1-нээр	–	–
Санхүүгийн хөрөнгө оруулалтаас дахин ангилал (Тодруулга 16)	26,876,310	–
УБХБ-аас шилжиж ирсэн (Тодруулга 6)	27,670,448	–
Нэгдлийн үр дүнд үүссэн олз (Тодруулга 10)	768,590	–
Нэгдлийн өдрөөрх хараат компанийн цэвэр хөрөнгийн бодит үнэ цэнэ	55,315,348	–
Хараат компанийн тайлант жилийн алдагдлын Банканд ногдох хувь	(14,501,873)	–
12 сарын 31-нээр	40,813,475	–
Хараат компани: МИК		
Нийт хөрөнгө	4,069,222,998	4,181,247,978
Нийт өр төлбөр	(3,918,897,123)	3,918,562,245
Эздийн өмч	150,325,875	262,685,733
Эзднийн өмч дэхь Банкны эзэмшлийн хувь (27.15%)	40,813,475	–
Хараат компани болсон өдрөөс хойших хугацааны цэвэр хүүгийн орлого	41,301,546	
Хараат компани болсон өдрөөс хойших хугацааны бусад дэлгэрэнгүй алдагдал	(53,413,898)	

18. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл

Доорх хүснэгтэд хөрөнгө болон өр төлбөрт бүртгэгдсэн санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийн бодит үнэ цэнийг нэрлэсэн үнийн хамтаар харууллаа. Нэрлэсэн үнэ нь санхүүгийн үүсмэл хэрэгслийн суурь болж буй хөрөнгө, жишиг ханш эсхүл индекс байх бөгөөд санхүүгийн үүсмэл хэрэгслийн үнэ цэнийн өөрчлөлтийг хэмжих суурь болно. Нэрлэсэн үнэ нь тайлант жилийн эцсийн байдлаарх гүйлгээний дүнг харуулах бөгөөд энэ нь зах зээлийн эрсдэл эсхүл зээлийн эрсдэлийг тодорхойлох үзүүлэлт болж чадахгүй юм.

	2020 оны 12 сарын 31-нээр			2019 оны 12 сарын 31-нээр		
	Нэрлэсэн үнэ мян.төг	Бодит үнэ цэнэ		Нэрлэсэн үнэ мян.төг	Бодит үнэ цэнэ	
		Хөрөнгө мян.төг	Өр төлбөр мян.төг		Хөрөнгө мян.төг	Өр төлбөр мян.төг
Арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн үүсмэл хэрэгсэл						
МИК, МБ-тай хийсэн валют, хүүгийн своп хэлцэл (а)	777,151,290	89,371,192	93,331,037	777,151,290	77,925,340	76,226,529
МБ-тай хийсэн валют, хүүгийн своп хэлцэл (б)	340,178,235	–	6,392,065	–	–	–
Форвард хэлцэл	–	–	–	78,162,784	1,930,305	–
	1,117,329,525	89,371,192	99,723,102	855,314,074	79,855,645	76,226,529
Мөнгөн гүйлгээний хейджд ашиглагдах санхүүгийн үүсмэл хэрэгсэл						
Валютын своп хэлцэл (в)	–	–	–	971,940,000	415,006,111	–
	1,117,329,525	89,371,192	99,723,102	1,827,254,074	494,861,756	76,226,529

Санхүүгийн үүсмэл хэрэгслийн хувьд анхны хөрөнгө оруулалт бага байх буюу эсхүл огт шаардахгүй. Хэдий тийм боловч эдгээр санхүүгийн хэрэгслүүд нь ихэвчлэн хөшүүргийн зэргийг өндөрсгөх бөгөөд нилээн тогтворгүй байна. санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийн хэлцлийн хөрөнгө, түвшин, индексийн үнэлгээний жижиг хэмжээний өөрчлөлт нь банкны ашиг, алдагдалд томоохон нөлөө үзүүлж болзошгүй.

18. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл (үргэлжлэл)

Банк нь санхүүгийн үүсмэл хэрэгслийн гэрээний эрсдэлд өртөх дүнг банкны зах зээлийн эрсдэлийн удирдлагын хүрээнд тодорхойлдог. Банкны эрсдэлийн удирдлагын стратеги ба түүний хэрэгжүүлэлтийн талаар Тодруулга 37-д толилуулав. Санхүүгийн байдлын тайлан дахь холбогдох хейджийн бүртгэл болон гүйцэтгэлийг Тодруулга 10-т болон дор толилуулав.

(а) Банк нь 2019 оны 3 дугаар сарын 28-нд МИК-тэй валют, хүүгийн своп хэлцэл (санхүүгийн үүсмэл өр төлбөр) хийсэн ба мөн өдөр Монголбанктай эсрэг позицийн хэлцэл (санхүүгийн үүсмэл хөрөнгө) хийсэн буюу Банк нь зуучлагчийн байр суурьнаас хэлцэлд орсон. Банк нь анх МИК-ээс америк долларын санхүүжилт хүлээн авч спот ханшаар тооцон төгрөг төлсөн ба мөн Монголбанканд америк долларын санхүүжилт шилжүүлж, спот ханшаар тооцон төгрөгийн санхүүжилт хүлээн авсан. Монголбанктай байгуулсан гэрээний хугацаанд, Банк нь америк долларын санхүүжилтэд LIBOR дээр тодорхой хэмжээний ашиг нэмсэн хүүг хүлээн авч төгрөгийн санхүүжилтэд төв банкны бодлогын хүүгээр хүү төлсөн. Нөгөөтэйгүүр МИК-тэй байгуулсан гэрээний хугацаанд, Банк нь америк долларын санхүүжилтэд Монголбанкнаас авсан хүүтэй ижил хувиар хүү төлж, төв банкны бодлогын хүү дээр 0.1%-ийг нэмсэнтэй тэнцэх хүү хүлээн авна. Банк нь энэхүү хоёр гэрээ дуусах өдрөөрх ханшийн зөрүүгээр санхүүжилтийг барагдуулж мөн төлбөрийг хүлээн авна.

(б) 2020 оны туршид Банк нь Монголбанктай нийтдээ 340,178,235 мян.төг-ийн нэрлэсэн дүн бүхий валют, хүүгийн своп хэлцэл хийсэн. Банк нь анх Монголбанканд америк долларын санхүүжилт төлж, спот ханшаар тооцон төгрөгийн санхүүжилт хүлээн авсан. Монголбанктай байгуулсан гэрээний хугацаанд, Банк нь америк долларын санхүүжилтэд LIBOR дээр тодорхой хэмжээний ашиг нэмсэн хүүг хүлээн авах ба төгрөгийн санхүүжилтэд төв банкны бодлогын хүүтэй тэнцүү хувиар тооцсон хүү төлнө. Гэрээний хугацаа дуусгавар болоход талууд анхны гүйлгээний валютын ханшаар үндсэн төлбөрийг солилцоно.

(в) Олон улсын зах зээлд гаргасан урт хугацаат америк долларын бондын хувьсах мөнгөн гүйлгээнээс үүсч болзошгүй эрсдэлийг хейдж хийх зорилгоор валютын свопын хэлцэлд орсон. Уг хэлцэл нь ердийн урт хугацаат своптой ижил бөгөөд хэлцлийн эхэн хугацаанд Банк нь америк долларын санхүүжилт төлж, спот ханшаар тооцсон төгрөгийн санхүүжилт хүлээн авсан. Уг санхүүгийн үүсмэл хэрэгсэл нь 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр хэрэгжиж дууссан ба хейджээр хамгаалагдсан хэрэгсэл болох 500 сая америк долларын нэрлэсэн үнэтэй, олон улсын зах зээл дээр гаргасан урт хугацаат, өрийн хэрэгсэл 2020 оны 5 дугаар сарын 19-нд бүрэн төлөгдөж дууссан. Банк уг своп хэлцлээс 6,693,889 мян.төг-ийн цэвэр олзыг хүлээн зөвшөөрсөн ба энэ нь уг өрийн хэрэгслээс хүлээн зөвшөөрсөн ханшийн зөрүүний алдагдалтай цэвэршүүлсэн дүн юм.

Мөнгөн гүйлгээний хейдж

Хейджийн үр ашиггүй байдалд нөлөөлөгч хүчин зүйлсүүд:

- Хейджийн хэрэгсэл ба хейджээр хамгаалагдсан зүйлсийн мөнгөн гүйлгээ хийгдэх цаг хугацааны ялгаатай байдал
- Бодит үнэ цэнэд нөлөөтэй талуудын зээлийн эрсдэл
- Харилцан тохирсон форвард ханш болон хейджийн хэлцэл хийгдсэн өдрөөрх зах зээлийн форвард ханшийн зөрүү

Мөнгөн гүйлгээний хейджийн үйл ажиллагааны хүрээнд хейджээр хамгаалагдсан өр төлбөрүүдийн байдал:

Гаргасан урт хугацаат америк долларын бонд	Хейджийн үр ашиггүй байдлыг хэмжихэд ашигласан хейджээр хамгаалагдсан зүйлийн тухайн тайлант үед үүссэн бодит үнэ цэнийн өөрчлөлт мян.төг	Мөнгөн гүйлгээний хейджийн нөөц – хэрэгжиж дуусаагүй байгаа хейдж мян.төг (Тодруулга 33)	Санхүүгийн байдлын тайлангийн зүйл
2020 оны 12 сарын 31-нээр	6,693,889	–	Гаргасан өрийн бичиг
2019 оны 12 сарын 31-нээр	6,054,050	–	Гаргасан өрийн бичиг

Доорх хүснэгтэд Банкны хейджийн стратегийн үр дүн, ялангуяа банкны ашигласан хейджийн хэрэгсэл буюу санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийн нэрлэсэн үнэ ба бодит үнэ цэнэ болон тэдгээрийн хейджийн үр ашиггүй байдлыг хэмжихэд ашигласан бодит үнэ цэнийн өөрчлөлтийн дүнг үр ашигтай ба үр ашиггүй хэсгээр нь хуваарилан үзүүлэв:

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 дугаар сарын 31

18. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл (үргэлжлэл)

Мөнгөн гүйлгээний хейдж (үргэлжлэл)

Хейджийн үр ашиггүй байдлыг хэмжихэд ашигласан хейджээр хамгаалагдсан зүйлийн тухайн тайлант үед үүссэн бодит үнэ цэнийн өөрчлөлт						
Нэрлэсэн үнэ мян.төг	Хөрөнгийн бодит үнэ цэнэ мян.төг	Нийт мян.төг	Бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн үр ашигтай хэсэг (Тодруулга 33) мян.төг	Ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн үр ашиггүй хэсэг (Тодруулга 10) мян.төг	Мөнгөн гүйлгээний хейджийн нөөцөөс ашиг, алдагдал руу ангилсан дүн (Тодруулга 33) мян.төг	
Валютын своп						
2020 оны 12 сарын 31- нээр	—	—	6,693,889	6,693,889	—	(6,693,889)
2019 оны 12 сарын 31- нээр	971,940,000	415,006,111	35,742,865	6,054,050	29,688,815	(35,452,296)

19. Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа

	2020 мян.төг	2019 мян.төг
Байгууллагын зээл	3,524,298,853	2,953,068,818
Иргэдийн зээл	639,059,508	574,038,238
Жижиг, дунд байгууллага (“ЖДБ”)-ын зээл	409,368,088	373,363,628
Гүйцэтгэх удирдлага, захирал, ажилтнуудад олгосон зээл	39,539,225	33,885,312
Харилцагчдад олгосон нийт зээл	4,612,265,674	3,934,355,996
Үнэ цэнийн бууралтын сан	(503,547,304)	(431,204,350)
Харилцагчдад олгосон цэвэр зээл	4,108,718,370	3,503,151,646

Нийт дүнгээр нь үл хүлээн зөвшөөрч шилжүүлсэн санхүүгийн хөрөнгүүд

Орон сууцны зээлийн багцын борлуулалт

Банк нь тайлант жилд (2020 оны 3 дугаар сарын 26 ба 7 дугаар сарын 8-нд) тогтмол хүүтэй орон сууцны барьцаат зээлийн багцаас орж ирэх мөнгөн урсгалыг хүлээн авах эрхийг МИК-ийн тусгай зориулалтын компаниудад худалдаж, оронд нь ИЗББ-ыг худалдан авдаг. Банк нь зээлийн багцыг үл хүлээн зөвшөөрч давуу эрхтэй болон энгийн ИЗББ-ыг санхүүгийн хөрөнгөөр хүлээн зөвшөөрсөн (Тодруулга 16-г харна уу).

Иргэдийн тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөв

Монгол улсын Улсын их хурлаас иргэдийн 6 сая.төг хүртэлх үлдэгдэлтэй бүх тэтгэврийн зээлийг тэглэх хуулийн төслийг баталсан. Зээлийн багцыг төрийн өмчит Эрдэнэс Монгол ХХК-иас гаргасан хөрөнгийн биржид бүртгэлгүй өрийн бичгээр солилцохыг зөвшөөрсөн. Үүний дагуу 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдөр Банк нь Эрдэнэс Монгол ХХК-тай гэрээ байгуулж тэтгэврийн зээлийн үлдэгдлийг өрийн бичигт хөрвүүлсэн. Тухайн тайлант жилд Банк нь 2,446 тэрбум төгрөгийн зээлийн багцыг үл хүлээн зөвшөөрч, хүлээн авсан өрийн бичгийг санхүүгийн хөрөнгөөр хүлээн зөвшөөрсөн ба 2020 оны 5 дугаар сарын 12-ны өдөр уг өрийн бичгийг Монголбанканд худалдсан. Мөн нэгдлийн үр дүнд УБХБ-аас 8,978 сая.төг дүнтэй ижил өрийн бичиг шилжиж ирсэн ба 2020 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр уг өрийн бичгийг Монголбанканд худалдсан.

Нийт дүнгээр нь үл хүлээн зөвшөөрөөгүй шилжүүлсэн санхүүгийн хөрөнгүүд

Банк нь 2020 онд МИК-д үл хөдлөх хөрөнгөөр барьцаалсан зээлийн багцаас орж ирэх ирээдүйн мөнгөн урсгалыг худалдсан ба зээлүүдийн гүйцэтгэлд үүрэг хүлээх нөхцөлтэй. Банк нь нийт 50,890 сая.төг-ийн дүнтэй орон сууцны зээлийг МИК руу худалдсан ба оронд нь 16% (2019 онд: 7.75%-16%)-ийн хүүтэй санхүүжилт хүлээн авсан. Эдгээр гүйлгээний дагуу зарагдсан зээлийн бүх эрсдэл ба өгөөжийг банк бүрэн хариуцна. Тиймээс уг хөрөнгө нь данснаас үл хүлээн зөвшөөрөх шаардлагыг хангаагүй. Үл хүлээн зөвшөөрөлтийг хангаагүй хөрөнгийн нийт дүн 558,249 сая.төг (2019 онд: 435,051 сая.төг) байсан ба нэгдлийн үр дүнд УБХБ-аас 103,439 сая.төг зээлийн багц шилжиж ирсэн (Тодруулга 32).

19. Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа (үргэлжлэл)**Чанаргүй активыг бууруулах хөтөлбөр**

2016 оны 6 дугаар сард Банк нь Монголбанктай Чанаргүй активыг бууруулах хөтөлбөр (“ЧАБХ”)-ийн хүрээнд хамтран ажиллах гэрээ байгуулсан ба уг гэрээгээр Банкны тодорхой хэдэн зээлдэгч нар Монголбанкнаас санхүүжилтийн дэмжлэг авахаар болсон. Хөтөлбөрийн хүрээнд, Банк нь 160 тэрбум төгрөгийн өрийн бичиг (Тодруулга 31) гаргаж, түүнийг нь Монголбанк худалдан авч, төлбөрийг бүрэн төлсөнөөр тус зээлдэгч нарт санхүүжилтийг олгосон. Түүнчлэн эдгээр зээлдэгч нарт олгосон зээлүүдийн эрсдэлийн санг Монголбанктай тусгайлан зөвшилцсөн.

Засгийн газраас авч хэрэгжүүлж буй Ковид-19 цар тахлын сөрөг нөлөөг бууруулах хөтөлбөр

2020 оны турш Монгол улсын Засгийн газар Монголбанктай хамтран Ковид-19 цар тахлын сөрөг нөлөөг бууруулах хөтөлбөрийг хэрэгжүүлсэн ба хөтөлбөрийн хүрээнд иргэдийн орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй зээлийн төлбөр болон хүүгийн төлөлтийг хойшлуулсан. Уг хөтөлбөрөөр зээлдэгчид 6-аас 8 сар хүртэлх хугацаанд зээлийн хүүгээс чөлөөлсөн ба зээлийн гэрээний төлбөр төлөх хугацааг мөн хугацаагаар хойшлуулсан. Уг хойшлуулагдсан төлбөрүүдийг зээлийн гэрээний сунгагдсан хугацаанд зээлдэгчид нөхөж төлнө. 2020 оны 12 дугаар сарын 31-нээрх харилцагчдад олгосон зээлийн үлдэгдэл нь 122.5 тэрбум төгрөг байсан ба орон сууцны зээлийн бүтцийн өөрчлөлтөөс 5,593 сая.төг (Тодруулга 10)-ийн алдагдлыг хүлээн зөвшөөрсөн.

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын сан

Доорх хүснэгтээр харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын сангийн хөдөлгөөнийг үзүүлэв:

	2020 мян.төг	2019 мян.төг
1 сарын 1-нээр	431,204,350	434,611,084
Тайлант жилийн эрсдэлийн сангийн зардал (Тодруулга 11)	43,917,310	41,897,020
Гадаад валютын ханшийн зөрүү	325,308	470,670
Тайлант жилийн хасагдуулга	(510,108)	(45,774,424)
Нэгдлийн үр дүнд УБХБ-аас шилжиж ирсэн	28,610,444	–
12 сарын 31-нээр	503,547,304	431,204,350

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар чанар муудсан зээлүүдийн барьцаа хөрөнгийн бодит үнэ цэнийг Тодруулга 37-д “Зээлийн барьцаа хөрөнгө ба бусад сайжруулалтууд” хэсэгт толилуулав. Бодит үнэ цэнийн үнэлгээг удирдлага нь хамгийн сүүлийн үеийн боломжит мэдээлэл дээр үндэслэн тооцоолсон.

Монголиан Коппер Корпорейшн ХХК ба Канетик Пте Лтд-д олгосон зээлийн үнэ цэнийн бууралт

Тайлант өдрийн байдлаар, Банкны Монголиан Коппер Корпорейшн ХХК (“МКК”) ба Канетик Пте Лтд (“Канетик”)-д олгосон зээлүүдийн хуримтлагдсан хүү ороогүй үлдэгдэл тус тус 150.0 тэрбум төгрөг ба 162.4 тэрбум төгрөг (2019 онд: 143.9 тэрбум төгрөг ба 159.3 тэрбум төгрөг) байсан. Эдгээр зээлүүдийн эргэн төлөгдөх байдал нь МКК ба Монгол улсын Засгийн газрын хооронд хэлэлцэгдэж буй Эрдэнэт Үйлдвэр ХХК-ийн 49%-ийн өмчлөлийн асуудал хир нааштай шийдэгдэхээс ихээхэн хамаарна. 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар, Банк нь МКК ба Канетик олгосон зээлүүдэд тус тус 52.5 тэрбум төгрөг ба 56.8 тэрбум төгрөг (2019 онд: 50.4 тэрбум төгрөг ба 55.8 тэрбум төгрөг)-ийн үнэ цэнийн бууралтын санг байгуулсан.

Харилцагчдад олгосон зээлийн ангилал ба үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сан байгуулах журамд орсон түр чөлөөлөлт

Монгол улсын Засгийн газар Монголбанктай хамтран коронавирус (“Ковид-19”) цар тахлын тархалттай холбоотойгоор Монгол Улсын эдийн засаг, зээлдэгч нарт учирч буй хүндрэлийг бууруулах зорилгоор хэд хэдэн хөтөлбөрүүдийг авч хэрэгжүүлсэн. Банкны салбарын хувьд зээлдэгч нарын зээлийн ангилал, үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сангийн асуудлаар Монголбанк 2020 онд 3 тогтоол (А-69, А-438, А-324) гаргаад байна.

Монголбанкнаас баталсан тогтоолуудын нөлөөний хураангуй:

- Иргэнд олгосон хэрэглээний зээлд тогтоох хугацааны ангиллыг дараах нөхцөлөөр тооцож, ангилахаар шинэчилсэн:
 - 90 хоног хүртэл хугацаа хэтэрсэн: “Хэвийн”
 - 91-120 хоног хугацаа хэтэрсэн: “Анхаарал хандуулах”
 - 121 хоногоос дээш хугацаа хэтэрсэн: “Чанаргүй” (Хэвийн бус, Эргэлзээтэй, Муу)
- Хэрэглээний зээлд 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн байдлаар тогтоосон чанарын ангиллыг тогтоол мөрдөгдөх хугацаанд хэвээр үлдээж, харгалзах эрсдэлийн санг байгуулах.
- Банк нь 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн Ковид-19-ын улмаас зээлийн эргэн төлөлт нь хүндрэлд ороод буй зээлдэгч нарын зээлийн төлөлтөө хойшлуулах хүсэлтийг хүлээн авч эхэлсэн. Уг хүсэлтээр төлбөр хойшилсон зээлүүдийн хувьд, бүтэц өөрчлөгдсөн зээлээр тооцоогүй.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 дугаар сарын 31

19. Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа (үргэлжлэл)

Харилцагчдад олгосон зээлийн ангилал ба үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сан байгуулах журамд орсон түр чөлөөлөлт (үргэлжлэл)

Монголбанкнаас баталсан тогтоолуудын нөлөөний хураангуй (үргэлжлэл):

- Банк нь 2020 оны 1 дүгээр сарын 31-ээс хойш бизнесийн зээлүүдийн эцсийн ангиллыг бууруулаагүй ба 2020 оны 1 дүгээр сарын 31-нээрх эцсийн ангилалыг хэвээр үлдээсэн. Учир нь удирдлага зээлдэгчид Монголбанкны А-438 тогтоолын 5-р заалтын дагуу 2021 оны 6 дугаар сарын 30 хүртэл зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийн хугацааг өөрсдийн төлбөрийн чадварт нийцүүлэн хойшлуулах боломжтой гэж үзсэн ба Монголбанкнаас мөн эдгээр бүтцийн өөрчлөлт хийгдсэн зээлүүдийн эцсийн ангилалыг 2020 оны 1 дүгээр сарын 31-нээрх эцсийн ангилал байна гэж зөвшөөрсөн.

Гэвч банкны зүгээс өндөр эрсдэлтэй гэж үзсэн зээлүүд дээр нэмэлт эрсдэлийн санг байгуулсан.

Хэрэв дээрх тогтоолууд гараагүй бол 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Банкны харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын сан 17,847,824 мян.төг-өөр нэмэгдэж, нийт 521,395,128 мян.төг болох байсан.

20. Бусад хөрөнгө

	2020 мян.төг	2019 мян.төг
Урьдчилж төлсөн зардал ба урьдчилгаа	24,907,800	19,005,651
Төлбөр тооцооны үйлчилгээний авлага	4,296,893	5,699,551
Хойшлуулсан ажилтнуудын зээл	3,306,669	3,719,276
Хэрэглээний болон бусад хангамжын материал	2,417,272	1,726,150
Үнэт металл	60,827	307,837
Дуусаагүй барилгын урьдчилгаа төлбөр	44,518,426	25,440,087
Гуравдагч талаас авах бусад авлага	39,246,468	5,888,742
Хасах нь: Гуравдагч талаас авах бусад авлагын үнэ цэнийн бууралтын сан	(17,441,048)	(270,511)
	101,313,307	61,516,783
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	38,511,494	69,676,287
Хасах нь: Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сан	(27,165,495)	(27,404,986)
	11,345,999	42,271,301
Нийт бусад хөрөнгө	112,659,306	103,788,084

Урьдчилж төлсөн зардал ба урьдчилгаанд олон улсын төлбөрийн картын байгууллагад байршуулсан барьцаа төлбөр болох 10,557 сая.төг (2019 онд: 10,128 сая.төг) багтсан.

Хойшлуулсан ажилтнуудын зээлд Банкны ажилтнууддаа хөнгөлөлттэй хүүгээр олгосон зээлийн бодит үнэ цэнийн тохируулгын дүн багтсан. СТОУС-ын дагуу ажилтнуудад олгосон хөнгөлөлттэй зээлийг анх олгоход тохируулах бодит үнэ цэнэ нь цалингийн урьдчилсан төлбөрт хамаарах ба зээлийн хугацаанд хорогдуулдаг.

Дуусаагүй барилгын урьдчилгаа төлбөр нь Банкны шинэ оффисын барилгын ажлыг гүйцэтгүүлэхээр Риверстөүн Пропертиз ХХК (“Риверстөүн”)–д төлсөн урьдчилгаа төлбөрийн дүнг илэрхийлнэ. Нийт гэрээний дүнгийн 51% (2019 онд: 48%)-ийг барилгын ажил гүйцэтгэх гэрээний дагуу Банк төлсөн ба үүнээс дуусаагүй барилгын гүйцэтгэлийн хувийн дагуу урьдчилгаа төлбөрийн 81% (88%)-ийг дуусаагүй барилгаар (Тодруулга 23-ыг харна уу) хүлээн зөвшөөрч бүртгэсэн. Дуусаагүй барилгын ажил нь 2022 онд дуусна гэсэн төлөвтэй байна.

Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгөд Банкны хугацаа хэтэрсэн зээлийн төлбөрт хүлээн авсан үл хөдлөх хөрөнгүүд багтана. Банк нь эдгээр хөрөнгүүдийг ирээдүйд зарж борлуулах төлөвлөгөөтэй.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 дугаар сарын 31****20. Бусад хөрөнгө (үргэлжлэл)**

Доорх хүснэгтээр бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сангийн хөдөлгөөнийг үзүүлэв:

	2020	2019
	мян.төг	мян.төг
Бусад авлагын үнэ цэнийн бууралтын сан		
1 сарын 1-нээр	270,511	724,883
Тайлант үеийн эрсдэлийн сангийн зардал	14,702,354	186,179
Буцаалт	(189,862)	(67,399)
Тайлант үеийн цэвэр эрсдэлийн сангийн зардал (Тодруулга 11)	14,512,492	118,780
Нэгдлийн үр дүнд УБХБ-аас шилжиж ирсэн	2,657,881	–
Тайлант үеийн хасагдуулга	–	(571,419)
Гадаад валютын ханшийн зөрүү	164	(1,733)
12 сарын 31-нээр	17,441,048	270,511

	2020	2019
	мян.төг	мян.төг
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сан		
1 сарын 1-нээр	27,404,986	10,361,264
Тайлант үеийн эрсдэлийн сангийн зардал	18,788,541	19,854,188
Буцаалт	(11,450,848)	(3,254,647)
Тайлант үеийн цэвэр эрсдэлийн сангийн зардал (Тодруулга 11)	7,337,693	16,599,541
Шилжүүлэг (Тодруулга 22)	–	444,181
Тайлант үеийн хасагдуулга	(11,246,598)	–
Нэгдлийн үр дүнд УБХБ-аас шилжиж ирсэн	3,669,414	–
12 сарын 31-нээр	27,165,495	27,404,986

21. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө

	2020	2019
	мян.төг	мян.төг
1 сарын 1-нээр	80,897,528	80,114,526
Шилжүүлэг	42,338,393	–
Нэгдлийн үр дүнд УБХБ-аас шилжиж ирсэн	5,631,893	–
Бодит үнэ цэнийн өөрчлөлт (Тодруулга 10)	20,122,404	783,002
12 сарын 31-нээр	148,990,218	80,897,528

Банкны хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөд оффисын зориулалттай талбай багтана. 2020 ба 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийг хараат бус мэргэшсэн үнэлгээний компанийн гүйцэтгэсэн үнэлгээнд үндэслэсэн.

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийг тооцоолоход ашигласан үнэлгээний аргууд, бодит үнэ цэнийн шатлалын тодруулга болон тэдгээрт ашигласан гол орцуудыг Тодруулга 38-д толилуулав.

22. Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө

	2020	2019
	мян.төг	мян.төг
Барилга байгууламж ба үл хөдлөх хөрөнгө	4,138,693	–

Удирдлагын зүгээс эдгээр барилга байгууламж ба үл хөдлөх хөрөнгийг одоогийн нөхцөл байдалд нь богино хугацаанд борлуулах боломжтой гэж үнэлсэн. Борлуулалтын ажил эхэлсэн байгаа ба эдгээр хөрөнгийг борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгийн ангилалд бүртгэснээс хойш 1 жилийн хугацаанд борлуулна гэж төлөвлөж байна. Тайлангийн өдрийн байдлаар тухайн хөрөнгүүдийг худалдан авах боломжит худалдан авагчдыг тодорхойлон, борлуулалтын хэлцэлийн үйл явц дуусах шатанд байна.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 дугаар сарын 31

23. Үндсэн хөрөнгө

	Барилга байгууламж ба газар мян.төг	Оффисын тоног төхөөрөмж ба тээврийн хэрэгсэл мян.төг	Компьютер ба бусад мян.төг	Дуусаагүй барилга мян.төг	Нийт мян.төг
2020 оны 12 сарын 31-нээр					
Өртөг/дахин үнэлгээгээр					
2020 оны 1 сарын 1-нээр	175,156,275	14,895,699	39,477,689	195,108,901	424,638,564
Нэмэгдсэн	3,125,000	10,755	1,708,753	75,200	4,919,708
Борлуулсан	(3,125,000)	(839,434)	(43,601)	–	(4,008,035)
Данснаас хассан (Тодруулга 12)	–	(30,060)	(175,053)	–	(205,113)
Дахин ангилсан	–	451,328	(451,328)	–	–
УБХБ-аас шилжиж ирсэн	78,876,806	1,565,034	3,708,152	–	84,149,992
2020 оны 12 сарын 31-нээр	254,033,081	16,053,322	44,224,612	195,184,101	509,495,116
Хуримтлагдсан элэгдэл					
2020 оны 1 сарын 1-нээр	4,833,079	6,311,621	21,182,643	–	32,327,343
Тайлант жилийн элэгдлийн зардал (Тодруулга 12)	4,838,078	1,464,026	6,675,868	–	12,977,972
Борлуулсан	(7,593)	(385,554)	(13,725)	–	(406,872)
Данснаас хассан (Тодруулга 12)	–	(19,824)	(151,170)	–	(170,994)
УБХБ-аас шилжиж ирсэн	3,673,798	865,210	1,584,648	–	6,123,656
2020 оны 12 сарын 31-нээр	13,337,362	8,235,479	29,278,264	–	50,851,105
Дансны цэвэр дүн	240,695,719	7,817,843	14,946,348	195,184,101	458,644,011

	Барилга байгууламж ба газар мян.төг	Оффисын тоног төхөөрөмж ба тээврийн хэрэгсэл мян.төг	Компьютер ба бусад мян.төг	Дуусаагүй барилга мян.төг	Нийт мян.төг
2019 оны 12 сарын 31-нээр					
Өртөг/дахин үнэлгээгээр					
2019 оны 1 сарын 1-нээр	172,858,275	20,394,732	29,367,629	172,529,071	395,149,707
Нэмэгдсэн	2,298,000	2,182,946	11,521,121	22,579,830	38,581,897
Борлуулсан	–	(7,739,667)	(1,016,194)	–	(8,755,861)
Данснаас хассан	–	57,688	(394,867)	–	(337,179)
2019 оны 12 сарын 31-нээр	175,156,275	14,895,699	39,477,689	195,108,901	424,638,564
Хуримтлагдсан элэгдэл					
2019 оны 1 сарын 1-нээр	1,475,901	5,069,075	16,544,714	–	23,089,690
Тайлант жилийн элэгдлийн зардал (Тодруулга 12)	3,357,178	1,304,461	5,653,777	–	10,315,416
Данснаас хассан	–	(61,915)	(1,015,848)	–	(1,077,763)
2019 оны 12 сарын 31-нээр	4,833,079	6,311,621	21,182,643	–	32,327,343
Дансны цэвэр дүн	170,323,196	8,584,078	18,295,046	195,108,901	392,311,221

Дуусаагүй барилгын дансанд банкны шинэ оффисын дуусаагүй барилга орсон. Банк нь шинэ төв оффисын барилгыг барьж гүйцэтгэх гэрээг Риверстөүнтэй байгуулсан (Тодруулга 20-г харна уу). Барилгыг 2022 онд барьж дуусгахаар төлөвлөж байна.

Барилга байгууламжийг бодит үнэ цэнээр хэмждэг. 2020 оны 12 дугаар сарын 31-нээр дахин үнэлэгдсэн барилга байгууламж ба газар нь түүхэн өртгөөрөө санхүүгийн тайланд тайлагнагдсан бол дансны цэвэр дүн нь 114,610 сая.төг (2019 онд: 77,417 сая.төг) байна.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 дугаар сарын 31

23. Үндсэн хөрөнгө (үргэлжлэл)

2018 онд Банк өөрийн эзэмшлийн газар, барилга байгууламжийн бодит үнэ цэнийг тогтоохдоо хараат бус мэргэшсэн үнэлгээнээр үнэлгээ хийлгүүлсэн. Зах зээлийн харьцуулах үнэлгээний аргыг бодит үнэ цэнийг тодорхойлоход ашигладаг. Бодит үнэ цэнийг тодорхойлоход ашигласан үнэлгээний аргуудыг түүнд ашигласан гол орцууд ба бодит үнэ цэнийн шатлалын тодруулгыг Тодруулга 38-т толилуулсан болно.

24. Ашиглах эрхтэй хөрөнгө ба түрээсийн өглөг

Банк нь өөрийн үйл ажиллагаанд ашигладаг салбаруудын оффисын талбайг түрээслэх гэрээтэй. Эдгээр түрээсүүд нь дунджаар дөрвөн жилийн түрээсийн хугацаатай байдаг. Банкны түрээсийн гэрээний дагуу хүлээсэн үүрэг нь түрээслүүлэгчийн өмчлөх эрхээр баталгаажсан болно.

Банк нь 12 сар болон түүнээс бага хугацаагаар оффисын талбай, авто машины зогсоол, АТМ-ийн талбайг түрээслэдэг. Банкны хувьд “богино хугацаат түрээс” гэсэн түрээсийн чөлөөлөлтийг эдгээр хөрөнгийн хувьд ашигласан.

Ашиглах эрхтэй хөрөнгө ба түрээсийн өглөгийн дансны дүн ба тайлант жилийн хөдөлгөөнийг дор харуулав:

	Ашиглах эрхтэй хөрөнгө мян.төг	Түрээсийн өглөг мян.төг
2019 оны 1 сарын 1-нээр	15,605,301	(15,605,301)
Нэмэгдсэн	1,043,140	(1,043,140)
Тайлант жилийн элэгдлийн зардал (Тодруулга 12)	(3,930,742)	–
Хүүгийн зардал (Тодруулга 9)	–	(2,135,697)
Түрээсийн төлбөр	–	5,192,740
2019 оны 12 сарын 31 ба 2020 оны 1 сарын 1-нээр	12,717,699	(13,591,398)
Нэмэгдсэн	1,682,331	(1,682,331)
УБХБ-аас шилжиж ирсэн	1,085,892	(970,544)
Цуцлагдсан түрээс	(487,733)	541,925
Тайлант жилийн элэгдлийн зардал (Тодруулга 12)	(4,865,339)	–
Хүүгийн зардал (Тодруулга 9)	–	(1,821,379)
Түрээсийн төлбөр	–	6,139,205
2020 оны 12 сарын 31-нээр	10,132,850	(11,384,522)

Түрээсийн өглөгийн хугацааны шинжилгээг Тодруулга 40-д тусгасан болно.

2020 оны 12 сарын 31-ний байдлаар Банкны богино хугацаат түрээсийн зардал 408,258 мян.төг (2019 онд: 796,128 мян.төг) байв. Үйл ажиллагааны зардалд Ашиглалтын зардлаар хүлээн зөвшөөрсөн зардалд индекс эсвэл хүүний хувиас үл хамаарах хувьсах түрээсийн төлбөр болох 363,139 мян.төг (2019 онд: 321,571 мян.төг) багтсан.

25. Биет бус хөрөнгө

	2020 мян.төг	2019 мян.төг
Өртгөөр		
1 сарын 1-нээр	17,061,275	11,865,156
Нэмэгдсэн	381,917	4,858,940
Шилжилт	–	337,179
УБХБ-аас шилжиж ирсэн	1,947,423	–
Данснаас хассан (Тодруулга 12)	(2,894,948)	–
12 сарын 31-нээр	16,495,667	17,061,275
Хуримтлагдсан хорогдуулалт		
1 сарын 1-нээр	11,190,658	9,088,747
Тайлант жилийн хорогдуулга (Тодруулга 12)	2,421,188	2,101,911
УБХБ-аас шилжиж ирсэн	1,058,279	–
Данснаас хассан (Тодруулга 12)	(2,548,872)	–
12 сарын 31-нээр	12,121,253	11,190,658
Дансны цэвэр дүн	4,374,414	5,870,617

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 дугаар сарын 31

26. Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж

	2020 мян.төг	2019 мян.төг
Банк санхүүгийн байгууллагын харилцах	15,623,929	23,482,750
Банк санхүүгийн байгууллагын хугацаатай хадгаламж	87,322,215	165,901,028
	102,946,144	189,383,778

2020 оны 12 сарын 31-ний байдлаарх Банк, санхүүгийн байгууллагын хугацаат хадгаламжинд жилийн 10.80% хүүтэй, 16-25 хүртэлх сарын хугацаатай төгрөгийн хадгаламжууд багтсан (2019 онд: 3-12 сарын хугацаатай жилийн 5.0%-иас 6.0% хүртэлх хүүтэй америк долларын хадгаламж болон жилийн 10% хүүтэй төгрөгийн хадгаламжуудаас бүрдсэн).

27. Репо хэлцэл

	2020 мян.төг	2019 мян.төг
Монголбанктай хийсэн урвуу репо хэлцэл	129,140,869	–
Чанаргүй активыг бууруулах хөтөлбөр	65,013,356	65,013,356
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөтөлбөр	30,133,391	–
	224,287,616	65,013,356

2020 оны 12 сарын 31-ний өдрөөр Банк нь Монголбанктай богино хугацаат репо хэлцэл хийж, хөрөнгийн биржид бүртгэлгүй 130 тэрбум төгрөгийн Монголбанкны үнэт цаасыг зарсан. Гэрээ нь жилийн 7.0% хүүтэй бөгөөд 2021 оны 1 сарын 4-ний өдөр дуусгавар болох хугацаатай.

Түүнчлэн, 2020 оны 12 дугаар сард Банк нь Монголбанктай урт хугацаат урвуу репо хэлцэл хийж, хөрөнгийн биржид бүртгэлгүй 30,290,000 мян.төгрөгийн Монголбанкны үнэт цаасыг борлуулсан. Уг гэрээг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөтөлбөрийн хүрээнд хийсэн ба гэрээний дагуу Банк нь шаардлага хангасан зээлдэгч нарт санхүүжилт олгож, тэдгээр зээлүүдийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд борлуулах үүрэгтэй ба хариуд нь хөрөнгөөр баталгаажсан бондыг хүлээн авна. Гэрээ нь жилийн 6.5% хүүтэй бөгөөд 2022 оны 11 сард дуусгавар болно.

2016 онд Банк нь Монголбанктай репо хэлцэл хийж, гурван тусдаа гэрээгээр нийтдээ 65,000,000 мян.төгрөгийн ХБ-н бондыг борлуулсан (Тодруулга 16). Гэрээнүүд нь жилийн 7.5% хувийн хүүтэй бөгөөд 2021 оны 10, 11, 12 саруудад тус тус дуусгавар болно.

28. Харилцагчдын харилцах, хадгаламж

	2020 мян.төг	2019 мян.төг
Засгийн газар		
- Харилцах данс	98,868,115	277,288,218
- Хугацаат хадгаламж	190,123,522	107,613,567
- Хугацаагүй хадгаламж	101,586,079	–
- Баталгааны эх үүсвэр	10,779,093	10,687,997
Хувийн сектор		
- Харилцах данс	901,330,229	764,207,019
- Хугацаат хадгаламж	601,095,942	503,991,177
- Баталгааны эх үүсвэр	58,331,514	59,124,327
- Бусад	112,866	507,890
- Хугацаагүй хадгаламж	172,252,719	894
Иргэд		
- Хугацаат хадгаламж	2,392,848,222	1,559,123,843
- Хугацаагүй хадгаламж	471,415,909	283,447,438
- Харилцах данс	308,651,933	254,628,922
- Бусад	4,022,040	812,842
	5,311,418,183	3,821,434,134

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 дугаар сарын 31

29. Зээлээр авсан санхүүжилт

	2020 мян.төг	2019 мян.төг
Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр		
Коммерзбанк ЭйЖи	153,283,109	10,426,411
Транскапитал Банк	42,860,755	27,439,394
ОХУ-ын ВиТиБи Банк	39,138,422	155,554,252
Азийн Хөгжлийн Банк	30,657,129	24,397,994
Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны агентлаг	19,747,864	20,671,649
Атлантик Форфайт Ирингс ЭйЖи	16,244,833	9,312,103
Олон Улсын Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Банк	12,741,515	3,124,045
ЮБиАй Банк	8,705,169	10,017,762
Москвагийн Кредит Банк	7,168,132	–
Эрстэ Групп Банк	6,848,035	16,462,860
БНХАУ-ын Үйлдвэр, Худалдааны Банк	5,381,672	7,555,807
KfW төсөл	5,102,212	3,282,210
Оддо БиЭйчЭф ЭйЖи	2,979,648	–
БНХАУ-ын Трейд Солюшнс	2,075,364	1,650,580
Олон Улсын Хөгжлийн Ассоциаци	1,109,650	1,130,275
БНХАУ-ын Экспорт-Импортын Банк	838,379	1,352,495
Өвөр Монголын Банк	289,080	60,866,396
Кроудкредит Эстони ӨүЮү	275,721	2,481,013
Дэлхийн банк	243,602	288,795
Дойче Банк ЭйЖи	–	56,769,907
БНХАУ-ын Хөгжлийн Банк	–	56,459,336
Хуишан Банк	–	48,034,171
Япон Олон Улсын Хамтын Ажиллагааны Банк	–	7,347,512
Банка Пополэр ди Сондрио	–	5,618,841
Сумитомо Мицуй Банк Корпораци	–	3,346,223
Баошан Банк	–	1,122,392
АйЭнЖи Банк	–	566,792
Засгийн газраас санхүүжсэн эх үүсвэр		
Монголбанк, Сангийн яам - Орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөр	93,938,943	99,000,370
Монгол Улсын Хөгжлийн Банк	74,583,772	124,798,312
Монголбанк-ны "Алт-2" хөтөлбөрийн санхүүжилт	33,760,274	–
Сангийн Яам	760,556	–
Боловсролын зээлийн сан	2,518	–
Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	–	212,810
	558,736,354	759,290,707

Ноос ноолуур хөтөлбөрийн хүрээнд Хөгжлийн банкнаас авсан болон Коммерзбанк ЭйЖи-ээс авсан 1,678 сая.төг (2019 онд: 1,979 сая.төг) ба 50 сая америк долларын (2019 онд: тэг) үлдэгдэлтэй эх үүсвэрүүдээс бусад зээллэгээр авсан санхүүжилтүүд нь барьцаагүй байна. Хөгжлийн банкны эх үүсвэрт Банкны 1.8 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэтэй Монголбанкны үнэт цаасыг барьцаалсан (Тодруулга 16). Харин Коммерзбанк ЭйЖи-ээс авсан эх үүсвэрт Тодруулга 15-д толилуулсан гадаадын банканд байшуулсан барьцааны дансанд багтсан 142.5 тэрбум төгрөгийн бэлэн мөнгө барьцаалсан.

Зээлийн гэрээнүүдийн ихэнх нь санхүүгийн тодорхой шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байхыг Банкнаас шаарддаг ба тус нөхцөлүүдийг дараах төрлүүдэд ангилан үзүүлж болно:

- Өөрийн хөрөнгийн харьцаа (эрсдэлээр жигнэсэн өөрийн хөрөнгийн харьцаа, 1 дүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон нийт хөрөнгийн харьцаа)
- Санхүүгийн эрсдэлийн холбогдох харьцаа үзүүлэлтүүд (гадаад валютын эрсдэлийн харьцаа, нийт гадаад валютын нээлттэй позиц, нэгж гадаад валютын арилжааны эрсдэлийн харьцаа, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа)
- Зээлтэй холбоотой харьцаа үзүүлэлтүүд (хамгийн том нэг зээлдэгч болон өөрийн хөрөнгийн харьцаа, холбоотой талын зээлийн харьцаа, нийт томоохон нөлөөллийн харьцаа)
- Бусад харьцаа үзүүлэлтүүд (нийт хөрөнгөд эзлэх эргэлтийн бус хөрөнгийн харьцаа, нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн харьцаа гэх мэт)

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 дугаар сарын 31

29. Зээлээр авсан санхүүжилт (үргэлжлэл)

Биелүүлсэн байх шаардлагатай харьцаа үзүүлэлтүүдийг хангаагүй тохиолдолд жишээ нь, Банк холбогдох зээлийн үүргийг биелэгдээгүй бол зээлээр авсан санхүүжилт нь нэхэмжилсэн үед төлөгдөх шаардлагатай болно. Тиймээс Банк эдгээр харьцаа үзүүлэлтүүдийн биелэлтийг сар болгон хянан ажилладаг.

30. Хоёрдогч өглөг

	2020 мян.төг	2019 мян.төг
Юнайтед Банкинг Корпорэйшн ХХК	—	150,046,057

2019 онд Банк нь Юнайтед Банкинг Корпорэйшн ХХК-аас 150 тэрбум төгрөгийг санхүүжилтийг хоёрдогч өглөг хэлбэрээр авсан. Хоёрдогч өглөг нь жилийн 15.0% хүүтэй бөгөөд 2025 оны 1 сарын 2-ны өдрөөр гэрээний дагуу төлөгдөх байсан. Хоёрдогч өглөгийг 2020 оны 12 сарын 1-ний өдөр бүрэн барагдуулсан.

31. Гаргасан өрийн бичиг

	2020 мян.төг	2019 мян.төг
Олон улсын зах зээлд гаргасан өрийн бичиг	—	1,376,348,436
Дотоодын зах зээлд гаргасан өрийн бичиг	160,140,274	160,140,274
	160,140,274	1,536,488,710

Банк нь 2015 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр эхлүүлсэн 500 сая америк долларын Глобал Дунд Хугацааны Өрийн Бичиг (“ГДХӨБ”) хөтөлбөрийн хүрээнд 2015 оны 5 дугаар сарын 19-ний өдөр 500 сая америк долларын баталгаатай бондыг (Монгол Улсын Засгийн газрын нэмэлт нөхцөл, буцалтгүй баталгаагаар баталгаажсан) гаргасан. Бонд нь 2020 оны 5 дугаар сарын 19-нд дуусгавар болох ба хагас жил тутам төлөх нөхцөлтэй жилийн 9.375% нэрлэсэн хүүтэй байсан. Бондын дуусгавар болох өдөр төлбөрийг бүрэн барагдуулсан.

ЧАБХ-ын хүрээнд, 2016 оны 6 дугаар сарын 28-нд Банк нь 160 тэрбум төгрөгийн өрийн бичиг гаргаж Монголбанканд арилжаалсан (Тодруулга 19). Өрийн бичгийн дуусах хугацаа нь 2021 оны 6 дугаар сарын 28 ба хагас жил тутам төлөх нөхцөлтэй, жилийн 8%-ийн хүүтэй.

32. Бусад өр төлбөр

	2020 мян.төг	2019 мян.төг
МИК-д үүрэгтэй худалдсан зээлийн багцын өглөг (Тодруулга 19)	558,248,580	435,050,735
Хойшлогдсон клирингийн төлбөр тооцоо	53,666,531	55,741,656
Гуравдагч талд өгөх өглөг	7,246,376	9,233,977
Хойшлогдсон орлого	3,732,611	4,383,314
Компьютерийн түрээсийн өглөг	1,034,874	1,496,274
Тэнцлийн гадуурх үүргийн нөөц (Тодруулга 36)	708,343	1,360,520
Орлогын албан татвараас бусад татварын өглөг	2,680,345	395,693
Бусад	1,085,586	858,332
	628,403,246	508,520,501

Хойшлогдсон клирингийн төлбөр тооцоо нь бэлэн мөнгө болон төлбөр тооцоотой хамааралтай байдаг. Холбогдох төлбөр нь дараа ажлын өдөрт бүрэн төлөгддөг.

Хойшлогдсон орлого нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас урьдчилж авсан хүүгийн орлого болон өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн борлуулалтаас хэсэгчлэн хүлээн авсан төлбөртэй холбоотой.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 дугаар сарын 31

33. Энгийн хувьцаа, нэмж төлөгдсөн капитал ба бусад нөөц

Энгийн хувьцаа ба нэмж төлөгдсөн капитал

	Гаргасан энгийн хувьцааны тоо		Энгийн хувьцаа		Нэмж төлөгдсөн капитал	
	2020	2019	2020 мян.төг	2019 мян.төг	2020 мян.төг	2019 мян.төг
1 сарын 1-нээр	3,305,102	3,649,150	50,000,707	55,205,582	19,298,006	210,393,158
Нэмж гаргасан хувьцаа	1,501,980	–	22,722,464	–	231,788,748	–
Эргэлтээс гаргасан	–	–	–	–	–	–
энгийн хувьцаа	–	(344,048)	–	(5,204,875)	–	(191,095,152)
12 сарын 31-нээр	4,807,082	3,305,102	72,723,171	50,000,707	251,086,754	19,298,006

Банк 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 5,000,000 (2019 онд: 4,000,000) ширхэг хувьцаа гаргах эрхтэй байсан үүнээс нийт 4,807,082 ширхэг хувьцаа (2019 онд: 3,305,102)-г гаргасан байна. Гаргасан бүх хувьцааны төлбөрийг хүлээн авсан ба нэгж хувьцааны нэрлэсэн үнэ нь 15,128 төгрөг байна.

2018 онд Монголбанкны зөвшөөрлийн дагуу Банк нь өөрийн хөрөнгийг нэмэгдүүлсэн боловч уг зөвшөөрлийг 2019 онд Монголбанкнаас цуцалсан тул нэмж гаргасан хувьцааг эргэлтээс гаргасан.

Нэгдлийн үр дүнд Банк 15,128 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 659,282 ширхэг хувьцааг нэмж гаргасан. Банкуудын нэгдэл болон нэмж гаргасан хувьцааг Монголбанк 2020 оны 6 дугаар сарын 23-нд баталсан. Банк нь УБХБ-аас шилжиж ирсэн цэвэр хөрөнгө (дахин үнэлгээний нөөцөөс бусад)-ийн дүн ба нэгдлийн үр дүнд нэмж гаргасан энгийн хувьцааны дүнгийн зөрүүг нэмж төлөгдсөн kapitалаар хүлээн зөвшөөрсөн.

Түүнчлэн, 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдөр Банк нь Монголбанк зөвшөөрсөний дагуу нэг бүр нь 178,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 842,688 ширхэг энгийн хувьцааг хуучин хувьцаа эзэмшигчдийнхээ нэгд гаргаж энгийн хувьцаагаа 150 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн.

2020 ба 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банкны хувьцаа эзэмшигчид, тэдгээрийн эзэмшлийн хувь дараах байдалтай байна:

	2020	2019
Глобулл Инвестмент ба Девелопмент ЭсСиЭй	45.26%	65.83%
Юнайтед Банкинг Корпорэйшн ХХК	31.25%	19.95%
Должингийн Эрдэнэбилэг	13.71%	–
ЮүЭс Глобал Инвестмент ХХК	5.03%	7.32%
ЖиЭс Монголиа Инвестмент Лимитед (Голдман Сакс)	3.28%	4.78%
Бусад хувьцаа эзэмшигчид	1.47%	2.12%
	100.00%	100.00%

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 дугаар сарын 31

33. Энгийн хувьцаа, нэмж төлөгдсөн капитал ба бусад нөөц (үргэлжлэл)

Бусад нөөц

	Хөрөнгийн дахин үнэлгээний нөөц мян.төг	Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын үнэлгээний нөөц мян.төг	Мөнгөн гүйлгээний хейджийн нөөц мян.төг	Нийт мян.төг
2020 оны 1 сарын 1-нээр	129,231,895	22,244,890	–	151,476,785
Бодит үнэ цэнийн цэвэр өөрчлөлт	–	889,293	6,693,889	7,583,182
Борлуулсан ба данснаас хассан	(17,689)	–	–	(17,689)
УБХБ-аас шилжиж ирсэн	39,744,614	–	–	39,744,614
Нэгдлийн үр дүнд хүлээн зөвшөөрсөн хараат компанийн нөөцийн дахин ангилал	–	3,277,296	–	3,277,296
Ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн хейджийн хэрэгслийн дахин үнэлгээний дүн	–	–	(6,693,889)	(6,693,889)
Бодит үнэ цэнийн өөрчлөлт дахь татварын нөлөө (Тодруулга 13.3)	–	(2,313,418)	–	(2,313,418)
2020 оны 12 сарын 31-нээр	168,958,820	24,098,061	–	193,056,881
2019 оны 1 сарын 1-нээр	129,231,895	10,738,119	29,398,246	169,368,260
Бодит үнэ цэнийн цэвэр өөрчлөлт	–	7,847,158	–	7,847,158
Хейджийн хэрэгслийн бодит үнэ цэнийн олз	–	–	6,054,050	6,054,050
Ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрсөн хейджийн хэрэгслийн дахин үнэлгээний дүн	–	–	(35,452,296)	(35,452,296)
Борлуулсан ба данснаас хассан	–	3,659,613	–	3,659,613
2019 оны 12 сарын 31-нээр	129,231,895	22,244,890	–	151,476,785

34. Сегментийн тайлан

Сегментийн мэдээллийг Банкны бизнесийн сегментэд үндэслэн тайлагнадаг. Банкны удирдлагын болон дотоод тайлагналын бүтэц зохион байгуулалтад суурилан сегментийн тайлангийн бүтэц болон үйл ажиллагааны сегментийг толилуулдаг.

Үйл ажиллагааны сегментүүд нь хөрөнгө ба санхүүжилтийн өртгийг оновчтой хуваарилах зорилгоор сунгасан гарын зарчмаар тодорхойлсон хүүгийн төлбөрийг Хөрөнгө зохицуулалтын газарт төлж эсвэл хүлээн авах гүйлгээ хийдэг.

Сегментийн хөрөнгийн нэмэгдэл нь гудвиллээс бусад үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгийг худалдан авахад гарсан нийт өртгийн дүнтэй тэнцүү байна.

Үйл ажиллагааны сегментүүд

Банкны үйл ажиллагааны сегмент нь дараах үндсэн сегментүүдээс бүрдэнэ:

Байгууллагын банк: Байгууллагын харилцагчдын харилцахын үлдэгдэл, зээл, хадгаламж болон бусад гүйлгээнүүдээс бүрдэнэ. Банк нь байгууллагын банкны харилцагчдын ангилалд 3 тэрбум төгрөгөөс дээш зээлийн үлдэгдэлтэй эсвэл жилийн борлуулалтын орлогын хэмжээ нь 6 тэрбум төгрөгөөс дээш харилцагчид (эсвэл санхүүгийн тайланг нь авах боломжгүй харилцагчдын хувьд Банканд хадгалуулсан харилцах дансаар гүйлгээ хийсэн хоёр жилийн дундаж нийт орлого 4 тэрбумаас дээш) болон Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийг оруулдаг.

Жижиг, Дунд Байгууллагын (ЖДБ) банк: Жижиг, дунд байгууллагын харилцагчдын харилцахын үлдэгдэл, зээл, хадгаламж болон бусад гүйлгээнүүдээс бүрдэнэ. Уг ангилалд Банканд 3 тэрбум төгрөг хүртэл зээлийн үлдэгдэлтэй, санхүүгийн тайлангаар жилийн 6 тэрбум төгрөг хүртэлхи борлуулалтын орлоготой харилцагчийг хамруулах (эсвэл санхүүгийн тайланг нь авах боломжгүй харилцагчдын хувьд Банканд хадгалуулсан харилцах дансаар гүйлгээ хийсэн хоёр жилийн дундаж нийт орлого 4 тэрбумаас доош) ба бизнесийн шинж чанартай бүтээгдэхүүн болон үйлчилгээ авч буй иргэдийг оруулна.

Иргэдийн банк: Жижиг, дунд байгууллагын банкны харилцагчдын шалгуур үзүүлэлтэд орсон бүтээгдэхүүн үйлчилгээнээс бусад бизнесийн бус зориулалттай бүтээгдэхүүн үйлчилгээ авч буй иргэдийг уг ангилалд хамруулна. Иргэдийн орон сууцны зээл, хэрэглээний зээл, хадгаламж, иргэдтэй хийж буй бусад гүйлгээ болон дижитал банк зэрэг орно. Банк цалин, тогтмол орлоготой үйлчлүүлэгчдээ иргэдийн сегментэд ангилдаг. Иргэдийн банк нь орлого, хадгаламж, хөрөнгийн түвшингээс хамааран Премиер, Ви Ай Пи, Комфорт, Классик гэсэн дэд сегментээс бүрдэнэ.

34. Сегментийн тайлан (үргэлжлэл)

Үйл ажиллагааны сегментүүд (үргэлжлэл)

Олон улсын байгууллагын банк: Олон улсын санхүүгийн зах зээлд бонд гаргах, санхүүгийн байгууллагаас санхүүжилт авах, уг зах зээл дээр арилжаа хийх үйл ажиллагааг хариуцдаг.

Хөрөнгө зохицуулалт: Үйл ажиллагаа нь Банкны хөрөнгийн удирдлагын үйл ажиллагаа юм. Үүнд зээл авах, өрийн бичиг гаргах, эрсдэлийн удирдлагын зорилгоор дериватив хэрэгсэл ашиглах, богино хугацаат хадгаламж хийх, Монголбанк, Засгийн Газрын болон компанийн өрийн бичиг зэрэг түргэн хөрвөх хөрөнгөнд хөрөнгө оруулалт хийх зэргээр Банкны санхүүжилт, эрсдэлийг төвлөрсөн удирдлагаар хангах үүргүүд багтдаг.

Бусад: Банкны байр болон аж ахуйн нэгжийн тодорхой зардлыг зохицуулдаг төв оффисын үйл ажиллагаа, төвлөрсөн дундын үйлчилгээний үйл ажиллагааг багтаасан болно.

Банк нь зөвхөн Монгол улсад үндсэн үйл ажиллагаа эрхэлдэг тул нэмэлтээр газарзүйн сегментийн талаар нэмэлт мэдээлэл тайлагнадаггүй. Банкны нэг харилцагчтай эсвэл гэрээний талтай хийсэн гүйлгээний орлого нь 2020 эсвэл 2019 оны нийт орлогын 10%-иас ихгүй байсан.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31

34. Сегментийн тайлан (үргэлжлэл)

2020 оны 12 сарын 31-нээр	Байгууллагын банк мян.төг	Жижиг, дунд байгууллагын банк мян.төг	Иргэдийн банк мян.төг	Олон улсын байгууллагын банк мян.төг	Хөрөнгө зохицуулалтын газар мян.төг	Бусад мян.төг	Нийт мян.төг
Сегментийн үр дүн							
Гадаад орлого							
Цэвэр хүүгийн орлого/(зардал)	139,374,202	50,481,235	(94,747,808)	(37,190,622)	144,555,494	(747,389)	201,725,112
Хураамж ба шимтгэлийн орлого	4,636,806	3,259,698	13,195,270	30,031,851	409,666	2,539,676	54,072,967
Хураамж ба шимтгэлийн зардал	(3,561)	–	(11,666,633)	(463)	(131,248)	(2,906,906)	(14,708,811)
Бусад үйл ажиллагааны цэвэр орлого/(зардал)	3,447,161	–	(5,657,950)	–	(20,762,595)	17,300,937	(5,672,447)
Сегмент хоорондын орлого/(зардал)	(116,839,576)	5,229,836	177,072,921	13,851,987	(171,312,362)	91,997,194	–
Нийт сегментийн орлого/(зардал)	30,615,032	58,970,769	78,195,800	6,692,753	(47,241,045)	108,183,512	235,416,821
Үйл ажиллагааны зардал	6,905,689	220,917	405,804	2,912,624	2,869,522	118,287,639	131,602,195
Хараат компанийн алдагдлын Банканд ногдох хувь	–	–	–	–	14,501,873	–	14,501,873
Санхүүгийн хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал	23,157,266	6,423,339	21,930,756	–	2,515,394	10,648,562	64,675,317
Татварын өмнөх ашиг/(алдагдал)	552,077	52,326,513	55,859,240	3,780,129	(67,127,834)	(20,752,689)	24,637,436
Орлогын албан татварын зардал	–	–	–	–	(1,921,609)	5,582,018	3,660,409
Тайлант жилийн цэвэр ашиг/(алдагдал)	552,077	52,326,513	55,859,240	3,780,129	(65,206,225)	(26,334,707)	20,977,027
Сегментийн хөрөнгө	3,194,436,232	303,501,642	670,269,700	31,289	3,167,711,051	780,868,116	8,116,818,030
Сегментийн өр төлбөр	2,202,554,586	857,174,662	3,108,776,374	360,746,159	548,820,303	21,234,823	7,099,306,907
Элэгдэл ба хорогдуулга	187,927	1,278	4,879,336	16,288	155,581	15,024,089	20,264,499
Хөрөнгийн нэмэгдэл*	1,453,202	6,301	25	3,543	–	3,838,554	5,301,625

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 дугаар сарын 31

34. Сегментийн тайлан (үргэлжлэл)

2019 оны 12 сарын 31-нээр	Байгууллагын банк мян.төг	Жижиг, дунд байгууллагын банк мян.төг	Иргэдийн банк мян.төг	Олон улсын байгууллагын банк мян.төг	Хөрөнгө зохицуулалтын газар мян.төг	Бусад мян.төг	Нийт мян.төг
Сегментийн үр дүн							
Гадаад орлого							
Цэвэр хүүгийн орлого/(зардал)	293,351,716	57,281,840	(130,353,063)	(186,037,170)	145,785,155	(118,251)	179,910,227
Хураамж ба шимтгэлийн орлого	7,280,430	(384,082)	47,533,110	368,558	707,270	(63,087)	55,442,199
Хураамж ба шимтгэлийн зардал	(517)	–	(14,900,509)	–	(119,905)	(48,638)	(15,069,569)
Бусад үйл ажиллагааны цэвэр орлого/(зардал)	1,289,991	–	7,265,116	–	23,031,156	481,192	32,067,455
Сегмент хоорондын орлого/(зардал)	(239,939,629)	(3,453,581)	201,696,135	193,744,203	(152,006,607)	(40,521)	–
Нийт сегментийн орлого/(зардал)	61,981,991	53,444,177	111,240,789	8,075,591	17,397,069	210,695	252,350,312
Үйл ажиллагааны зардал	2,897,156	18	50,594,611	5,298,517	3,317,975	67,780,197	129,888,474
Санхүүгийн хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал	37,181,478	4,290,567	16,504,129	–	16,468	94,285	58,086,927
Татварын өмнөх ашиг/(алдагдал)	21,903,357	49,153,592	44,142,049	2,777,074	14,062,626	(67,663,787)	64,374,911
Орлогын албан татварын зардал	–	–	–	–	–	206	206
Тайлант жилийн цэвэр ашиг/(алдагдал)	21,903,357	49,153,592	44,142,049	2,777,074	14,062,626	(67,663,993)	64,374,705
Сегментийн хөрөнгө	2,678,840,188	350,794,030	674,196,579	–	3,569,685,356	550,181,412	7,823,697,565
Сегментийн өр төлбөр	29,409,430	560,583	3,485,242,435	1,914,125,500	1,673,281,520	17,375,702	7,119,995,170
Элэгдэл ба хорогдуулга	31,257	–	5,952,756	13,335	12,591	10,338,130	16,348,069
Хөрөнгийн нэмэгдэл*	52,524	–	11,624,813	25,177	9,183	31,729,140	43,440,837

*Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгийн нэмэгдэлийг илэрхийлнэ.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31

35. Мөнгөн гүйлгээний нэмэлт мэдээлэл

	2020 мян.төг	2019 мян.төг
Бэлэн мөнгө ба Монголбанканд байршуулсан мөнгө (Тодруулга 14)	856,968,353	1,096,100,972
Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө (Тодруулга 15)	570,008,607	301,381,272
Биржид бүртгэлгүй Монголбанкны үнэт цаас - 3 сараас доош хугацаатай (Тодруулга 16)	688,492,320	598,900,912
Нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	2,115,469,280	1,996,383,156
Хасах нь: Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд ашигладаггүй Монголбанканд байршуулсан заавал байлгах нөөц	(593,534,740)	(465,197,209)
Хасах нь: Гадаадын банканд байршуулсан барьцаа	(143,779,003)	(15,250,230)
Хасах нь: Дотоодын банканд байршуулсан хамтын зээлжүүлэлтийн эх үүсвэр	–	(87,601,514)
Хасах нь: Барьцаанд байршуулсан биржид бүртгэлгүй Монголбанкны үнэт цаас - 3 сараас доош хугацаатай	(1,782,246)	(1,988,613)
Цэвэр мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,376,373,291	1,426,345,590

36. Болзошгүй өр төлбөр ба үүрэг

Харилцагчдын санхүүгийн хэрэгцээ, шаардлагыг хангахын тулд, Банк нь янз бүрийн буцалтгүй үүрэг болон болзошгүй өр төлбөр хүлээж байдаг. Хэдийгээр эдгээр үүргийг санхүүгийн байдлын тайланд тусгаагүй байж болох ч, эдгээр нь зээлийн эрсдэл, улмаар Банкны нийт эрсдэлийг бүрдүүлж байдаг (Тодруулга 37-с үзнэ үү).

	2020 мян.төг	2019 мян.төг
Эх үүсвэргүй баталгаа болон аккредитив	289,565,616	350,275,914
Ашиглаагүй зээлийн шугам	275,547,390	179,013,676
	565,113,006	529,289,590

Доорхи хүснэгтээр тэнцлийн гадуурх хүлээж болзошгүй үүрэг дээрх үнэ цэнийн бууралтын сангийн хөдөлгөөнийг харуулав:

	2020 мян.төг	2019 мян.төг
1 сарын 1-нээр	1,360,520	2,055,572
Тайлант жилийн эрсдэлийн сангийн зардал	599,175	1,182,040
Тайлант жилийн буцаалт	(1,251,352)	(1,877,092)
Цэвэр буцаалт (Тодруулга 11)	(652,177)	(695,052)
12 сарын 31-нээр	708,343	1,360,520

2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Банк нь дуусаагүй барилгын гэрээний дагуу 99 сая америк доллар (2019 онд: 106 сая америк доллар)-ын үүрэг хүлээсэн байна (Тодруулга 20 ба 23-аас үзнэ үү).

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2017 оны шийдвэрийн дагуу Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй бүх арилжааны банкууд 2021 оны эцэс гэхэд өөрийн хөрөнгийн доод хэмжээг 100.0 тэрбум төгрөг байлгах шаардлагатай. Банкны дүрмийн сан нь нэмж төлөгдсөн капиталыг оруулан 2020 оны 12 сарын 31-ний байдлаар 323.8 тэрбум байна.

Болзошгүй өр төлбөр

Аккредитив, баталгаа нь тусгай үйл явдал тохиолдоход харилцагчийн өмнөөс голдуу тендер, төлбөрийн баталгаатай холбоотойгоор төлбөр хийх үүргийг банканд ногдуулдаг. Баталгаа нь зээлийн эрсдэлтэй ижил эрсдэлийг агуулдаг.

Үүрэг

Үүрэг гэдэг нь Банкны зүгээс зээл олгох, зээлийн шугам нээх гэрээт үүргүүдийг хүлээснийг илэрхийлдэг. Ийм үүргүүд нь тогтсон дуусах хугацаа эсвэл цуцлах бусад төрлийн заалтуудтай байдаг. Зээл олгох үүрэг нь хэрэгжээгүй байтал тус үүргийнх нь хугацаа нь дууссан байж болох тул гэрээнд заасан дүн нь ирээдүйн мөнгөний шаардлагыг илэрхийлдэг гэсэн ойлголт биш юм.

36. Болзошгүй өр төлбөр ба үүрэг (үргэлжлэл)**Ашиглаагүй зээлийн шугам**

Энэхүү хэрэгслийн гол зорилго нь харилцагчид шаардлагатай хэмжээний санхүүжилт бэлэн байгааг баталгаажуулах юм. Батлагдсан зээлийн шугамын эрхээс ашиглагдаагүй байгаа хэсэг нь зээлийг нэмэгдүүлэх үүргийг тодорхойлно. Зээлийг нэмэгдүүлэх үүргийн эрсдэл нь, ашиглаагүй зээлийн эрхийн хэмжээгээр Банк алдагдал хүлээх эрсдэл юм. Гэсэн хэдий ч, зээлийн эрхийг хэвийн байлгах тодорхой шалгуур үзүүлэлтүүдээс хамааран алдагдлын дүн нь нийт ашиглаагүй зээлийн эрхийн хэмжээнээс бага байх талтай байдаг.

Шүүхийн нэхэмжлэл

Бизнесийн онцлог шинж чанарын улмаас Банкны салбарт аливаа маргааныг шүүхийн үйл ажиллагааны дагуу шийдвэрлэх нь энгийн үзэгдэл байдаг. Банк нь шүүхийн нэхэмжлэлтэй хэрхэн ажиллах талаар тогтсон журамтай. Нэгэнт мэргэжлийн зөвлөгөө авсан, гарч болох хохирлын хэмжээг зохистойгоор тооцоолсон бол Банк нь тухайн нэхэмжлэлийн банкны санхүүгийн байдалд үзүүлж болох сөрөг нөлөөллөөс хамгаалан дансандаа залруулах бичилт хийдэг.

Монголын Татварын Албатай холбоотой татварын маргаан

Татварын ерөнхий газар ("ТЕГ") 2020 онд Банкны 2016-2018 оны албан татвар ногдуулалт, төлөлтийн байдалд шалгалт хийсэн. Шалгалтын үр дүнд хэд хэдэн зөрчил илэрсэн. Тэдгээрийн нэг нь Банк ба ТЕГ-ын чөлөөлөгдөх орлогот ногдох хасагдах зардалыг ялгаатай тодорхойлсон байдлаас үүссэн. ТЕГ нь 2020 оны 2 дугаар сарын 3-ны өдөр нөхөн татвар болон торгуулийн төлбөрт нийт 6,898,140 мян.төгрөгийн төлбөр ногдуулсан ба, үүнээс 4,480,130 мян.төг-ийг Банк зөвшөөрч бүрэн барагдуулсан ба үлдэх 2,418,010 мян.төг-ийн торгуулийг хуульд заасан хэмжээнээс давсан гэж үзсэн тул Банк хүлээн зөвшөөрч төлөөгүй. Банк 2020 оны 3 дугаар сарын 3-нд Татварын ерөнхий газрын дэргэдэх маргаан таслах зөвлөлд ("ТМТЗ") өөрсдийн уг торгуулийн төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа үндэслэлийг тусган гомдол гаргасан. Гэсэн хэдий ч, ТМТЗ уг гомдлыг хэрэгсэхгүй болгосон учир Банк ТМТЗ-ээс албан ёсоор гомдлыг хэрэгсэхгүй болгосон албан бичигийг авсаны дараа 2021 оны 2 дугаар сарын 10-ны өдөр Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан. Удирдлагын зүгээс уг маргаанаас үүсэх алдагдлын магадлал бага болон найдвартай хэмжих боломжгүй гэж үзсэн.

2020 ба 2019 оны 12 дугаар сарын 31-ний тайлант жилийн эцэст дээрхиэс өөр Банканд томоохон үүрэг хүлээх шүүхийн нэхэмжлэл байхгүй байсан.

Татварын тухай хууль тогтоомж

Монгол Улсын татварын хууль тогтоомжид тайлбар, өөрчлөлт тодорхой хэмжээгээр орж байдаг. Банкны гүйлгээ, үйл ажиллагаанд хамааралтай ийм хууль тогтоомжийн талаарх удирдлагын тайлбарыг татварын алба үгүйсгэж болно.

Монголын татварын алба хууль тогтоомж, үнэлгээг тайлбарлахдаа илүү хатуу байр суурь баримталж байгаа бөгөөд урьд өмнө маргаан үүсгээгүй гүйлгээ, үйл ажиллагааг татварын алба няцааж болзошгүй юм. Үүний үр дүнд ихээхэн хэмжээний нэмэлт татвар, торгууль, хүүг тооцож болзошгүй. Санхүүгийн жилүүд татварын талаар хянах жилийн өмнөх таван жилийн хугацаанд эрх бүхий байгууллагуудаар хянуулахад нээлттэй хэвээр байна. Зарим тохиолдолд тойм нь илүү урт хугацааг хамарч болно.

Монгол Улсын үнэ шилжилтийн тухай хууль тогтоомж нь татварын албанд үнэ шилжилтийн тохируулга хийх, хянах боломжтой бүх гүйлгээ, түүний дотор дотоод шилжилтийн үнэтэй холбоотой нэмэлт татварын өр төлбөр ногдуулах боломжийг олгож байна. Гүйлгээний нөхцөл нь зах зээлийн нөхцлөөс гажсан тохиолдолд татварын алба татвар ногдуулах зүйлд тохируулга хийх, нэмэлт татвар, торгууль, хүүгийн торгууль ногдуулах эрхтэй. Одоогийн Монгол Улсын үнэ шилжилттэй холбоотой өөрчлөлтийн үр нөлөөг найдвартай үнэлэх боломжгүй хэдий ч байгууллагын санхүүгийн байдал, нийт үйл ажиллагаанд томоохон нөлөөтэй байх боломжтой.

Монгол Улсын татварын хууль тогтоомж нь тодорхой чиглэлээр, ялангуяа НӨАТ, суутганы албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар болон бусад чиглэлээр эцсийн шийдвэрлэх зааварчилгаа өгдөггүй. Банк нь аль болох ойрхон хугацаанд татварын ерөнхий хэмжээг бууруулж болохуйц эргэлзээтэй хэсгүүдийг тодорхой болгохыг эрмэлздэг. Дээр дурдсанчлан сүүлийн үеийн захиргааны болон шүүхийн үйл ажиллагааны зохицуулалтын өөрчлөлт, шинэчлэлтийн үр дүнд нарийн хяналтын дагуу татварын ийм байр сууриуд бий болж болох юм. Эдгээр нь байгууллагын санхүүгийн байдал болон ерөнхий үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой буюу нөлөөтэй байх боломжтой хэдий ч Татварын албанаас бий болгож болох аливаа шийдвэр, хяналт шалгалтын үр нөлөөг найдвартай үнэлэх боломжгүй билээ.

Удирдлагын зүгээс татварын эрсдэлийн талаар тогтмол үнэлгээ, шинжилгээ хийдэг боловч одоогийн байдлаар хангалттай урьдчилан таамаглах боломжгүй ирээдүйн өөрчлөлтөөс болж нөхцөл байдал өөрчлөгдөж болох юм.

37. Эрсдэлийн удирдлага**(1) Оршил**

Банкны үйл ажиллагааны салшгүй гол эрсдэлүүд бол зээлийн эрсдэл, хөрвөх чадварын эрсдэл, хүүний түвшний эрсдэл, валютын ханшийн эрсдэл, үйл ажиллагааны эрсдэлүүд байдаг. Энэхүү тодруулгад Банкны хөрөнгө зохицуулалт, эрсдэлийн удирдлага ба хяналтын үйл ажиллагаа, бодлого, зорилтууд болон дээр дурьдсан эрсдэлд өртөх байдлын талаарх мэдээллийг толилуулав.

Эрсдэлийн удирдлагын бүтэц, зохион байгуулалт

Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”) нь Банкны эрсдэлийн удирдлагын ерөнхий тогтолцоог хариуцах ба эрсдэлийн удирдлагын бодлого болон эрсдэл хүлээх чадвар болон хүлээн зөвшөөрөх эрсдэлийг тусгасан зээлийн бодлогыг батлах үүрэгтэй. Эрсдэлийг хянах, удирдах үүрэгтэй хараат бус бүрэлдэхүүнүүд мөн байна.

ТУЗ-ийн дэргэдэх эрсдэлийн удирдлагын хороо (“ТУЗЭУХ”)

ТУЗЭУХ нь банкны эрсдэлийн удирдлагын үндсэн чиг хандлагыг тодорхойлж, стратеги, бодлого, зарчмыг батлах ба гүйцэтгэх удирдлага эрсдэлийн удирдлагын бодлогыг банкны үйл ажиллагаанд мөрдүүлж, хэрэгжүүлж ажилладаг. ТУЗЭУХ нь дотоодын аудитын үйл ажиллагаанд туслах үүрэгтэй ажилладаг.

Дотоод аудит

Банкны эрсдэлийн удирдлагын үйл явцад Дотоод аудитын газар жилд нэг удаа аудит хийх ба аудитын үед Банкны журмуудын зохистой байдал хийгээд Банканд дагаж мөрдөж байгаа байдлыг шалгадаг. Дотоод аудит нь журмын зохистой байдлыг шалгахад гадна Банкны журмын мөрдөлт, хэрэгжүүлэлтийг хянадаг.

Гүйцэтгэх удирдлагын хороо

Гүйцэтгэх удирдлагын хороо нь Банкны Гүйцэтгэх удирдлагуудаас бүрдэх бөгөөд Банкны стратегийн асуудал, бизнесийн бодлого төлөвлөлт болон банкны үйл ажиллагааны тогтвортой хөгжлийн талаар хэлэлцэж шийдвэр гаргаж, захируудын харилцан уялдааг ханган ажилладаг.

Актив пассивын удирдлагын хороо (“АПУХ”)

АПУХ нь санхүүжилтийн хөрөнгө болон өр төлбөрийг төвлөрсөн удирдлагаар хангах, хөрвөх чадвар, гадаад валют, эргэн төлөгдөх хугацаа болон хүүгийн эрсдэлийг тодорхой түвшинд хангаж ажиллах үүрэгтэй. АПУХ-ны зорилго нь Банкны санхүүгийн тайлангийн актив пассивын бүтцийг Банкний тогтвортой хөгжлийг хангах байдлаар тогтоох, актив пассивын ерөнхий удирдлагаар ашигт ажиллагаа болон хөрвөх чадварыг хангах мөн валютын, хүүгийн болон зах зээлийн бусад эрсдэлийг хянах болон удирдахад оршино.

Эрсдэлийн удирдлагын хороо (“ЭУХ”)

Эрсдэлийн Удирдлагын хороо нь Банкны болон Банкны бизнес нэгжийн үйл ажиллагаанд учирсан болон учирч болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлох, мөн үйл ажиллагааны эрсдэл, зах зээлийн эрсдэл болон бусад эрсдэлийг багасгах зорилгоор тэдгээрийг үнэлэх, түүнийг хэрэгжүүлэх заавар удирдамж өгч ажилладаг.

Зээлийн хороод

Банкны Эрсдэлийн удирдлагын газар (“ЭУГ”) нь Банкны зах зээл, зээлийн эрсдэлийг удирдах үүргийг хүлээдэг. Зээлийн хорооны бүтцийг Банкны бүх төрлийн зээлийн эрсдэлийг удирдахад дөхөм байхаар зохион байгуулсан. Зээлийн хяналт болон шийдвэр гаргалтанд дараах түвшний Зээлийн хороод оролцдог:

1. Зээлийн ерөнхий хороо нь 500 сая төгрөгөөс дээш дүнтэй зээлийн өргөдлийг хэлэлцэн батлахаас гадна Банкны зээлийн үйл ажиллагааны заавар журмын өөрчлөлтийг батална. Түүнчлэн, одоогийн мөрдөгдөж буй бодлого журмын дагуу тодорхой заасан хэмжээнээс давсан зээлийн саналыг ТУЗ-д танилцуулан батлуулдаг.
2. Жижиглэн зээлийн хороо нь салбар зээлийн хорооны батлах хязгаараас дээш 500 сая төгрөг хүртэлх зээлийн эрсдэлийг баталдаг.
3. Цалин, хадгаламжаар баталгаажсан зээлийн зээлийн хороо нь 20 сая төгрөгөөс дээш цалин, тэтгэврийн зээлийг баталдаг.
4. Зээлийн дэд хороо нь салбарын зээлийн хорооны, тооцооны төв болон бизнес төвүүдийн зээлийн эрхээс давсан 60-180 сая төгрөг, цалин болон тэтгэврийн 20 сая төгрөг хүртэлх зээлийн хүсэлтийг хэлэлцэн батална.

Банкны эрсдэлийн удирдлагын бодлогыг Банканд тулгарч буй эрсдэлийг тодорхойлох, дүн шинжилгээ хийх, эрсдэлийн зохих хязгаарлалт, хяналтыг тогтоох, эрсдэл ба хязгаарлалтад нийцэж буй байдалд хяналт тавих зорилгоор тогтоодог. Зах зээлийн нөхцөл байдал, санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээний өөрчлөлтийг тусгахын тулд эрсдэлийн удирдлагын бодлого, системийг тогтмол хянаж үздэг. Банк нь сургалт, стандарт, журмаараа дамжуулж ажилтнуудаа өөрсдийн үүрэг, хариуцлагаа ухамсарлаж байх сахилга баттай, үр дүнтэй хяналтын орчинг бий болгохыг зорьж байна.

37. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**Эрсдэлийг хэмжих болон тайлагнах систем**

Банк нь статистик загваруудын тусламжтайгаар түүхэн алдагдлаас ойролцоолон тооцсон ердийн тохиолдолд хүлээж болзошгүй алдагдал болон гэнэтийн тохиолдолд учирч болзошгүй онцгой алдагдлыг давхар хэмжиж чадах системийг ашиглан эрсдэлийг хэмждэг. Эдгээр статистик загваруудыг түүхэн өгөгдлөөр тооцсон магадлалыг эдийн засгийн өнөөгийн орчинд нийцүүлэх байдлаар хэрэглэдэг. Эрсдэлийн удирдлага, хяналт нь гол төлөв Банкнаас тогтоосон хязгаарын биелэлтэд суурилна. Эдгээр хязгааруудад Банк өөрийн бизнесийн стратеги зорилт, тухайн зах зээлийн орчин, мөн цаашид хүлээх боломжтой эрсдэлийн түвшинг тусгаж өгсөн байна. Үүнээс гадна Банк нь өөрийн эрсдэл даах чадварыг бүх үйл ажиллагаа болон эрсдэлийн төрлүүдээр тодорхойлон хэмжиж, түүнд хяналт тавьдаг.

Эрсдэлийг цаг тухайд нь олж илрүүлэх, шинжлэх, хянах үүднээс бизнесийн бүх нэгжүүдээс цуглуулсан мэдээллүүдийг шинжилдэг. Боловсруулсан мэдээллээ ТУЗ, ЭУХ, АПУХ, зээлийн хороод болон бүх газар, хэлтсийн захирлуудад танилцуулж, тайлагнана. Тайланд зээлийн эрсдэлд өртөж болох нийт багцын хэмжээ, зээлийн метрикийн таамаглал, хөрвөх чадварын харьцаа болон эрсдэлийн төлөвүүдийн өөрчлөлтийг тусгана.

Улирал бүр Актив пассивын удирдлагын хороо болон Эрсдэлийн хороо нь Банкны эрсдэлд үнэлэлт, дүгнэлт өгөхөд бүх шаардлагатай мэдээллээр хангах зорилготой иж бүрэн эрсдэлийн тайланг хүлээн авдаг. Долоо хоног бүр Актив пассивын удирдлагын хороонд VaR, хөрвөх чадварын шинжилгээ, зах зээлийн эрсдэлийн лимитийн биелэлт болон бусад аливаа эрсдэл үүсгэх хүчин зүйлийн талаар танилцуулдаг.

Эрсдэлийг бууруулах арга зам

Хүүгийн түвшний эрсдэл, гадаад валютын ханшийн өөрчлөлт, зээлийн эрсдэл болон ирээдүйн үйл ажиллагаанаас үүдэж болох болзошгүй эрсдэлийн хэмжээг мэдрэмжийн шинжилгээгээр тооцон, хянаж ажилладаг. Банк зээлийн эрсдэлийг бууруулах зорилгоор барьцаа хөрөнгө болон хувь хүний батлан даалт авдаг.

Эрсдэлийн хэт төвлөрөл

Төвлөрөл нь ижил, төстэй бизнесийн үйл ажиллагаанд оролцож байгаа, эсвэл нэгэн ижил газар зүйн бүсэд, эдийн засгийн ойролцоо шинж чанартай олон тооны оролцогч талуудад улс төр, эдийн засаг болон аливаа бусад өөрчлөлт нь тэдгээрийн гэрээний үүргээ гүйцэтгэх чадварт ижил маягаар нөлөөлж байгаа үед бий болдог. Төвлөрөл нь тухайн нэгж салбарт болон газар зүйн байрлалд нөлөөлж буй нөхцөл байдалд Банкны гүйцэтгэлээ хангах мэдрэмжийг илтгэнэ.

Эрсдэлийн хэт төвлөрлөөс зайлсхийх үүднээс Банк өөрийн бодлого, журамдаа олон төрлийн багцтай байх тодорхой удирдамжийг тусгасан байдаг. Үүнд нийцүүлэн зээлийн эрсдэлд тодорхойлсон төвлөрлийг хянаж удирдана.

Монголбанк дараах стандарт хязгаарлалтуудыг тогтоож, биелүүлэхийг шаарддаг. Үүнд:

- Нэг зээлдэгч болон түүний холбогдох этгээдэд олгох нийт зээлийн дүн болон зээлтэй адилтгах бусад хөрөнгийн нийлбэр дүн банкны өөрийн хөрөнгийн 20% -иас хэтрэхгүй.
- Банкны холбогдох этгээдэд олгосон зээлийн хэмжээ болон зээлтэй адилтгах бусад хөрөнгийн дүн нь банкны өөрийн хөрөнгийн 5% -иас, тэдгээрийн нийлбэр дүн нь өөрийн хөрөнгийн 20% -иас тус тус хэтрэхгүй.

Банк журмаараа хадгаламжийн төвлөрлийн түвшинд харгалзах хангалттай хөрвөх чадварыг барихыг шаарддаг.

(2) Зээлийн эрсдэл

Банкны харилцагч гэрээний дагуух үүргээ биелүүлээгүй тохиолдолд Банканд үүсч болох алдагдлын эрсдэлийг зээлийн эрсдэл гэнэ. Банк нь зээлийн өргөдлүүдийг анхааралтай хянах, эрсдэлийн түвшинд тохируулсан хүүгийн хувь хэмжээг тогтоох, харилцагч талуудыг газарзүйн байршил, аж үйлдвэрийн салбараар ангилан зээлийн эрсдэлд өртөх түвшинд хязгаар тогтоох зэргээр зээлийн эрсдэлд хяналт тавьдаг.

Банк нь харилцагч талуудын зээлжих чадварт орж болзошгүй өөрчлөлт (барьцаа хөрөнгөө тогтмол шинэчлэх гэх мэт)-ийг эртнээс олж таних зорилгоор зээлийн чанарын хяналтын процессийг нэвтрүүлсэн. Зээлийн чанарын хяналтын процесс нь Банканд болзошгүй алдагдлыг тодорхойлох, засах арга хэмжээг эрт авах боломжийг бий болгодог.

Банк зээлийн үйл ажиллагааг сайжруулахын тулд зээлийн журам зааврыг тогтмол шалгаж, сайжруулж шинэчилдэг.

Зээлтэй холбоотой болзошгүй үүргийн эрсдэл

Банк нь харилцагчийн өмнөөс төлбөр төлөх магадлал бүхий баталгаа, аккредитивийг гаргадаг. Төлбөр төлөгдөх тохиолдолд баталгаа, аккредитивийн нөхцөлд тулгуурлан харилцагчаас эх үүсвэрийг төвлөрүүлнэ. Банканд зээлтэй нэгэн адил эрсдэл учруулах тул эдгээрийг зээлийн үйл ажиллагааны бодлого, журмаар зохицуулна.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 дугаар сарын 31

37. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

(2) Зээлийн эрсдэл (үргэлжлэл)

Барьцаа хөрөнгө болон бусад зээлийн баталгаа, батлан даалтыг тооцохгүйгээр зээлд учирч болзошгүй эрсдэлийн дээд хэмжээ

Доорх хүснэгт нь тайлан тэнцлийн үзүүлэлт бүрийн хувьд зээлийн эрсдэлд өртөж болох нийт багцыг харуулсан байна. Эрсдэлд өртөж болох нийт багцыг барьцаа хөрөнгөөр эрсдэлийг бууруулахаас өмнөх нийт дүнгээр илэрхийлсэн болно.

	2020 мян.төг	2019 мян.төг
Бэлэн мөнгө ба Монголбанканд байршуулсан мөнгө (бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах данснаас бусад)	–	452,916,902
Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	570,008,607	301,819,280
Санхүүгийн хөрөнгө оруулалт (өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт ба өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгөөс бусад)	1,677,576,345	1,775,327,393
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	89,371,192	494,861,756
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	4,612,265,674	3,934,355,996
Бусад санхүүгийн хөрөнгө	54,100,796	21,715,985
	7,003,322,614	6,980,997,312
Эх үүсвэргүй баталгаа, аккредитив	289,565,616	350,275,914
Ашиглаагүй зээлийн шугам	275,547,390	179,013,676
	565,113,006	529,289,590
Зээлийн эрсдэлд өртөж болох нийт дүн	7,568,435,620	7,510,286,902

Бодит үнэ цэнээр бүртгэсэн санхүүгийн хэрэгслийн хувьд дээрх дүнгүүд нь өнөөгийн зээлийн эрсдэлийн өртөлтийг харуулж байгаа боловч ирээдүйн үнэ цэнийн өөрчлөлтөөс бий болж болох эрсдэлийн дээд хэмжээ биш болно.

Эрсдэлийн төвлөрлийн шинжилгээ

Дараах хүснэгтэд Банкны харилцагчдад олгосон зээл, урьдчилгааг (Тодруулга 19) аж үйлдвэрийн салбараар нь ангилан, зээлийн барьцаа хөрөнгийн бодит үнэ цэнэ эсвэл зээлийн чанарыг сайжруулах бусад зүйлүүдийг авч үзэхээс өмнөх нийт дүнгээр нь үзүүлэв.

	Нийт багцын хэмжээ			
	2020 мян.төг	%	2019 мян.төг	%
Худалдаа, үйлчилгээ	962,746,676	20.87%	887,182,636	22.55%
Уул уурхай, олборлолт	799,360,866	17.33%	583,301,116	14.83%
Барилга байгууламж	524,185,807	11.37%	497,090,897	12.63%
Санхүүгийн үйлчилгээ*	345,712,883	7.50%	374,814,148	9.53%
Үйлдвэрлэл	461,682,664	10.01%	353,795,538	8.99%
Орон сууц	350,099,986	7.59%	272,320,795	6.92%
Төлбөрийн карт	226,380,742	4.91%	212,807,471	5.41%
Шатахуун импорт, худалдаа	117,908,067	2.56%	148,581,652	3.78%
Зочид буудал, ресторан, аялал жуулчлал	165,981,324	3.60%	113,409,481	2.88%
Тээвэр, харилцаа холбоо	83,803,673	1.82%	72,825,008	1.85%
Хадгаламж барьцаалсан	58,371,337	1.27%	63,471,973	1.61%
Эрүүл мэнд	39,975,288	0.87%	33,724,233	0.86%
Боловсрол	72,553,155	1.57%	26,242,865	0.67%
Цахилгаан, эрчим хүч ба дулаан	24,946,194	0.54%	22,188,970	0.56%
Хөдөө аж ахуй	25,445,356	0.55%	21,606,289	0.55%
Бусад	353,111,656	7.66%	250,992,924	6.38%
	4,612,265,674	100.00%	3,934,355,996	100.00%

*Бусад салбарын компаниудын хувьцааг л эзэмшдэг холдинг компанийг банкны салбарын кодчилолын дагуу санхүүгийн үйлчилгээ гэж ангилсан.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 дугаар сарын 31

37. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

(2) Зээлийн эрсдэл (үргэлжлэл)

Зээлийн барьцаа хөрөнгө ба бусад сайжруулалтууд

Барьцаа хөрөнгийн төрөл болон үнэлгээний дүн нь зээлдэгчийн зээлийн эрсдэлийн үнэлгээ болон олгох зээлийн төрлөөс хамаарна. Барьцаанд авсан хөрөнгийн гол төрлүүдийг доор үзүүлэв. Үүнд:

- Байгууллагуудад олгосон зээл: Үл хөдлөх хөрөнгө, бараа материал, үйлдвэр ба тоног төхөөрөмж, машин механизм;
- Иргэдийн зээл: Тээврийн хэрэгсэл; орлого; үл хөдлөх хөрөнгө; орон сууцны үл хөдлөх хөрөнгө
- Жижиг, дунд үйлдвэрлэлд олгосон зээл: Үл хөдлөх хөрөнгө

Банк барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийг тогтмол хянадаг ба гэрээний дагуу шаардлагатай үед нэмэлт барьцаа хөрөнгө гаргуулахыг шаардаж болно.

Банк журмын дагуу өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийг зохион байгуулалттайгаар борлуулдаг. Хөрөнгө борлуулсанаас олсон орлогыг зээлийн үлдэгдэл төлбөрийг багасгах болон төлж дуусгахад зориулна. Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийг Банк нь өөрийн бизнесийн хэрэгцээнд ашигладаггүй.

Доорхи хүснэгтээр хугацаа хэтэрсэн болон үнэ цэнэ буурсан зээл, урьдчилгааг барьцаа хөрөнгийн бодит үнэ цэнийн хамт харуулав:

	2020			2019		
	Нийт мян.төг	Цэвэр дүн мян.төг	Барьцаа хөрөнгийн бодит үнэ цэнэ мян.төг	Нийт мян.төг	Цэвэр дүн мян.төг	Барьцаа хөрөнгийн бодит үнэ цэнэ мян.төг
Анхаарал хандуулах	1,096,565,227	947,822,463	881,283,776	716,815,475	583,922,496	555,815,787
Хэвийн бус	193,117,566	135,504,099	130,332,661	83,886,838	64,488,389	62,501,138
Эргэлзээтэй	191,081,361	108,900,020	108,100,952	291,571,638	163,973,135	163,848,300
Муу	232,070,583	39,112,805	39,002,187	144,620,533	21,620,084	21,619,953
	1,712,834,737	1,231,339,387	1,158,719,576	1,236,894,484	834,004,104	803,785,178

Санхүүгийн хөрөнгийн ангилал тус бүрийн зээлийн чанар

Банк санхүүгийн хөрөнгийн зээлийн чанарыг дотооддоо хэрэглэдэг зээлийн үнэлгээний систем Монголбанкны зохицуулалтыг ашиглан удирддаг. Банк зээлийн багцдаа зохистой, байнгын эрсдэлийн зэрэглэл тогтоож байх бодлогыг баримталдаг. Энэ нь зарим төрлийн эрсдэлийг удирдах боломжийг олгохын зэрэгцээ, бүх зээлүүдийн эрсдэлийг нэг хэмжигдэхүүнээр илэрхийлэн харуулах боломж олгодог.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 дугаар сарын 31

37. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

(2) Зээлийн эрсдэл (үргэлжлэл)

Санхүүгийн хөрөнгийн ангилал тус бүрийн зээлийн чанар (үргэлжлэл)

Дараах хүснэгтэд зээлийн чанарыг Банкны зээлийн дотоод үнэлгээний систем дээр үндэслэн зээлтэй холбоотой хөрөнгийг бүлэг тус бүрээр нь үзүүлэв. Үнэ цэнийн бууралтын санг оруулаагүй дүнгээр харуулав.

	Бэлэн мөнгө ба Монголбанканд байршуулсан мөнгө (бэлэн мөнгө ба Монгол банк дахь харилцах данснаас бусад) мян.төг	Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө мян.төг	Санхүүгийн хөрөнгө оруулалт (өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт ба өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгөөс бусад) мян.төг	Санхүүгийн үүсмэл хэрэгсэл мян.төг	Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа* мян.төг	Бусад санхүүгийн хөрөнгө мян.төг
2020 оны 12 сарын 31- нээр						
Хэвийн	–	570,008,607	1,677,576,345	89,371,192	2,899,430,937	23,558,869
Анхаарал хандуулах	–	–	–	–	1,096,565,227	13,938
Чанаргүй:						
Хэвийн бус	–	–	–	–	193,117,566	375,029
Эргэлзээтэй	–	–	–	–	191,081,361	26,943,132
Муу	–	–	–	–	232,070,583	3,209,828
Нийт дүн	–	570,008,607	1,677,576,345	89,371,192	4,612,265,674	54,100,796
Эрсдэлийн сан	–	–	–	–	(503,547,304)	(17,441,048)
Дансны цэвэр дүн	–	570,008,607	1,677,576,345	89,371,192	4,108,718,370	36,659,748
2019 оны 12 сарын 31- нээр						
Хэвийн	452,916,902	301,819,280	1,775,327,393	494,861,756	2,697,461,512	21,503,902
Анхаарал хандуулах	–	–	–	–	716,815,475	5,823
Чанаргүй:						
Хэвийн бус	–	–	–	–	83,886,838	2,759
Эргэлзээтэй	–	–	–	–	291,571,638	5,199
Муу	–	–	–	–	144,620,533	198,302
Нийт дүн	452,916,902	301,819,280	1,775,327,393	494,861,756	3,934,355,996	21,715,985
Эрсдэлийн сан	–	(438,008)	–	–	(431,204,350)	(270,511)
Дансны цэвэр дүн	452,916,902	301,381,272	1,775,327,393	494,861,756	3,503,151,646	21,445,474

*2020 оны 12 сарын 31 хүртэлх Ковид-19-ийн үр дүнд зээлийн ангилалын түр зуурын хөнгөлөлттэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг тодруулга 19-ээс харна уу.

Үнэ цэнийн бууралтын үнэлгээ

Зээлийн үндсэн эсвэл хүүгийн төлбөр 90-ээс дээш хоногоор хугацаа хэтэрсэн, зээлдэгчийн мөнгөн урсгалд мэдэгдэхүйц хүндрэл учирсан, зээлийн үнэлгээ буурсан, эсвэл зээлийн гэрээний анхны нөхцөл зөрчигдсөн эсэх зэргийг үндэслэж зээлийн үнэ цэнийн бууралтын шинжилгээг хийнэ.

Банк нь үнэ цэнийн бууралтын шинжилгээг бүлгийн болон тусгай үнэлгээгээр авч үздэг.

Тусгай үнэлгээгээрх үнэ цэнийн бууралтын сан

Банк нь дангаараа ач холбогдол бүхий томоохон зээл тус бүрийн хувьд тохирох чанарын үнэлгээг тодорхойлж, тогтоосон чанарын үнэлгээг ашиглан эцсийн үнэлгээ, цаашлаад сангийн хэмжээг тогтооно. Чанарын зэрэглэлийг тодорхойлохдоо харилцагчийн бизнесийн тогтвортой байдал, санхүүгийн гүйцэтгэл, гэрээний нөхцлийг зөрчсөн байдал, бусад санхүүгийн дэмжлэг байгаа эсэх, барьцаа хөрөнгийн бодит үнэ цэнэ зэргийг харгалзан үзнэ. Үнэ цэнийн бууралтыг сар бүр үнэлж, тайлант өдөр бүртгэнэ.

37. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**(2) Зээлийн эрсдэл (үргэлжлэл)****Бүлгийн үнэлгээгээрх үнэ цэнийн бууралтын сан**

Дангаараа ач холбогдол бүхий биш, томоохон бус зээлүүдийн хувьд хамтад нь бүлгийн үнэлгээ хийнэ. Сангийн хэмжээг зээлийн хугацааны шинж чанараар, тухайлбал хугацаа хэтэрсэн хоногийн тоон дээр үндэслэн сар бүр тооцдог.

Баталгаа, аккредитивийн үнэлгээг харилцагчийн зээлийн чанарын үнэлгээ болон гэрээний хугацааг харгалзан авч үзэж зээлийн нэгэн адилаар ижил төстэй аргаар хийнэ.

Зээлийн төвлөрлийн харьцаа

Банкнаас аливаа этгээд, түүнтэй холбогдох этгээд, харилцан хамаарал бүхий этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалт, бусад хэлцлийн нийлбэр дүн нь тухайн банкны өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтэрч болохгүй. Хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн дарга болон гишүүн, гүйцэтгэх удирдлага, банкны ажилтан эсвэл түүнтэй холбоотой аливаа этгээдэд олгох зээл, түүнтэй адилтгах хөрөнгө, баталгааны дээд хэмжээ нь банкны өөрийн хөрөнгийн 5 хувиас нийт дүн нь Банкны өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй байх ёстой.

2020 болон 2019 оны 12 сарын 31-ний байдлаар дээрх шаардлагыг зөрчөөгүй болно.

(3) Төлбөрийн чадварын эрсдэл

